



**МОНГОЛЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ
ГАЗРУУДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ БА
ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД
КОНЦЕСС ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ**

ТАЙЛАН

2013 оны аравдугаар сар



Бэлтгэсэн:



Prepared for:



Prepared by:



Хариуцлагын санамж

Энэхүү баримт бичигт тусгагдсан буюу илэрхийлэгдсэн аливаа хүсэлт, мэдэгдэл, санал эсвэл зөвлөлгөө нь уг тайланг гаргах хугацаанд TRC Tourism байгууллагад хуримтлагдсан боломжит мэдээлэлд үндэслэгдсэн зөв итгэл үнэмшлээр гаргахыг хичээсэн зүйлс болно. Тийм учраас TRC Tourism байгууллага нь энэхүү баримт бичигт тусгагдсан аливаа гомдол, мэдэгдэлтэй холбоотой аливаа хувь хүн болоод бусдад учирсан болон учирч болох хохирол, тохиолдсон буюу тохиолдож болзошгүй аливаа үйлдэл болон эс үйлдэлд хариуцлага хүлээхгүй болно.

© Copyright TRC Tourism – албан ёсны зөвшөөрөлгүйгээр энэхүү тайлангийн аль ч хэсгийг олшруулж болохгүй. enquiries@trctourism.com руу хандан энэхүү тайлангийн талаарх мэдээллийг авч болно.

Хураангуй

Концессийн амжилттай гэрээ нь байгалийн болон соёлын үнэт зүйлсийг хамгаалах, зочлогсад аялагсад байгалийн сайхнаас сэтгэл ханамж авч улмаар хамгаалалттай газрын үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих, орон нутгийн бүлгүүдэд ашиг тусаа өгөх зэрэгт эерэг нөлөө үзүүлж чухал хувь нэмэр оруулан тогтвортой үр дүнд хүргэх хамтын ажиллагаа, түншлэлийн хэлбэр юм.

Концессийн менежмент нь цаашилбал биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, соёлын өвийг хамгаалах, сэргээх болон Монголын тусгай хамгаалалттай газар нутгуудын (ТХГН) талаар олон нийтэд таниулах, сэтгэл ханамжийг бий болгох зэрэг зорилтуудтай уялдах юм. ТХГН-ийн тухай хуулиар концессийн олон янзын ашиглалтыг зөвшөөрч байгаа хүрээ нь одоогийн байдлаар тун сул байна. Энэ нь концессийн талаарх засаглалын болон зохицуулалтын хэд хэдэн арга хэмжээг баталгаажуулаагүй, Монгол улсын ТХГН-т хэрэгжүүлэх концессийн үр ашгийг нэмэгдүүлж эрсдлийг бууруулах тэнцвэрийг хадгалж чадахгүй байгаатай холбоотой.

Концессийн стратеги нь арилжааны болон уламжлалт ашиглалтын үр дүнтэй менежмент, ТХГН-ийн одоогийн хамгаалал, хөрөнгө оруулснаар үйлчилгээ болон тоног төхөөрөмжийн чанар, сонголтыг нэмэгдүүлэх болон Монгол улсын ТХГН-ын сүлжээнд орлого оруулах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Энэхүү стратеги нь ТХГН-ийн захиргаад болон БОНХЯ-ны ажилтнууд өөрсдийнхөө эрх мэдлийн хүрээнд бүхий л нөөц газруудад газар ашиглалттай холбоотой зохицуулалтыг хариуцан хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ. Концессийн стратеги нь үр дүнтэй, тэгш эрхийг хангасан ба хэрэгжүүлэхэд хялбар байхаар загварчлагдсан болно. Түүнчлэн концессийн менежменттэй холбоотой стандартууд, баримт бичгүүд болон горим, журмуудтай холбоотой зөвлөмжүүд мөн бодлогын өргөн хүрээний асуудлаар чиглэл өгөх юм. Тэрчлэн ТХГН-ийн сүлжээг таниулан сурталчлах, удирдан зохион байгуулах, зочлогсад аялагсдын энэ талаарх ойлголт, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн бүлгүүд болон бусад олон хамтрагчдийн гүйцэтгэх үүрэг үнэлж баршгүй чухал болохыг тэмдэглэсэн болно.

Стратегийн Алсын Хараа

Монголын ТХГН-ийн сүлжээ нь байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийг хөхүүлэн дэмжиж сайжруулан орон нутгийн бүлгүүдэд мэдэгдэхүйц өгөөж өгөх ил тод, үр дүнтэй концессийн тогтолцоотой болно.

Зорилго

Стратеги нь энэ зайг нөхөхийн тулд бэлтгэгдсэн бөгөөд доорх зорилгыг агуулсан болно:

- ▶ Байгаль хамгаалаллыг дэмжих, сайжруулах
- ▶ Арилжааны болон хэт арилжааны үйл ажиллагааг хянаж ажиглах
- ▶ Хамгаалалттай газарт аялагсдын авах таашаалыг нэмэгдүүлэх
- ▶ Тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах ба ажлын байр бий болгохыг дэмжих
- ▶ Иргэдийн амьжиргааны өөр эс үүсвэрийг олж хөгжүүлэхэд чиглэсэн хуримтлал бий болгох болон чадавх, чадварыг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих
- ▶ ТХГН-ийн сүлжээнд үр дүнтэй менежмент явуулахын тулд Засгийн газарт болон орон нутгийн захиргаанд орох эдийн засгийн ашгийг нэмэгдүүлэх

- ▶ Концесс зохион байгуулалтын ил тод, үр дүнтэй байдлыг сайжруулах
- ▶ Стратеги хэрэгжүүлснээр Монгол улсын ТХГН-уудад доорх дорвитой үр дүн авч ирэх бололцоо байна:
- ▶ Хувийн хэвшил болон төр-хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ) хамтын ажиллагаанаас хөрөнгө оруулалт нэмэгдэх
- ▶ Хамгаалалттай газрын хамгаалал болон менежмент үр дүнтэй болох
- ▶ Зочлогсодод зориулсан байгууламж, үйлчилгээний чанар нэмэгдэх, хөгжих
- ▶ Засгийн газрын орлого нэмэгдэх
- ▶ Орон нутгийн иргэд, бүлгүүдийн чадавч нэмэгдэх, сургалт зохион байгуулах, ажлын байр бий болох.

Орон нутгийн бүлэг концессийн менежментэд чухал үүрэг гүйцэтгэхийг стратеги хүлээн зөвшөөрч байна. Концессийг бүлгүүдэд шууд олгох нь орлого олоход туслах, нөөцөд нэвтрэх эрхээ алдсан зардлыг нь нөхвөрлөх, тэнцвэржүүлэх, боловсрол ба сургалтанд хамруулах мөн байгаль хамгаалалх ажилд орон нутгийн бүлгийн дэмжлэгийг авах зэргээр асуудал шийдэх нэг арга байж болно. Мөн үүн дээр нэмээд хэлэхэд орон нутгийн хүмүүсийн амьжиргаа нь эндээс хамааралтай байдаг учраас тэд ихэнхдээ өөрсдийнхөө нөөцийн гайхамшигтай хамгаалагчид байж чаддаг. Орон нутгийн бизнес эрхлэгчид ч мөн ялгаагүй хамгаалалттай газрын агентлагт хямд зардлаар үйлчилгээ үзүүлж болох юм. Концесс эсвэл нэвтэрсний хураамжаас олсон орлогоосоо нутгийн иргэдтэй хуваалцдаг байж ч бас болно.

Хүндрэлтэй Асуудлууд

Дэлхийн бусад ТХНГ-уудийн сургамжаас үзэхэд концессийн ашиг тус нь тодорхой байгаа хэдий ч бас анхаарах шаардлагатай асуудлууд ч мөн байна. Үүнд:

- ▶ Зорилго зөрчилдөөнтэй байх асуудал – ТХНГ-ыг хамгаалах, хадгалж үлдэх хууль эрхзүйн үндсэн зорилго, чиглэл нь арилжааны аялал жуулчлалын бизнесийн орлого олох гэсэн сэдэлтэй зохицохгүй байх
- ▶ Бодлого болон тогтолцооны саадууд - эдгээр нь хувийн хэвшлийг ТХГН-т үйл ажиллагаа явуулахыг зогсоох буюу хязгаарлах талтай
- ▶ Хувийн бизнес эрхлэгчдийг сонгох- ТХГН-ийн менежерүүд хувийн хэвшлийн зохистой оролцоо, бизнесийн арга барил болон энэ хэвшлийн тэргүүлэх чиглэлийн талаар мэдлэггүй байх
- ▶ Хамтын ажиллагаа тогтоох- урт хугацааны арилжааны хамтын ажиллагааг тогтоох тал дээр ТХГН-ийн менежерүүдэд хүндрэл учрах
- ▶ Ашиглалтын зөрчил – ТХГН-ийн менежерүүд арилжааны үйл ажиллагааны зохист хэм хэмжээг мөрдүүлэх мөн бусад ашиглагч ба ТХГН-ийн доторх өөр үйл ажиллагаатай зөрчилдөхгүй байхад анхаарах ёстой
- ▶ Хэт арилжааны хэлбэрт шилжих- арилжааны үйл ажиллагаанаас уламжлалаараа ангид байсан ТХГН-ийн ажилтнууд болон олон нийт ТХГН-ийг хариуцсан агентлагыг хамтын эсвэл хувийн бизнестэй хутгалдсан хэмээн хардах байдал.

Үндсэн Чиглэл ба Үйл ажиллагаа

Монгол улсын ТХГН-т зориулсан концессийн үр дүнтэй стратегийг бий болгох зорилгоор гурван гол чиглэл ба үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсрууллаа. Чиглэл бүр нь өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бөгөөд эдгээр нь ач холбогдлоор нь эрэмбэлж санал болгосон үйл ажиллагааны жагсаалт болон энэ стратегийг хэрэгжүүлэхийн тулд

хийгдсэн гол үйл явцыг мөн тодорхойлон гаргасан. Тодорхой бөгөөд хэмжигдэхүйц хариуцлагууд нь үйл ажиллагаа нэг бүрийг хэрэгжүүлэх хариуцлагыг баталгаажуулна.



Хамгийн эхэнд эрэмбэлэгдэх ажил нь хууль эрхзүйн хүрээний зохицуулалт бий болгох явдал бөгөөд энэ нь концессийн тогтолцооны байгаль орчин, санхүү, нийгмийн зорилго ба концесс эзэмшигчдэд тавигдах хариуцлагуудыг тодорхойлж гаргах болно. Энэ нь ТХГН-ийн хуульд зохих өөрчлөлт оруулахыг шаардах болно.

Санал болгож буй өөрчлөлтүүд нь ТХГН-ийн тухай хуулинд концессийн менежментийн хууль эрхзүй хүрээний хамгаалалт болж хууль ёсны дагуух газар ашиглалт болохыг нь хүлээн зөвшөөрнө. Энэ илүү тэнцвэртэй арга нь концессийн үйл ажиллагааг хамгаалалттай газрын хамгаалалын ажилд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай шинэ шинэлэг тоног төхөөрөмжүүд ба үйлчилгээ оруулж ирэх, эзэмших эрхийн баталгааг хангах ба нутгийн иргэдийн концессийн менежментэд оролцох эрхийг зөвшөөрөхөд дэмжлэг болно.

Санал болгож буй өөрчлөлтүүд нь доорх нөхцөлийг бүрдүүлнэ:

- ▶ Концессийг олгож болох бүхийл үйл ажиллагаа,
- ▶ ТХГН болон түүний орчны бүсэд концессийн үйл ажиллагааны олон төрлийг явуулж болох нөхцөл, хэлбэр,

- ТХГН-т концесс эзэмшигч үйл ажиллагаа явуулахдаа заавал мөрдөх тогтвортой байдлын хэм хэмжээ , хугацаа (5 жил, 10 жил үүнээс ч урт хугацаанд),
- Орон нутгийн захиргаатай хуваалцахаар тохиролцох орлого, хураамж
- Гадаадын хөрөнгө оруулах боломжууд
- Өрсөлдөхүйцээр олгогдсон концессууд
- Концессийг эхлүүлэх ба үргэлжлүүлэх хугацаа болон концессийн гэрээ заасан хугацаанаас өмнө дуусгавар болох нөхцөлүүд
- Засгийн газар мөн үйлдвэр/бүлгийн тэргүүлсэн концессийг хэрэгжүүлэх хөшүүрэг
- Концессийн үйл ажиллагааны удирдлага
- ТХГН-т концессийн үйл ажиллагааны явцад байгалийн онгон байдал, байгаль орчныг сайжруулах нөхцлүүд.

Бусад чухал үйл ажиллагаа:

- Засгийн газар болон хөрөнгө оруулагч талын аль алины тэргүүлсэн тогтвортой хөгжлийн зохистой боломжуудыг нийт ТХГН-ийн хэмжээнд хэрэгжүүлэх зохицуулалтын болон тогтолцооны тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх
- Соёлын өвийг зохистой ашиглах, экологийн тогтвортой байдлыг дэмжих мөн тухайн газар, нөөцийн менежментийн зорилготой нь нийцэхүйц ашиглагчдийн үйл ажиллагаа, эрхийг зохицуулах тодорхой бодлого болон журмыг энэхүү стратегид тусгасан зарчмыг үндэслэн гаргах
- Концессийн менежментийн үр дүнтэй, тэгш эрхийг хангасан, хөглөн явуулахад хялбар, өнөөгийн тогтолцоонд зохицсон, хэрэгжихүйц эрхзүйн орчинг бий болгох шаардлагатай.
- Концессийн менежментийн тогтолцооны төвлөрсөн зохицуулалт бий болгох
- ТХГН-т хөрөнгө оруулах идэвхтэй аргыг нэвтрүүлж тогтвортой аялал жуулчлал болон уламжлалт ашиглалтыг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх болон бусад нийгэм эдийн засгийн үр дүн өгөх Төр-Хувийн хэвшлийн Түншлэл (ТХХТ) хамтын ажиллагааны санаачлагыг өрнүүлэх,
- Стратегийн төлөвлөлт боловсруулан ТХГН-т чанартай зочин\жуулчны үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц, тоног төхөөрөмж, үйлчилгээний хэлбэр бий болгох, орон нутгийн иргэд, бүлгүүдийн амьдрах арга, ахуй соёлд түшиглэн байгалийн болон соёлын сайн чанартай бүтээгдэхүүн санал болгож чадахуйц бөгөөд тэр хэмжээгээр хамгийн ихээр хөрөнгө оруулалт шаардагдаж буй газруудад хөрөнгө оруулалтыг чиглүүлэх. Энэ аргыг бусад шаардлагагүй газарт концессийг хязгаарлах арга болгон ашиглах
- Концессийн үйл ажиллагааг засгийн газарт орлого оруулахад тэр нь улмаар ТХГН-ийн сүлжээний хамгаалал, менежментэд дамжин ороход чиглүүлэн ашиглах
- Концессийн менежментийн сургалт, чанарын баталгааг хангах ба албан хаагчид болон бүлгүүдийн бизнесийн хөгжил, үйлчилгээний чанар ба стандартыг нутагшуулах\өөриймшүүлэх зэрэгт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- Бүлгийн зөвлөлдөх хэсгийг байгуулан Монгол улсын ТХГН-уудад концессийн менежментийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх

- ▶ Эрхзүйн өөрчлөлт хийгдсэн тохиолдолд концессийн шинэ менежментийг Орхоны Хөндийн Байгалийн Цогцолборт Газар болон Их Нартын Байгалийн Нөөц Газарт турших.

Концессийн стратегид тусгагдсан гол үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх нь концессийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ба хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд ихээхэн чухал. Эдгээр үйл ажиллагааг доор тоймлосон бөгөөд үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэхийн тулд хийх алхмуудыг 8-р бүлгийн төгсгөл хэсгийн хүснэгтүүдэд оруулав.

Концессийн стратеги амжилттай хэрэгжихэд юу хэрэгтэй вэ?

Улс төрийн дэмжлэг –Концессийн менежментийн хүрээний өөрчлөлт хийх эрх үүсэх нь улс төрийн хүчтэй хамгаалалттай болохтой нэгэн адил чухал зүйл бөгөөд ил тод байдлыг сайжруулахын эсрэг ужгирсан сонирхлуудыг давж гарах мөн сайн засаглалд шаардагдах хэрэгцээтэй нөөцийг гаргахад чухал хэрэгтэй.

Засгийн газрын хамтын ажиллагаа – стратегийг амжилттай хэрэгжүүлэх талаар Байгаль Орчны болон Сангийн яам ба холбогдох бусад яам хоорондын сайд нарын түвшний хэлэлцээр хийгдсэнээр агентлаг хооронд хариуцлагын талаар аливаа давхардал гарахгүй байхыг баталгаажуулж тогтолцооны чадавх сайжирна.

Хандивлагч/гэрээлэгч төрийн албан хаагчдыг сургахад дэмжлэг үзүүлэх – Хандивлагч агентлагууд нь байгууллагын чадавх дутмагаас шалтгаалан хийгдэхгүй байгаа ТХГН-ийн сүлжээний бүтээн байгуулалтанд дэмжлэгээ үргэлжлүүлэн үзүүлэх нь чухал болно. Захиргааны үйл ажиллагаа, системийн хөгжлийн талаар болон концессийн менежментийн талаарх сургалт, төрийн албан хаагчид ба орон нутгийн бүлгийн чадавх бэхжүүлэх дэмжлэг нь одоогоор чухал хэвээр байна.

ГАРЧИГ

ХАРИУЦЛАГЫН САНАМЖ	I
ХУРААНГУЙ	II
1 ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 УДИРТГАЛ.....	3
1.2 МОНГОЛ УЛСЫН ТХГН-Т КОНЦЕССИЙГ АМЖИЛТТАЙ НЭВТРҮҮЛЭХ БИЗНЕСИЙН БОЛОМЖ.....	4
1.3 БИЗНЕСИЙН СААДЫГ ДАВАН ТУУЛАХ НЬ.....	7
1.4 ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ.....	8
2 КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТИЙН ОНОВЧТОЙ ПРАКТИК.....	9
2.1 ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРУУДАД КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОНОВЧТОЙ ПРАКТИК ХАНДЛАГА	9
2.2 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ГАЗАРТ КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРАХ АСУУДЛУУД.....	10
2.3 КОНЦЕСС БАЙГУУЛАХ НЬ	11
2.4 КОНЦЕССИЙН ГЭРЭЭНИЙ АГУУЛГА	13
2.5 ХУРААМЖ.....	13
2.6 КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТИЙН ОНОВЧТОЙ ПРАКТИК	14
2.7 ЖИШИГ СУДАЛГАА: ДЭЛХИЙ ДАЯАР ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗРУУДАД АЖИЛЛАЖ БАЙГАА КОНЦЕССУУД.....	15
3 МОНГОЛ УЛСЫН ТХГН ДАХЬ КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	33
3.1 ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	33
3.2 БУСАД АСУУДЛУУД.....	43
4 ӨӨРЧЛӨЛТ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ – ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ НӨХЦӨЛД КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТ	46
4.1 ӨНӨӨГИЙН СИСТЕМ ДЭХ ХЯЗГААРЛАХ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД БОЛОН БУСАД АСУУДЛЫН ТОВЧООН	46
5 МОНГОЛ УЛСЫН ТХГН ДАХЬ КОНЦЕССИЙН СТРАТЕГИ.....	49
5.1 Үндсэн чиглэл ба үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд	50
6 ХУУЛЬ ЭРХ, БОДЛОГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ.....	61
6.1 САНАЛ БОЛГОЖ БҮЙ ЭРХЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ	61
6.2 ЗӨВЛӨМЖ БОЛГОЖ БОДЛОГО БА ЖУРМУУД	62
6.3 САНАЛ ГАРГАГЧДАД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ НЬ.....	69
6.4 ТАЛБАРЫГ СОНГОХ ЖУРМУУД	70
6.5 КОНЦЕССИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРЫН ЗААВАР	72
6.6 Хөгжлийн үзэл баримтлал (илүү цогц концесст зориулсан)	74
6.7 Концепцийг эцэслэх ба Концессийн гэрээ\Батлах үйл ажиллагаа	75

7	КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТИЙН СТРАТЕГИ БА ҮЗҮҮЛЭХ ТУРШИЛТЫН ТАЛБАРУУД	81
7.1	Орхоны Хөндийн Байгалийн Цогцолбор Газар	81
7.2	Их Нартын Байгалийн Нөөц Газар.....	88
8	ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ	91
8.1	Зөвлөмжүүд	91
8.2	Бусад зөвлөмжүүд	91
	ИШ ТАТСАН ЭХ СУРВАЛЖ	98
	ХАВСРАЛТ 1 ҮҮРЭГ БА ХАРИУЦЛАГА	100
	ХАВСРАЛТ 3. ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН СТАНДАРТ ЗАГВАРЫН ЖИШЭЭ	104
	ХАВСРАЛТ 4. КОНЦЕССИЙН НИЙТЛЭГ ГЭРЭЭ - БОНХЯ/ТХГНУ-ЫН КОНЦЕССИЙН ГЭРЭЭНИЙ АГУУЛГА БА НӨХЦӨЛҮҮД	107

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Удиртгал

Дэлхийн улсуудын ТХГН-ийн агентлагууд концессийг зохион байгуулах болон олгох олон төрлийн үзэл баримтлал, стратегийг ашигладаг. Стратеги буюу ихэнхдээ үзэл баримтлал нь хувь хүн эсвэл байгууллага (арилжааны болон ажилжааны бус) ТХГН эсвэл түүний орчны бүс дэх байгалийн нөөцийг хувийн ашиг олох зорилгоор ашиглах санал тавьсан байдлаар илэрч гардаг. Ашиглалтын хэлбэр нь байгалийн аялал жуулчлал, үйлчилгээ хөгжүүлэх байр болон хөтөчтэй аяллыг зохион байгуулах мөн байгалийн нөөц ашиглах тухайлбал мод бэлтгэх болон орон нутгийн бүлгүүд малаа бэлчээрлүүлэх зэрэг ашиглалт юм. Мөн ТХГН-ийн агентлагаас олон нийтийн хүсэлтийн дагуу зочлогсад, аялагсад үйлчлэх үйлчилгээг сайжруулах, амралт зугаалгын боломжийг бүрдүүлэх зорилгоор концессийг олгож болно.

Монгол улсын ТХНГ-ийн тухай хууль (1994) нь ТХГН-ийн сүлжээний газруудыг байгуулах, удирдан чиглүүлэх боломжийг бүрдүүлсэн. Хуулийн зорилго нь:

байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэ хуулийн дагуу Монгол улсын хэмжээнд 99 ТХГН-ийг байгуулж эдгээр доорх 4 ангилалд хуваагддаг:

- 20 Дархан цаазат газар, IUCN-ний Ia ба Ib ангилал
- 32 Байгалийн цогцолборт газар, IUCN-ний II ангилал
- 34 Байгалийн нөөц газар, IUCN-ний III ангилал
- 13 Дурсгалт газар, IUCN-ний III ангилал

Эдгээр ТХГН нь орон нутгийн бүлгүүд болон зочлон ирэгсдэд олон төрлийн ашиг тусаа өгдөг ба үүнийг ашиглалтын болон ашиглалтын бус ашиг цаашилбал дотор нь шууд, шууд бус, сонголтын, өв хөрөнгө болон оршин суух өгөөж хэмээн ангилж болдог. Концесс нь төрийн байгууллага болон ТХГН-аас шууд хувийн ашиг ологч ашиглагчийн хооронд байгуулсан хэлэлцээр юм. Концесс нь доорх боломжийг бүрдүүлдэг:

- ТХГН-т үйл ажиллагаа явуулах хууль ёсны эрх
- Концесс эзэмшигч болон ТХНГ-ийн агентлагийн хооронд албан ёсны харилцаа тогтоож улмаар талууд өөрсдийн хүлээсэн үүргийн талаар мэддэг байх
- Концессийн хугацааны баталгааг хангах

Концессийг хувийн байгууллага, ТББ болон бусад ашгийн бус байгууллага болон иргэдийн бүлэгт олгоно. Аль ч тохиолдолд концесс эзэмшигч нь хэлэлцээрийн дагуу ТХГН-т тусгайлсан үйлчилгээ явуулна. Хүснэгт 1-д Монгол улсын ТХГН-аас олж буй өгөөжийн зарим төрлүүдийг гаргалаа. ТХГН-аас олж буй өгөөжийн жагсаалт нь тухайн газрын экологийн төлөв байдлаас ихээхэн хамааралтай агаад ашиг хүртэгсэд болон хэрэглэгчдэд хүрэх байдал, ТХГН-ийн бодлогын орчин болон тогтолцооны бүтцээс мөн хамааралтай.

Хүснэгт 1. Монгол улсын ТХГН-ийн сүлжээний газруудаас олдог ашиглалтын болон ашиглалтын бус ашиг

Ашиглалтын			Ашиглалтын бус	
Шууд ашиглалт (ТХГН-ийн хуулинд зааснаар)	Шууд бус ашиглалт	Сонголтын	Өв хөрөнгө	Оршин суух
<ul style="list-style-type: none"> ▷ Байгалийн аялал жуулчлал ▷ Амралт зугаалга ▷ Загасчлах ▷ Орон байр ▷ Орон нутгийн хэрэгцээнд байгалийн нөөцийг олборлох ▷ Мод түүх ▷ Мал бэлчээрлүүлэх ▷ Уламжлалт МАА ▷ Фото\видео зураг авах ▷ Рашаан, эмчилгээний бусад нөөц ашиглах ▷ Ойн цэвэрлэгээ арчилгаа ▷ Судалгаа ▷ Сургалт ▷ Уламжлалт зан үйл\ёслол 	<ul style="list-style-type: none"> ▷ Экосистемийн үйлчилгээ ▷ Цаг уурын тогтворжилт ▷ Үерийн хяналт ▷ Гүний усны сэргэлт ▷ Нүүрстөрөгчийн хуримтлал ▷ ХАА ▷ Идээшсэн орчин ▷ Эрдсийн нөхөн сэргэлт ▷ Байгалийн эрсдэлээс хамгаалах ▷ Усны хагалбарын хамгаалал ▷ Байгалийн үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> ▷ Ирээдүйн мэдээлэл ▷ Ирээдүйн ашиглалт (шууд ба шууд бус) 	<ul style="list-style-type: none"> ▷ Өв хөрөнгийн ашиглах ба ашиглахгүй үнэ цэнэ 	<ul style="list-style-type: none"> ▷ Биологийн олон янз байдал ▷ Зан үйлийн болон оюун санааны үнэ цэнэ ▷ Соёлын ба өв ▷ Бүлгийн үнэт зүйл ▷ Ландшафт

Хүснэгт 1-д тодорхойлсон ашиглалтыг концессоор эзэмших эрхзүйн хүрээ сул ба эдгээр нь концессийг баталгаажуулах талаарх засаглалын болон зохицуулалтын олон зөвшилцөлөөс хамааралтай. Үүнд:

- ▷ ТХГН-т зочлогсдийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх
- ▷ Байгаль хамгааллыг сурталчлах, бэхжүүлэх
- ▷ Арилжааны болон хэт арилжааны үйл ажиллагааг хянах
- ▷ Тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэхийг дэмжих
- ▷ Чадавх, чадварын хөгжил ба иргэдийг амьжиргааны өөр эх үүсвэр олоход нь дэмжлэг үзүүлэх
- ▷ Хамгаалалтын захиргааны тогтвортой, үр дүнтэй менежментэд түүнчлэн засгийн газар ба орон нутгийн захиргаанд орох эдийн засгийн өгөөжийг дээшлүүлэх

Концессийн менежмент нь цаашилбал биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, соёлын өвийг хамгаалах, сэргээх болон Монгол улсын ТХГН-ийн талаар олон нийтэд таниулах, сэтгэл ханамжийг бий болгох зэрэг зорилтуудтай уялдах юм.

1.2 Монгол улсын ТХГН-т концессийг амжилттай нэвтрүүлэх бизнесийн боломж

Энэ төсөл нь арилжааны болон уламжлалт ашиглалтын үр дүнтэй менежмент, ТХГН-ийн одоогийн хамгаалал, хөрөнгө оруулалт оруулснаар үйлчилгээ болон бүтээн байгуулалтын чанар, сонголтыг нэмэгдүүлэх болон Монгол улсын ТХГН-ын сүлжээнд орлого оруулах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

Зөв зохион байгуулалттай концесс нь Монгол улсын ТХГН-уудад доорх дорвитой хувь нэмрийг оруулах бололцоотой. Үүнд:

- Хувийн хэвшил болон төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- ТХГН-ын үр дүнтэй хамгаалал ба менежмент
- Аялагчдад зориулсан үйлчилгээ, тоног төхөөрөмжийн чанарын өөрчлөлт ба хөгжил
- Засгийн газрын орлогыг нэмэгдүүлэх
- Community development Бүлгийн хөгжил ба ажлын байр бий болгох зэрэг болно.

Хувийн хэвшил болон төр –хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

Монголын аялал жуулчлалын салбар 2011 онд 256.3 сая ам доллар буюу ДНБ-ий бараг 4 хувийг оруулжээ. Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагын (ДАЖБ) тооцоолсноор энэ тоо цаашид өсөх бүрэн боломжтой буюу 2012 онд ДНБ-ий 7.3%-ийг оруулах боломжтой хэмээн урьдчилан тооцоолжээ.

Эдгээр тооцооноос дүгнэхэд Монгол улсын ТХГН болон түүний орчны бүсэд хувийн хэвшлийнхэн аялал жуулчлалын бүтээн байгуулалт болон үйлчилгээнд хөрөнгө оруулах боломж байгаа болох нь харагдаж байна.

Монгол улсын ТХГН болон түүний орчны бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагааны 80% нь явагдаж байгаагаас харахад хувийн хэвшлийнхэнд ийм концесс байгуулах онцгой шаардлага байгаа нь тодорхой¹.

Аялал жуулчлалын салбарын өсөлтийн төлөв энэ хэвээр байвал хувийн хэвшлийнхэнд эдгээр ТХГН-ийн дотор шинээр бүтээн байгуулалт, үйлчилгээ эрхлэх эрх шаардах шаардлага хэвээр байх нь.

Хэдийгээр хөрөнгө оруулалт нь аялал жуулчлалын салбарт үлэмж хэмжээний эдийн засгийн ашиг авч ирэх ч хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаасаа олох хувийн ашгийн талаар илүү анхаарч харин засгийн газар болон нутгийн иргэдийн бүлгийн хүсэж буй нийгмийн өгөөжийн талаар бага анхаарах талтай. Концессийг олгохдоо гадны сөрөг хүчин зүйлээс сэргийлсэн буюу ТХГН-ийн сүлжээний хамгаалал баталгаатай байхуйцаар шийдвэрлэх ёстой.

Төр-Хувийн хамтын ажиллагаа нь концессийн гэрээгээр хамтын хөрөнгө оруулалт хувийн болон нийгмийн өгөөжөө өгөхүйц байх болно. Эцэст нь засгийн газраас одоогоор санхүүжүүлж буй бүтээн байгуулалт, үйлчилгээний менежментийг хувийн эсвэл ашгийн төлөө бус хэвшлийнхэнд концессийн гэрээгээр аутсорсинг хийж болно. Энэ нь нийгмийн салбарын зардлыг ихэнхдээ бууруулж хувийн хэвшил бүтээн байгуулалтыг илүү үр дүнтэй зохион байгуулах боломжийг олгоно. Гэхдээ иймэрхүү төрлийн бүтээн байгуулалт, үйлчилгээнээс олох орлого байхгүй болох тул концессийн хураамжаар энэ орлогыг нөхөх ёстой.

Өргөн утгаараа концесс нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны нэг хэлбэр юм. Үйлчилгээ үзүүлэхийн тулд төр ба хувийн хэвшил хамтран ажиллаж байгаа аливаа зохицуулалт нь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа хэмээн мөн тодорхойлж болно. Томоохон хэмжээний дэд бүтцийн төслүүд болох зам, барилга барих болон зарим нийгмийн

¹ Financial Sustainability Options for Mongolia's Specially Protected Areas, Report for Strengthening Protected Area Network UNDP 2011

үйлчилгээ бий болгох, үйл ажиллагаа явуулахын тулд Төр-хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагаа нь ихэнх тохиолдолд засгийн газартай холбогдож хувийн хэвшилтэй хамтран ажиллах болдог. Бага хэмжээний Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хэлбэр нь Монгол улсын ТХГН-т шууд хамааралтай болно. Концессийн стратеги нь хөрөнгө оруулалтанд шаардлагатай хамтын ажиллагааг бий болгохын чацуу гарч болох гадны сөрөг хүчин зүйлээс сэргийлэх юм.

ТХГН-ийн үр дүнтэй хамгаалал ба зохион байгуулалт

ТХГН нь концесс эзэмшигчийн хэрэгжүүлж буй менежментийн зарим үйл ажиллагаанаас буюу тэдний хооронд байгуулсан хэлэлцээрийн хэсэг болох зам жим, тэмдэглэгээг засаж тордох эсвэл хамгаалалттай газрын нөөцийн талаарх мэдээллийг олох буюу хувааж ашиглах зэрэг үйл ажиллагааны болон арчилгаа засварын үйлчилгээний талаар хүлээх хариуцлагад тусгагдсан зүйлээс өгөөжийг нь хүртэж болох юм. Энэ нь ялангуяа ТХГН-ийн дотор болон орчны бүсэд амьдарч байгаа орон нутгийн бүлгүүдэд илүү хамааралтай.

Хувийн аж ахуйн нэгжийн хэрэгжүүлдэг аялал жуулчлалын концесс нь жуулчны сэтгэл ханамж, үйлчилгээ болон шинэлэг төрөл, түвшний үйл ажиллагааг санал болгож чадах ба иймэрхүү ажиллагааг засгийн газрын байгууллагууд нь тусгай хамгаалалттай болон байгалийн үзэсгэлэнт газруудад өөрсдийн дотоод нөөц, туршлагаараа хэрэгжүүлэх боломж ихэнхдээ тааруу байдаг. Жишээлбэл: зочлогсдийг арилжааны зорилготой байгууламж болон хөтөчтэй аялалд хамруулснаар тухайн онцгой газрын тухай мэдэж суралцан бас цаашид бусдад таниулан ойлгуулах боломжийг бүрдүүлдэг. Хэрвээ тэд энэ үйл ажиллагаанд хамрагдаагүй бол тухайн газрын талаар хэзээч мэдэхгүй өнгөрч болох талтай. Зарим газруудад зочлогсдод зориулсан үйлчилгээ болон бүтээн байгуулалтын чиглэлээр концесс байгуулснаар БОНХЯ\ТХГН-ийн хамгаалалтын захиргаа нь өөрийн үйл ажиллагаа, нөөцөө хамгаалалттай газрын хамгаалал болон менежментэд илүү төвлөрүүлэх боломжтой.

ТХГН-т зочлогсдод зориулсан бүтээн байгуулалт, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөгжүүлэх

Зочлогсдод зориулсан байгууламж, үйлчилгээний чанар, сонголтыг нэмэгдүүлэх зорилгоор тухайн хамгаалалттай газрын үр дүнтэй хамгаалал болон менежментийг дэмжиж чадахуйцаар зохион байгуулагдсан Концессийг тусгайлан боловсруулж олгож болно. ТХГН дахь байгалийн аялал жуулчлалын концесс нь аялал жуулчлалын үндэсний бодлого болон салбарын хөгжлийн стратегийг дэмжихэд чиглэгдсэн байх ёстой. Төр санхүүгийн болон чадавхийн дутуу байдлаас болж хийж чадахгүй байгаа хөрөнгө, туршлага ба шинэчлэл зэргийг хувийн хэвшлийг оруулснаар шийдвэрлэж болно. Зөв зохион байгуулагдсан концессийн стратеги нь ТХГН-ийн нөөцөд гарч буй нөлөөллийг зөв зохион байгуулан хамгаалж үлдэж чадахуйц үйл ажиллагааг явуулахын чацуу хөтөчтэй аяллыг үр дүнтэй хийж дотоодын болон олон улсын зочлогсдын байгаль орчин хамгааллын талаар ойлголт, ухамсарыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Засгийн газрын орлогыг нэмэгдүүлэх

Монгол улсын ТХГН нь голдуу улсын төсөв буюу төсвийн хөрөнгө, нэвтэрсний хураамж, аялал жуулчлалын ба менежментэд зориулсан хандивлагчдийн тусламж зэргээр санхүүждэг. Тогтолцооны хувьд ТХГН-ийн хамгаалалтын захиргаад орлогын шинэ үүсвэр бий болгох, хөгжүүлэх боломж маш хязгаарлагдмал. Концессийг олгосноор орлого олж зардал бууруулах санхүүгийн олон ач холбогдол байгаа. Концессийн хураамжийг авч шууд орлого олохоос гадна хувийн хэвшил үйл ажиллагаагаа өргөжүүлснээр татвараас олох орлого ч нэмэгдэх өргөн боломж буй.

Бүлгийн хөгжил ба ажлын байр буй болгох

Монголын хүн амын 30 хувийн амьжиргаа нүүдэлчин буюу хагас нүүдлийн мал аж ахуйгаас хамааралтай. Монгол улсын ТХГН-ийн менежмент нь хамгаалалттай газрын дотор болон

орчны бүсэд амьдарч буй хүмүүсийг тухайн нутгийн байгаль хамгаалал болон аялал жуулчлалын хөгжилд чухал холбоос болсон орон нутгийн иргэд хэмээн хүлээн зөвшөөрдөг.

Энэхүү холбоосыг бэхжүүлэн уламжлалт ашиглалтын энэ хэлбэрийг үргэлжлүүлэх нь байгаль хамгааллын зорилгоо биелүүлэх, концессийн стратегийг хэрэгжүүлэх суурь болно.

ТХГН-ийн дотор болон орчны бүс дэх концесс нь орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хурдасгуур болохын зэрэгцээ орон нутгийн бүлгүүдэд нийгмийн болон эдийн засгийн өгөөжөө өгч цаашилбал ТХГН-ийн менежментэд ч орох орлогыг нэмэгдүүлэх болно.

Эдгээр орлого нь орон нутгийн бүтээгдэхүүнийг ашиглах, ханган нийлүүлэлт хийлгэх, нутгийн иргэдийг ажиллуулах зэргээр орохоос гадна орон нутгийн бизнес бий болоход түлхэц болно.

Энд онцгойлон тэмдэглэж хэлэхэд орон нутгийн бүлгийг ажилд авах үйл ажиллагаа хязгаарлагдмал байж болох ба энэ нь хэрвээ нутгийн иргэд туршлага, чадвар багатай байх тохиолдолд хөрөнгө оруулагч тэдгээрийг сургахад хөрөнгө оруулснаас боломжийн хөлсөөр өөр газраас ажилтан олдож болох тохиолдол юм. Орон нутгийн бүлгүүд концесс эзэмшигчийн оруулах хөрөнгө оруулалтаас өгөөжийг нь хүртэх нь хамгийн чухал болно. Зарим тохиолдолд орон нутгийн бүлгүүд концессийн дагуу байгууламж барих, үйлчилгээ үзүүлэх ашигтай байрлалд байж тэдгээрийн газар орон, нутгийн мэдлэг эсвэл бүтээгдэхүүн нь бусадтай харьцуулахад давуу боломжийг бүрдүүлэх нь бий.

Концессийн стратеги нь ТХНГ болон орон нутгийн бүлгийн аль алины сонирхолд сайтар нийцсэн тохиолдолд концессийн гэрээг орон нутгийн бүлэгт шууд олгох боломжийг бүрдүүлнэ.

1.3 Бизнесийн саадыг даван туулах нь

ТХНГ-ууд, түүний дотор ба орчны бүсэд амьдарч буй орон нутгийн бүлгүүдэд Концесс ач тусаа өгөх нь Концессийн стратеги болон түүнийг дагалдан гарах зөвлөмжүүдэд заавал тусгагдах ёстой хэд хэдэн хүчин зүйлээс хамааралтай.

Монгол улсын Газрын тухай хуулийг дахин хянах, ТХГН-ийн тухай болон Орчны бүсийн тухай хуулинд өөрчлөлт оруулах ажил одоо явагдаж байна.

Концессийг хэрэгжүүлэхээр шалгарсан газруудын хамгааллыг баталгаажуулахын тулд юуны өмнө концессийн системийн байгаль орчин, эдийн засаг ба нийгмийн зорилгыг тодорхой болгосон эрхзүйн зохицуулалт болон концесс эзэмшигчээс шаардах хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлагатай.

Эрхзүйн судалгаанаас үзэхэд ТХГН-ийн менежментийг үр дүнтэй болгоход тустай концессийг нэвтрүүлэхэд шаардлагатай эрхзүйн үндсийг баталгаажуулах зорилгоор ТХГН-ийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байгаа нь харагдлаа. Дэлхийн Байгаль Хамгаалах Сан болон НҮБХХ-ийн 2009 онд хийсэн судалгаагаар Монгол улсын ТХГН-ийн боловсон хүчин болон санхүүгийн нөөц боломж хангалтгүй, экосистемийн хамгаалал ба үйлчилгээний зохицуулалтын талаарх бодлого хязгаарлагдмал болох нь тогтоогджээ. Бодлого боловсруулагчид болон олон нийт ТХГН-ийн ач холбогдолын талаарх мэдлэг тааруу байж ингэснээрээ ТХГН-ийн үр дүнтэй хамгаалалтанд шаардлагатай улс төрийн болон санхүүгийн өргөн дэмжлэг олж авч чадахгүй байна. ТХГН-ийн хамгаалал нь үлэмж хэмжээний хөрөнгө санхүү шаарддаг ба энэ нь олсон орлогын дийлэнх хувь нь хэрэгцээ шаардлага ихтэй нийгэм эдийн засгийн салбарт зарцуулагддаг буурай хөгжилтэй орнуудын хувьд бүр илүү хүндрэлийг үүсгэдэг.

Эдгээр хязгаарлах хүчин зүйлийг харгалзан энэхүү стратеги нь ТХГН-ийн захиргаад болон БОНХЯ-ны ажилтнууд өөрсдийнхөө эрх мэдлийн хүрээнд бүхий л нөөц газруудад газар ашиглалттай холбоотой зохицуулалтыг хариуцан хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэхэд чиглэгдэнэ. Концессийн стратеги нь үр дүнтэй, тэгш эрхийг хангасан ба хэрэгжүүлэхэд хялбар байхаар загварчлагдсан болно. Түүнчлэн концессийн менежменттэй холбоотой стандартууд, баримт бичгүүд болон горим журмуудтай холбоотой зөвлөмжүүд мөн чухал асуудлуудын талаар өргөн хэмжээний бодлогын чиглэл өгөх юм. Мөн ТХНГ-ийн сүлжээг таниулан сурталчлах, удирдан зохион байгуулах, зочлогсдийн энэ талаарх ойлголт, таатай байдал, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн бүлгүүд болон бусад олон хамтрагчдийн гүйцэтгэх үүрэг үнэлж баршгүй чухал болохыг тэмдэглэсэн болно.

Энэ стратеги нь ТХГН-ийн Удирдлагын газраас хамгаалалттай газрын сүлжээнд концессийг хэрэгжүүлэх үндсийг бүрдүүлэх болно.

“Концесс” хэмээх ойлголтыг энэхүү баримт бичигт Монгол улсын ТХГН-т болон түүний орчны бүсэд тогтвортой үйл ажиллагааг хамтран явуулах явдал хэмээн үзэж ашигласан болно. Концесс нь зөвхөн ашиглалт явуулах зорилготой газрын нэгж талбар (жишээ нь дэд бүтцийн хөгжилгүй ч хөтөчтэй аялал зохион байгуулах, ой цэвэрлэх болон мод түүх уламжлалт ашиглалт зэрэг) төдийгүй мөн явуулах үйл ажиллагаа нь ТХГН-ийн дотор болон орчны бүсэд байх шаардлагатай ажлуудыг ч хамарсан болно. “Концесс эзэмшигч” гэж концессийн эрхийг эзэмшигч аж ахуйн нэгжийг томьёолсон олно.

1.4 Тайлангийн бүтэц

Энэхүү тайлан нь доорх бүтэцтэй:

Бүлэг 2	ТХГН-т концессийг хэрэгжүүлдэг олон улсын туршлагаас гадна Монгол улсын Концессийн стратегид харгалзан үзвэл зохих концессийн менежментийн шилдэг туршлагуудын онцлог шинжийг тодорхойлсон.
Бүлэг 3	Концессийг хэрэгжүүлж байгаа одоогийн арга барил болон энэ үйл ажиллагааны менежмент, батлах явцад оролцож буй олон байгууллагыг тодорхойлов. Эрхзүйн өнөөгийн байдал, концессийн стратегийг Монгол улсын ТХГН-т үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөлөөлж болох хүчин зүйлүүдийг дүгнэв.
Бүлэг 4	Энэ бүлэгт өнөөгийн систем дэх боломж болон хязгаарлах хүчин зүйлүүдийг тэмдэглэснээс гадна гол асуудлууд ба таарах арга замыг хураангуйлав.
Бүлэг 5	Концессийн Стратегийг танилцуулна – Алсын Хараа, Зорилго, Гол Чиглэл ба Арга хэмжээ
Бүлэг 6	Концессийн Бодлого ба Удирдамжийн санал болгож буй агуулга ба эрхзүйн хүрээний санал болгож өөрчлөлтүүдийн дэлгэрэнгүйг оруулав
Бүлэг 7	Их Нартын Байгалийн Нөөц Газар болон Орхоны Хөндийн Байгалийн Цогцолборт Газарт энэ стратегийг хэрхэн хэрэгжүүлэх талаар тодорхойлов.
Бүлэг 8	Хэрэгжүүлэх гол үйл ажиллагаануудыг тодорхойлов.
Хавсралтууд	Туслах бичиг баримтууд

2 КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТИЙН ОНОВЧТОЙ ПРАКТИК

2.1 Тусгай хамгаалалттай газруудад концессийн менежмент хэрэгжүүлэх оновчтой практик хандлага

Концессийн гэрээг амжилттай байгуулна гэдэг нь байгалийн болон соёлын үнэт зүйлсийг хадгалж үлдээх, аялагчдын сонирхолыг татах байдлыг дээшлүүлэх, байгалийг үнэлж сэтгэл ханамж авахад эерэг хувь нэмэр оруулахад хүргэх түншлэл бөгөөд орон нутгийн иргэдэд ч үр ашгаа өгөх зүйл юм. Энэ зорилгод хүрэхэд засгийн газар ба хувийн хөрөнгө оруулагчид өөр, өөр үүрэгтэй ба тэдгээрийн сонирхол нь ч өөр байдгийг хүснэгт 2-т харуулав.

Дэлхийн улс орнуудын тусгай хамгаалалттай газрын захиргаад нь хувийн болон ашгийн төлөө бус сектортой янз бүрийн хэлбэрээр түншлэж ажилладаг бөгөөд зарим хэлбэр нь дараахь төрлийн концессийн гэрээнүүдэд түшиглэсэн байдаг. Үүнд:

- ▶ Газрын түншлэл - засгийн газраас тусгай хамгаалалттай бүсийн ойр орчмын хувийн эзэмшлийн газарт байгаль хамгаалах ба аялал жуулчлалын дэд бүтэц байгуулах санаачлагыг урамшуулах
- ▶ Төлөвлөлтийн түншлэл - орон нутгийн засаг захиргаа нь тусгай хамгаалалттай газрын захиргаатай хавсран тусгай хамгаалалттай газарт бага дарамттай байх "гарц"-ыг хөхүүлэн дэмжих
- ▶ Орон нутгийн түншлэл - аялал жуулчлалын ашиг сонирхол нь Үндэсний тусгай хамгаалалттай газар дахь аялал жуулчлалд зориулсан үндсэн дэд бүтцэд шууд дэмжлэг үзүүлнэ
- ▶ Хөрөнгө оруулалтын түншлэл - тусгай хамгаалалттай газарт ашгийн төлөө аялал жуулчлалын хязгаарлагдмал дэд бүтцийг байгуулах (тэр нь жуулчдаас болох нөлөөллийг багасгахад тустай байх)
- ▶ Бүлгийн түншлэл - нутгийн иргэд болон бизнесийн байгууллагууд тусгай хамгаалалттай газрын захиргаанд сайн дураараа үйлчилгээ үзүүлэх
- ▶ Засгийн газрын түншлэл - засгийн газрын агентлагууд хамтарч тусгай хамгаалалттай газрын ажилтнууд, нутгийн иргэдийн ур чадварыг дээшлүүлэх
- ▶ Судлагааны түншлэл - жуулчдын хураамжийн орлогын тодорхой хэсгийг тусгай хамгаалалттай газрын захиргааны менежментийн мэдээллийн зорилгоор зарцуулах.

Энэ бүлэгт тусгай хамгаалалттай газруудад хэрэгжиж байгаа концессийн олон улсын жишээг харуулсан ба энд тодорхойлсон концессийн менежментийн оновчтой практикийн шинж чанаруудыг Монгол улсын концессийн стратегид

Хүснэгт 2. Засгийн газар ба хөрөнгө оруулагчдын концесст хандах байдал

Засгийн газар	ТХГ-ыг ашиглахыг хүсэгч
Байгалийн үнэт зүйлсийг хэвээр хадгалах, жуулчдад зориулсан дэд бүтэц ба үйлчилгээг бий болгох, орчуулгын үйлчилгээ хүргэх гэх мэтийн байгалийн менежментийн зорилгуудыг хангахад тус болох үр дүнг эрж хайна.	Хүсч байгаа ашгийг өгч чадах байршил, боломжуудыг харна. Жишээлбэл, аялал жуулчлалын байгууллага бол аль болох очих газрын байршил нь байгалийн аялагч, жуулчлагчдад урьд нь үзээгүй сэтгэгдэл төрүүлэхүйц байдлыг харах бол орон нутгийн байгууллага нөөцийг аль болох сайн ашиглах боллоцоог хайдаг байна.
Засгийн газарт орох орлогыг харна.	Хөрөнгө оруулалтаас орох арилжааны, нийгмийн эсвэл бүлгийн өгөөж хамгийн чухал. Түүнгүйгээр урт хугацааны туршид аж ахуй амжилттай байх, засгийн газрын зорилтуудад хүрэх асуудал эргэлзээтэй болох юм. Хөрөнгө оруулалтын өгөөж боломжийн байхын зэрэгцээ амжиргаанд дарамт үзүүлэхээргүй хураамж, төлбөрийг хайна.
Нутгийн иргэдэд орох үр ашгийг харна. Үүнд олон аргаар, тухайлбал орон нутгийн эдийн засгийн урамшуулал, байнга буюу түр гэрээгээр ажилд авах, орон нутгийн ханган нийлүүлэлт авах зэргээр хүрч болно.	Нутгийн иргэдийн байгалийн нөөцийг ашиглах гол зорилго нь болох хандлагатай байдаг. Хөрөнгө оруулагчид ч үүнийг хүсэх боловч аж ахуйд ашигтай байхыг эрмэлзнэ. Орон нутгийн санаачлагыг урамшуулна.
Хэрэглэж буй шийдвэр гаргах процесс болон төсөл батлахад тавигдах шаардлагууд хууль тогтоомж, засгийн газрын бодлогод нийцсэн. Процессууд нь хүний нөөц, цаг хугацаа, орон байр болон бусад судлагаанд шаардагдах зардалтай холбоотой үр дагаварыг агуулна.	Зөвшөөрлийн процессоос гарч болох үр дүн зардал хэмнэсэн, тодорхой байх эсэхийг харна.
Аялал жуулчлалын үйл ажиллагааг түрээс, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл буюу гэрээний нөхцлүүд зэргээр, түүнчлэн хууль дүрэм ба төлөвлөлтийн журмаар дамжуулан зохицуулна.	Нөхцөл, заалтууд нь хэрэгжих боломжтой, аж ахуйн амьдрах чадварт нийцэх эсэхэд санаа тавина.
Концессийг хэрэгжүүлэх шийдвэр гаргалтын шатанд болон дараа нь, түрээс, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл буюу гэрээг хэрэгжүүлэх үед шударга, ил тод байх шаардлагыг хангах ёстой.	Процессууд нь оюуны өмчийн ашиглалт ба хамгаалалттай нийцэж байгаа эсэхэд санаа тавина.
Концессийн талаархи олон нийтийн саналыг хууль тогтоомж, бодлогын шаардлага, зөвлөлдөх ба маргаан таслах процессын дагуу шударгаар авч үзнэ.	Олон нийтийн эсэргүүцлээс болж гарах зардалд санаа тавина.

2.2 Тусгай зөвшөөрөлтэй газарт концессийн менежмент хэрэгжүүлэхэд тулгарах асуудлууд

Тусгай хамгаалалттай газарт концесс хэрэгжүүлснээс гарах үр ашиг тодорхой хэдий ч тулгарах асуудлуудаас сурах сургамжууд байна. Ном хэвлэлд дараах гол асуудлуудыг хөндсөн байдаг. Үүнд:

- Зорилгын зөрчил - тусгай хамгаалалттай газрууд нь хуулийн дагуу олгогдсон Бодлогын ба институцын саад - эдгээр хязгаарлалтууд нь хувийн секторын тусгай хамгаалалттай газарт орох замыг хаах буюу хориглодог.

- Policy and institutional barriers—these constraints can deter or restrict private sector engagement in protected areas
- Хувийн операторыг оролцуулах - тусгай хамгаалалттай газрын захирагчид нь хувийн секторыг татан оролцуулах, тухайн секторын бизнесийн арга, тэргүүлэх чиглэлийн талаар мэдлэг дутах.
- Түншлэлийг хэрэгжүүлэх - урт хугацааны худалдааны түншлэлийг хэрэгжүүлэх асуудал бол тусгай хамгаалалттай газрын захирагчдад тулгардаг нэг бэрхшээл юм.
- Ашиглалтын зөрчил - тусгай хамгаалалттай газрын захирагчид нь худалдааны үйл ажиллагаа зүй зохистой байж, тусгай хамгаалалттай газрыг ашиглаж буй бусад аж ахуй, тэдгээрийн үйл ажиллагаатай зөрчилдөхгүй байх явдлыг хангах ёстой.
- Коррупц - хөгжиж байгаа улсуудад засгийн түшмэд ба улс төрийн удирдагчид нь эрх мэдлээ ашиглан, шийдвэр гаргах хүрээнээс гадуур газар ашиглах, үйл ажиллагаа явуулах эрх олгодог

Хэт худалдаанд автах - хамгаалалттай газруудад уламжлалаараа арилжааны үйл ажиллагаа байгаагүй ба хамгаалалттай газрын ажилтнууд болон ард иргэд тусгай хамгаалалттай газрын захиргааг аливаа байгууллагатай гэрээ байгуулах буюу хувийн сектортой түншлэлд орохыг эсэргүүцэж болно.

Дэлхий даяар, тусгай хамгаалалттай газрууд дахь концессийн хэрэгжилт голдуу дараах үйл ажиллагаануудтай уялдаж явагддаг байна. Үүнд:

- | | |
|-------------------------------|---|
| ‣ Байр сууц, буудал | ‣ Жуулчны баазын арчилгаа |
| ‣ Жуулчны оператор | ‣ Мэдээллийн хангамж |
| ‣ Хог хаягдал цуглуулах | ‣ Ан агнуур, мал хариулга болон бусад уламжлалт зүйлс |
| ‣ Тээврийн үйлчилгээ | |
| ‣ Уламжлалт гар урлалын зүйлс | |
| ‣ Газар нутгийн арчилгаа | |

2.3 Концесс байгуулах нь

Төрөл бүрийн зорилтуудыг хангахын тулд, шийдвэр гаргагч (засгийн газрын толгойлсон) болон гүйцэтгэгч (хувийн, ашгийн төлөө бус, засгийн газрын бус толгойлолттой) байгууллагуудын аль алины хандлагыг концесст ашиглана. Эдгээр хандлага нь өөр өөрийн давуу ба сул талуудтай байдгийг хүснэгт 3-т харуулав.

Хүснэгт 3. Хөрөнгө оруулагч ба Засгийн газрын толгойлсон процессын давуу ба сул талууд

Хандлага	Давуу тал	Сул тал
Хөрөнгө оруулагч толгойлсон	Хөрөнгө оруулагчдын бизнес хандлага, шинэчлэлийг хөхүүлэн дэмжнэ. Явцуу хүрээнд хязгаарлагдаагүй цогц хандлага нь хөрөнгө оруулагчдад олж тогтоосон шинэ боломжийг ашиглахад тус болдог.	Ил тод байдал дутмаг байж болох талтай. Засгийн газрын агентлагийн ажлын ачаалал нэмэгдэж, асуудал шинээр, яаралтай гарч ирснээс үүдэн хугацаа хоцроож болох талтай. Тодорхой журам бэлэн бус, эсвэл түүнийг баримтлаагүйгээс болж тавьсан саналыг авч үзэхдээ хоцроох, саад тотгор гарах боломжтой.
Засгийн газар толгойлсон (хамгаалалттай бүс, нутаг дэвсгэрийн хэмжээнд)	Хөрөнгө оруулагчдын бизнес хандлага, шинэчлэлийг тодорхой хил хязгаарын хүрээнд хөхүүлэн дэмжнэ. Тусгай хамгаалалттай бүсийн зөвхөн нэг тэргүүлэх хэсэгт анхаарлаа төвлөрүүлснээс үүдэн засгийн газрын саналаар үр дүн гарах магадлал өндөр. ОСИ (оролцох саналаа илэрхийлэх) журмын дагуух ил тод байдал. Засгийн газрын агентлагууд ажлын ачааллаа зохицуулах боломжтой. Саналыг авч үзэх тусгай журам, цаг хугацаа нь ОСИ-р зохицуулагдах магадлал өндөр.	Худалдааны болон оюуны өмчийн асуудлыг зохицуулах - хөрөнгө оруулагч нар, өөрсдийн өгөх мэдээлэл, санааныхаа нууцыг өрсөлдөгчиддөө алдахаас болгоомжилж өгөх дургүй байдаг. Зарим оролцуулчихмаар хөрөнгө оруулагчид нээлттэй уралдаант шалгаруулалтад ашиг/зардлын харьцаа нь өрсөлдөхүйц хэмжээнд хүрэхгүйгээс болон оролцох боломжгүй байдаг. Ялангуяа жижиг, нөөц багатай хэдий ч их чадварлаг операторууд орж чаддаггүй. Процессын менежментийг сайн хийгээгүйгээс болж шийдвэр гаргалт удааширч саатахад хүрдэг.
Засгийн газар толгойлсон (нэг хэсэг газрын хэмжээнд)	Засгийн газрын зүгээс саналыг урьдчилж багцлахад хялбар. Оролцох саналаа илэрхийлэх журмын дагуу ил тод явагдна. Одоогийн ашиглаж, хөгжүүлж буй газрыг шинэ нөхцөлд дасгаж ашиглах засгийн газрын сонирхолд нийцсэн тэргүүн эгнээний процесс. Саналыг авч үзэх тусгай журам, цаг хугацаа нь ОСИ-р зохицуулагдах магадлал өндөр.	Хөрөнгө оруулагчийн боломж, харах хүрээг хязгаарлана. Хил хязгаараас хамаарч дэд бүтэц, барилга байгууламж барих боломж хязгаарлагдмал байж болох талтай. Илүү сайн талбайг үл харгалзан тааруухан талбайг сонгох эрсдэлтэй. Агентлагууд тохиромжтой газар, эсвэл худалдааны боломжийг үл харгалзан тохироогоор газар сонгох тохиолдол гардаг. Худалдааны болон оюуны өмчийн асуудлыг зохицуулах - хөрөнгө оруулагч нар, өөрсдийн өгөх мэдээлэл, санааныхаа нууцыг өрсөлдөгчиддөө алдахаас болгоомжилж өгөх дургүй байдаг. Зарим оролцуулчихмаар хөрөнгө оруулагчид нээлттэй уралдаант шалгаруулалтад ашиг/зардлын харьцаа нь өрсөлдөхүйц хэмжээнд хүрэхгүйгээс болон оролцох боломжгүй байдаг. Ялангуяа жижиг, нөөц багатай хэдий ч их чадварлаг операторууд орж чаддаггүй. Процессын менежментийг сайн хийгээгүйгээс болж шийдвэр гаргалт удааширч саатахад хүрдэг.

2.4 Концессийн гэрээний агуулга

Тусгай хамгаалалттай газрын захиргааны зүгээс гэрээний зорилгыг тодорхойлох нь, тусгай хамгаалалттай газрын байгалийг хамгаалах, хууль тогтоомжийн дагуу тухайн газрын нөөцийг ашиглах боломж олгох, жуулчдын тодорхой хэрэгцээг бий болгоход чиглэгдсэн зорилтуудыг хангахад оршино. Иймд концессийн гэрээнд шаардагдах үйлчилгээ, тэдгээрийн цаг хугацаа ба чанарын үзүүлэлтийг нарийвчлан заасан байдаг.

Концессийн гэрээнд зааж өгдөг нийтлэг асуудлуудын заримаас дурьдвал:

1. *Тохиромжтой байдал* - Хүсэлт гаргагчийн мэргэжил, ур чадвар
2. *Үйл ажиллагааны нарийвчлсан тодорхойлолт ба гүйцэтгэлийн стандарт* - ажиллах цаг, үйлчилгээний хүрээ болон үйлчилгээний төвшин гэх мэт зүйлсийг гэрээнд заасан байна.
3. *Хураамж* - Зарим орны хууль тогтоомжоор тусгай хамгаалалттай газруудыг монополь гэж үздэг учраас үнийн зохицуулалт хийх шаардлагатай гэдэг бол заримд нь тусгай хамгаалалттай газрын өөр өөр хэсэгт хэд хэдэн оператортой концессийн гэрээ байгуулж өрсөлдөөнийг бий болгодог байна.
4. *Мониторинг ба хэрэгжүүлэлт* - концесс эзэмшигч тохирсон стандартуудыг мөрдөж ажиллаагүй бол авах арга хэмжээ, журам..

2.5 Хураамж

Концессийн хураамж нь концесс эзэмшигчээс тусгай хамгаалалттай газрын захиргаанд концессийн гэрээний дагуу эдэлж буй эрх ямбынхаа төлөө төлж буй мөнгөн төлбөр юм. Концесс эзэмшигч концессийн гэрээнд заагдсан эрхийнхээ дагуу явуулж буй үйл ажиллагаанаас олсон орлогоосоо концессийн хураамжийг төлөх шаардлагатай байдаг.

Концессийн хураамжийн хэмжээг тогтоох арга янз бүр байна. Тухайн улсын хууль тогтоомж болон бусад зүйлээс шалтгаалан концессийн хураамжийг зах зээлийн ханшаар тогтоож болно. Зах зээлийн ханш гэдэг нь, концессийн боломжийн төлөө хүсч буй худалдан авагч хүсч буй худалдагчид төлөхөд бэлэн байгаа үнэ юм. Практик дээр бараг бүх концессийн төлбөрийг дараах хэдэн ерөнхий механизмыг ашиглан тогтоодог. Үүнд:

- хүсэлт гаргагчтай шууд тохиролцож, ижил төстэй концессийн үйл ажиллагаанд тогтоосон хураамжтай харьцуулах замаар;
- хүсэлт гаргагчтай шууд тохиролцож, тухайн боломж, тохиолдолд үнэлгээ хийх замаар; эсвэл,
- нээлттэй зах зээл дэх боломжийг санал болгох замаар.

Концессийн онцгой боломж нь, онцгой бус боломжоосоо илүү өндөр хураамжтай байх хандлага байдаг.

Концессийн хураамжийг тогтоох нэг арга нь, концесс эзэмшигчийн орлоготой уялдуулсан томъёо ашиглах явдал юм. Энэ аргаар тогтоосон концессийн хураамж нь, бизнесийн орлогоосоо талууд бизнест оруулсан хөрөнгө оруулалтандаа тохирох хувиар хүртэх зарчимд нийцэж байна. Газар нутгийн менежер нь газар болон бусад нөөцөөр (татвар төлөгчдийн өмнөөс) "хөрөнгө оруулалт хийж" байгаа бол концесс эзэмшигч өөрийн хөрөнгө болон бизнесийн туршлагаараа оруулж байна. Ерөнхийдөө, энэ хэмжээг томъёо ашиглан нийт орлогын тодорхой хувь, буюу хэрэв жуулчны оператор бол жуулчин нэг бүрийн хураамж маягаар тогтоож авдаг байна.

2.6 Концессийн менежментийн оновчтой практик

Дэлхий даяар тусгай хамгаалалттай газарт концесс хэрэгжүүлсэн байдлыг дүгнэж үзэхэд хамгийн үр дүнтэй концессийн систем нь ерөнхийдөө хэд хэдэн шинж чанараар илэрхийлэгддэг ажээ. Тэдгээр шинж чанарыг доорх маягаар дүгнэж болох юм.

Концессийн менежмент - Оновчтой практикийн шинж чанар	Жишээ
Тусгай хамгаалалттай газрын захиргаа концессийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бодлого зохицуулалт тов тодорхой байх	Жишиг судлагаа 1 ба 9
Концессийн гэрээг стратегийн зохицуулалттай, өргөн хүрээг хамарсан хандлагаар тодорхойлж хөгжүүлсэн байх	Жишиг судлагаа 4
Концессийн системийн зорилгыг тодорхой илэрхийлсэн байх бөгөөд, тэр нь юуны өмнө байгаль хамгааллыг сайжруулж урамшуулахад чиглэсэн байна. Түүнчлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжлийг хязгаарлах, засагт орох орлогыг нэмж зардлыг бууруулах, орон нутгийн иргэдийн нийгэм эдийн засгийн үр шимийг дээшлүүлэх зэрэг зорилтууд байж болно	Жишиг судлагаа 1 ба 9
Концессийн талаарх шийдвэр гаргахдаа, хууль тогтоомж, бодлого чиглэлтэй нийцсэн, зардал багатайгаар үр дүнд хүрэх стратеги төлөвлөлтийг ашигласан байх	Жишиг судлагаа 2
Агентлагууд түншлэлийн болон концессийн үр дүнтэй гэрээ байгуулахдаа, орон нутгийн хамтлагууд, орон нутгийн болон төвийн засаг захиргаа, хувийн сектор болон ашигийн төлөө бус/засгийн газрын бус байгууллага, бусад төвлөрсөн засаглалын байгууллагуудын оролцоог тооцсон бизнесийн загвар ашигласан	Жишиг судлагаа 4 ба 10
Шийдвэр гаргагч (засгийн газрын толгойлсон) болон гүйцэтгэгч (хувийн, ашгийн төлөө бус, засгийн газрын бус толгойлолттой) байгууллагуудын хандлагыг концесст ашигласан	Жишиг судлагаа 2,3 ба 11
Боломжтой түрээслэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, урин дуудаж урамшуулсан маягаар, хүсэлт гаргагчдад түншлэлийн зарчмыг сайтар ойлгуулж дэмжиж явуулсан	Жишиг судлагаа 3,7,8 ба 11
Агентлагийн ажилтнууд, хувийн сектор болон сонирхогч талуудад концессийн эрх олгох сонгон шалгаруулалтыг хийх энгийн бөгөөд ил тод арга бэлэн болсон, хариуцлагатай шийдвэр гаргах бүтэцтэй	Жишиг судлагаа 1 ба 6
Экотуризмийн, уламжлалт хэрэглээний, судлагааны, давуу байдлын, цахилгаан холбооны гэх мэт янз бүрийн тохиолдолд ашиглаж болохуйц концессийн гэрээнүүд бэлэн байх	Жишиг судлагаа 10
Гэрээ хэрэгжих хугацааны туршид оруулах хөрөнгө оруулалт болон хоёр талд орох ашгийн төвшинг тусгасан уян хатан эзэмшлийн хэлбэрүүд ба үнийн механизм бэлэн байгаа	Жишиг судлагаа 5
Концессийг орон нутгийн хамтлагуудад шууд олгох боломжийг бүрдүүлсэн механизм бэлэн байгаа	Жишиг судлагаа 5,12 ба 13)
Агентлагийн байгаль хамгаалалтын, тогтвортой байдлын, нийгэм эдийн засгийн зорилтуудыг Концессийн гэрээний заалт, нөхцлүүдэд тусгасан байх	Жишиг судлагаа 6,12 ба 13

Концессийн менежмент - Оновчтой практикийн шинж чанар	Жишээ
Гүйцэтгэлийн стандартуудыг тогтоосон, тэдгээрийг хэрэгжүүлдэг, сайн гүйцэтгэлийг тодруулж үнэлдэг	Жишиг судлагаа 6 ба 11
Хаалтын үйл ажиллагааны механизм бэлэн байдаг, түүнийг хэрэгжүүлж баримтладаг	Жишиг судлагаа 6
Концессийн тухай хууль, бодлого ба журмыг байнга, төлөвлөгөөтэйгээр судлаж танилцаж байх механизм бүрдсэн	Жишиг судлагаа 1 ба 6
Нарийн төвөгтэй концессийн менежментийг төвлөрсөн байдлаар, харин энгийн концессийг бол чанарын батлагаа, агентлагийн хэмжээний стандартуудыг бүрдүүлсэн тохиолдолд тухайн орон нутагт нь эрх олгон хэрэгжүүлдэг	Жишиг судлагаа 8
Концессийн менежментийг амжилттай хэрэгжүүлэхэд тусгай хамгаалалттай газрын захиргааны ажилтнуудын чадавх маш чухал байдаг	Жишиг судлагаа 6 ба 8

2.7 Жишиг судалгаа: Дэлхий даяар тусгай хамгаалалттай газруудад ажиллаж байгаа концессууд

Тусгай хамгаалалттай газрын захиргаанаас концессийн менежмент хэрэгжүүлж, экотуризм болон бусад үйлчилгээнд хувийн сектор, засгийн газрын бус байгууллагуудын хөрөнгө оруулалтыг татахад ашигласан хандлагуудын жишээг доор үзүүлэв.

Австрали

Австралийн тусгай хамгаалалттай газруудад 2000 гаруй концесс хэрэгжиж байна. Эдгээрийн бараг ихэнх нь, хөтөчтэй аялал, хөнгөн адал явдал (сал, уулын дугуй), суурин болон түр барьсан буудаллах байр, кемпингийн талбай, тээврийн үйлчилгээ, хүнс ундаа борлуулах цэгүүд зэргээс бүрддэг.

Бага хэмжээний үйл ажиллагаа явуулахад, хүсэлт гаргаж баталгаажуулах журмын дагуу арилжааны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг голдуу олгодог байна. Өргөдөл гаргахдаа хураамж төлдөг ба дараа нь лицензийг ашигласан жил тутам (жилийн хураамж) төлнө. Зарим тохиолдолд, үйлчлүүлэгч тутмаас 'тоо толгой'-н хураамж авдаг. Концессийн тусгай зөвшөөрлийг ихэнхдээ 1-5 жилийн хугацаатай, заримдаа 10 хүртэл жилээр олгоно.

Томоохон аж ахуйн нэгжтэй бол концессийн гэрээг гол төлөв түрээсийн хэлбэрээр байгуулдаг. Түрээсийн хугацаа ба нөхцлийг хөрөнгө оруулалтын хэмжээ, үргэлжлэх хугацаанаас хамаарч араваас дөчин тав хүртэл жилийн хооронд олгодог байна. Түрээсийн заалт, нөхцлүүдэд концесс эзэмшигчийн байгаль орчны талаар, засгийн газрын харж буй менежментийн болон нийгмийн үр дүнгийн талаар хүлээх үүргүүдийг тусгасан байдаг.

Зарим харьяа нутагт тусгай хамгаалалттай газрууд болон улсын мэдлийн зарим газрын сонголт, хөрөнгө оруулалтын журмыг боловсруулсан байдаг байна. Ийм тохиолдолд засгийн газрын зүгээс худалдааны ашигтай байж болох газрыг тогтоож, хөрөнгө оруулалтыг урамшуулах, хувийн сектороос гарах зардлыг багасгах үүднээс тухайн газрын урьдчилан чөлөөлсөн зөвшөөрлийг бүрдүүлсэн байдаг ажээ. Хувийн аялал жуулчлал хөгжүүлэхтэй холбоотой дэд бүтцийг байгуулахад засгийн газраас үзүүлэх дэмжлэгийн хэмжээ нь хөрөнгийн эх үүсвэрийн боломжоос хамаарана. Зарим тохиолдолд тусгай хамгаалалттай газарт болон нутгийн иргэдэд хүрэх үр шим нь нэн илэрхий байвал засгийн газрын зүгээс дорвитой хөрөнгө оруулалт оруулах нь ч бий.

Шинээр гарсан хувийн хөрөнгө оруулах саналыг судлаж батлах хууль эрх зүйн орчин болон шийдвэр гаргалтын хүрээ нь тогтвортой байдлыг тусгасан байх ба, гүйцэтгэлд тулгуурласан

түрээсийн нөхцлүүд болон хяналт шалгалтуудаар түрээслэгч нь тогтвортой байдлын шаардлагыг хэрхэн биелүүлж байгаад мониторинг хийхэд чиглэгднэ.

Жишиг судалгаа 1. Тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой концессийн орчныг бүрдүүлэх нь

НСВ (Нью Саут Вест) мужийн үндэсний парк ба онгон байгалийн захиргаа, Австрали.

Зөвшөөрөгдөж байгаа бүтээн байгуулалтыг тодорхой болгох, аялал жуулчлалыг хөгжүүлэх саналыг үнэлэхэд хэрэглэх шалгууруудыг тогтоох, шийдвэр гаргалтын үүрэг болон бусад шаардлагуудыг тодруулахын тулд хууль эрх зүйн ба бодлогын орчныг шинээр бүрдүүлжээ.

Хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд

НСВ мужийн үндэсний парк болон дархан цаазтай газруудыг тогтвортой аялал жуулчлалд ашиглахын тулд ямар бүтээн байгуулалтыг зөвшөөрч болохыг тодруусан (байр сууц болон туслах байгууламжууд орно).

- ▶ Бүтээн байгуулах үйл ажиллагаанд тавих байгаль орчны хяналтыг сайжруулсан
- ▶ Түрээс болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлуудын талаар шийдвэр гаргах хүрээний шалгууруудыг тогтоосон.
- ▶ Бүтээн байгуулалтын санал (Акт/Хууль-д заагдсан)-ыг үнэлэх - Акт-тай зохицож байх; холбогдох Менежментийн төлөвлөгөөгөөр зөвшөөрөгдсөн байх; тогтвортой байдлын 3 шалгуурт нийцсэн байх ёстой
- ▶ Тухайн газар болон орчин тойрны байгалийн ба соёлын үнэ цэнтэй нийцсэн
- ▶ Байгалийн нөөц баялаг, эрчим хүч ба усны тогтвортой, хэмнэлттэй ашиглалтыг хангасан
- ▶ Овор хэмжээ, өндөр, дэвсгэр зураг, саад бартаа, нягтрал зэргийг оруулсан дүрс ба масштаб
- ▶ Түрээсийн ба тусгай зөвшөөрлийг (Акт-д байгаа) олгох шийдвэр гаргалтын хүрээ
- ▶ Холбогдох сайд ба департаментын үүрэг ба хамрах асуудлууд.
- ▶ Тухайн саналыг тухайн газарт ашиглахад тохиромжтой эсэхийг тодорхойлох тогтвортой байдлын үнэлэмжийн шалгуурыг нарийвчлан боловсруулж нийтлэх.
- ▶ Олон нийтийн өмнө тайлагнах, ил тод байдлыг хангах - түрээсийн ба тусгай зөвшөөрлийг нийтэд дэлгэн харуулах; 10-аас дээш жилийн түрээсийн талаар Үндэсний парк ба онгон байгалийн үйлчилгээний газрын зөвлөлд танилцуулах.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Тусгай хамгаалалттай газрын захиргаа концессийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бодлого зохицуулалт тов тодорхой байх
- ▶ Концессийн системийн зорилгыг тодорхой илэрхийлсэн байх бөгөөд, тэр нь юуны өмнө байгаль хамгааллыг сайжруулж урамшуулахад чиглэсэн байна
- ▶ Агентлагийн ажилтнууд, хувийн сектор болон сонирхогч талуудад концессийн эрх олгох сонгон шалгаруулалтыг хийх энгийн бөгөөд ил тод арга бэлэн болсон, хариуцлагатай шийдвэр гаргах бүтэцтэй.

Эх сурвалж: Байгаль орчны Департамент, Цаг агаарын өөрчлөлт ба ус НСВ муж, *НСВ мужийн үндэсний паркийг аялал жуулчлалын зорилгоор ашиглах тогтвортой байдлыг үнэлэх шалгуур ба НСВ мужийн үндэсний паркийг аялал жуулчлалын зорилгоор ашиглах тогтвортой байдлын зааварчилгаа*, 2011

Жишиг судалгаа 2. Засгийн газраас удирдаж хэрэгжүүлсэн, аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын стратег төлөвлөлт

Нортерн Территори дэх үндэсний парк ба онгон байгалийн захиргаа, Австрали

Мужийн оршин суугчид, бусад муж болон олон улсаас ирэх жуулчдын сонирхлыг гойд татдаг НТ (Нортерн Территори) мужийн алдартай газрын нэг нь Дарвин хотоос хойш 120 километрт орших Личфилдийн үндэсний парк билээ. Бүс нутгийнхаа аялал жуулчлалын нэг гол зүтгүүр болсон энэ газарт 2009 онд л гэхэд 270 мянга гаруй жуулчин иржээ. Энэхүү парк нь, үзэсгэлэнтэй хүрхрэнүүд; аюулгүй усанд сэлэх, явган аялах, кемпинг болон жийпээр зугаалах боломжууд; байгалийн өвөрмөц төрх; биологийн олон төрөл зүйл болон уугуул абориген иргэдийн соёлын өв зэргээрээ алдартай. НТ мужийн Байгалийн нөөц, байгаль орчин, урлаг спортын департаментын 2011 оны 5 сард олон нийтийн санал авахаар нийтэлсэн менежментийн төлөвлөгөөний төсөлд тус паркийн дэд бүтэц, үйлчилгээг дэмжих, аялагчдын үзэж харах зүйлсийн хүрээг сайжруулах ажлыг, департаментын дэвшүүлсэн 'бүсийн хөгжил аялал жуулчлалын урт хугацааны суурь болгон байгаль хамгааллыг 21-р зуунд танилцуулах нь' (NRETAS, 2011 оны 11 сар) сэдэвт гол тэргүүлэх чиглэлүүдийн нэгтэй уялдуулан хийхийг заасан байна. Энэхүү төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа аялал жуулчлалын салбарын төлөөлөл болон уугуул абориген иргэдийн саналыг авч оруулжээ. Төлөвлөгөөний төсөлд Личфилдийн үндэсний паркийн өсөн нэмэгдэж буй зорилтот зах зээл болох шинийг хайгч жуулчдын (хөгжилтэй адал явдал, чөлөөт байдлыг хүссэн, тайван амарч эрч хүч авах гэсэн, байгальд ойртож нутгийн соёлд уусах гэсэн) зах зээлийг тодорхойлсон байна. Паркийн нэг хэсэгт тийм, соёлд уусах мэдрэмж төрүүлэхүйц дээд зэрэглэлийн эко сууц барихад тохиромжтой газрыг сонгожээ. Тус цэгийг сонгохдоо байгалийн өвөрмөц төрх, харагдах үзэсгэлэнт байдал, төвийн байрлал, жилийн турш ажиллах боломж, өнөө хир жуулчдын хөлд дарагдаагүй байгаа зэргийг харгалзжээ. Хэрэв дээрх сонгосон газар цаашдын судлагаагаар ашиглах боломжгүй гэж гарвал түүнийг орлох өөр боломжийн газрыг ч бас тогтоосон байна. Хэрвээ энэ санал эцсийн төлөвлөгөө байдлаар зөвшөөрөгдвөл аялал жуулчлалын салбар болон олон нийтэд засгийн газраас энэ эко боломжийг ашиглах, тухайн газар болон орчин тойронд менежментийн өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулахаар шийдсэнийг илэрхийлэх дохио болох юм. Төлөвлөгөөний төсөлд зааснаар Үндэсний парк ба онгон байгалийн газар нь боломжийн дэмжин ажиллагчтай хамтран ойр орчмын газрын төлөвлөгөөг (жуулчдын орон байр г.м.) боловсруулах юм. Энэхүү санал болгож буй Личфилдийн үндэсний парк дахь эко жуулчлалын байрууд нь НТ мужийн захиргаанаас дэвшүүлээд буй, шинэ, дээд зэрэглэлийн зах зээлийн хэрэгцээг хангах 'Загвар лодж' болох ирээдүйтэй бөгөөд жуулчдын очих дуртай газар байх болно. Энэ санаачлагын дагуу НТ мужийн захиргаа гол гол цэгүүдэд урьдчилан бэлтгэсэн газруудыг ОСИ журмын дагуу хувийн хөрөнгө оруулагчдад олгохоор байгаа юм. Энэ зорилгоор, засгийн газар нь уламжлалт уугуул абориген эзэмшигчид болон бусад холбогдох агентлагуудаас 'зарчмын' зөвшөөрөл авах; тахиж шүтдэг газруудыг тодруулах; тухайн газрын хязгаарлалт болон боломжийг үнэлэх инженер байгаль орчны урьдчилсан техник эдийн засгийн үнэлгээ хийх; шаардлагатай үйлчилгээнүүдийг байгуулахад хийх зүйлсийг тодруулах зэргийн урьдчилсан бэлтгэл ажлуудыг хийх юм.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- Концессийн талаарх шийдвэр гаргахдаа, хууль тогтоомж, бодлого чиглэлтэй нийцсэн, зардал багатайгаар үр дүнд хүрэх стратеги төлөвлөлтийг ашигласан байх
- Шийдвэр гаргагч (засгийн газрын толгойлсон) болон гүйцэтгэгч (хувийн, ашгийн төлөө бус, засгийн газрын бус толгойлолттой) байгууллагуудын хандлагыг концесст ашигласан.

Эх сурвалж: Байгалийн нөөц, байгаль орчин, урлаг спортын департамент (NRETAS) (2011 оны 5 сар), Личфилдийн үндэсний паркийн төлөвлөгөөний төсөл. NRETAS (2011 оны 9 сар), Жилийн тайлан 2010-11.

Жишиг судалгаа 3. Засгийн газраас хувийн секторын хөрөнгө оруулалтыг дэмжих нь

Саузерн Оушн Лодж, Кенгуру арал, Австрали

Концессийн төрөл: ТХГН захиргаанаас зөвшөөрсөн жуулчдын эко буудал

Концесс эзэмшигч: Бэйлли лодж

Үр, ашиг: Хамгаалалттай бүс нутагт байгуулсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тансаг зэрэглэлийн буудал, засгийн газарт орох орлого нэмэгдэж, бүс нутгийн аялал жуулчлалын дүр төрх сайжирсан

Агуулга: Саузерн Оушн Лодж нь Кенгуру арлын алслагдсан, үзэсгэлэн төгс хэсэгт байрлах хувийн эзэмшлийн газар дээр 12 сая долларын хөрөнгөөр боссон, 2008 онд нээгдсэн тансаг зэрэглэлийн эко буудал юм. Энэ төслийн үзэл баримтлал нь бүс нутаг болон улсын хэмжээнд аялал жуулчлал болон хөрөнгө оруулалтыг татахуйц үлгэр жишээ бүтээн байгуулалт болохын хувьд Өмнөд Австралийн захиргаанаас дээд зэргийн дэмжлэг авсан юм. Энэхүү төслийг Тэргүүлэх төслийн бүтээн байгуулалт хэмээн зарлаж, батламжлах болон төлөвлөх үе шатууд нь Тэргүүлэх төслийн хуулийн заалтуудаар явагдсан ба ерөнхий сайдын департаментын удирдлагын доор хэрэгжсэн юм. Төлөвлөлт болон батлагаажуулалтанд тавигдсан шаардлагууд болон холбогдох асуудлаар дараах зүйлсийг хэлэлцсэн байна. Үүнд:

Бүтээн байгуулалтыг батлагаажуулахад Кенгуру арлын зөвлөл ба Өмнөд Австралийн Төлөвлөлт, орон нутгийн захиргааны департамент оролцсон бөгөөд тэдэнтэй үе үе харилцаж байсан

- ▶ Шигүү ойн түймрийн менежментийг тооцож галын газартай холбоотой ажилласан
- ▶ Үндэсний ургамалын хуулийн дагуу зэрлэг ургамалтай холбоотой зөвшөөрлийг авч Үндэсний ургамалын зөвлөлтэй уулзалж, харилцаж, шаардлагатай мэдээллийг өгч байв
- ▶ Хамтын нийгэмлэгийн захиргааны 1999 оны *Байгаль хамгаалах ба биологийн төрөл зүйлийн Акт* - тай холбоотой асуудлаар харилцсан болно
- ▶ Кенгуру арал дээр олон нийтийн зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан.

Мөн төслийг хэрэгжүүлэгч өөрийн зүгээс, агентлагуудтай харилцах, төлөвлөлт ба батлагаажуулалтын шаардлагыг хангах асуудлыг зохицуулж ажиллах төслийн менежерийг авч ажиллуулжээ. Түүнчлэн Саузерн Оушн Лодж -ийн ТЭЗҮ-г эхний шатанд шийдвэрлэх талаар Өмнөд Австралийн захиргаа чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Засгийн газраас хоёр жилийн турш.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Боломжтой түрээслэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, урин дуудаж урамшуулсан маягаар, хүсэлт гаргагчдад түншлэлийн зарчмыг сайтар ойлгуулж дэмжиж явуулсан
- ▶ Шийдвэр гаргагч (засгийн газрын толгойлсон) болон гүйцэтгэгч (хувийн, ашгийн төлөө бус, засгийн газрын бус толгойлолттой) байгууллагуудын хандлагыг концесст ашигласан

Эх сурвалж: Аллен зөвлөх групп (2011), *Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг дэмжих ерөнхий зааварчилгаа*, Мельбурн. Л.Е.К. Консалтинг (2011), *Аялал жуулчлалын хөрөнгө оруулалт ба зохицуулалтын тойм: Төгсгөлийн тайлан, 2011 оны 3 сар*.

Жишиг судалгаа 4. Орон нутаг ба Засгийн газраас хөрөнгө оруулалтыг төлөвлөх нь

Крейдл Валлей, Тасмани

Концессийн төрөл: Онгон байгаль дахь амьтны байр, уран зураг ба гар урлалын үзэсгэлэн

Концесс эзэмшигч: Засгийн газраас эрх авсан байгууллагууд

Үр, ашиг: Засгийн газар, орон нутаг ба хувийн секторын түншлэлийн үр дүнд, дутагдаж буй дэд бүтцийг илрүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжсэнээр, дэд бүтэц болон зочлон ирэгсдэд хүргэх үйлчилгээ сайжирч, засгийн газарт орох орлого нэмэгдэж, бүс нутгийн аялал жуулчлалын дүр төрх сайжирсан.

Агуулга: Сент Клерийн үндэсний паркт орших Крейдл уул-нуур (Тасманийн онгон байгалийн хэсэг ба дэлхийн өвд бүртгэгдсэн) тийш очих жуулчид олширсонтой холбоотойгоор, Крейдл уулын парк руу ордог гол хаалгатай залгаа байдаг зочид хүлээн авах хэсэг болон зочдод үйлчлэх газруудын төлөвлөлтийг сайжруулж оновчтой болгох ажил засгийн газар, бизнесийн байгууллагууд ба газрын менежерүүдийн хамтын ажиллагааны үр дүнд биеллээ олсон байна. Паркийн орох хаалганы ойролцоо хувийн эзэмшлийн газар дээр нилээд олон тооны байр сав, зочдын үйлчилгээний газрууд өмнө нь баригдсан байжээ. Парк дотор зочдын мэдээллийн төв, Волдхейм сүм, Дав нуур тийш очих зам (алсын бараа харах хүмүүсийн дуртай цэг), явган аяллын замын сүлжээ зэргийг өмнө нь байгуулсан байлаа. Крейдл уулын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг 2003 онд, Кентиш зөвлөл, Крейдл эргийн алба, Тасманийн аялал жуулчлалын газар, Тасманийн эдийн засгийн хөгжлийн департамент, Тасманийн үндэсний парк ба онгон байгалийн үйлчилгээ, Крейдлийн туризм ассошиэйтед-аялал жуулчлалын холбоо, болон Крейдлийн найзууд зэрэг байгууллагуудын түншлэлийн үр дүнд боловсруулжээ. Энэхүү бүтээн байгуулалтын төлөвлөгөөний зорилтууд нь, улсын болон хувийн аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц хандлагыг төлөвшүүлэх; сайн чанарын тогтвортой байгууламж, дэд бүтэц (бохир зайлуулах болон хаягдал ус цэвэрлэх байгууламж г.м.) барьж байгуулах, дэлхийн өвийн зиндааны үйлчилгээг бий болгох, байгаль хамгаалах; тухайн газрын брэндийн үнэ цэнг идэвхжүүлэх зэрэг явдал байлаа. Үндэсний парк ба онгон байгалийн үйлчилгээний газар өөрийн зүгээс, өсөн нэмэгдэж буй жуулчдын хэрэгцээ, Крейдлийн хөндий болон Дэлхийн өв болсон газрын шаардлагыг хангах зорилгоор паркийн ойр орчинд үйлчилгээ, байгууламжууд (сайжруулсан явган зам, хучилттай зам, паркийн доторх автобус г.м.)-ыг байгуулсан байна. Энэхүү хөгжлийн төлөвлөгөө нь тухайн газрын сэтгэл татам байдал болон шинээр бий болгосон дэд бүтцийн давуу талыг ашиглан гарч ирэх аялалын бизнес арилжааны шинэ боломжийг ч бас нээж өгч байгаа юм. Тухайлбал Тасманийн чөтгөрийн байр (зочид орж үзэхийн хамт тасманийн чөтгөр хэмээх ховордсон амьтныг хамгаалах үйл ажиллагаанд оролцох), үзэсгэлэн, арга хэмжээ зохион байгуулах Онгон байгалийн үзэсгэлэн зэрэг шинэ бүтээгдэхүүнийг нэрлэж болно.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Агентлагууд түншлэлийн болон концессийн үр дүнтэй гэрээ байгуулахдаа, орон нутгийн хамтлагууд, орон нутгийн болон төвийн засаг захиргаа, хувийн сектор болон ашгийн төлөө бус/засгийн газрын бус байгууллага, бусад төвлөрсөн засаглалын байгууллагуудын оролцоог тооцсон бизнесийн загвар ашигласан
- ▶ Орон нутгийн хамтлагуудтай байгуулах концессийн зохицуулалтыг тодорхойлж хөгжүүлэхдээ стратеги, харилцан ажиллагааны зөв стратеги баримтлаж ажилласан.

Эх сурвалж: Мереди Врай ... нар (2010), *Бүс нутгийн аялал жуулчлалын тогтвортой чиглэлүүд: сайн практикийн менежмент, бүтээн байгуулалт ба маркетинг*, CRC for Sustainable Tourism Pty Ltd; Тасманийн үндэсний парк ба онгон байгалийн үйлчилгээ (2006), *Пенсил Пайн-Крейдл хөндийн зочдын үйлчилгээ, Бүсийн төлөвлөгөө 2006*.

Kakadu National Park, Australia**Какаду үндэсний парк, Австрали**

Концессийн төрөл: Кемпинг, хөтөчтэй явган аялал, орчуулгын үйлчилгээ

Концесс эзэмшигч: Орон нутгийн абориген иргэд

Үр, ашиг: Засгийн газар ба орон нутгийн түншлэлийн үр дүнд, хэд хэдэн газрын дэд бүтэц болон зочлон ирэгсдэд хүргэх үйлчилгээ, орон нутгийн иргэдийн орлого, ажлын байр, боловсрол болон сургалт сайжирсан

Агуулга: Какаду үндэсний паркийн менежментийг Австралийн засгийн газар тус нутгийн уламжлалт эзэмшигчид нь болох Абориген иргэдтэй хамтран хэрэгжүүлдэг. Барилга байгууламжуудын арчилгаа болон замын ажлуудын гэрээг абориген иргэдэд голдуу эхлээд санал болгох ба тэд зочдод замчлах, зочидтой харилцаж ярилцах ажлыг гол төлөв хийдэг байна.

Ойрмогхон нэгэн Абориген гэр бүлд бэлэн байгаа кемпингийн газарт сафари маягийн жуулчны бааз байгуулах эрхийг санал болгожээ. Засгийн газрын тусламжаар асар майхнуудыг худалдан авч барьжээ. Бизнесийг нь амжилттай болгоход туслахын тулд абориген гэр бүлийн гишүүдэд кемпингийн талбайн арчилгаатай холбоотой цэвэрлэгээ, хог хаягдал цуглуулах, хураамж цуглуулах болон хэв журам сахиулах зэрэг ажлуудыг олгожээ.

Үүнтэй нэгэн адилаар, өөр нэг газарт бас нэг өөр гэр бүлд үйл ажиллагаа явагдаж байгаа кемпингийн газарт худалдааны мухлаг байгуулах эрх олгожээ. Мөн байр талбайн арчилгааны ажлын гэрээнээс гадна, долоо хоногт хэд хэдэн удаа хөтөч ой хамгаалагчийн үүрэг гүйцэтгүүлдэг байна.

Дээрх тохиолдол тус бүрт бизнес нь улирлын чанартай байгаа бөгөөд гэрээт ажилчдыг жилийн турш орлоготой байлгахын тулд жуулчны бус улиралд паркийн захиргаа тэднийг өөр ажлаар хангадаг байна.

Кимберлейн алслагдсан хэсэгт уугуул иргэдийн хамтлагт зориулсан бизнесийн төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд, тэнд кемпингийн талбайн менежментийг засгийн газрын өмнөөс хийх гэрээг нутгийн иргэд Үндэсний парк ба онгон байгалийн департаменттай байгуулжээ. Энэ тохиолдолд Паркийн агентлаг анхдагч дэд бүтцийг байгуулж уугуул иргэдэд жуулчны баазын менежментийн сургалт зохион байгуулах ба эхний хэдэн жилийн орсон бүх орлогыг орон нутагт олгож байх юм.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Зочлон ирэгсдийн үйлчилгээний концессийг орон нутгийн хамтлагуудад шууд олгох боломж бий болгосон арга зам
- ▶ Гэрээ хэрэгжих хугацааны туршид оруулах хөрөнгө оруулалт болон хоёр талд орох ашгийн төвшинг тусгасан уян хатан эзэмшлийн хэлбэрүүд ба үнийн механизм

Эх сурвалж: TRC Tourism 2013

Жишиг судалгаа 6. ТХГН захиргаанаас боловсруулсан жуулчны операторын тусгай зөвшөөрлийн систем

НСВ мужийн Үндэсний парк ба онгон байгалийн газрын Паркийн эко үнэмлэх

"Паркийн эко үнэмлэх" тусгай зөвшөөрлийн системийг тусгай зөвшөөрлийн зохицуулагч төвлөрсөн байдлаар захирах бөгөөд шаардлагатай бүх мэдээлэл, өргөдөл хүсэлтийн маягтуудыг онлайн хэлбэрээр авч болно. Энэхүү шинэ системийн дагуу арилжааны аялал жуулчлалын операторт олгодог дөрвөн төрлийн тусгай зөвшөөрөл байдаг байна (1 жил, 3 жил, ба 10 жилийн зөвшөөрөл). Байгалийн болон соёлын үнэ цэнд үзүүлэх нөлөөллийг бага байлгах, аялагчид паркийг ашиглахтай холбоотой гарч болох асуудлуудыг зохицуулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахын тулд хаана, хэзээ ямар үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг тусгай зөвшөөрлийн нөхцлүүдээр зааж өгсөн байна. Бүх тусгай зөвшөөрөлд үйл ажиллагааны ерөнхий болон тухайн газрын онцлог нөхцлүүдийг тусгасан байдаг. Тусгай зөвшөөрөл эзэмшигч бүр аюулгүй байдал, олон нийтийн хариуцлагын даатгал болон байгаль орчныг хамгаалах талаар тусгай зөвшөөрөлд заасан шаарлагыг биелүүлэх үүрэгтэй. Операторуудад тавигддаг тэдгээр шаардлагын заримаас дурдвал:

- ▷ парк, дархан цаазтай газар болон тэдгээрийн удирдлагад өндөр хариуцлагатай хандах
- ▷ санал болгож буй үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын болон байгаль хамгааллын талаар сайтар ойлгосон байх
- ▷ санал болгосон бүх үйл ажиллагааныхаа талаар гүнзгий мэдлэг, ажлын туршлага ур чадвартай байх
- ▷ санал болгож буй үйл ажиллагаанд тавигддаг ерөнхий болон тусгай стандартыг мөрдөх, түүнд шаардлагатай аюулгүй ажиллагааны болон сэргээн босголтын боловсронгуй тоног төхөөрөмжтэй байх
- ▷ санхүүгийн чадавхитайгаа харуулах
- ▷ Үйлчлүүлэгчдэд чанартай үйлчилгээ үзүүлэх
- ▷ нийтийн хариуцлагын даатгалын анхан шатны шаардлагыг хангасан байх
- ▷ Тээврийн яам болон бусад газрын тавьдаг заавал биелүүлэх шаардлагуудыг хангах.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн газрыг тогтвортой, соёлтой ашиглахын тулд үйлчлүүлэгчиддээ зааж сургах, үйл ажиллагаагаа зүй зохистой явуулах тухай заалтыг бүх тусгай зөвшөөрлийн гэрээнд зааж өгдөг байна. Тухайлбал:

- ▷ үйлчлүүлэгчиддээ жуулчны бааз дээр сөрөг нөлөөллийг яаж гаргахгүй байх талаар тайлбарлах
- ▷ байгалийн болон соёлын өвийг хамгаалах менежментийн тухай ойлголтыг бүрдүүлэх
- ▷ аялагчдад чанартай үйлчилгээ хүргэх, орчуулга хийх, танин мэдэхүйн сургалт явуулах
- ▷ түүхэн газрууд, уугуул абориген иргэдийн нутгийг хүндэтгэх үзлийг дэлгэрүүлэх
- ▷ тухайн газарт үзүүлэх аялагчдын нөлөөг багасгах
- ▷ үнэт зүйлсийг хамгаалах, нийтийн аюулгүй байдлыг сахих
- ▷ байгаль хамгаалах үйл ажиллагаанд хүмүүсийг идэвхтэй оролцуулах
- ▷ байгаль орчны тогтвортой байдлыг хангах практикийг нэвтрүүлэх
- ▷ учирсан хохирол, хууль бус үйл ажиллагаа, гарч болох асуудлын талаар мэдээлэх

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▷ Агентлагийн байгаль хамгааллын, тогтвортой байдлын, нийгэм эдийн засгийн зорилтуудыг Концессийн гэрээний заалт, нөхцлүүдэд тусгасан байх
- ▷ Гүйцэтгэлийн стандартуудыг тогтоосон, тэдгээрийг хэрэгжүүлдэг, сайн гүйцэтгэлийг тодруулж үнэлдэг
- ▷ Хаалтын үйл ажиллагааны механизм бэлэн байдаг, түүнийг хэрэгжүүлж баримтладаг.

Эх сурвалж: НСВ мужийн Үндэсний парк ба онгон байгалийн газар, Паркийн Эко үнэмлэх хүсэгчдэд зориулсан зааварчилга, 2013

Шинэ Зеланд

Шинэ зеландын төвийн ба орон нутгийн захиргаа, агентлагууд эко жуулчлалын байр байгууламжийн ажилд хувийн секторын хөрөнгө оруулалт татах хөшүүргийг идэвхтэй дэмждэггүйгээрээ Австралиас ялгаатай билээ. Байгаль хамгаалах департаментын (БХД) зүгээс хувийн секторын хөрөнгө оруулах хүсэлтийг хүлээн авч голдуу хариу өгөхөөс биш, сонирхолоо илэрхийлэхийг урих юм уу хөрөнгө оруулагчдын өмнөөс санаа тавьдаггүй ажээ. Хувийн секторынхон БХД-ын боловсруулсан, өргөн хүрээг хамарсан бодлого төлөвлөлтийн баримт бичгээс чухам аль хэсэгт хувийн хөрөнгө оруулалтыг зөвшөөрч буй тухай ерөнхий ойлголт л авдаг байна. Гол гол, хуулийн чиглүүлэгч баримт бичгийн тоонд (i) Үндэсний парк, Нөөц газар, Дархан цаазтай газрын ерөнхий бодлого (ii) Бүс нутгийн байгаль хамгаалах менежментийн стратеги ба (iii) Үндэсний паркийн менежментийн төлөвлөгөө зэрэг ордог болно. БХД хувийн сектортой тогтоох харилцааг сайжруулах зорилгоор дотроо бизнесийн нэгжийг 2011 онд байгуулсан ба түүний ерөнхий хандлага нь бодлого менежментийг сайжруулж, байгаль хамгаалах орчныг бүрдүүлж, бизнесийн түншлэлийг хөгжүүлэх явдал юм.

Шинэ зеландын үндэсний паркууд дахь хувийн барилга байгууламжийн тод жишээ болох Эрмитаж зочид буудал, Шато Тонгариро, Милфорт Трек хатс зэргийг хувийн секторынхон 1991 онд засгийн газар өмчөө зарахад нь худалдаж авчээ (тэгэхэд шинэ хуулиар Жуулчны зочид буудлын комиссыг татан буулгасан). Түүнээс хойш ховорхон тохиолдолд, тухайлбал 1990-ээд оны дундуур Маунт Кук Үндэсний паркийн менежментийн төлөвлөгөөний дагуу Каролин хат, Маунт кук уулын үүргэвтэй аялагчдын бааз, Маунт Кук Үндэсний парк зэргийг өөрсдийнх нь хүсэлтээр хувьчилсан байна.

БХД тусгай хамгаалалттай газрын 4000 гаруй худалдааны үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл гаргасны бараг бүгдийг газар ашиглалт, усан ба агаарын аялал, кемпингийн талбай ба тээврийн оператор, цанын бааз болон хоолны газруудад олгожээ. Тэдгээрийн заримд нь байнгын ба түр байгууламж орсон байх ба хувийн эко жуулчны зочид буудал ороогүй юм.

Шинэ зеландын үндэсний паркуудын орчин тойронд болон тусгай хамгаалалттай газар доторх хувийн эзэмшлийн газруудад олон тооны, дэлхийн зэрэглэлийн эко жуулчлалын буудлууд байдаг. Тусгай хамгаалалттай газарт буюу ойр орчмын хэрэгцээг хангах Аварао (Абель Тасманы үндэсний парк), Фиордланд Лодж (Фиордланд үндэсний парк), Артурс Пасс ба Мозраки Вайлдернес Лодж (Артурс Пасс ба Баруун өмнөд Шинэ зеландын дэлхийн өвд бүртгэгдсэн газар) болон бусад хувийн буудлууд байдаг. Түүнчлэн Шинэ зеландын тусгай хамгаалалттай газар болон дархан цаазтай газруудаар байрлаж байгаа 900 гаруй улсын мэдлийн байр, байшингууд жуулчдын эрэлтийг хангаж байна. Тэдгээрийн 90 гаруй хувийг БХД хариуцдаг бол үлдсэн хэсгийг амралт зугаалгын клубууд, дархан цаазтай газрын группууд ажиллуулж байгаа.

Жишиг судалгаа 7. ТХГН-т хувийн секторын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих нь

Деннистон, Шинэ Зеланд

Шинэ зеландын өмнөд аралд байдаг, цагтаа 1500 гаруй оршин суугчтай байсан баруун эргийн уурхайчдын тосгон Деннистон, 1960-аад оны сүүлчээр эгц налуугаараа алдартай төмөр замыг нь хааснаас хойш хүн ам нь аажмаар цөөрсөөр бараг хий үзэгдлийн тосгон болон хувирчээ. Тосгоны газар болон хуучин уурхай нь одоо 1-р зэрэглэлийн түүхт газарт тооцогддог. Хэдэн арван жилийн дараа, орон нутгийн төлөөлөл засгийн газартай хамтран Деннистоны үзэсгэлэнт өвөрмөц байрлал, ховор түүх, түүхийн ач холбогдлыг ашиглан дэлхийн зэрэглэлийн аялал жуулчлалын газар болгон сэргээхээр зорьсон байна.

Дархан цаазтай газрын департамент (ДЦД) ба Баруун эргийн хөгжлийн газраар удирдуулсан анхны төлөвлөгөөгөөр, оператор нь эхнээсээ Деннистоны өвийн сан (ДӨС)-тай (тус санд Шинэ Зеландын хатуулаг эрчим хүчний компани, Толгойн Найз нар сан, Буллер дүүргийн зөвлөл, ДЦД, Баруун эргийн хөгжил зэрэг нэгдсэн) түншилж ажиллахаар заажээ.

Гэвч, жуулчны операторуудаас гаргасан Оролцох саналаа илэрхийлэх (ОСИ) хүсэлтүүд гол нь бүтээн байгуулалтын нүсэр хэмжээнээс болоод амжилтанд хүрээгүй байна. Тийнхүү ДЦД өөрөө дэд бүтцийг байгуулах ажилд оройлон оролцов. Анхны ОСИ поцессоос хойш ДЦД болон ДӨС сангийн бусад гишүүд тухайн газрын түүхэн байдлыг сэргээн босгох, жуулчлалтай хобоотой маркетинг гэх мэт ажилд 3 сая гаруй ШЗ доллар зарцуулсан ажээ. Тус газрын жуулчдыг татах, тэдэнд үзүүлэх гол бүтээгдэхүүн нь газар доорхи уурхайг 'бодит' байлаар нь сэргээн байгуулах явдал байв.

ДЦД тус газар дахь аялал жуулчлалын үйл ажиллагааг хэдэн сар хариуцаж ажиллуулсны дараа, 2009 оны сүүлээр, концессийн гэрээгээр өөрийгөө санхүүжүүлж ажиллах хөрөнгө оруулагчийг татах зорилгоор хоёр дахь удаагаа ОСИ зарлав. Үйл ажиллагаа явуулахдаа ДӨС-тай түншлэж ажиллахаар тооцсон бөгөөд ДӨС-ийн зүгээс операторт 'зохих' түвшний дэмжлэг туслалцаа үзүүлэхэд бэлэн байлаа.

ОСИ хоёр дахь удаагаа зарласнаар тохиромжтой хамтрагчийг олж чаджээ. Анхны маркетинг, вэб хуудас болон аяллын чиглэлүүдийг боловсруулсан байсан болохоор шинэ оператор бизнесийн үйл ажиллагаагаа шууд эхлүүлэхэд төвөггүй байв. Дэд бүтцийн дорвитой ажлуудын ихэнх нь дуусч зарим нь хийгдэж байхад дараагийн хөгжлийн ажлуудын төлөвлөгөө батлагдаж байлаа.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- Боломжтой түрээслэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, урин дуудаж урамшуулсан маягаар, хүсэлт гаргагчдад түншлэлийн зарчмыг сайтар ойлгуулж дэмжиж явуулсан.

Эх сурвалж: ДЦД & ДӨС (2010), *Түүхт Деннистонд жуулчны бааз байгуулах ажилд Жуулчны оператор оролцох саналаа илэрхийлэх нь*. ДЦД ба операторын вэб хуудас - www.doc.govt.nz and www.dennistonmineexperience.co.nz.

Канад

Хувийн сектор голдуу Үндэсний паркуудын эко жуулчлалын хөрөнгө оруулалтын хөгжлийг хөтөлдөг талаараа Канад улс Шинэ Зеландтай ерөнхийдөө төстэй юм. Канадын Рокиз Үндэсний паркт үйл ажиллагаа явуулдаг Брюстер Трэвел зэрэг томоохон операторууд үндэсний паркуудад жуулчидтай холбоотой үйл ажиллагаанд давамгайлах хандлагатай байдаг. Шинэ бизнесийн боломжуудын талаарх удирдлага менежментийн төлөвлөгөө улам нээлттэй болсоор байна. Тухайлбал, Жаспер Үндэсний паркийн 2010 оны менежментийн төлөвлөгөөнд одоо байгаа болон шинээр нэмэгдэх бизнесүүдэд худалдааны сайн нөхцөлд үйл ажиллагаа явуулах бодлогыг улам сайжруулж өгсөн юм. Одоогийн байдлаар Жаспер паркийн зүгээс хамгаалалттай уулын авиралт (via ferrata), параплан, болон уулын дугуйн аяллын чиглэлээр ажиллах хувийн секторын саналыг хүлээж байгаа юм. Паркийн удирдлага саналуудыг үнэлэхдээ жуулчны ажил явуулж байсан туршлага ба ажлын чанарыг удирдлага болгохыг зорьж байсан боловч одоогийн байдлаар ихэнх саналыг байгаль орчны шалгуураар үнэлж байгаа билээ.

Жаспер үндэсний паркийн жуулчны үйл ажиллагааны нийт эргэлтийн 10 хувийг тоног төхөөрөмж бусад зүйлсийн түрээс эзэлдэг. Паркс Канада байгууллага Жаспер сууринг оруулан бусад бүх дархан цаазтай газруудыг удирддаг байна. Оршин суугчид нь байраа 42 жилийн хугацаатай, автоматаар сунгагдах нөхцөлтэй түрээсээр эзэмшдэг юм байна. Сүүлийн жилүүдэд оршин суугчдын байгуулсан албан ёсны тосгоны зөвлөлөөс бизнес төлөвлөгөөний тусгай зөвшөөрлийг олгодог болсон хэдий ч Паркс Канада төлөвлөх эрхийг олгосон хэвээр байгаа ажээ. Олон тооны зочид буудал, байрны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг 21 жилээр олгодог ба тусгай зөвшөөрлийн хугацаа дуусмагц байр сав Паркс Канадагийн мэдэлд ирдэг. Фэрмонтод байдаг алдарт Жаспер Ризорт буудал л гэхэд түрээсийн толгой гэрээтэй ба түүнд холбогдох хэд хэдэн (гольфын, морь унуулах, зоогийн газрын, завиар аялуулах болон жижиглэн худалдааны г.м.) тусгай зөвшөөрлийг эзэмшдэг ажээ. Брюстер Дискавери Вок гэдэг сонирхолтой Жишигийн судлагаа бий (www.glacierdiscoverywalk.ca). Брюстер Трэвел нь Канадын тусгай хамгаалалттай газарт 120 жилийн турш үйл ажиллагаа явуулж байна. Дискавери Вок бизнесийн санал бол 1960-аад оны Жаспер Гондола-аас хойш тус тусгай хамгаалалттай газарт гарсан хамгийн дорвитой санал юм. Брюстерийн зүгээс Паркс Канадад хандаж жуулчдын алсыг харах цэгүүдийг авч зочлон ирэгсдэд шинээр Дикавери Вок (танилцах, судлах явган аялал) аялалын маршрут нээх санал гаргажээ. Паркс Канада энэ хүсэлтийн үнэлгээг хийхдээ, гол нь байгаль хамгаалах хүчин зүйлтэй холбоотой ямар арга хэрэгслэл байгаагаар нь авч үзсэн байна. Ашиглах гэж буй хэсгийн дагуу томоохон хашлагатай замууд тавигдсан байсан нь онгон байгаль руу түрж орохгүй байх байгаль хамгаалах шаардлагыг хангаж байв (энэ тусгай хамгаалалттай газрын 97% онгон байгалийн зэрэглэлд байдаг).

Брюстер Трэвел одоо байгаа дэд бүтцээ ашиглах боломжтой байсан учраас байгальд учруулах нөлөө бага байлаа. Тэд жуулчдыг одоо байгаа Айсфилд Парквэй зочдын төвөөс Дискавери Вокийн тавцан хүртэл автобусаар зөөх болно. Өөр шинэ бизнесийн байгууллагын хувьд эдгээр шалгуурыг хангахад туйлын бэрхшээлтэй байх байсан юм. Дискавери Вок шинэ бүтээгдэхүүн нь Брюстерийн түрээсийн гол гэрээний хавсралт болох бөгөөд тусд нь худалдах боломжгүй юм. Брюстер Трэвел бас алсыг харах өөр цэгүүдийг сайжруулах, тэдгээрт хүрэх нийтийн зам шинээр гаргах, тус хамгаалалттай газарт шинэ бүтээгдэхүүн нь хэрхэн шинэ боломжуудыг авч ирэхийг харуулах аялал жуулчлалын стратеги боловсруулах зэрэг үүрэг хүлээнэ.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- Концессийг үр дүнтэй хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын орчин бүрэлдсэн
- Экотуризмийн, уламжлалт хэрэглээний, судлагааны, давуу байдлын, цахилгаан холбооны гэх мэт янз бүрийн тохиолдолд ашиглаж болохуйц концессийн гэрээнүүд бэлэн байх.

Жишиг судалгаа 8. Засгийн Газрын концессын менежмент хэрэгжүүлэх чадавхи

Альбертагийн засгийн газар - Аялал жуулчлал, Парк ба Зугаа цэнгэлийн яам

Альберта муж бол аялал жуулчлалын нилээд томоохон чиглэл бөгөөд тэнд Парк Канадагийн хамаардаг таван тусгай хамгаалалттай газар (үүнээс Банф ба Жаспер үндэсний паркууд нь Канадын Роки Маунтэнс дэлхийн өвд бүртгэгдсэн газрын хэсэг байдаг), ба Мужийн динозаврын парк (дэлхийн өвд бүртгэгдсэн бүс) зэрэг паркуудыг багтаасан тусгай хамгаалалттай газрууд олон бий. Альбертагийн засгийн газрын Аялал жуулчлал, Парк ба Зугаа цэнгэлийн яам, мужийн паркууд, тэдгээрийн ойролцоох газрууд болон бусад тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг татан оролцуулах талаар идэвх санаачилгатай ажилладаг. Жуулчлалын салбарт хандуулах хөрөнгө оруулалтын боломжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл яамны вэб хуудсанд бий. Департаментын тусгай нэгж болох Аялал жуулчлалын бизнес, судлагаа хөрөнгө оруулалтын салбар нь хөрөнгө оруулалтыг урамшуулах, хөрөнгө оруулагчдад хүсэлтээ гаргах үед нь болон үйл ажиллагааны үе шатуудад нь дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Тус салбарын үүргийг дараах байдлаар тодорхойлжээ:

- ▶ Хөрөнгө оруулах сонирхол ба санхүүгийн чадавхийг, тохирох бизнесийн хөрөнгө оруулалтын боломжтой харьцуулан үнэлгээ хийх.
- ▶ Бизнесийн сонирхолыг дэмжин туслах зорилгоор холбоо тогтоох хүмүүсийн шаардлагатай мэдээллийг өгч уулзалтууд зохион байгуулах.
- ▶ Бизнес жишиг буюу ТЭЗҮ-г үндэслэлтэй болгоход туслах мэдээллээр хангах.
- ▶ Сонирхож байгаа жуулчлалын секторын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх.
- ▶ Альберта муж руу аялал жуулчлалын хөрөнгө оруулалтын аялал зохион байгуулах.
- ▶ Альбертагийн жуулчлалын ба зугаа цэнгэлийн зорилгоор газар түрээслэх журмын дагуу төрийн мэдлийн газрыг түрээслэх боломжийн талаарх мэдээлэл өгч туслах.

Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, өргөтгөх талаар бизнесийн мэдээлэл өгч зөвлөх үйлчилгээг мөн үзүүлнэ. Салбар нь дараах зүйлсийг хийх боломжтой. Үүнд:

- ▶ Санхүүгийн зөвлөгөө өгч үйлчлүүлэгч/хувиараа бизнес эрхлэгчдэд хөрөнгө олоход нь туслах
- ▶ Аялал жуулчлал хөгжүүлэх төслийг холбогдох зохицуулалтаар оруулахад нь үйлчлүүлэгчдээ зааварчлах
- ▶ Засгийн газрынхаа департаментуудтай хамтран гол бодлогын салбаруудаар, тухайлбал агаарын зам, хурдны замын тэмдэглэгээ, бүтээгдэхүүн хөгжүүлэх зэрэгт аялал жуулчлалын салбарыг төлөөлж зөвлөх
- ▶ Аялал жуулчлалтай холбоотой эдийн засгийн нөлөөллийн үнэлгээнд зөвлөгөө өгөх.

Альбертагийн засгийн газрын олон улсын салбарууд нилээд хэдэн оронд байдаг бөгөөд тэдгээр нь бас хөрөнгө оруулалтын зөвлөгөө, тусламж үзүүлдэг.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Боломжтой түрээслэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, урин дуудаж урамшуулсан маягаар, хүсэлт гаргагчдад түншлэлийн зарчмыг сайтар ойлгуулж дэмжиж явуулсан
- ▶ Нарийн төвөгтэй концессийн менежментийг төвлөрсөн байдлаар, харин энгийн концессийг бол чанарын батлагаа, агентлагийн хэмжээний стандартуудыг бүрдүүлсэн тохиолдолд тухайн орон нутагт нь эрх олгон хэрэгжүүлдэг
- ▶ Агентлаг нь концессийг мэргэжлийн төвшинд зохицуулах чадавхтай.

Эх сурвалж: Альбертагийн засгийн газар, Аялал жуулчлал, Парк ба Зугаа цэнгэлийн яамны вэб хуудас, www.tpr.alberta.ca.

АНУ

АНУ-ын жишээ нь Шинэ Зеланд ба Австралийнхаас нилээд ялгаатай. АНУ-ын холбооны засгийн газар нь үндэсний паркуудынхаа аялал жуулчлалтай холбоотой бүх хөрөнгийг эзэмшдэг бөгөөд, тэдгээрийг олон нийтэд ил тод концессийн гэрээгээр хувийн секторт өгч ажиллуудаг байна. Үндэсний паркийн газар (ҮПГ) жилийн 1 тэрбум долларын нийт эргэлттэй 500 гаруй концессийн гэрээг захиран хариуцдаг. ҮПГ-ын концесс эзэмшигчид оргил улиралд 25000 гаруй хүнийг хоол ба байраар үйлчлэхээс аваад, салаар хөвөх, автомашинаар аялах хүртэл янз бүрийн үйл ажиллагаа явуулдаг ажээ.

Уралдаант шалгаруулалтыг маш тодорхой чиглэлээр, бүтээгдэхүүн, зах зээл, нийт орлогын түүх, үнэ зэргийг ойлгомжтой илэрхийлж зохион байгуулдаг. Дэд бүтэц нь уламжлалт, урт удаан хугацааны турш байсан, засгийн газраас зочид юуг хүсч байгааг хэрхэн ойлгосноор хийгдсэн, аялагчдын зонхилох хэсгийг эзэлдэг дотоодын зах зээлдээ зориулсан байдаг учраас шинэчлэл, инновацийн төвшин доогуур байдаг байна.

1998 онд хуулиар байгуулагдсан Концессийн менежментийн зөвлөл нь Үндэсний паркийн системд концессийн менежментийн талаар зөвлөгөө өгдөг. Тус зөвлөлийн бүрэлдэхүүнд Дотоод яамны сайдын томилсон долоон гишүүн орно. Зөвлөлийн гишүүд нь АНУ-н иргэн байх бөгөөд холбооны засгийн газарт ажилладаггүй байх ёстой. Хуульд зааснаар, зөвлөлийн гишүүд нь дараах чиглэлүүдээр сайн мэргэшсэн байх ёстой. Үүнд: аялал жуулчлал, зочдын үйлчилгээ, нягтлан бодох бүртгэл, жижиглэн худалдаа ба хөтөч, дархан цаазтай парк ба зугаа цэнгэлийн газрын ашгийн бус хөтөлбөр, уламжлалт гар урлал ба уран зураг, улсын парк ба зугаа цэнгэлийн хөтөлбөр зэрэг болно.

Концесстэй холбоотой асуудлуудаар зөвлөл нээлттэй, олон нийтийг хамарсан уулзалтуудыг зохион байгуулах ба өөрийн үйл ажиллагааны талаар засгийн газарт тайлагнана.

2000 оноос эхлэн, *Ногоон шугам* сонин байгаль орчны асуудал, парк доторх байгаль орчны сайн менежментийн практик зэрэг асуудлуудаар концесс эзэмшигчид ба тусгай хамгаалалттай газрын ажилтнуудын боловсролыг дээшлүүлж байгаль хамгаалахад туслаж байна. ҮПГ-н ажилтнууд дээрх сонингоор дамжуулан, концесс эзэмшигчдийг байгаль орчны зохицуулалт болон шинэ санаачлагуудтай танилцуулж, тухайн үеийн сайн менежментийн практикийн тухай мэдээлэл өгч, үйл ажиллагааныхаа туршид байгаль хамгаалах талаар онцгой сайн ажилласан концесс эзэмшигчдийг урамшуулдаг байна.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- Концессийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бодлого зохицуулалт тов тодорхой байх
- Концессийн системийн зорилгыг, тухайлбал аялал жуулчлалын үйлчилгээ ба дэд бүтэцэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, засгийн газрын орлогын нэмэгдүүлж, зардлыг багасгах зэргийг тодорхой илэрхийлсэн байх
- Гүйцэтгэлийн стандартуудыг тогтоосон, тэдгээрийг хэрэгжүүлдэг, сайн гүйцэтгэлийг тодруулж үнэлдэг
- Хаалтын үйл ажиллагааны механизм бэлэн байдаг, түүнийг хэрэгжүүлж баримталдаг
- Концессийн тухай хууль, бодлого ба журмыг байнга, төлөвлөгөөтэйгээр судлаж танилцаж байх механизм бүрдсэн
- Нарийн төвөгтэй концессийн менежментийг төвлөрсөн байдлаар, харин энгийн концессийг бол чанарын батлагаа, агентлагийн хэмжээний стандартуудыг бүрдүүлсэн тохиолдолд тухайн орон нутагт нь эрх олгон хэрэгжүүлдэг
- Концессийн менежментийг амжилттай хэрэгжүүлэхэд тусгай хамгаалалттай газрын захиргааны нөөц бололцоо хангалттай.

Жишиг судалгаа 9. Хувийн секторт олгосон томоохон концессийн гэрээнүүд

АНУ-ын паркийн захиргаа

Концессийн төрөл: Зочид буудал, тээвэр, хоол ба ундаа, дэлгүүр

Концесс эзэмшигч: АНУ-ын үндэсний ба мужийн паркийн хамгийн том концесс эзэмшигч Шантера Паркс & Ризорт, Инк

Үр, ашиг: Засгийн газар ба хувийн секторын хоорондын түншлэлийн үр дүнд үндэсний хэмжээнд аялагчдын үйлчилгээ ба дэд бүтэц сайжирч, Засгийн газрын орлогын эх үүсвэр нэмэгдэж, үйл ажиллагааны зардал буурсан

Агуулга: АНУ-ын Үдэсний паркийн захиргаа 2012 оны 8 сард Шантера Паркс & Ризорт, Инк (Шантера) компанийг Глэймер үндэсний паркт 16 жилийн хугацаатай жуулчны үйл ажиллагаа явуулахаар сонгожээ.

2014 оны 1 сараас хэрэгжиж эхлэхээр хүлээгдэж байгаа тусгай хамгаалалттай газрын концессийн шинэ гэрээнд зочдын байрлах байр, хоол ундааны үйлчилгээ, жижиглэн худалдаа, тээвэр болон хамгаалалттай газрын доторх бусад зочдын үйлчилгээнүүд орсон байна.

Энэхүү гэрээнд жилийн нийт орлогын 1 хувиар франчайзингийн хураамж төлөхөөр тусгажээ. Түүнчлэн засвар үйлчилгээний нөөц санд жилийн нийт орлогын 2.35%, Ред Бас Риабилитэйшн нөөцөд 2.5%-ийг тус тус төлөхөөр оруулсан байна. Жилийн нийт орлогыг ойролцоогоор 18 сая 500 мянган доллар байна гэж үзсэн.

Гэрээнд тусгай хамгаалалттай газарт буй олон байр буудлын тоноглолыг сольж шинэчлэхээр тусгасан бөгөөд Мэни Глэйсер буудал, МакДоналд Лодж зэргийн зарим өрөөг шинэчлэн засварлах, Мэни Глэйсер буудлын Хэйдис хоолны газар болон бааз дээрх хоёр эмийн сангийн үйлчилгээг сайжруулах, эрүүл хоолны сонголтыг сайжруулах, Ред Бас тээвэрт жуулчны хоёр автобус шинээр нэмэх, хамгаалалттай газрын гадна хэсэгт захиргааны дэмжлэг үзүүлэх зэргийг заасан байна.

Концессийн гэрээний төлөөх өрсөлдөөнт процессыг 2012 оны 12 сарын 11-д эхлүүлж товч төлөвлөгөөг нийтлэжээ. Бүх саналыг 2013 оны 4 сарын 16-ны дотор багтаан авах байв. Үндэсний паркийн захиргаа ба Глэйсер үндэсний паркт хамааралгүй техникийн экспертүүдээс бүрдсэн үнэлгээний баг ирсэн саналуудыг судлаж үзээд, төлөвлөгөөнд заасан хүчин зүйлүүд дээр үндэслэн хамгийн сайн саналыг сонгон шалгаруулжээ.

Шантера Паркс & Ризортс, Инк. улсын хэмжээгээр үндэсний ба мужийн хэд хэдэн тусгай хамгаалалттай газруудад, тухайлбал Галт уулын нуур, Үхлийн Хөндий, Гранд Каньон, Петрифидийн ой, Роуки Маунтэн, Йеллоустоун ба Зайон үндэсний парк, ба Маунт Рашмор зэрэг газруудад аялал жуулчлалын төрөл бүрийн үйлчилгээ явуулдаг.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Тусгай хамгаалалттай газрын захиргаа концессийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бодлого зохицуулалт тов тодорхой байх
- ▶ Концессийн системийн зорилгыг, тухайлбал аялал жуулчлалын үйлчилгээ ба дэд бүтэцэд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, засгийн газрын орлогын нэмэгдүүлж, зардлыг багасгах зэргийг тодорхой илэрхийлсэн байх.

Эх сурвалж: АНУ-ын Паркийн захиргааны концессийн менежментийн зааварчилгаа вэб хуудас www.nps.gov 2013

Жишиг судалгаа 10. ТХГН дахь Корпорацийн санхүүжилт ба түншлэлийн шинэ хэлбэр

АНУ-ын паркийн захиргаа

Ашиг хуваах нь

Ашиг хуваах нь: Гранд Тетон Альпайн Спрингс Вотер ба Йеллоустоун Спрингс Спринг Вотер хоёр бол баруун Йеллоустоун паркийн байгалийн булгийн цэвэр усыг савладаг компаниуд бөгөөд түүнээс олсон орлогоо Гранд Тетон ба Йеллоустоун үндэсний паркуудад илгээдэг байна. Тэр хавийн савласан ус түгээгчид ч мөн тусгай хамгаалалттай газруудад шууд хандив оруулдаг аж. Тийнхүү орж ирсэн мөнгийг захиргааны зардалд бус зөвхөн төсөлд зарцуулдаг.

Байгууллагуудын хандив

Байгууллагын санаачилга: Спэниш Пикс шар айргийн компани 1998 онд өөрийн Блэк Дог Эйль бүтээгдэхүүнээ Хорайзон Айрт худалдсан хайрцаг тутмаас 10 центийг Йеллоустоун паркийн санд нийлүүлж байжээ.

Шинжлэх ухааны судалгаа ба рояльти

Йеллоустоун үндэсний парк нь Дайвэрса корпорацтай парк доторх халуун рашааны судлагааны мэдээллийг солилцох болон рояльти татварын гэрээ байгуулжээ. Дайвэрса компани таван жилийн хугацаанд Үндэсний паркийн захиргаанд 100 мянга гаруй доллар төлөх бөгөөд өөрийн эмийн бүтээгдэхүүний борлуулалтын орлогын 0.5%–10% -ийг рояльти таварт төлөх юм. Энэ олсон орлогыг Йеллоустоуны дархан цаазтай газрын судлагаанд ашиглах болно.

Тоног төхөөрөмжийн түрээс

Охайогийн улсын паркийн захиргаа орлогоо нэмэгдүүлж, төсвийн татаасаас хамаарах байдлаа багасгах зорилгоор ирсэн зочдод зөөврийн зуух, майхан, зөөврийн ор гэх мэт кемпингийн төхөөрөмж түрээслэдэг байна.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Судлагаа, тоног төхөөрөмжийн түрээс, байгаль хамгаалахад тус нэмэртэй рояльти зэрэг ашиглалтын олон хэлбэрт тохирох концессийн хувилбарууд бэлэн буй
- ▶ Агентлагууд түншлэлийн болон концессийн үр дүнтэй гэрээ байгуулахдаа, орон нутгийн хамтлагууд, орон нутгийн болон төвийн засаг захиргаа, хувийн сектор болон ашгийн төлөө бус/засгийн газрын бус байгууллага, бусад төвлөрсөн засаглалын байгууллагуудын оролцоог тооцсон бизнесийн загвар ашигласан.

Эх сурвалж: Пол Ф.Ж. Ийглс, Стивен Ф МакКул ба Кристофер Д. Хейнес *Тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлал; Тусгай хамгаалалттай газрын оновчтой практикийн зааварчилгаа дугаар 8, Дэлхийн тусгай хамгаалалттай газрын комисс* Нэгдсэн үндэстний байгалийн хөтөлбөрт зориулж боловсруулав, Дэлхийн аялал жуулчлалын байгууллага ба Дэлхийн дархан цаазтай газрын холбоо. 2002

Өмнөд Африк

Өмнөд Африк холимог загварыг хэрэглэсээр ирсэн түүхтэй учраас тусгай хамгаалалттай газрын эко жуулчлалын хөрөнгө оруулалтыг засгийн газраас ч гаргадаг, хувийн сектороос ч оруулдаг байна.

2000 оны худалдааны стратегийг нэвтрүүлж эхэлснээс хойш, ӨАҮП (Өмнөд Африкийн тусгай хамгаалалтын газрын агентлаг) голдуу засгийн газрынхаа санаачилгаар шинэ боломжуудыг тодруулан дэмжсээр иржээ.

Олон улсын санхүүгийн байгууллага (ОУСБ-Дэлхийн банкны коммерц хариуцсан байгууллага)-н тусламжтай, улсын ба хувийн анхны дорвитой түншлэлийн бүтцийг боловсруулж хэрэгжүүлсний үр дүнд эко жуулчлалын 9 концессын гэрээ байгуулснаас долоо нь алдарт Крюгерийн үндэсний паркт хэрэгжсэн төдийгүй өөр хэд хэдэн үндэсний паркт жижиглэн худалдаа ба рестораны концессийн эрхийг хувийн операторуудад олгожээ. Эдгээр ажлууд 2000 ба 2001 онуудад тус тус хэрэгжиж дууссан байна.

Маш амжилттай хэрэгжиж байгаа энэхүү эко жуулчлалын улсын ба хувийн түншлэлээс одоогийн байдлаар 20 сая гаруй ам. долларын орлого олоод байгаа юм. Түншлэлийн хүрээнд 36 сая гаруй долларын өртөгтэй дэд бүтэц, бусад хөрөнгө бий болгосон ба гэрээний хугацаа дуусахад эдгээр хөрөнгө ӨАҮП агентлагийн мэдэлд очих болно. Төсөл хэрэгжүүлсэн газар бүр нь жуулчдын очих дуртай, эрэлт ихтэй, гайхалтай сайхан байрлалтай байсан нь дээрх түншлэлийг амжилттай болгоход нөлөөлжээ.

ОУСБ ногоон талбайн концессийг, 'зураг төсөл боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх' загвараар 20 жилийн хугацаатай байхаар боловсруулжээ. Ийм концессийн дагуу, хувийн операторууд зочид буудал байгуулж эко жуулчлалын үйл ажиллагаа явуулах газрыг ашиглах онцгой эрхээр хангагдаж, ӨАҮП агентлаг газар ба түүн дээрх барилга байгууламжийн өмчийн эрхээ хадгалж үлдэх юм. Энэхүү концессийн гэрээнд сунгах болон гэрээ дуусахад давамгайл эдлэх эрхийг тусгаагүй болно. Концесс эзэмшигч нь уралдаант шалгаруулалтын үед санал болгосон үнийн тодорхой хувиар ӨАҮП-т жилийн хураамж төлнө.

ӨАҮП агентлагаас паркуудад төсөл хэрэгжүүлэхэд оролцох саналаа илэрхийлэхийг дэмжиж ажилласаар байгаа бөгөөд зарим төсөл маш их анхаарал татдаг бол зарим нь тийм ч амжилттай биш байдаг.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- Концессийн талаарх шийдвэр гаргахдаа, хууль тогтоомж, бодлого чиглэлтэй нийцсэн, зардал багатайгаар үр дүнд хүрэх стратеги төлөвлөлтийг ашигласан байх
- Шийдвэр гаргагч (засгийн газрын толгойлсон) болон гүйцэтгэгч (хувийн, ашгийн төлөө бус, засгийн газрын бус толгойлолттой) байгууллагуудын хандлагыг концесст ашигласан
- Боломжтой түрээслэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, урин дуудаж урамшуулсан маягаар, хүсэлт гаргагчдад түншлэлийн зарчмыг сайтар ойлгуулж дэмжиж явуулсан.

Жишиг судалгаа 11. ТХГН дахь гадаадын хөрөнгө оруулалт

Кени улсын онгон байгалийн захиргаа

Кенийн онгон байгалийн захиргаа (КОБЗ)-ны захирал нь Онгон байгалийн менежментийн хуулийн дагуу, хувийн секторын хөрөнгө оруулалтыг тусгай хамгаалалттай газрын дэд бүтэц, барилга байгууламж (зочид буудал г.м) барихад оролцуулахыг зөвшөөрч, санхүүгийн ашиг олох эрхээр хангагдсан байдаг. Зэрлэг онгон байгалийн жуулчлал нь дотоод гадаадын жуулчдыг татах гол боломж учраас түүнийг хөгжүүлэх нь Кенийн засгийн газрын тэргүүлэх зорилт юм. Энэхүү зорилтоо хэрэгжүүлэхийн тулд КОБЗ-ийн зүгээс ТХГ-т хувийн секторыг түлхүү оруулж зочид буудал болон бусад байгууламжийн багтаамжийг нэмэгдүүлснээр аялал жуулчлалын потенциалыг дээшлүүлэх' ба 'улсын ба хувийн түншлэлээр тусгай хамгаалалттай газрын зочид буудлуудад шаардлагатай байгаа дээд зэрэглэлийн өрөөнүүдийн тоог нэмэгдүүлэх' бодлого баримтлаж байна. КОБЗ-ны вэб хуудсанд, лоджууд (буюу бөх бат бүтэцтэй байр); эко лодж (байгаль орчинтойгоо зохицсон түр бүтэцтэй байр); өндөр зэрэглэлийн майхант кемпинг; коттеж (дотроо хоол хийх хэрэгслэлтэй); болон гадаа унтах (өндөрт байрлуулсан задгай ортой) кемп зэрэгт хөрөнгө оруулахыг уриалсан байна. Хөгжүүлэх шаардлагатай зарим тодорхой газруудыг ч зааж өгсөн байгаа юм. Байгуулах буудлын төрлүүдийн гол гол үзүүлэлтийг хөрөнгө оруулахаар сонирхогчдод зориулж зааж өгснөөс дурьдвал:

- ▶ барилга байгууламж байгуулахад тохиромжтой ТХГ, бүсийн төрөл
- ▶ зочдын орны тооны зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- ▶ тухайн газрын санал болгож буй хэсэг
- ▶ санал болгож буй түрээсийн болон сунгалтын хугацаа
- ▶ санал болгож буй жилийн түрээсийн төлбөрийн хэмжээ.

Үйл ажиллагааны талаарх бусад нөхцөлд, үйлчилгээний байх ёстой стандарт; БОНУ-ний тайлан болон хог хаягдал устгах талаарх холбогдох журмын шаардлагад нийцэх; зэрлэг амьтан, ургамалын нөлөөллийн менежмент зэргийг оруулжээ. Бас, Кенийн засгийн газраас тавьж буй хөрөнгө оруулалтын тодорхой нөхцлүүд болон эрсдэлийн нөхцлүүдийг сайтар тооцож үзсэн дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад зарим урамшууллыг олгодог байна. Үүнд:

- ▶ зочид буудал, суудлын болон ачааны автомашин, компьютер ба бусад албан таслагааны төхөөрөмжүүдийн элэгдлийн хөнгөлөлтөөр дамжсан татварын урамшуулал
- ▶ алдагдлын төлбөрийг ирээдүйн татвар төлөх ашгаасаа нөхөхөөр хойшлуулах боломж
- ▶ үндсэн хөрөнгө оруулалтын барааг гаалийн татвараас чөлөөлөх

Дээр нь, Кенийн засгийн газраас хувийн өмчийг хураахгүй байх батлагаа гаргаж улс орныхоо хөрөнгө оруулалтын тогтвортой, тааламжтай байдлыг идэвхтэй сурталчилдаг байна. Мөн Дэлхийн банкны дэргэдэх Хөрөнгө оруулалтын олон талт батлагааны агентлагаар дамжуулан худалдааны бус эрсдлийн батлагааг ч гаргаж өгдөг.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Боломжтой түрээслэгчийг сонгон шалгаруулахдаа ил тод, урин дуудаж урамшуулсан маягаар, хүсэлт гаргагчдад түншлэлийн зарчмыг сайтар ойлгуулж дэмжиж явуулсан
- ▶ Шийдвэр гаргагч (засгийн газрын толгойлсон) болон гүйцэтгэгч (хувийн, ашгийн төлөө бус, засгийн газрын бус толгойлолттой) байгууллагуудын хандлагыг концесст ашигласан.
- ▶ Гүйцэтгэлийн стандартуудыг тогтоосон, тэдгээрийг хэрэгжүүлдэг, сайн гүйцэтгэлийг тодруулж үнэлдэг

Эх сурвалж: Кенийн онгон байгалийн захиргааны вэб хуудас, www.kws.org/tourism/investment_procedures.

Жишиг судалгаа 12. Концессийг орон нутгийн иргэдийн нөхөрлөлд шууд олгох нь Вэтланд Парк, Өмнөд Африк

Концессийн төрөл: Тээвэр, орчуулгын үйлчилгээ

Концесс эзэмшигч: Орон нутгийн хамтлагууд

Үр, ашиг: Засгийн газар ба орон нутгийн иргэдийн түншлэлийн үр дүнд аялагчдын үйлчилгээ ба дэд бүтэц, орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн байдал сайжирсан

Агуулга: Санта Лучиа нэртэй 80 хүний суудалтай, хоёр давхар, гүехэн усны катамаран завиар өдөрт гурван удаа 90 минутын аялалыг Сэнт. Лучиа голын адгаар хийдэг байна. Энэ нь Өмнөд Африкийн дэлхийн өвөөр зарлагдсан анхны газарт урсах голын адаг хэсгийн хосгүй үзэсгэлэнг зочдод үзүүлэх боломжийг өгдөг. Энэ завийг байгаль хамгаалах захиргаа (БХЗ)-нд зориулан 1993 онд 600 мянган рандын өртгөөр бүтээсэн бөгөөд тэр цагаас хойш цаг агаар муу юмуу засвар үйлчилгээ хийхээс бусдаар өдөр бүр тасралтгүй ашигласаар иржээ. Өртгөө нөхөх хугацаа нь маш богино, ердөө 9 сар байсан ба дахиад нэг ихэр завь барих асуудлыг ч нухацтай ярилцжээ. Гэвч орон нутгийн иргэд, хамтлагт боломжийг өгөхөөр шийдэж хэд хэдэн концессийг хувийн операторуудад уралдаант шалгаруулалтаар олгожээ. БХЗ энэхүү завин аялалын нэр алдрыг ашиглан завинд суухаар хүлээх талбай дээр гар урлалын бүтээгдэхүүний зах ажиллуулснаар орон нутгийн эмэгтэйчүүд өөрсдийн урласан зүйлээ борлуулах боломжтой болжээ. Хлуклуве-Умфолози паркт хэрэгжсэн энэхүү амжилттай төслийн үр дүнд саявтархан БХЗ дахин нэг ийм завийг Хлуклуве Дамд ашиглалтанд оруулсан байна. Орон нутгийн иргэдийг энэ ажилд хөтөч, үйлчлэгчээр авч сургаж ажилуулж байгаа юм.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Концессийг орон нутгийн хамтлагт шууд олгосон
- ▶ Агентлаг/захиргааны байгаль хамгаалах, тогтвортой байдлын, нийгэм, эдийн засгийн зорилтуудыг концессийн гэрээний нөхцөлд тусгасан
- ▶ Гар урлалын зах зээлийг нэмэгдүүлэх гэх мэт бусад боломжуудыг олгосноор орон нутгийн иргэдийн нийгэм, эдийн засгийн үр ашгийг дээшлүүсэн.

Эх сурвалж: Пол Ф.Ж. Ийгис, Стивен Ф МакКул ба Кристофер Д. Хейнес *Тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлал; Тусгай хамгаалалттай газрын оновчтой практикийн зааварчилгаа дугаар 8, Дэлхийн тусгай хамгаалалттай газрын комисс* Нэгдсэн үндэстний байгалийн хөтөлбөрт зориулж боловсруулав, Дэлхийн аялал жуулчлалын байгууллага ба Дэлхийн дархан цаазтай газрын холбоо. 2002) (*БХЗ-ны Алан Мартин, КваЗулу-Натал нараас ирүүлсэн*).

Жишиг судалгаа 13. Байгалийн баялаг ашиглах концессийг орон нутгийн иргэдэд олгосон нь

Зимбабве, Өмнөд Африк

Орон нутгийн иргэд байгаль хамгааллаас ашиг хүртэх байдлыг хангах талаар Зимбабве улс шинэлэг хандлага нэвтрүүлсэн байна. Африк хүмүүс бүх бичиг баримтыг нь боловсруулж менежментийг нь хэрэгжүүлсэн УИХОМХ (Уугуул Иргэдийн Нөхөрлөлийн Орчны Менежментийн Хөтөлбөр) 1980-д оны дундуур хэрэгжиж эхэлжээ. Энэ нь орон нутгийн иргэд онгон байгалийнхаа менежмент ба хяналтын талаарх шийдвэрийг өөрсдөө гаргах асуудалд урам зоригийг өгсөн юм. Хүмүүс байгалийн нөөц баялгаа ургамал, амьтан, хүмүүс - нийт экосистемд үр шимээ хүртээх байдлаар ашиглахад зориулагдсан болно. Орон нутгийн иргэд нутгийнхаа байгалийн нөөцийг ашиглан мөнгө байнга олж байх хууль ёсны замыг бас нээсэн байна. Үүний үр дүнд орон нутгийн хамтлагууд нутгийнхаа онгон байгалийн үнэ цэнг мэдэрч идэвхтэй хамгаалдаг болсон байна. Зарим хүнсний хомсдолтой газрын иргэдэд нутгийн хамтлагууд хүнс, цэвэр ус нийлүүлсэн ч тохиолдол гарчээ.

Ан агнуур, зэрлэг амьтны худалдаа, аялал жуулчлал зэрэг голлох үйл ажиллагаанаас нутгийн хамтлагууд нэмэлт орлого олж байна. УИХОМХ төсөлд оролцогч тосгон бүр (одоогоор 26 дүүргийг хамарсан) онгон байгалийн зөвлөлтэй бөгөөд эдгээр зөвлөлүүд нь ан амьтны тооллого хийх, хулгайн анчидтай тэмцэх, 'асуудалтай амьтны' талаар гарсан зөрчлийг шийдэх, сургалт явуулах зэргийг хариуцан ажилладаг ажээ. Скаутуудыг сургаж хулгайн анг зогсоох, онгон байгалийн менежмент хийхэд туслуулж байгаа юм. Ан агнуурын концессийг авах, онгон байгалийн тогтвортой байдлыг хангахын тулд орон нутгийн хамтлагууд зэрлэг ан амьтны тоо толгойг хянаж, тэдний амьдрах орчныг хамгаалж, хулгайн ан хийх болон газар тариалан эрхлэх зэргээр зүй бусаар ашиглахаас хамгаалж ажиллах хэрэгтэй болдог.

Жуулчны операторууд нь, агнасан ангийн талаарх нарийвчилсан мэдээлэл, тухайлбал хэмжээ, жин, зарим амьтны өөрийнх нь болон эвэр, соёоны урт зэргийг бүртгэж тэмдэглэл хөтлөх ёстой. Ингэснээр бага, залуу амьтныг агнахгүй байх, тэр төрлийн тоо толгой нь хорогдохгүй байхад ач холбогдолтой юм. Операторууд ийм тайлангаа Үндэсний паркийн департаментад гаргаж өгөхгүй бол нэмж ангийн зөвшөөрөл олгодоггүй байна. Мөн, нутгийн иргэд 'асуудалтай' хэмээх амьтан агнах зөвшөөрөл (эсвэл тийм концесс худалдахыг) хүсч болно.

Дүүргийн зөвлөл орлогыг хураан авч УИХОМХ хөтөлбөрт заасан зааврын дагуу хуваарилна. Тэнд зааснаар орлогын 80%-ийг нутгийн хамтлагуудад өгөх бөгөөд тэд өөрсдөө яаж зарцуулахаа хамтаараа шийднэ, үлдсэн 20%-ийг дүүргийн зөвлөл хөтөлбөрийн удирдлага менежментэд ашиглана гэжээ. Дүүргийн зөвлөл Үндэсний паркийн захиргаагаар дамжуулан засгийн газартаа тайлагнана. УИХОМХ-ийн 1993 онд 26 дүүрэгт хэрэгжүүлсэн том, жижиг төслөөс нийт 1.4 сая гаруй долларын орлого олжээ. Тааламжтай жилүүдэд, олсон орлогоо эмнэлэг сургууль барьж тоноглох, хашаа барих, худаг гаргах, зам тавих, хөтөчид хөлс төлөх, орон нутгийн спортын багаа санхүүжүүлэх гэх мэт нийтийн хэрэгцээнд зарцуулдаг байна. Харин тааламжгүй, гол төлөв гантай жилд бол нутгийн иргэдэд будаа гурил гэх мэт хүнсний зүйл худалдаж авах.

хэрэгцээнд шууд олгодог ажээ. 1989 оноос хойш 250 мянга гаруй Зимбабвечүүд УИХОМХ төслүүдэд оролцжээ.

Оновчтой практикийн шинж чанарууд:

- ▶ Концессийг орон нутгийн хамтлагт шууд олгосон
- ▶ Орон нутгийн иргэд орсон орлогоос шууд үр шим хүртэх
- ▶ Агентлаг/захиргааны байгаль хамгаалах, тогтвортой байдлын, нийгэм, эдийн засгийн зорилтуудыг концессийн гэрээний нөхцөлд тусгасан.

Эх сурвалж: Өмнөд Африкийн паркууд www.sanparks.org/ 2013

3 МОНГОЛ УЛСЫН ТХГН ДАХЬ КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Энэ бүлэгт Концессийг хэрэгжүүлж байгаа одоогийн арга барил болон энэ үйл ажиллагааны менежмент, батлах явцад оролцож буй олон байгууллагыг тодорхойлов.

Мөн эрхзүйн өнөөгийн байдал, концессийн стратегийг Монгол улсын ТХГН-т үр дүнтэй хэрэгжүүлэхэд нөлөөлж болох хүчин зүйлүүдийг дүгнэв.

3.1 Эрхзүйн зохицуулалт

ТХГН-ийн болон Газрын тухай хуулиуд нь ТХГН-ийн сүлжээнд төрөл бүрийн ашиглалтын хэлбэрийг зөвшөөрөх хуульзүйн үндэслэл болдог. Эдгээр хуулийг үндэслэн газар ашиглалтын болон аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогддог.

ТХГН-ийн тухай хуулийн 33-р зүйлд заахдаа:

“Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно” гэжээ.

ТХГН-ийн тухай хуулинд нөлөөлж болохуйц бусад хуулийг дурьдвал:

- › Үндсэн хууль
- › Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хууль
- › Байгаль хамгаалалын хууль
- › Амьтны тухай хууль
- › Ангийн хууль
- › Байгалийн ургамлын тухай хууль
- › ТХГН-ийн Орчны бүсийн хууль
- › Ойн хууль
- › Усны хууль
- › Газрын тухай хууль
- › Концессийн хууль
- › Аялал жуулчлалын хууль

Иргэн болон аж ахуйн нэгж нь ТХГН-ийн хамгаалтын захиргаа эсвэл хамгаалалтын захиргаа байгуулагдаагүй газарт харьяалах сум, дүргийн засаг даргад газар ашиглах тухай хүсэлтээ гаргана. Газрын тухай хуулийн дагуу холбогдох журмуудыг үндэслэн хүсэлт гаргахдаа газар ашиглалтын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, байршил болон газрын хэмжээг тодорхойлно.

ТХГН-ийн сүлжээний газруудын менежментэд бусад агентлагууд ч мөн оролцоно. Жишээ нь арван гурван байгалийн нөөц газар болон дурсгалт газрын менежментийг сум болон аймгийн засаг даргын тамгын газар хариуцдаг. Хавсралт 1 –д ТХГН-ийн сүлжээний газруудын менежментэд оролцдог олон байгууллагын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон.

ТХГН-ийн хамгаалалтын захиргаа эсвэл харьяалах засаг дарга нь төрийн захиргааны төв байгууллагад (БОНХЯ) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын гаргасан газар ашиглах тухай хүсэлтийг өөрийн саналын хамт хүргүүлэх шаардлагатай.

БОНХЯ нь хүсэлттэй холбоотой шийдвэрийг гарган газар ашиглах гэрчилгээг хүсэлт гаргагчид олгож хүсэлт гаргагч, сумын засаг дарга, хамгаалалтын захиргааны хооронд гурвалсан гэрээ хийдэг. Шаардлагатай тохиолдолд хамгаалалтын захиргааны дарга газар ашиглалтын гэрээг баталдаг.

Газар ашиглалтын гэрээ эзэмшигч нь холбогдох хамгаалалтын захиргааны зөвлөмжилсөн буюу үүрэг болгосоны дагуу байгалийн төрхийг сэргээх, хадгалах, хамгаалахад тодорхой хэмжээний хөрөнгийг хуваарилан зарцуулах үүрэгтэй. Гэрээнд тусгагдсан газар ашигласны хураамж нь Газар Ашигласны Хураамжийн тухай хуулинд заасан хэмжээтэй байна. Газар ашигласны хураамжийг олгогдсон газрын га-гаар тооцон ноогдуулах ба ТХГН-ийн дотор олгогдсон газар ашиглалтын хураамж нь бусад газрынхаас гурав дахин өндөр байхаар хуулинд заажээ. Сум бүр хураамжийн хэмжээг өөрөө тогтооно. *Байгалийн баялгийн хураамжаар дахин хөрөнгө оруулах тухай* хуулиар газар ашиглалтын хураамжийн 30%-ийг тухайн нөөцийг хамгаалахад зориулан үлдээхээр заажээ. Дөрвөн ТХГН-ийн хамгаалалтын захиргаа холбогдох сумтайгаа газар ашиглалтын хураамжийн орлогоос дээрх хэмжээний хувийг авахаар тохиролцоонд хүрсэн байна.

Зөвшөөрөгдсөн газар ашиглалтын-Дархан цаазат газар болон Байгалийн Цогцолборт газар

ТХГН-ийн ангилал болон хамгаалалтын бүсээс хамааран зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа нь янз бүр байна. Хүснэг 4 ба 5-д үйл ажиллагаануудыг тоймлов.

Хүснэгт 4 Зөвшөөрөгдсөн ашиглалт – Дархан цаазат газрын бүсүүдэд

Дархан цаазат газар	Онгон бүс	Хамгаалалтын бүс	Хязгаарлалтын бүс
	<ul style="list-style-type: none"> ▶ Байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах шаардлагад нийцүүлж хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх ▶ Судалгаа, шинжилгээний ажил явуулах 	<ul style="list-style-type: none"> ▶ Хамгаалалтын бүсэд ургамал, амьтны аймгийн өсч үржих нөхцөлийг хангах, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> ▶ хөрс, ургамлын бүрхэвчийг нөхөн сэргээх; ▶ ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх; ▶ ан амьтны тооллого, тэдгээрийн тоо, нас, хүйс, сүргийн бүтцийг зохицуулах үйл ажиллагааг батлагдсан хөтөлбөр, аргачлалын дагуу явуулах; ▶ рашаан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг ашиглах; ▶ байгалийн аялал, жуулчлалын үйл ажиллагаа; ▶ түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах; ▶ зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиол бүтээл туурвихад ашиглах; ▶ уул, овоо тахих, уламжлалт зан үйлийн бусад ёслол үйлдэх; ▶ нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг зохих журмын дагуу түүж ашиглах

Хүснэгт 5 Зөвшөөрөгдсөн ашиглалт – Байгалийн цогцолбор газрын бүсүүдэд

Баягалийн цогцолборт газар	Онцгой бүс	Аялал жуулчлалын бүс	Хязгаарлалтын бүс
	<ul style="list-style-type: none"> ▶ Байгалийн унаган төрхийг нь хадгалах шаардлагад нийцүүлэн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авна. 	<ul style="list-style-type: none"> ▶ Аялал, жуулчлалын бүсэд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгээр дараахь үйл ажиллагаа явуулж болно: ▶ зөвшөөрөгдсөн газар загас барих болон дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд зөвшөөрөгддөг үйл ажиллагаа. 	<ul style="list-style-type: none"> ▶ Хязгаарлалтын бүсэд дараахь үйл ажиллагаа явуулж болно: ▶ хүснэгтэнд орсон дархан цаазат газрын хязгаарлалтын бүс болон байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүсэд зөвшөөрөгддөг үйл ажиллагаа; ▶ уламжлалт аргаар мал аж ахуй эрхлэх; ▶ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих; ▶ батлагдсан зураг төсөл, зохих журмын дагуу зам тавих, тээврийн хэрэгслийн зогсоол гаргах; ▶ биеийн тамир, нийтийн арга хэмжээнд шаардагдах талбайг засч тохижуулах; ▶ тухайн нутаг дэвсгэр дэх сууринг экологийн магадлан шинжилгээ хийж баталсан ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх.

Байгалийн нөөц газарт зөвшөөрөгддөг ашиглалтууд

Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэж болно.

ТХГН-ийн тухай хуулиар байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно

Дурсгалт газарт зөвшөөрөгддөг ашиглалтууд

Дурсгалт газар хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулан өгөх зэргээр хамгаалалтын арга хэмжээ авна. Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0,1-3,0 км-ийн рчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуиц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Санал

ТХГН-ийн тухай хууль ашиглалтын олон боломжийг (арилжааны болон арилжааны бус) олгодог. Концессийн стратегитай шууд хамаатай байж болох хувийн ашиг олохуиц үйл ажиллагаанууд тусгагдсан (Хүснэгт 1-д хамаатай). БОНХЯ(ТХГН-ийн хамгаалалтын захиргааны зорилготой нийцсэн концессийн системийг боловсруулан эдгээр ашиглалтыг хангалттай зөв зохион байгуулах шаардлагатай.

Газрын тухай хуулиар ТХГН-ийн дотор явагдах ашиглалт, үйл ажиллагааны (арилжааны болон арилжааны бус) зөвшөөрөгдсөн олон төрлийг заасан.

Эдгээр ашиглалтыг зохицуулах хууль эрхзүйн одоогийн хүрээ нь (Газрын тухай хууль) газар ашиглалтын зарим хэлбэрт тохиромжтой хэдийч ТХГН-ийн тухай хуулиар зөвшөөрөгдсөн бүхий л үйл ажиллагаанд төдийлөн таарахгүй болно. Эдгээр нь ТХГН-ийн нөөцийг шууд ашиглах ашиглалт болон үйл ажиллагаанд хамгийн тохиромжтой ч дэлхийн бусад орнуудын ТХГН-т элбэг тохиолддог аялал жуулчлал ба тээврийн үйлчилгээ, уламжлалт гар урлалын зүйлийн худалдаа, мэдээллийн үйлчилгээ, боловсрол, зугаалга, адал явдлын үйл ажиллагаа зэргийг эрхлэх аж ахуйн нэгжид хамаатай эсэх нь тодорхойгүй. Эдгээр үйл ажиллагааны талаарх бодлого, зохицуулалтыг тодорхой байлгах нь чухал. ТХГН-ийн хамгаалал болон одоогийн явагдаж буй менежментэд орон нутгийн бүлгүүд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд концессийн стратегид энэ үүргийг хүлээн зөвшөөрч уламжлалт ашиглалтыг оруулан бүх үйлчилгээг тусгасан бизнесийн загварын нэг хэсэг нь байх шаардлагатай.

Газар ашиглалтын хүсэлт гаргах ба ба шийдвэр гаргах зөвшөөрөл

ТХГН-ийн хуулийн 35-р зүйлд хүсэлт гаргагч нь Газрын тухай хуулийн газар ашиглах зөвшөөрөл хүсэх тухай журмыг баримтлан ТХГН-т газар ашиглах тухай хүсэлтээ гаргахаар заасан. Мөн хүсэлт гаргагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаа буюу хамгаалалтын захиргаа байгуулаагүй тусгай хамгаалалттай газар нутагт сум, дүүргийн Засаг даргад гаргана хэмээжээ. Мөн хамгаалалтын захиргаа буюу Засаг дарга нь газар ашиглах тухай иргэн, аж ахуйн нэгж,

байгууллагын хүсэлт болон түүний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад буюу өнөөгийн тохиолдолд БОНХЯ-нд уламжилна.

ТХГН-ийн тухай хуулийн 36-р зүйлд төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргах эрхтэй тухай заажээ. Хуулийн 30-р зүйлд хамгаалалтын захиргаа нь тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих эрхтэй тухай мөн 37-р зүйлд Сум, дүүргийн Засаг дарга төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг өөрөө буюу хамгаалалтын захиргаатай хамтран байгуулах тухай заажээ.

Газар ашиглах тухай гэрээнд Газрын тухай хуулинд зааснаас гадна дараахь зүйлийг тусгахаар заасан. Үүнд:

- ▶ тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгө;
- ▶ газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа;
- ▶ газрыг ашиглах, хамгаалах талаарх талуудын эрх, үүрэг, хариуцлага;
- ▶ гэрээ дуусгавар болсон тохиолдолд газрыг эргүүлж авах нөхцөл, журам, уг газрыг нөхөн сэргээх, засаж тохижуулах, хүлээлгэн өгөх журам.

Яаманд бүртгэгдсэнээр Монгол улсын хэмжээнд аялал жуулчлалын 202 байгууллага ажил үйлчилгээ явуулах эрхтэй болох нь харагддаг. Гэхдээ бодит зөвшөөрлийн тоо 800-д дөхөх буюу Богд хан уулын дархан цаазат газар болон бусад боломжтой байршилүүдэд хаус, байшин барих 300 орчим зөвшөөрлийг олгосон байдаг. Газар ашиглалтын зөвшөөрөл олгох одоогийн хууль эрхзүйн хүрээний гадуур олон тооны зөвшөөрөл олгогдсон болохыг энэ тоо харуулж буй.

Санал

ТХГН-т газар ашиглах тухай хувь иргэний хүсэлтийг зөвшөөрөх одоогийн үйл явц нь зөрчилтэй. Засгийн газраас ТХГН-ийн дотор болон орчны бүсэд концессийг хянах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг чиглүүлэх боломж, бололцоо одоогоор алга. Монгол улсын ТХГН-т концессийн гүйцэтгэх үүргийг тодорхойлсон зорилтыг тодорхой болгох шаардлагатай. Зорилт нь хүсэлт гаргагч, төрийн албан хаагчид ба ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажилтнуудын аль алинд нь хэрэгтэй. Монгол улсын ТХГН-т Концессийг хэрэгжүүлэх удирдамж болсон зорилтгүй байх нь менежерүүд шийдвэр гаргахад хүндрэлтэй байдал үүсгэхээс гадна боломжит хөрөнгө оруулагчдад тодорхойгүй бус байдал үүсгэнэ.

Иймэрхүү стратеги байхгүй тохиолдолд ТХГН-ийн менежментийн төлөвлөгөө болон орон нутгийн захиргааны газар ашиглах төлөвлөлтийн баримт бичгүүд нь хамгаалалтын захиргаа болон сумын менежерүүдийг чиглүүлэхэд чухал үүрэгтэйгээс гадна хүсэлт гаргагчдад ч мөн зарим туслалцаа үзүүлэх боломжтой болохыг тэмдэглэж байна.

ТХГН-ийн хамгаалалтын захиргааны ажилтнууд нь газар ашиглалтын талаар хүсэлт гаргагчтай холбоотой асуудлаар сум, дүүргийн засаг даргатай аль болох хамтран ажиллах шаардлагатай гэж ойлгогдсон. Энэ харилцаа нь ТХГН болон орчны бүсэд явагдаж байгаа концессийг хэрэгжүүлэхэд чухал болно. ТХГН-ийн сүлжээний дотор болон гадна талд газар зохион байгуулах тухай хийгдэж байгаа яриа хэлэлцээ нь концессийн үр дүнтэй стратегийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх болно.

ТХГН-т газар ашиглах эцсийн шийдвэрийг төрийн төв байгууллага гаргадаг нь зарим тохиолдолд зөв байдаг ч бүх тохиолдолд зөв байж чаддаггүй. Шаталсан арга буюу жижиг газар ашиглалтын хүсэлтийг хамгаалалтын захиргаа эсвэл сумын ЗДТГ шийдвэрлэхээр эрх шилжүүлж тохирох зөвлөмж, хяналтыг бий болгоход анхаарах нь зүйтэй. Нийгэм, эдийн засгийн дорвитой өгөөж өгөхүйц, байгаль орчинд нөлөөлөх байдал ихтэй болон бусад босго шалгуурт хамрах газар ашиглалтын хүсэлтийг төрийн төв байгууллагад хандаж шийдвэрлүүлэх хэрэгтэй.

Газар ашиглалттай холбоотой зөвшөөрлийг олгох төрийн төв байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь хөрөнгө оруулагчид, орон нутгийн бүлэг, захиргаа ба хамгаалалтын захиргааны ажилтнуудад ойлгомжтой байх хэрэгтэй. Шийдвэр гаргах хүрээг орхигдуулан төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчдийн олгосон зөвшөөрөл нь ТХГН-ийн сүлжээний одоогийн хамгаалал болон концессийн стратегийн үр дүнгээс ухарсан хэрэг болно. Газар ашиглалтын гэрээнд байгаль орчны үйл ажиллагааны стандартууд, хураамж, үүрэг, хариуцлага, хяналт ба үнэлгээ, гэрээг шинэчлэх болон маргааныг зохицуулах асуудлыг тусгасан байх ёстой. ТХГН-т газар ашиглахад жишиг нөхцөл тавьдаг байх хэрэгтэй.

Газар ашиглах хүсэлт гаргах нь:

ТХГН-ийн тухай хуулинд (33-р зүйл) “Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно” гэж заасан.

Мөн “Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглох ба энэ заалт нь гадаад улсын болон олон улсын байгууллага тусгай хамгаалалттай газрын зохих бүсэд энэ хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд төслийн дагуу үйл ажиллагаа явуулахад хамаарахгүй” хэмээжээ.

Санал

ТХГН-т гадаадынханд газар ашиглуулахгүй байх хязгаарлалт нь зочдод үзүүлэх үйлчилгээ болон дэд бүтцийн төрөл, чанарт яаж нөлөөлөх тухай мөн хэрвээ энэ хязгаарлалтыг болиулж гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрөх тодорхой бодлого, зөвлөмжтэй болох тохиолдолд ямар өөрчлөлтүүд гарахыг ч мөн анхаарах шаардлагатай.

ТХГН-т газар ашиглан гадаадын тодорхой хөрөнгө оруулалттай аялал жуулчлалын ажиллагаа эрхлэх нь орон нутгийн бүлгүүдэд өргөн боломжийг олгож болзошгүй. Хуульд заагдсанаас харахад аялал жуулчлалын бизнесийг гадаадын хөрөнгө оруулалтаар явуулж болох эсэх нь тодорхойгүй байгаа тул хөрөнгө оруулагчид болон төрийн төлөөлөлүүдэд тодорхой зөвлөмж, заалт шаардлагатай болохыг тэмдэглэж байна.

Өрсөлдөөн

ТХГН-ийн тухай хуулинд “тухайн газрыг хоёр буюу түүнээс дээш этгээд ашиглах хүсэлт гаргавал газар ашиглалтын зориулалт, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, байгаль орчныг хамгаалах талаар авах арга хэмжээний зардал зэргийг харгалзан сонголт хийнэ” хэмээжээ. Харин “Аялал, жуулчлал эрхлэх зориулалтаар газар ашиглах тухай хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аялал, жуулчлалын үйл ажиллагаа явуулах материаллаг

баазыг олон улсын стандарт, түвшинд хүргэсэн байдлыг нь харгалзан сонголт хийнэ” гэж заасан.

Хуулинд “заасан шийдвэрт ашиглуулах газрын зориулалт, орших бүс, байршил, зааг, хэмжээ, дангаар буюу дундаа ашиглах талаар тодорхой заана” гэжээ. Мөн “газар ашиглуулахаас татгалзсан бол төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрт үүний шалтгаан, үндэслэлийг заана” гэсэн байдаг.

Санал

Газар ашиглах хүсэлт гаргагчийн хүсэлтийн зохицолтой байдлыг өөр нэгний хүсэлттэй харьцуулах шалгуур нь хангалттай тодорхой, нарийн бус. Жишээлбэл зарим тохиолдолд орон нутгийн бүлгүүдийн хувьд харгалзаж үзэх асуудал (аль хүсэлт гаргагч нь орон нутгийн бүлэгт илүү өгөөжөө өгөх вэ гэдэг ч юм уу) байдгийг анхаарах ёстой. Аялал жуулчлалын үйлчилгээний тухайд бол олон улсын стандарт, түвшинд хүрсэн байх шалгуур нь бодит бус юм. Харин газар ашиглалт/үйл ажиллагааны стандарт шалгуурыг тогтоож оруулах нь илүү үр дүнтэй буюу өрсөлдөж байгаа аж ахуйн нэгжүүд эдгээр шалгуурыг хэрхэн биелүүлж чадах талаараа өөрийгөө харуулах боломж бүрдүүлнэ.

Тухайн газар эсвэл үйлчилгээг хоёр буюу түүнээс дээш этгээд ашиглах хүсэлт гаргах үед дээрх шалгуур тогтоосон тохиолдолд үр өгөөжийг тооцох өрсөлдөөний журмаар хамгаалалтын захиргаа газар ашиглалтын гэрээ байгуулах тогтолцоо бүрдэнэ. Шийдвэр гаргалтын хүрээ тунгалаг байх шаардлага үүнд маш чухал.

Газар ашиглалтын хугацаа

ТХГН-ийн тухай хуулийн 34-р зүйлд “газар ашиглах тухай гэрээний хугацаа 5 жилээс илүүгүй байх бөгөөд уг гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна” гэжээ. Мөн “тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ашиглуулах газрын хэмжээг төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээний дотор хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг дарга тогтооно” гэж заажээ.

Санал

Концессийн гэрээний богино хугацаа, гэрээ шинэчлэх заалтын тодорхойгүй байдал, газар ашиглалттай холбоотой шийдвэр хойшилж гардаг зэрэг нь ТХГН болон бусад газарт аялал жуулчлалын хамтарсан үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчдын сонирхлыг бууруулдаг хүчин зүйл хэмээн олон баримтад тэмдэглэгджээ. Гэрээний хугацаа богино байх болон гэрээг шинэчлэх эрх дутагдалтай байх нь хөрөнгө оруулагчдад шинэ санаачлага хэрэгжүүлэх, сайжруулалт хийх санхүүжилт олоход хүндрэлийг үүсгэхээс гадна үйл ажиллагааны өндөр стандартыг мөрдөх ба засвар үйлчилгээнд шаардлагатай хөрөнгө оруулалтыг бууруулдаг. Хамгаалалтын захиргаа болон аж ахуйн нэгжид үүсэх эрсдэлийн түвшин, хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааран газар ашиглалтын гэрээний хугацаа янз бүр байх боломжийг эрэлхийлэх нь чухал.

Эрх бх үүрэг

ТХГН-ийн тухай хуулийн 38-р зүйлд “тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан эрх эдэлнэ” хэмээн заасан. Мөн “тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 45 дугаар зүйлд заасан үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ” гэжээ.

- тухайн газрын унаган төрхийг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

- ашиглахаар авсан газартаа тогтоосон замаар орж, гарах;
- хууль буюу гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, ашиглалтын зориулалтыг өөрчлөхөд хүрвэл холбогдох зураг төслөө төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах;
- газар ашиглах эрх дуусгавар болоход ашиглаж байсан газраа нөхөн сэргээх, засаж тохижуулан хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх.

Санал

ТХГН-т газар ашиглагчдийн хүлээх үүргийг хуулиар тодорхойлжээ. Эдгээр үүргийг концессийн гэрээнд мөн адил тусгах нь чухал. Хамгаалалтын захиргааны тогтвортой байдлын зорилготой нийцэх үйл ажиллагааны стандарт, концесс эзэмшигч эдгээр стандартыг гэрээний хугацааны туршид мөрдөх шаардлагуудыг нарийн тодорхойлох хэрэгтэй.

Газар ашиглах эрх дуусгавар болох, газрыг чөлөөлөх

ТХГН-ийн тухай хуулийн 40-р зүйлд “Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх дараахь тохиолдолд дуусгавар болно” гэжээ Үүнд :

- Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан үндэслэлээр,
- Тухайн Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн хамгаалалтын горимыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн,

Мөн хуулинд заахдаа “газар ашиглах эрх дуусгавар болоход иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглаж байсан газраа чөлөөлж энэ хуулийн 37 дугаар зүйлд заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол 90 хоногийн дотор тухайн газар нутгийн хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө” гэжээ.

Санал

Гэрээг дуусгавар болгох, цуцлах шаардлагууд нь ямарч концессийн гэрээний зайлшгүй чухал нэг хэсэг болдог. Энэ зүйлд газар эзэмшилтэй холбоогүй үйл ажиллагааг мөн хамаатуулж болохоор санал дэвшүүлж байна. Жишээ нь хэрвээ аялал жуулчлалын байгууллага нь тухайн газрыг байнга ашиглахгүй зөвхөн богино хугацаанд (аялалын баг гэх мэт) ашигладаг бол газар ашиглалтын гэрээг цуцалж болно.

Төлөх хураамж

Газрын төлбөрийн тухай Монгол улсын хуулиар бүхийл газар ашиглагч газрын хураамж төлөхөөр заагдсан. Газар ашиглалтын хураамж болон газрын төлбөрийн хэмжээ, хувийг га-гаар тооцоолж ноогдуулдаг зарчимтай. Орон нутгийн захиргаа эдгээр зарчмыг үндэслэн газрын төлбөрийн хэмжээг тогтоох үүрэгтэй.

Газрын төлбөрийн тухай хуулийн 7-р зүйлд зааснаар ТХГН-т газар ашиглах хураамж нь тариалангийн газар, хот, тосгон, бусад суурин газрынхаас гурав дахин өндөр тогтоохоор заажээ.

Энд хамаатай өөр нэг хууль бол Байгаль орчин ба Байгалийн нөөцийг нөхөн сэргээх тухай хууль болно. Энэ хуулиар байгалийн нөөцийг ашигласны хураамжийг байгаль орчин ба байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд ашиглах хувь, хэмжээг тодорхойлсон.

Нөөц ашигласны хураамж нь газрын хураамжийн орлого, ус болон рашаан ашигласны хураамжийн орлого, мод, түлээ бэлтгэсний хураамжийн орлого, ангийн нөөц ашигласны

төлбөр ба ан хийх, барих зөвшөөрлийн хураамжийн орлого, байгалийн ургамал ашигласны хураамжийн орлого зэргийн тодорхой хувиас бүрдэхээр нарийвчлан заасан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь байгаль орчныг хамгаалах болон байгалийн нөөцийг сэргээх, хураамжийн орлогоос олсон хөрөнгийг ашиглан төлөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах үүрэгтэй. Дөрвөн ТХГН-ийн хамгаалалтын захиргаа холбогдох сумтайгаа газар ашиглалтын хураамжийн орлогоос энэ хувийг авахаар тохиролцоонд хүрсэн байна.

Байгаль орчин хамгаалах болон байгалийн нөөцийг нөхөн сэргээх үйл ажиллагаанд жил бүр зарцуулах хураамжийн орлогын доод хэмжээг доорх байдлаар тооцжээ:

Байгалийн ургамал ашигласны хураамжийн орлого	30%
Ангийн нөөц ашигласны төлбөр	50%
Газрын хураамжийн орлого	30%
Мод, түлээ бэлтгэсний хураамжийн орлого	85%
Ус болон рашаан ашигласны хураамжийн орлого,	35%

Аялал жуулчлалын тухай Монгол улсын хуулийн 19-р зүйлд “дэд бүтцийг хөгжүүлэх, Монгол орныг гадаад, дотоодод сурталчлах, жуулчлалаас байгаль орчинд сөргөөр нөлөөлөх нөлөөллийг багасгах, түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах, байгаль, түүх, соёлын өвийг дэмжих, хамгаалахад шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор аялал жуулчлалын сан байгуулна. Аялал жуулчлалын сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ.

- 20.1.1. тухайн жилд улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- 20.1.2. гадаад, дотоодын иргэд, байгууллагын тусламж, хандив;
- 20.1.3. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр” хэмээжээ.

Энэ хуулиар аялал жуулчлал байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг зохицуулахад дэмжлэг үзүүлсэн байх агаад харин санг (хэрвээ байдаг бол) хэрхэн хувиарласан болон үндэсний аялал жуулчлалын 80 хувь нь явагддаг ТХГН-т хэдий хэмжээтэй нь хувиарлагдсан тухай асуудал тодорхой бус.

Санал

Газар ашиглалтын зөвшөөрөлтэй холбоотой хураамжууд нь Газар ашиглалтын хураамжийн тухай хуулийн дагуу төлөгддөг. Мөн хуулиар ТХГН дахь газар ашиглалтын хураамжийг өндөр тогтоож хамгаалалттай газрын үнэ цэнийг хүлээн зөвшөөрсөн байна. Ашиглаж буй газрын га-гын ханшаар хураамжийг тогтоодог буюу бусад оронд жилийн нийт борлуулалтын хэмжээний хувиар эсвэл түүнтэй төстэй системийг хэрэглэдэгээс өөр байна.

Орлогын эс үүсвэр болох тухайд хураамжийн өнөөгийн тогтолцоо нь үр ашиггүй буюу орлогын багахан хувь нь ТХГН-ын сүлжээнд эргэж ордог оос үр дүнтэй концесс байгуулах урамшуулал болж чаддаггүй. Хамгаалалтын захиргааны дарга нар ТХГН-т арилжааны болон уламжлалт ашиглалт явуулсан үйл ажиллагааны нөлөөллийн зохицуулалтын зардлыг тэнцвэржүүлэх зорилгоор орон нутгийн захиргаатай харилцан зөвшилцөж иргэн, аж ахуйн нэгжээс авах газрын хураамжийн хувь хэмжээг тогтоолгох шаардлагатай болдог.

Сум бүр газар ашиглалтын хураамжийг өөр өөр түвшинд тогтоодгоос хураамж нь ТХГН бүрт өөр байдаг. Жишээлбэл Хөгнө хаан жуулчны бааз гурван га газрын төлбөрт жил бүр 360000 төгрөг төлдөг. 202 жуулчны бааз нь ойролцоогоор 500 га талбайг эзэлдэг. Хэрвээ дээрх үйл ажиллагаа хэвшмэл бол газар ашиглалтын хураамжийн 30 хувийг тухайн газрын нөхөн сэргээлт, хамгаалалтанд ашиглах заалтын дагуу хамгаалалтын захиргаад 202 жуулчны баазаас 20 сая төгрөг авч болох нь. Эндээс үзэхэд хураамжийн өнөөгийн механизм нь үр дүнгүй болох нь харагдаж байна.

ТХГН-т явуулах концессийн хураамжийн шинэ зохицуулалттай болох шаардлагатай.

Энэ зохицуулалтын хүрээнд бүртгэлийн хураамж, жилийн хураамж эсвэл шаардлагатай түрээсийн хэмжээ мөн ийм хураамж, төлбөрөөс чөлөөлөх, хамруулах зэргийг шийдвэрлэнэ.

Шаардлагатай тохиолдолд орон нутгийн захиргаа болон бүлгүүдтэй хамтран орлого хуваах төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй. Эдгээр төлөвлөгөөнд хамгаалалттай газар болон орон нутгийн бүлгүүдэд ноогдох ашгийг зарцуулах нөхцөл болон хугацааг заах ёстой.

Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээний ажил явуулах байгууллага, түүний үүрэг

ТХГН-ийн тухай хуулийн 44-р зүйлд “Тусгай хамгаалалттай газар нутагт төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан байгууллага, гадаадын болон олон улсын эрдэм шинжилгээний байгууллага судалгаа, шинжилгээний ажлыг гэрээний үндсэн дээр явуулж болно” гэжээ. Тусгай хамгаалалттай газар нутагт судалгаа, шинжилгээ явуулах байгууллагын үүргийг доорх байдлаар тодорхойлжээ:

- ▶ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж, хамгаалалтын горимыг сахин биелүүлэх;
- ▶ судалгаа, шинжилгээний ажил явуулахдаа зохих зөвшөөрөл авах, хураамж төлөх;
- ▶ судалгаа, шинжилгээний ажлыг байгаль орчинд сөрөг нөлөөгүй аргаар гүйцэтгэх;
- ▶ судалгаа, шинжилгээний ажлын талаар хамгаалалтын захиргаа болон төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;
- ▶ судалгаа, шинжилгээний ажлын явцад байгаль орчинд хохирол учруулсан бол түүнийг нөхөн сэргээх арга хэмжээ авч тухайн газар нутгийг хамгаалалтын захиргаа буюу сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгөх.

Санал

Хууль ТХГН-т судалгаа, шинжилгээний ажил зохион байгуулах хангалттай үндэслэл бүрдүүлжээ. ТХГН-ийн эсвэл Газрын тухай хуулинд хангалттай тусгагдаж чадаагүй (өмнөх хэсгийг үзэх) газар ашиглалтын бусад хэлбэрт мөн иймэрхүү заалтыг оруулж өгөх шаардлагатай.

Хяналт ба тохиромжтой байдал

ТХГН-ийн тухай хуулийн 42-р зүйлд “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд мэргэжлийн хяналтын байгууллага, хамгаалалтын захиргаа, бүх шатны Засаг дарга эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина” гэж заасан.

Түүнчлэн “байгаль орчны хяналтын улсын байцаагчид тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, зөрчигчдөд эрх хэмжээнийхээ хүрээнд хариуцлага хүлээлгэнэ” гэжээ.

Мөн хуулийн 31-р зүйлд хамгаалалтын захиргааны хамгаалалт хариуцсан ажилтан болон байгаль хамгаалагч нь байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэгтэй байхаар заажээ.

Хуулинд зааснаар тусгай хамгаалалттай газар нутагт ажиллаж байгаа байгаль хамгаалагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тогтоожээ:

1. энэ хууль болон байгаль орчныг хамгаалах бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг таслан зогсоож, гэм буруутай этгээдэд зохих хариуцлага хүлээлгэх;

2. хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, шалгалт хийх;
3. хууль тогтоомж зөрчсөн сэжиг бүхий иргэний бичиг баримтыг шалгах, түр хураах, шаардлагатай гэж үзвэл унаа хөсөгт нь үзлэг хийх, зэвсэг хэрэгсэл, агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйлийг хураан авах;
4. хууль тогтоомж, хамгаалалтын горимыг зөрчиж байгаль орчинд сөрөг нөлөөлөх үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг түр зогсоох, тэдгээрт хугацаатай үүрэг, даалгавар өгөх, шаардлага тавих.

Санал

ТХГН-ийн тухай хуулийн хяналтын талаарх заалт нь хамгаалалттай газарт концессийг зохион байгуулах хууль эрхзүйн багтай үндэслэлийг тавьжээ. Хамгаалалттай газрын захиргааны эдгээр үйл ажиллагааг явуулах чадавхийг сайжруулах нь зайлшгүй чухал. Үйл ажиллагааны шалгуур ба концесс эзэмшигчийн байгаль орчны тайлангийн шаардлагыг тогтоох хүлээн зөвшөөрөгдсөн эсвэл хамгаалалтын захиргаа (ХЗ) баталгаажуулсан бизнес эрхлэгчид ба сайн үйл ажиллагааг урамшуулах зэрэг нь тохиромжтой байдлын таалрх чармайлтад туслах ашигтай арга болно.

3.2 Бусад асуудлууд

Хамгаалалттай газрын Мэдлэг ба Ухуулга сурталчилгаа

Монголчууд хамгаалалттай газрын ашиг тус, байгаль орчны тогтвортой байдал ба байгаль хамгаалахын ач холбогдолыг сайн ойлгож хүндэтгэлтэй ханддаг. Энэ нь тэдгээрийн сайн сайхан болон амьжиргаа нь байгаль орчин ба байгалийн нөөцийг хэрхэн тогтвортой ашиглахаас хамаардаг амьдралын уламжлалт хэв шинж ба боловсролтой холбоотой.

Концессийн системийг ажиллуулахад боловсрол, концесс эзэмшигчтэй тогтоосон харилцаа болон орон нутгийн бүлгийн дэмжлэг чухал. Үүнд хураамж төлөх, байгаль орчны болон менежментийн зөвшөөрлийн нөхцлийг баримтлах байдал, хамгаалалтын захиргааны менежментэд (алслагдсан газарт ХЗ-ны нэрийн өмнөөс нэвтрэх хураамж хураах болон бусад хамгаалалттай холбоотой үйл ажиллагаа) концесс эзэмшигч туслах хамтын ажиллагаа зэрэг орно.

Шийдвэр гаргалтын ил тод ба хариуцлагатай байдал

Концессийн менежментийн шинэчлэл нь хөгжлийн үндсэн зарчмууд болох хэт ядуурлыг бууруулах, Мянганы Хөгжлийн Зорилтыг хангах, сайн засаглалыг хөгжүүлэх ба төрийн байгууллагын санхүүгийн менежментийг ил тод болгох зэрэгт дэмжлэг болно.

Хөгжиж буй орнуудад концессийг зохион байгуулахдаа сайн засаглалын зарчмыг зөрчих нь түгээмэл ажиглагддаг. Үүний шалтгаан нь:

- Бодлого, зохицуулалтын орчин дутмаг
- Тогтолцооны үр дүн муутай, хэсэгчилсэн зохицуулалтууд нь доорх дутмаг байдалтай холбогдох
- Засгийн газар болон орон нутгийн захиргааны түвшинд үүрэг, үйл ажиллагаа тодорхой бус
- Олон оронд бие даасан аудит болон ил тод үйл ажиллагаанаас хүчтэй зайлсхийдэг яагаад гэвэл засгийн газрын болон орон нутгийн захиргааны ажилтнууд ба улс төрийн лидерүүдийн ашиг сонирхол явдаг.
- Концессийг хуваарьлах ба зохицуулах эрх мэдэлтэй холбоотой улс төрийн хөндлөнгийн оролцоо

- ▷ Концесстой холбоотой мэдээлэл дутмаг
- ▷ Статистикийн мэдээлэл, мэдээллийн үнэн бодит, байдал, концессийг судалсан байдал сул

Концессийг зохицуулалт сул засаглалтай байх нь бүх салбарт буюу эдийн засгийн хөгжил, байгаль орчин, улстөрийн хууль ёсны байдал ба хөгжлийн хамтын ажиллаанд маш хүчтэйгээр нөлөөлнө. Энэ нь ТХГН-ийн сүлжээний хамгаалалд мөн төрд өгөх орлого болон газар зохицуулалтанд шууд ба шууд бус хэлбэрээр нөлөөлнө. Төрийн сан ба өмчийг төрийн байгууллагад бус сонгогдсон цөөнхийн гарт шилжүүлэн өглөө гэсэн үг.

Цаашилбал энэ нь сайн засаглалын гол хүчин зүйл болох олон нийт засаглалыг барих ба засаглалын үйл ажиллагаанд итгэх итгэлийг шууд ганхуулна.

Байгууллагын чадавхи

Хамгаалалтын захиргааны менежментийн чадавх нь хангалтгүй орон тоо, захиргаа, санхүү, эдийн засаг ба менежментийн төлөвлөлтийн хангалттай мэдлэг байхгүй зэргээр хязгаарлагддаг. Бага цалин, чадавх дутагдалтай байх нь ажилтнууд тогтвор суурьшил муутай байх, байгууллагын мэдлэг алдагдах, дэвшил, өөрчлөлтийг батжуулахад хүндрэл учрах ба хуулийг хэрэгжүүлэхэд байгаль хамгаалагчдийн урамшил байхгүй болоход хүргэдэг.

Чадавх сул байх нь хамгаалалтын захиргаа болон харьяа яамны Сангийн яам болон бусад төрийн захиргааны төв байгууллагатай харьцаж концессийн стратегид шаардлагатай санхүүгийн болон эрхзүйн хүрээний шинэчлэл хийх чадамжид нөлөөлнө. Концессийн системийг хэрэгжүүлэх хамгаалалтын захиргааны чадамжид ч энэ нь мөн нөлөөлнө. Арилжааны бизнесийн нэгж байгуулах, ажилтнуудын сургалт ба концессийн менежментийн талаарх мэдлэгийг сайжруулах шаардлагатай.

Концессийн менежментийн стратеги дахь агуулгын хомсдол

Монгол улсын ТХГН-ийн Санхүүгийн Тогтвортой Байдлын Боломжууд (НҮБХХ 2011) тайланд хамгаалалттай газруудын менежментийн болон бизнес төлөвлөгөө цөөхөн байгааг дурьдаад эдгээрт “хамгаалалттай газрын системийн хэмжээнд тохиролцсон үйл ажиллагаа, үр дүн хомс” хэмээн тэмдэглэжээ. Үүнээс үзэхэд хамгаалал болон аялал жуулчлалын менежментийн тогтсон ойлголт байхгүй болох нь харагддаг.

ТХГН-ийн тухай хуулинд хамгаалалттай газрын ангилал бүрт болон тэдгээрийн дотоод бүсэд ямар хөгжил, үйл ажиллагаа явагдаж болохыг ерөнхийд нь чиглүүлдэг хэдийч менежмент болон бизнесийн төлөвлөгөөгүйгээр концессийн стратегийг нарийн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх болно.

Түүнчлэн концесст тавигдах менежментийн шаардлага, байршил, мөн чанарыг шийдэх болон үнэт зүйлийг хамгаалах, зочлон ирэгсдийн сэтгэл ханамж болон концесс эзэмшигчид тавигддаг үйл ажиллагааны стандарт зэргийг шийдвэрлэхэд хүндрэлтэй болно.

Улсын төсвийн байдал ба ХЗ-нд орлогыг нь буцаан олгох тухай

Монгол улсын төрийн төсвийг Сангийн Яам хариуцан зохицуулдагаас хамгаалалтын захиргаадад хуваарьлагдах үндсэн төсвийн хэмжээ болон тэдгээрийн олсон орлогоо буцааж авах боломж хамаардаг. Энэ нь эргээд хамгаалалтын захиргаадын менежментийн чадавхаа сайжруулах нөөц бүрдүүлэхэд мөн концессийн аливаа гэрээнээс олох ирээдүйн орлогыг хамгааллын менежментэд ашиглахад нь нөлөөлнө.

ТХГН-ийн тухай хуулинд хамгаалалттай газар доорх эс үүсвэрээс санхүүжихээр заажээ:

- ▶ улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт;
- ▶ аялал, жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээний орлого;
- ▶ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;
- ▶ тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийн учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого

Амьдрал дээр энэ нь *Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар* зохицуулагдаж Сангийн яам төрийн яамдад төсвийг нэгдсэн байдлаар хуваарьлаж (бусад олон оронд мөн түгээмэл) олсон бүхий л орлогыг төрийн санд төвлөрүүлэхийг шаарддаг.

Сангийн яам өнгөрсөн жилийн үйл ажиллагаа ба зардлыг тооцоолон тухайн жилийн төсвийн төлөвт үндэслэн газруудын санхүүжилтийг хуваарьладаг. Хамгаалалтын захиргааны төсөв нь БОНХЯ-ны нэгдсэн төсөвт орж тусгагдана. Хэрвээ яамны төсөвт илүүдэл гарах тохиолдолд зарим орлогыг ирэх санхүүгийн жилд тухайн орлогыг олсон газарт буцаах боломж онолын хувьд л бий. Гэсэн хэдийч сүүлийн жилүүдэд хамгаалалтын захиргаа орлогоо эргүүлж авсан тохиолдол гараагүй. Үүнээс гадна төлөвлөсөн орлогоос илүү оруулсан орлогыг зарцуулах эрх байдаггүйгээс хамгаалалтын захиргаад орлогоо нэмэгдүүлэх хөшүүрэггүй/сонирхолгүй байх нөхцлийг систем нь бүрдүүлдэг. Хэрэв хамгаалалтын захиргааны төсөвлөсөн орлого дутвал дараа жилийн зардлаасаа танаж нийт төсвийн алдагдлаа нөхөх шаардлагатай болдог.

4 ӨӨРЧЛӨЛТ ШААРДЛАГАТАЙ ТУХАЙ – ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ НӨХЦӨЛД КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТ

4.1 Өнөөгийн систем дэх хязгаарлах хүчин зүйлүүд болон бусад асуудлын товчоон

Энэ бүлэгт өнөөгийн систем дэх боломж болон хязгаарлах хүчин зүйлүүдийг тэмдэглэсэнээс гадна гол асуудлууд ба таарах арга замыг хураангуйлав

Концессийн стратегийг үр дүнтэй байлгахын тулд Монгол улсын хамгаалалттай газруудын сүлжээнд нөлөөлж байгаа хууль эрхзүй, бодлого, зохицуулалт болон тогтолцоог тодорхой болгох шаардлагатай. Байгууллагын хариуцлагыг тодорхой болгож бодлого, эрхзүйн хүрээний таатай нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй. Одоогийн тогтолцоонд доорх хэдэн сул тал байна: Үүнд:

- Хамгаалалттай газарт хамааралтай үйл ажиллагааны хүлээн зөвшөөрөгдөхүйц стандартын удирдамжгүй зохицуулалтын орчин
- Зөвшөөрөл олгох, хураамжийн хэмжээ тогтоох, хураах болон үйл ажиллагааг хянах засаглалын ээдрээтэй зохицуулалт
- Концессийн зохицуулалтын менежмент, хөгжил, ойлголтыг харах нэгдсэн, хэтийг харсан зохицуулалт хомс.
- Батлах явц дахь улс төрийн нөлөө
- Концессийн үр дүнтэй менежментийг хэрэгжүүлэх бизнесийн арга дутмаг
- Өнөөгийн тогтолцоо нь газар ашиглалтыг арилжааны үйл ажиллагаанд буюу газар авахад, олгоход чиглэгдэхээс газар авахгүй аялал жуулчлал эрхлэх эсвэл бусад үйл ажиллагаанд (аялал, замчлах) чиглэхгүй (эсвэл ашиглагдахгүй) байна. Нэмж хэлэхэд тогтолцоо нь эдгээр бусад арилжааны үйл ажиллагааны ая холбогдлийг олж үнэлэхгүй байна.
- Концессийн тогтолцооны хүрээнд хамгаалалттай газрын нутаг дэвсгэр дээр жуулчны байр сав, төхөөрөмж, аялал, замчлал, жижиглэнгийн худалдаа, сонирхлын агнуур болон аялал жуулчлалын бус үйл ажиллагаа болох холбоо харилцаа, бэлчээрлэлт, мод бэлтгэх, эрчим хүч үйлдвэрлэл, салхин тээрэм, зураг авах зэрэг олон төрлийн үйл ажиллагаа явагдаж болно.
- Өнөөгийн тогтолцоо нь ирээдүйг харсан гэхээсээ илүү одоогийн байдалд тулгуурласан байна. Концессийн үйл ажиллагааны сонгон шалгаруулалтын журам эсвэл хэтийг харсан төлөвлөлт байхгүй.
- Хүсэлт гаргагч нарыг урьж уриалсан, тодорхой нөхцөлтэй мөн ХЗ\БОНХЯ-нд дутагдаж байгаа хамтын ажиллагааны хэлбэрийн мөн чанарыг дэлгэн харуулсан боломжит концесс эзэмшигчдийг сонгох, ангилах үр дүнтэй журам мөн хомс.
- Концессийн хамтын ажиллагааны талаар нээлттэй, олон нийтэд танилцуулах, сурталчлах ажил хийгддэггүй
- Концессийн үйл ажиллагааны гэрээнд байгаль орчны үйл ажиллагааны стандартууд, хураамжууд, үүрэг ба хариуцлага эсвэл маргааныг шийдвэрлэх талаар тусгадаггүй буюу маш бага үр дүнгүй хязгаарыг тогтоодог.
- Концессийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд үргэлжлүүлэх хүсэлт эсвэл асуудлуудад цаг тухайд нь, үр дүнтэй хариу өгөх зөвлөмж, журам байдаггүй.
- Концессийн асуудалтай холбоотой шийдвэр гаргах бүтэц дутмаг.
- ХЗ\БОНХЯ-нд орон нутгийн бүлгийн чадвар, мэдлэг, үйлчилгээнээс ашиг хуримтлуулан эдгээрийг концессийн гэрээнд тусгах журам алга.
- Идэвхтэй хамтын ажиллагааг үнэлэх, хэмжих мөн хамтрагчидтай урт хугацаанд ажиллах хамтын зорилтыг урамшуулах журам дутмаг.

- Гэрээний нэгдсэн бүртгэл эсвэл концессийн системийг дэмжих мэдээллийн технологийн систем байхгүй.
- Хамгаалалтын захиргаанаас концессийг зохицуулах нөөц хангалтгүй
- Газар ашиглалтын төлбөрийг Газрын тухай хуулиар зохицуулдаг буюу Яам үүнд бага оролцдог эсвэл хяналт бүрэн байхгүй
- Гадаадын хөрөнгө оруулалтыг хориглосноор боломжит хөрөнгө оруулагчид хязгаарлагдсан.
- Олон хамгаалалттай газар менежментийн төлөвлөгөө байхгүйгээс концессийг хэрэгжүүлэх эсвэл эс хэрэгжүүлэх бүсийн тодорхой хил хязгаар тогтоогоогүй.
- Хураамж нь бизнесийн боломжийн жинхэнэ үнэ цэнэ эсвэл түүний байгаль орчинд нөлөөлөх боломжит нөлөөллийг тооцоогүй.
- Концессийн үйл ажиллагаанаас олох орлого нь хамгаалалтын захиргаанд буцаж орох эсэх нь баталгаагүй.

Хүснэгт 6-д олон улсын тэргүүн туршлагын жишиг стандарт, Монгол улс дахь концессийн системийн өнөөгийн байдал болон Концессийн стратегээс хүлээж буй хүсэмжит үр дүн зэргийг тодорхойлов.

Хүснэгт 6 Өнөөгийн ба Хүсэмжит үр дүн-Монгол улсын хамгаалалттай газрууд дахь концессийн менежмент

Тэргүүн туршлага	Өнөөгийн байдал	Хүсэмжит үр дүн
Концессийн системийг үр дүнтэй зохион байгуулах хамгаалалттай газрын агентлагын хууль эрхзүйн тодорхой эрх ба чадавх	Эрхзүйн үндэслэл нь бусад хууль тогтоомж болон шийдвэр гаргахад оролцох байгууллага зэрэгтэй холилдож бүдгэрсэн	Хамгаалалттай газар дахь концессийн хуулийн тодорхой үндэслэл Тодорхой бодлого зөвлөмж Ил тод шийдвэр гаргалт Агентлаг нь концессийн үр дүнтэй менежмент хэрэгжүүлэх чадавхтай болох
Концессийн системийн зорилго нь тодорхой байж хамгааллыг дэмжих, сайжруулахад анхнаасаа чиглэгдсэн байх	Концессийн зорилго тодорхой бус	Концессийн менежментийн системийн зорилго нь ажилтнууд, төрийн бусад агентлаг болон хүсэлт гаргагчдад тодорхой байх
Ирээдүйг харсан (төрийн тэргүүлэлтэй) одоогийн байдалд тулгуурласан (хувийн хэвшил\NFP\ ТББ тэргүүлсэн) аргыг концессийн зорилгод хүрэхийн тулд ашигладаг	Зөвхөн өнөөгийн нөхцөлийг тооцоолсон	Ирээдүйг харсан (төрийн тэргүүлэлтэй) одоогийн байдалд тулгуурласан (хувийн хэвшил\ NFP\ ТББ тэргүүлсэн) аргыг концессийн зорилгод хүрэхийн тулд ашиглах, урих, хөрөнгө оруулалтыг хянах
Хууль, бодлого, хамтын чиглэлд нийцсэн, орлого, зарлагыг тооцоолсон арилжааны үйл ажиллагааг чиглүүлэхэд стратегийн төлөвлөлт ашиглагддаг.	Хамгаалалттай газруудад шаардлагатай хөрөнгө оруулалтын түвшинг тодорхойлсон стратеги төлөвлөлт байхгүй	Монголын ТХГН-ийн сүлжээн дэх арилжааны\ТББ-ийн үйл ажиллагааны төрөл ба түвшинг тодорхойлж гаргах стратегийн төлөвлөгөө боловсрогдох
Агентлагууд нь орон нутгийн бүлэг , орон нутгийн болон бүсийн төрийн удирдах байгууллага, хувийн хэвшил болон ашгийн бус	Гол оролцогч талуудын хооронд зохистой харилцаа үүссэн	Аялал жуулчлал, боловсролын салбар болон бусад салбарыг оролцуулан харилцааг бэхжүүлэх, өргөжүүлэх.

Тэргүүн туршлага	Өнөөгийн байдал	Хүсэмжит үр дүн
байгууллага\ТББ тай концессийн үр дүнтэй гэрээ, хамтын ажиллагаа тогтоох эрүүл зөв харилцаатай байх		Орон нутгийн бүлэгтэй тогтоох харилцааг дэмжих ба концессийн менежментийн хүрээнд гол үүрэг гүйцэтгэх
Агентлагийн ажилтнууд, хувийн хэвшлийнхэн болон бусад талуудад шаардлагатай концессийг олгох, үнэлэх энгийн, ил тод аргазүйтэй байж зөв шийдвэр гаргалтын орчинтой байх	Хүсэлт гаргаж байгаа одоогийн үйл явж нь энгийн ч үнэлэх байдал тодорхойгүй. Шийдвэр гаргалт ил тод биш Хэвшсэн журамгүй - Үйл ажиллагааны стандарт байхгүй	Ажилтнууд болон талуудад зориулсан концессийг олгох, үнэлэх энгийн журам, үйл ажиллагааны стандарт бий болгох
Экологийн аялал жуулчлал, уламжлалт ашиглалт, судалгаа, зугаалга, харилцаа холбоо зэрэг ашиглалтын төрлүүдэд зориулсан концессийн олон төрлийн гэрээнүүд бэлэн байх	Ганцхан төрлийн гэрээ байдаг.	Монголын хамгаалалттай газруудын сүлжээнд хэрэглэгдэх төрөл бүрийн ашиглалтыг тусгасан концессийн энгийн ба цогц гэрээнүүд бэлэн байх
Эзэмшлийн уян хатан боломжууд болон гэрээний хугацаанд талуудын олсон орлого болон хөрөнгө оруулалтын хэмжээг тусгасан үнэлгээний журам болон орон нутгийн бүлэгт концессийг шууд олгох журамтай байх	Уян хатан байдал хязгаарлагдмал	Хөрөнгө оруулалтын хэмжээ болон ашиглалтын байдлыг тусгасан хураамж ба эзэмшлийн төрөл бүрийн боломжууд бий болгох
Концессийн гэрээний хугацаа болон нөхцөл нь агентлагийн хамгаалал, тогтвортой байдал, эдийн засаг, нийгмийн зорилтыг тусгах ба үйл ажиллагааны стандартыг тогтоож тогтвортой сахих	Концессийн гэрээний хугацаа болон нөхцөл нь агентлагийн зорилго, зорилтыг харгалздаггүй	Гэрээний хугацаа болон нөхцөл нь агентлагийн зорилго, зорилтыг тодорхой тусгадаг
Хэрэгжилт, зохицолтой байдал болон цуцлах тухай журамтай байх	Журмууд байдаг ч эдгээр нь хэр үр дүнтэй болох нь тодорхойгүй.	Хэрэгжүүлэх, нийцүүлэх ба цуцлах журамтай
Концессийн хууль эрхзүй, бодлого ба журмыг байнга төлөвлөгөөтэй хянаж байх журамтай байх	Төлөвлөгөөтэй хянаж байх журам байхгүй	Концессийн хууль эрхзүй, бодлого ба журмыг байнга төлөвлөгөөтэй хянаж байх журамтай болох
Концессийн цогц менежментийг төвлөрүүлсэн байх	Концессийн бүхийл шийдвэрийг одоогийн байдлаар төвлөрүүлсэн Бусдаар хариуцуулан гүйцэтгүүлдэггүй Мэдээллийн менежментийн систем бүрдүүлээгүй.	Гол концессийг төвлөрүүлж энгийн концессийг бүсийн захирлуудад даалган чанарын баталгааг хангуулах, агентлагийн хэмжээний стандартыг бий болгох

5 МОНГОЛ УЛСЫН ТХГН ДАХЬ КОНЦЕССИЙН СТРАТЕГИ

Алсын Хараа

Монголын ТХГН-ийн сүлжээ нь байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийг хөүүлэн дэмжиж сайжруулан орон нутгийн бүлгүүдэд мэдэгдэхүйц өгөөж өгөх ил тод, үр дүнтэй концессийн тогтолцоотой болно.

Зорилгууд:

Монгол улсын ТХГН-ийн Концессийн Стратеги нь:

- ▶ Байгаль хамгааллыг сурталчлах ба сайжруулах
- ▶ Ядуурлыг бууруулах болон ажлын байр бий болгох, тогтвортой хөгжлийг хөүүлэн дэмжих
- ▶ Хэт арилжааны хэлбэрт шилжих байдлыг хянах болон арилжааны чанартай үйл ажиллагаанд ажиглалт, хяналт хийх
- ▶ ТХГН-т зочлох зочдын үзэх зүйлийн чанарыг сайжруулах
- ▶ Амьжиргааны өөр эх үүсвэр бий болгох хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх иргэдийн чадвар, чадавхийн хөгжилд дэмжлэг үзүүлэх
- ▶ ТХГН-ийн зохистой менежментэд шаардлагатай Засгийн газар, орон нутгийн захиргааны эдийн засгийн орлогыг нэмэгдүүлэх.
- ▶ Концессийн үйл ажиллагааны ил тод, үр дүнтэй байдлыг сайжруулах болно.


Хүсэмжит Үр дүнгүүд:

- ▶ Монгол улсын ТХГН-т концесс хэрэгжүүлэх тодорхой эрхзүйн үндэс бүрдэх
- ▶ Засгийн газар ба үйлдвэрлэгч аль алин ашиглах бололцоотой концесс олгох, үнэлэх хялбар энгийн журамтай концессийн бодлого, удирдамж
- ▶ Засгийн газар үр дүнтэй концессийн менежмент хэрэгжүүлэх чадавхтай болж ил тод шийдвэр гаргах сайн засаглалтай болох
- ▶ Зорилгодоо хүрэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хянах, урих проактив (засгийн газар тэргүүлсэн) болон реактив (хувийн хэвшил/NFP/ТББ тэргүүлсэн) аргыг аль алиныг нь ашиглах
- ▶ Монгол улсын ТХГН-ийн сүлжээнд байгаа арилжааны\ТББ эрхэлдэг үйл ажиллагааны төрөл, түвшинг тодорхойлохуйц стратегийн төлөвлөгөө гарах
- ▶ Аялал жуулчлал, боловсрол зэрэг Монгол улсын ТХГН-уудад концессийн хамгийн сайн таарах боломжуудыг хэрэгжүүлэх салбарынхантай харилцаа тогтоох өргөжүүлэх
- ▶ Орон нутгийн бүлэгтэй хэрэгжүүлэх концессийг дэмжих ба нийгэм эдийн засгийн өгөөж мэдэгдэхүйц байх,
- ▶ Монгол улсын ТХГН-т оруулах хөрөнгө оруулалтын түвшин ба ашиглалтын зориулалт ямар байх талаар тусгасан энгийн ба цогц концессийн гэрээний төрлүүд бэлэн байх
- ▶ Концессийн гэрээний хугацаа ба нөхцөл нь агентлагийн зорилгыг тодорхой тусгасан байх
- ▶ Гэрээг цуцлах журам болон хуулийн хэрэгжилтийг хангах, мөрдөх боломжтой байх
- ▶ Концессийн талаарх хууль эрхзүй, бодлого ба дүрмүүдийг тогтсон хугацаанд нягтлан эргэж харах журамтай байх.

Коцессийн
Стратегийн
Алсын хараа,
Зорилго, Үндсэн
чиглэлүүд ба йл
ажиллагааг
танилцуулна.

5.1 Үндсэн чиглэл ба үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд

Монгол улсын ТХГН-т зориулсан концессийн үр дүнтэй стратегийг бий болгох чиглэлээр гурван үндсэн чиглэл ба үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсрууллаа. Чиглэл бүр нь өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй бөгөөд эдгээр нь ач холбогдлоор нь эрэмбэлж санал болгосон үйл ажиллагааны жагсаалт болон энэ стратегийг хэрэгжүүлэхийн тулд хийгдсэн гол үйл явцыг мөн тодорхойлон гаргасан. Тодорхой бөгөөд хэмжигдэхүйц хариуцлагууд нь үйл ажиллагаа нэг бүрийг хэрэгжүүлэх хариуцлагыг баталгаажуулна.



Үндсэн чиглэл 1 **Концессийн менежментийн бодлого, зохицуулалтыг бэхжүүлэх**

Хамгийн түрүүнд буюу хамгийн чухал ач холбогдолтой үйл ажиллагаа нь Монгол улсын ТХГН-т концесс зохион байгуулах зохицуулалт ба тогтолцооны үр дүнтэй суурь бүрдүүлж хөгжүүлэх явдал юм. Концесс олгогдсон газруудын хадгалалт, хамгаалалтыг баттай байлгахын тулд концесс эзэмшигчийн ажиллах байгаль орчин, санхүү ба нийгэм мөн хамтын хариуцлагын талаар бодлого эрхзүйн хүрээнд маш сайн тодорхойлсон байх шаардлагатай. Түүнчлэн концессийн удирдамжууд, тусгай гэрээнүүдэд ч дээрхийг тусгасан байх шаардлагатай. Цаашилбал гэрээтий биелэлтийг хянах мониторингийн хүчтэй нэгж байгуулах хэрэгтэй.

Үйл ажиллагаа 1.1 Концессийн менежментийн стратегийг баталж Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй холбох.

Концессийн менежментийн стратегит дэмжлэг олж улс төрийн хүчтэй хамгаалалттай болох нь чухал бөгөөд ил тод байдлыг сайжруулахын эсрэг ужгирсан сонирхлуудыг давж гарах мөн сайн засаглалд шаардагдах хэрэгцээтэй нөөцийг гаргахад чухал хэрэгтэй. Стратегийг амжилттай хэрэгжүүлэх талаар Байгаль Орчны болон Сангийн яам ба холбогдох бусад яам хоорондын сайд нарын түвшний хэлэлцээр хийгдсэнээр агентлаг хооронд хариуцлагын талаар аливаа давхардал гарахгүй байхыг баталгаажуулж тогтолцооны чадавх сайжирна

Үйл ажиллагаа 1.1-ийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх алхмуудыг Хүснэг 7-д харуулав.

Үйл ажиллагаа 1.2 ТХГН-ийн тухай хуулийг эргэн харж концессийн менежментийг төвд нь тавих

Хамгийн эхний үйл ажиллагаа нь хуулийг эргэн харж ТХГН-ийн тухай хуулийн төвд концессийн менежментийн асуудлыг оруулах. ХЗ ба Яам нь хамгаалалттай газарт концессийг хэрэгжүүлэх бүрэн эрх эдлэх ба менежментийн шийдвэр нь бизнесийн зохистой зарчимд үндэслэгдсэн байх шаардлагатай. Байгаль орчин, нийгэм ба бизнесийн төлөвлөлтийн хэрэгжилтийг лавтай хангах үүднээс ашиглагчид болон хамгаалалттай газрын менежерүүдийн холбогдох эрх, үүргийг тодорхой гаргасан байх шаардлагатай. Хуулинд ямар өөрчлөлт оруулах талаарх дэлгэрэнгүй мэдээлэл Х бүлэгт бий. Үйл ажиллагаа 1.2-ийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх алхмуудыг Хүснэг 7-д харуулав.

Үйл ажиллагаа 1.3 – Концессийн менежментийн тогтвортой байдлыг хангах бодлого, удирдамж бий болгох

Ашиглагчдийн үйл ажиллагаа, ашиглалтыг зохицуулах, тэдгээр нь нөөц ба талбарын менежментийн зорилготой нийцэлтэй байх, экологийн хувьд тогтвортой, соёлын хувьд зохистой ашиглалт байхыг баталгаажуулах зорилгоор бодлого, удирдамж гаргах шаардлагатай. Бодлого, удирдамжийн санал болгох агуулга 6-р бүлэгт бий. Үйл ажиллагаа 1.3-ийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх алхмуудыг Хүснэг 7-д харуулав.

Хүснэгт 7. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх I Концессийн менежментийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх I Концессийн менежментийн бодлого, зохицуулалтыг бэхжүүлэх		
Үйл ажиллагаа	Алхмууд	Ач холбогдол
1.1 Концессийн менежментийн стратегийг баталж Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй холбох.	<i>Холбогдох сайд нар, агентлагуудын дарга нар болон орон нутгийн удирдлагад стратегийг танилцуулж нэмэлт оруулах</i>	Яаралтай
	<i>Сайд ба улс төрийн дэмжлэг олох эсвэл концессийн стратеги йн гол хандивлагч-ялагчийг олох</i>	Яаралтай
	<i>ХЗ ба бусад төрийн холбогдох ажилтнуудад стратеги ба агуулга танилцуулах</i>	Яаралтай
	<i>Концессийн стратеги хэрэгжүүлэх төсөв тодорхойлох ба 2014/15 онд хэрэгжүүлэх бизнесийн кейс бэлтгэж нутгийн иргэд ба ХЗнд оруулж болох төсөв ба ашгыг таамаглан гаргах</i>	Яаралтай
1.2 ТХГН-ийн тухай хуулийг эргэн харж концессийн менежментийг төвд нь тавих	<i>Энэ стратегийн 5.1.1 ба 5.2.2 бүлэгт санал болгосны дагуу ТХГН-ийн тухай хуулинд (мөн бусад холбогдох хуулинд) оруулах нэмэлт өөрчлөлтийг бэлтгэх</i>	Өндөр
	<i>Концессийн ач холбогдлын талаар Сайд нар болон зөвлөхүүдэд сайн тайлбарлаж хууль эрхзүйн нааштай өөрчлөлтийг хийхийг баталгаажуулах</i>	Яаралтай
1.3 Концессийн менежментийн тогтвортой байдлыг хангах бодлого, удирдамж бий болгох	<i>5.2 дугаар бүлэгт санал болгосны дагуу үйлдвэрлэгчид, орон нутгийн бүлэг болон төрийн бусад агентлагтай хамтран зөвлөлдөж Концессийн Бодлогын ноорог бэлтгэх</i>	Өндөр
	<i>5.3 дугаар бүлэгт санал болгосны дагуу үйлдвэрлэгчид, орон нутгийн бүлэг болон төрийн бусад агентлагтай хамтран зөвлөлдөж Санал гаргагчид зориулсан Журам бэлтгэх</i>	Өндөр
	<i>5.4 дүгээр бүлэгт санал болгосны дагуу үйлдвэрлэгчид, орон нутгийн бүлэг болон төрийн бусад агентлагтай хамтран зөвлөлдөж Талбар сонгох Журам бэлтгэх</i>	Өндөр
	<i>5.5 дугаар бүлэгт санал болгосны дагуу үйлдвэрлэгчид, орон нутгийн бүлэг болон төрийн бусад агентлагтай хамтран зөвлөлдөж Концессийн Саналыг Үнэлэх Шалгуур гаргахад бэлтгэх</i>	Өндөр
	<i>5.7 дугаар бүлэгт санал болгосны дагуу том, дунд, жижиг хэмжээний Концесс байгуулах Гэрээний Загвар бэлтгэх</i>	Өндөр
	<i>Орхоны хөндий болон Их Нартын Байгалийн нөөц газарт хэрэгжүүлэх концессийн туршилтын бодлого, удирдамж, үнэлэх шалгуур ба загварын талаар үйлдвэрлэгчид болон төрийн байгууллагын санал авч тусгах шаардлагатай.</i>	Өндөр
	<i>Бодлого, зохицуулалтын хүрээг 2 жилийн дотор эргэн харж зорьсон зорилгод хүрэх ба хууль хэрэгжүүлэх журмын авцалдаа холбоог баталгаажуулах</i>	Дунд зэрэг

Үйл ажиллагаа 2.1 – Засаглалын үр дүнтэй ил тод зохицуулалтууд бий болгох

Концессийн менежментийн үр дүнтэй, тэгш эрхийг хангасан, хөтлөн явуулахад хялбар, хэрэгжихүйц тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай. Үндсэн чиглэлийн 1-д дурьдагдсан бодлого ба удирдамж бий болгох нь сайн засаглалын үндэс болно. Дараагийн алхмууд нь засаглал ба захиргааны зохицуулалтууд бий болгох, концессийн стратегийн зорилгод хүрэхэд шаардлагатай чадавхийг бүрдүүлэх явдал болно.

Концессийн Менежментийн Зохицуулалт

Агентлагын дотоод чадавх бүрдүүлэх ба концессийн менежментийн үр дүнг баталгаажуулахад концессийн менежментийн төвлөрсөн зохицуулалт шаардлагатай.

Санал гаргахаас эхлэн шийдвэр гаргалтын бүх шатанд кейс менежментийн аргыг (тухайлсан ажилтан эсвэл нэгж үйл явцыг хариуцаж ажиллаж байгаа тохиолдолд) хэрэглэх нь засгийн газар болон хөрөнгө оруулагчдад аль алинд нь үйл явцыг оновчтой болгоход дэмжлэг үзүүлнэ. Засгийн газрын хангалттай нөөц ба шаардлагатай тохиолдолд холбогдох агентлагуудын тохирсон туршлагатай ажилтнууд үйл явцад оролцох нь мөн чухал хэрэгтэй (Кейс Судалгаа 6-гаас Аялал жуулчлалын бизнес, Судалгаа ба Хөрөнгө Оруулалтын хэвшлийн үйл ажиллагааг үзэх: Алберта, Аялал жуулчлал, Хамгаалалттай газар ба Амралт зугаалгын яам).

Засгийн газрын зүгээс концессийг удирдан зохион байгуулах илүү үр дүн, зохицуулалттай байж хариуцах хариуцлагыг тодорхойлох нь үйлдвэрлэлд илүү тогтвортой байдал бүрдүүлнэ. Үүний хариуд хөрөнгө оруулалтын сонирхол татахуйц орчин бүрэлдэнэ. Ил тод байдал нь хувийн хэвшилд мөн ялгаагүй ашиг тусаа өгнө. Мэргэшсэн ажилтнуудаас бүрдсэн үнэнч баг нь доорх ажлыг хариуцан гүйцэтгэхээр тооцоолов.

Захиргааны асуудал

- ▶ Концессийн менежментийн ажиллагааны стандарт, ёсзүйн зарчим болон холбогдох талуудтай зөвлөлдөж гаргах концесс эзэмшигчид зориулсан удирдамж зэргийг бэлтгэх
- ▶ Концессийн менежменттэй холбоотой бодлого, үйл явц, удирдамж, стратеги зэргийг тогтмол хугацаанд эргэж харах, хяналт хийх
- ▶ Тухайн бүсийнхээ онцлогтой уялдан үйл ажиллагаа явагдах тул концессийн төрөл бүрийн үйл ажиллагаа, байршилд зориулан хэрэглэж болохуйц багц нөхцлүүдийг бэлтгэх, хэрэглэх. Хянан баталгааны хуваарь болон ёсзүйн дүрмийг боловсруулахад саналаа оруулах
- ▶ Концессийн үйл ажиллагааг бодлого, журмын дагуу удирдан зохион байгуулах
- ▶ Бодлого, журмын дагуу концессийн санал хүлээн авах ба боловсруулах
- ▶ Хээрийн судалгааны ажилтнууд, бусад хувийн хэвшил, болон төрийн байгууллагатай хүлээж авсан саналын тохирох ба боломжтой эсэхийг тодорхойлох талаар хамтран ажиллах. Концессийн загвар гэрээг загвар хугацаа, нөхцлийн (Х хавсралтын дагуу) дагуу бэлтгэх мөн шаардлагатай Тусгай нөхцөл ба Талбарын Онцгой нөхцлийг холбогдох бүс ба бүлэгтэй зөвлөлдөн гаргаж хавсаргах
- ▶ Үйл ажиллагааны мониторинг, гэрээний хэрэгжилтийн асуудлаар бүсүүдтэй харилцах
- ▶ Бүсүүдтэй хамтран концессийн байдлыг хянах- хүчинтэй ба хүлээгдэж байгаа саналууд, шинэчлэх/эргэж харах шаардлагатай концессууд, шийдэгдээгүй өр, гэрээний нөхцлийн дагуу байгаа эсэх зэргийг

- ▶ Ажилтнууд, боломжит ба одоо байгаа концесс эзэмшигчид ба гадаад хамтрагч талуудад ТХГН-ийн концессийн менежментийн талаар зөв мэдээллийг цагт нь өгч байх
- ▶ Сайд болон ХЗ-ны даргад бодлого ба техникийн зөвлөлгөө өгөх
- ▶ Бүсүүд болон бусад засгийн газрын агентлагуудад байгууллага доторх зөвлөх үйлчилгээ өгөх шаардлагатай тохиодолд шууд туслалцаа үзүүлэх

Концессийн боломжуудыг хөгжүүлэх нь

- ▶ Бүсүүдтэй хамтран концессийн шинэ боломжуудыг хайх, хөгжүүлэх
- ▶ Арилжааны зориулалтаар олгогдсон лицензийг тэндэр\ ЕОI-оор дамжуулан зохион байгуулах
- ▶ Өрсөлдөөний журмаар олгогдсон концессийг үнэлэх ажиллагааг зохион байгуулах,
- ▶ Амжилттай санал гаргагч/нарт өрсөлдөөний журмаар олгогдсон лицензийг хөгжүүлэх талаар ажил зохион байгуулах

Үйлчлүүлэгч, үйлдвэрлэгч болон сонирхсон бүлгүүдтэй холбоотой ажиллах

- ▶ боломжийн бизнес эрхлэгчидтэй холбоо тогтоох мөн үйлдвэрлэгчдийн уулзалтанд оролцож боломжийн бизнес эрхлэгчдэд танилцуулах илтгэл тавих
- ▶ аялал зохион байгуулагчид, сонирхол ихтэй бүлгүүдэд зориулсан үйлдвэрлэгчдийн уулзалт санаачлан зохион байгуулж шинэ системийг дэлгэн танилцуулах, зах зээлийн мэдээлэл ба гол асуудлуудтай холбоотой зөвлөгөө өгөх зэрэг дэмжлэг үзүүлэх
- ▶ концесс эзэмшигчдэд зориулсан мэдээллийн стратеги бэлтгэх, хэрэгжүүлэх
- ▶ концесс эзэмшигчдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нутгийн бүлгүүдтэй зөвлөлдөж хамааралтай хэсэгт нь соёлын талаар таниулга сургалт мөн явуулах

Мэдээллийн үйлчилгээ

- ▶ олон нийт, бизнес, концессийн лавлагаанд хариулт өгөх
- ▶ хүсэлтийн дагуу дотоод, гадаадын оролцогч талуудыг концесстой холбогдох мэдээллээр хангах
- ▶ зочлогсад, боломжит болон одоо байгаа концесс эзэмшигч нарт зориулсан үйлчлүүлэгчдийн мэдээлэл интернэтэд байршуулах
- ▶ Аялал жуулчлалын агентлагуудтай хамтран интернэтийн сүлжээгээр концессийн боломжуудыг сурталчлах, борлуулах

Системүүд

- ▶ Концессийн менежментийн системд зориулагдсан ашиглагчдийн менежерийн үүргийг тодорхойлох
- ▶ концессийн мэдээллийн сан бүрдүүлж мөн бусад холбогдох мэдээллийн хамт интернэтэд байршуулах
- ▶ концессоос олсон орлогын бүртгэл хөтлөх
- ▶ Сайд\Захиралд концессийн асуудлаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх
- ▶ Концессийн үйл ажиллагаатай холбоотой менежментийн жилийн тайлан бэлтгэх
- ▶ Бүсийн холбондох ажилтнуудыг арилжааны аялал зугаалга, аялал жуулчлалын бизнес эрхлэх лицензийн олгох зэрэгт сургах, дадлагажуулах,

Ил тод байдал

Хэрэв нөөцийг амжилттай удирдуулахыг хүсэж байгаа бол засгийн газар нь явуулж буй үйл ажиллагаагаа тайлагнах ёстой. Үүний тулд хамгаалалттай газарт хэрэгжүүлж байгаа концессийн талаарх мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох шаардлагатай. Гэхдээ дан ганц хэвлэсэн мэдээлэл нь хангалттай бус. Мэдээллийг олон нийтэд ямар мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн нь мөн адилхан чухал болно. Тийм учраас мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох нь ихэнх тохиолдолд ажиллагаа ихтэй, хүнд сурталтай үйл явц байдгийг харгалзан засгийн газрын чадавхид өргөн хүрээнд ашигаа өгөх ил тод байдлын санаачлагын нэг хэсэг болгон өргөн хэмжээний өөрчлөлт, бодлогуудыг нэвтрүүлэх хэрэгтэй.

Цаашилбал авилга, буруу хуваарьлалт нь сүлжээний ил тод хэсгээс сул хэсэг рүүгээ шилжих тохиолдол гарч болзошгүй учраас ил тод байдлыг шийдвэр гаргалтын сүлжээний бүхийл шатанд (концесс хэрэгжүүлэх шийдвэр гарахаас эхлэн) системтэйгээр ашиглах хэрэгтэй. Сайн засаглал ба ил тод байдлыг бий болгох анхны чухал алхмуудын нэг нь мэдээллийн систем болно. Хэрэг дээрээ энэ нь ил тод байдлын доод түвшинд анхлан хийгдэх алхам тул шинэчлэлтээс ихээхэн үр дүн гарна хэмээн найдаж болно.

Мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй болох төдийгүй төрийн олон газруудын хооронд мэдээлэл шалгах, тал талаас нь нягтлах боломж бүрдүүлэх зохицуулалтыг хийснээр цаашилбал төрийн бодлогын үр дүнтэй байдал сайжирхад нөлөөлнө. Хамгаалалттай газарт хэрэгжих томоохон концессийн талаарх шийдвэрийг хянах бие даасан гуравдагч талыг томилох аргыг зарим хууль эрхзүйд ашиглаж бие даасан үнэлгээ явуулж олон нийтийн хариуцлага тооцолтыг нягтлуулдаг. Зарим газарт хяналтын аудиторыг бие даасан үнэлгээ хийлгэх буюу явуулсан үйл ажиллагаа нь хуулийн шаардлага, ёс зүйн дүрэм, журам, бодлого ба зөвлөмжийн дагуу явсан эсэхийг хянах, нууц хадгалах журам ба сонирхлын зөрчлийг арилгах, ил тод, хариуцлагатай мөн мөнгөний үнэ цэнэ зэргийг мөрдсөн эсэхийг хянахын тулд томилж ажиллуулдаг.

Үйл ажиллагаа 2.1-ийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх алхмуудыг Хүснэг 8-д харуулав.

Үйл ажиллагаа 2.2 – Засгийн газрын болон бүлгийн дотоод чадавх бүрдүүлэх

Уламжлалаараа хамгаалал, газар ба байгалийн нөөцийн менежментийн чиглэлийн ажилтнуудтай хамгаалалттай газрууд болон бусад газрын менежментийн агентлагуудад аялал жуулчлалын чиглэлийн туршлага, мэргэжлийн чадвартай ажилтан ихээр дутагдалтай байж болно. Тийм учраас хөрөнгө оруулагчдад зориулсан боломжуудын тухай мэдээ боловсруулах үед болон концессийн саналуудыг үнэлэх үед тэдгээрт тавигдах арилжааны шаардлагын талаарх ойлголт хязгаарлагдмал байсан байж болзошгүй. Концессийн менежментийн сургалт, чанарын баталгаа, албан хаагчид ба бүлгийн бизнес хөгжил, үйлдвэрлэлийн “өмчилсөн” стандарттай болох, үйлчилгээний чанарыг анхаарах зэрэгт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь үр дүнтэй систем бүрэлдэхэд нэн чухал. Бүлгүүдийн зөвлөлдөх бүлгийг байгуулах нь Монгол улсын ТХГН-т концессийн менежмент ба хөгжил тууштай явагдахад дэмжлэг болно. Ажилтнуудыг аялал жуулчлал эрхлэгчид, орон нутгийн захиргаа ба бүлгүүдтэй ойлголцож, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь концессийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь дэмжлэг болно. Үүнийг доорх байдлаар шийдвэрлэж болно:

- ▶ Тогтвортой ашиглалт ба үнэт зүйлсийг хамгаалахад концессийн оруулах хувь нэмрийг засгийн газрын бодлогод тусгах
- ▶ Нарийн ур чадвар ба аялал жуулчлалыг дэмжих үүрэгтэй ажилтнууд (кейс судалгаа 6-г үзэх: Алберта, Аялал жуулчлал, Хамгаалалттай газар ба Амралт зугаалгын яам)
- ▶ Хамгаалалттай газрын менежментэд концессийн оруулах хувь нэмрийг ойлгож дэмжих чиглэлийн ажилтнуудыг сургах
- ▶ Аялал жуулчлалын болон орон нутгийн захиргаатай хамтын ажиллагаа тогтоох (бусад газруудад хамгаалалттай газрын агентлаг нь засгийн газрын аялал жуулчлалын агентлагтай хамтран талбар\ газрын тохиромжтой эсэх эхний үнэлгээ болон сонгон шалгаруулалт явуулдаг нь харагдсан)
- ▶ Шаардлагатай тохиолдолд арилжааны мэргэжлийн туслалцаа авах (жишээ нь талбар сонгох, санал үнэлэхтэй холбоотой мөн эзэмших эрхийн хугацаа ба нөхцлийг тохиролцох талаар зөвлөгөө)
- ▶ Хамгаалалттай газрын менежмент болон мониторингийн зорилгод бизнесийн оруулж буй хувь нэмрийг үнэлэх үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт тогтоох

Хамгаалалттай газрын агентлагууд, аялал жуулчлалын байгууллагууд, орон нутгийн захиргаа, эдийн засгийн хөгжлийн байгууллагууд болон бүлгүүд хамгаалалттай газар дахь концесстэй холбоотой асуудлаар ойр холбоотой ажиллах нь хөрөнгө оруулалтыг татах уур амьсгал бүрдүүлэх, орон нутаг\бүс\үндэсний хэмжээнд аялал жуулчлалын стратеги ба

санаачлагыг удирдан зохицуулахад дэмжлэг болж чадна. Энэ нь мөн бүлэг \агентлаг хоорондын харилцааг сайжруулж мөн тогтвортой аялал жуулчлалын асуудлуудыг ойлгоход болон бүлгийн санаа зовоосон асуудал, эсэргүүцэлээс шалтгаалан ажил хойшлогдох магадлалыг бууруулахад тусаа өгөх болно.

Үйл ажиллагаа 2.2-ийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх алхмуудыг Хүснэг 8-д харуулав.

Хүснэгт 8. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 2 Тогтолцоо ба бүлгийн хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх

Үндсэн чиглэл 2. Тогтолцоо ба бүлгийн хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх		
Үйл ажиллагаа	Алхмууд	Ач холбогдол
2.1 Засаглалын үр дүнтэй ил тод зохицуулалтууд бий болгох	<i>Концессийн бодлогын хэрэгжилт, хөгжилт, удирдамж мөн батлах ажиллагааг хариуцсан мэргэжлийн ажилтнуудтай концессийн менежментийн нэгжийг БОНХЯ\ХЗ-нд байгуулах</i>	Өндөр
	<i>Концессийн менежментийн стратегийн хэрэгжилтэнд хангалттай хөрөнгө хуваарьлагдсан байхыг баталгаажуулах</i>	Өндөр
	<i>Хариуцлага иж бүрэн цуваа тогтолцоо бүрдүүлэх: бүсийн захирлуудад хариуцуулсан эрхүүд, жишиг үйл ажиллагаа, санхүүгийн хяналт, сонирхлын зөрчлийн тухай дүрмүүд зэргийг оруулан</i>	Өндөр
	<i>Эдгээрийн засгийн газрын авилгын эсрэг бодлоготой уялдуулж боловсруулах .</i>	Дунд зэрэг
	<i>Концессийн зөвлөлдөх бүлгийг гол хамгаалалттай газрууд орших бүсүүдийн үйлдвэрлэл, орон нутгийн захиргаа ба бүлгийн төлөөллийг оруулан байгуулах</i>	Өндөр
	<i>Бүлгийн гүйцэтгэх гол үүрэг нь концессийн стратеги төлөвлөгөө ба концессийн менежментийг батлах үйл ажиллагааг ХЗ\БОНХЯ хэрхэн явуулж буйг хянах болно</i>	Дунд зэрэг
	<i>Санхүүгийн менежментийн үйл явцын ил тод байдлыг бүрдүүлж концессийг үнэлэх, орлогыг ил тод байлгах ба тайлагнах зэргийг тусган оруулах</i>	Өндөр
	<i>Засаглалын нэмэлт дэмжлэг хүсэх: авилгатай тэмцэх газраас мэргэжлийн концессийн менежментийн ажилтнуудад дэмжлэг үзүүлж эрх мэдэлтний ба засгийн газар дахь хувийн ашиг сонирхлын бүлгийн дарамтаас хамгаалах.</i>	Дунд зэрэг
	<i>Хамгаалалттай газар дахь концессийн менежментийн талаар веб хуудас нээж концессийн менежментийн бодлого, үйл ажиллагааг үйлдвэрлэгчид ба бүлэгт мэдээлэх</i>	Дунд зэрэг
2.2 Засгийн газрын болон бүлгийн дотоод чадавх бүрдүүлэх	<i>Орон нутгийн захиргаа, бүлэгт стратегийг танилцуулан тэдний саналыг тусгах</i>	Өндөр
	<i>Концессийг зохицуулахад оролцогч засгийн газрын байгууллагууд, ХЗ-ны ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх стратеги ба тусгай сургалтын хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх</i>	Өндөр
	<i>Зөвлөлдөх бүлгийн хурлын хөтөлбөрийг гаргаж концессийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, орон нутгийн бүлэгт санал болгох концессийн боломжуудыг хэлэлцэх ба концессийн менежментийг батлах үйл ажиллагааг ХЗ\БОНХЯ хэрхэн явуулж буйг хянах</i>	Өндөр
	<i>Бодлого ба удирдамж бэлэн болсоны дараа орон нутгийн бүлэгт концессийг 1 жилийн хугацаатай шууд олгож одоо явагдаж байгаа концессийн гэрээг эргэж харах</i>	Өндөр
	<i>Бүлэгт олгогдсон концесст дэмжлэг, зөвлөгөө өгч байгаль хамгаалал ба бүлэгт нийгэм-эдийн засгийн өгөөж өгөх зорилгоо биелүүлэхийг нь баталгаажуулах</i>	Өндөр

3.1 Зорилгодоо нийцсэн хөрөнгө оруулалтын стратегийн боломжуудыг тодорхойлох

Хэдийгээр тодорхой арга, зөвлөмж нь үйл ажиллагаанд оролцох тааламжтай нөхцлийн бүрдүүлэх ч эдгээр нь дангаараа хөрөнгө оруулагчдийн баталгаа болж чадахгүй. Бусад орны хувийн хэвшлийн үр дүнтэй хөгжил нь тэдгээр улсын засгийн газрын ирээдүйг харсан бодлого, саналыг хүлээн авахад бэлэн байдаг болон хөрөнгө оруулалтын саналыг өндөр түвшинд нааштайгаар хүлээж авдагтай ихэнх тохиолдолд холбоотой байдаг. Жишээлбэл Канад улсын Алберта мужийн Аялал жуулчлал, Хамгаалалттай газар ба Амралт зугаалгын яам нь аялал жуулчлалд зориулсан хөрөнгө оруулалтыг идэвхийлэн хайж байна. Үүнд зориулан онлайн хэлбэрийн товхимол гаргаж чадамжтай хөрөнгө оруулалтын боломжууд, санал гаргах үйл ажиллагааг дэлгэрэнгүй танилцуулснаас гадна тусгай нэгж хөрөнгө оруулалтын санал гаргах явц болон санал гаргагчдад туслалцаа үзүүлэх үүрэгтэй хэмээжээ (Судалгаа 8-ыг үзэх: Алберта мужын Аялал жуулчлал, Хамгаалалттай газар ба Амралт зугаалгын яам).

Концессийн стратегийн боломжуудыг тодорхойлсноор ТХГН-т чанартай зочин\жуулчны үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц, тоног төхөөрөмж болон үйлчилгээ болон орон нутгийн бүлгүүдийн амьжиргааг тэтгэхүйц, нийгэм эдийн засгийн өгөөжөө өгөх чанартай бүтээгдэхүүн санал болгож чадахуйц хамгийн ихээр хөрөнгө оруулалт шаардагдаж буй газруудад хөрөнгө оруулалтыг чиглүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэ аргыг бусад газарт концессийг хязгаарлах арга болгон ашиглах

Монгол улсын аялал жуулчлалын боломжуудын маркетингийг сайжруулах санаачлагын үр дүнд тэднийг энэ санаачлагад нэгдэх боломж олгож хөрөнгө оруулалт хийх хөшүүрэг бий болно. Монгол улсын томоохон хөрөнгө оруулагчид болон олон улсын хөрөнгө оруулагчдийн сонирхлыг татах зорилгоор хамгаалалттай газарт аялал жуулчлал хөгжүүлэхэд хөрөнгө оруулах чиглэлээр үндэсний бодлого шаардлагатай.

ХЗ\БОНХЯ нь концессийн үйл ажиллагаа ба бодлогын жигд мөрдөгдөх байдлыг хадгалахаас гадна Монгол улсын хамгаалалттай газруудад хөрөнгө оруулалтыг татах маркетингийн үндэсний хандлага шаардагдаж байна.

Энэ хандлагын үр өгөөжүүдийг дурьдвал:

- ▶ Хүчин чармайлтыг давхардуулахгүй байхаар загварчилсан нэгдсэн хандлага
- ▶ Үндэсний боломжуудын талаарх илүү нэгдсэн гадаад (олон улсын хөрөнгө оруулагч) дүр зураг
- ▶ Засгийн газар болон хөрөнгө оруулагчдийн аль алины түвшинд ямар боломж байгаа, эдгээрийг хамгийн сайнаар яаж хэрэгжүүлэх талаар бага төөрөгдөх
- ▶ Хамгаалалттай болон байгалийн үзэсгэлэнт газруудад бүтээн байгуулалт хийх хүсэл эсвэл санаатай бизнес эрхлэгчид\бүлэг ба хөрөнгө оруулагчдад тодорхой зам нээгдэх

Монгол улсын аялал жуулчлалын боломжуудын маркетингийг сайжруулах санаачлагын дүнд хөрөнгө оруулагчдийн сонирхлыг татаж тэднийг эдгээр санаачлагад оролцуулах хөшүүрэг бий болж болох юм. Хэрвээ олон улсын хөрөнгө оруулагчид эсвэл Монголын үндэсний томоохон хөрөнгө оруулагчид анхаарлаа хандуулахаар бол хамгаалалттай газруудад аялал жуулчлалын бүтээн байгуулалт бий болгох үндэсний бодлого шаардлагатай.

Үндэсний аялал жуулчлалын санаачлагын хүрээнд хамгаалалттай болон байгалийн үзэсгэлэнт газарт хөрөнгө оруулалтын сонирхлыг татахын тулд доорх тодорхой асуудлуудыг шийдэх хэрэгтэй:

- БОНХЯ\ХЗ ба аялал жуулчлалын хоорондын харилцааны төвлөрсөн зохицуулалт
- Санхүүгийн дэмжлэг;
- Хөрөнгө оруулалтыг татахын тулд Хөрөнгө оруулалтын товхимол бэлтгэх., байгалийн үзэсгэлэнт газруудын тухайд хамгаалалттай газарт хөрөнгө оруулалтыг татахыг хүсэж байгаа бүсүүдийг тодорхойлох
- Хөрөнгө оруулалт хийхэд нээлттэй дурын тусгай хамгаалалттай газрууд ба ямар зөвшөөрөл байгаа тухай болон шийдэгдээгүй асуудлууд
- Хамгаалалттай газартаа хөрөнгө оруулалт татахыг хүсэж байгаа бүсүүд
- Хөрөнгө оруулалт хийхэд нээлттэй\шаардлагатай дурын тусгай хамгаалалттай газрууд

Магадгүй менежментийн төлөвлөгөө\төлөвлөлтийн зохицуулалтыг эргэн харж концессийг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрчлөлт оруулах, хөрөнгө оруулагчдийн сонирхлыг илүү татаж болзошгүй газруудыг эрэмбэлэх үйл ажиллагаа явуулах хэрэгтэй.

Товхимолыг хийх явцдаа ХЗ хэрэгцээний үнэлгээ хийх жишээ нь юу хэрэгтэй, хэрэгцээний шаардлага хэр өндөр болох, юу нь шаардлагатай бус гэх мэтээр тооцох шаардлагатай. Үүнийг хийснээр санал гаргагчийн оруулах хувь нэмрийг үнэлэх бүтэц бий болно. Товхимолын агуулгыг жишээлбэл доорх байдлаар гаргах:

- Газрын байршил болон үйл ажиллагааны хамрах хүрээ
- Өмчийг төлөвлөх, загвар гаргах ба бүтээн байгуулалт хийхдээ байгалийн болон соёлын орчныг хамгаалахад дэмжлэг үзүүлдэг байхыг шаардах
- Бүтээн байгуулалтанд шаардлагатай үйлчилгээ ба төлөвлөлт
- Хамгаалалттай газрын ирээдүйн хөгжлийн хандлагад үндэслэгдсэн зах зээлийн боломжууд
- Агентлагаас бүрдүүлсэн одоо байгаа болон төлөвлөгдсөн байгууламжууд
- Гэрээний бодлого, хэлэлцээр, хугацаа ба нөхцлүүд
- Эхний шатны хөрөнгө оруулалтын шаардлага, шаардагдах нийт хөрөнгө оруулалт ба санхүүгийн чадавх
- Сонгон шалгаруулалтын төлөвлөгөөний шаардлагууд (загвар, хэмжээ, бараа бүтээгдэхүүн, дуусах хугацаа, тодорхойлолт гаргагчид) ба сонгон шалгаруулах журам

Үйл ажиллагаа 3.1-ийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх алхмуудыг Хүснэг 9-д харуулав.

3.2 Гол газруудад тогтвортой концесс хөгжүүлэхийн тулд үйлдвэрлэл, бүлэг ба төрийн бусад байгууллагатай тогтоосон харилцаагаа бэхжүүлэх

Зохицуулалт, бодлогын хүрээнд ТХГН-т хөрөнгө оруулах идэвхтэй аргыг нэвтрүүлж тогтвортой аялал жуулчлал болон уламжлалт ашиглалтыг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх болон бусад нийгэм, эдийн засгийн үр дүн өгөх хувийн хэвшил ба Төр -Хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өрнүүлэхэд анхаарах хэрэгтэй. Концессийн үйл ажиллагааны үр дүнд засгийн газарт оруулсан ашгийг хамгаалалттай газрын сүлжээний хамгаалал ба менежментийн үйл ажиллагаанд зориулан зарахад чиглүүлэх хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэх арга зам нь төлөвлөлт хийж бусадтай хамтран ажиллах явдал юм. Стратегийн төлөвлөлт хийснээр бүлэг, хувийн хэвшил, орон нутгийн захиргаа ба ХЗ\БОНХЯ-ны хоорондын харилцааг бататгаж хөрөнгө оруулалт хийх ба найдвартай байх лавтай нөхцлийг баталгаажуулна. Үйл ажиллагаа 3.2-ийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэх алхмуудыг Хүснэг 9-д харуулав.

Хүснэгт 9 Үндсэн чиглэл хэрэгжүүлэх 3 Зорилгодоо хүрэхийн тулд стратеги болон олон талт бизнес хөгжлийн загвар хөгжүүлэх

Үндсэн чиглэл 3 Стратеги ба олон талт бизнес хөгжлийн загвар хөгжүүлэх		
Үйл ажиллагаа	Алхмууд	Ач холбогдол
3.1 Зорилгодоо нийцсэн хөрөнгө оруулалтын стратегийн боломжуудыг тодорхойлох	<i>Засгийн газрын агентлагууд, аялал жуулчлалын байгууллагууд, орон нутгийн бүлэг ба аялал жуулчлалын бизнес эрхлэгчидтэй бүс\орон нутгийн хэмжээнд хамтран ажиллаж концессийн үйл ажиллагааны боломжуудыг тодорхойлох</i>	Дунд зэрэг
	<i>Концессийг хэрэгжүүлэхийн тулд өөрчлөх шаардлагатай менежментийн төлөвлөгөө\ төлөвлөгөөний зохицуулалтуудыг эргэн харах</i>	Дунд зэрэг
	<i>Засгийн газрын сүлжээгээр үйлдвэрлэгчид, бүлэгт түгээгдсэн товхимолоор дамжуулан гол бүсүүдийн үйлдвэрлэгчид, бүлэгт хүртээмжтэй концессүүд, хөрөнгө оруулалтын боломжуудыг хөгжүүлэх, санал дэвшүүлэх</i>	Дунд зэрэг
	<i>Орон нутгийн үйлдвэрлэгчид, бүлэгт тогтоосон бодлого, удирдамжийн дагуу концессийн гэрээ санал болгох</i>	Дунд зэрэг
3.2 Гол газруудад тогтвортой концесс хөгжүүлэхийн тулд үйлдвэрлэл, бүлэг ба төрийн бусад байгууллагатай тогтоосон харилцаагаа бэхжүүлэх	<i>Одоо байгаа концесс эзэмшигчдийг оролцуулах зорилгоор ойлголт бий болгох, цаашидын хамтран ажиллагааны төлөө 2.1 ба 2.2-т зөвлөмжлэсэн дагуу бүлгийн зөвлөлдөх хороо байгуулах</i>	Дунд зэрэг
	<i>Одоо байгаа концесс эзэмшигчидтэй байнгын харилцаа тогтоож сониноор дамжуулан сайн үйл ажиллагааг сурталчлан хамгаалалттай газрын сүлжээний талаарх шинэ мэдээлэл өгч тэдний дэмжлэгийг авах</i>	Дунд зэрэг
	<i>Цаашилбал Монгол улсын ТХГН-ийн сүлжээний хэмжээнд концесс эзэмшигчдийн сүлжээ бий болгож үүнийг засгийн газар болон концесс эзэмшигч нар харилцан мэдээлэл солилцох, цаашидын хөрөнгө оруулалт, санал дэвшүүлэх зорилготой хамтын ажиллагаа бүрдүүлэх боловсролын чуулган хэлбэрээр ашиглах</i>	Дунд зэрэг

6 ХУУЛЬ ЭРХИЙН БОЛОН БОДЛОГЫН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

6.1 Санал болгож буй эрхзүйн шинэчлэлт

**Хууль
ТОГТООМЖИД
оруулах
өөрчлөлт,
концессийн
бодлого ба
заавар
чиглэлийн
агуулгын
талаар санал
дүгнэлт**

Хамгаалалттай газрын талаарх эрхзүйд концессийн менежментийг оруулж бататгахын тулд ТХГН-ийн тухай хуулинд (мөн бусад холбогдох хуулинд) нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвлөж байгаа бөгөөд эдгээр нь доорх заалтыг агуулна:

- ▶ Концессийг олгож болох бүхийл үйл ажиллагаа
- ▶ ТХГН болон түүний орчны бүсэд концессийн үйл ажиллагааны олон төрлийг явуулж болох нөхцөл,
- ▶ ТХГН-т концесс эзэмшигч үйл ажиллагаа явуулахдаа заавал мөрдөх тогтвортой байдлын хэм хэмжээ, хугацаа (5 жил, 10 жил үүнээс ч урт хугацаанд),
- ▶ Орон нутгийн захиргаатай хуваалцахаар тохиролцох орлого, хураамж
- ▶ Гадаадын хөрөнгө оруулах боломжууд
- ▶ Өрсөлдөөнөөр олгогдсон концессууд
- ▶ Концессийг эхлүүлэх ба үргэлжлүүлэх хугацаа болон концессийн гэрээ заасан хугацаанаас өмнө дуусгавар болох нөхцөлүүд
- ▶ Төр, үйлдвэр\бүлгийн тэргүүлсэн концессийн хөгжлийн журам
- ▶ Концессийн үйл ажиллагааны удирдлага
- ▶ ТХГН-т концессийн үйл ажиллагааны явцад байгаль, хүрээлэн буй орчинг сайжруулах нөхцөлүүд

Саяхан Австрали улсын хамгаалалттай газруудын агентлаг нь 1974 онд батлагдсан *Үндэсний хамгаалалттай газрууд ба Зэрлэг ан амьтны хуулинд* нэмэлт өөрчлөлт оруулан хамгаалалттай болон нөөц газрууд дахь жуулчид, зочлогсдийн хөгжлийн саналын талаар шийдвэр гаргах нарийн бүтцийг боловсруулжээ.

Энэ хүрээнд шийдвэр гаргах хуульзүйн үндсийг тодорхой болгож хамгаалалттай газар болон нөөц газруудад зөвшөөрөгдөх аялал жуулчлалын хөгжилт болон саналуудыг үнэлэх дэлгэрэнгүй шалгуур, шийдвэр гаргалтын үйл ажиллагааны зөвлөмжүүд зэргийг тусгажээ (Судалгаа 1-ийг харах: хамгаалалттай газарт аялал жуулчлал хөгжүүлэх эрхзүй NSW).

Зохицуулалтын шинэ бүтцийн хүрээнд санал болгож буй зарчмууд

- ▶ Одоогийн байдлаар концессийн асуудлыг Эдийн Засгийн Хөгжлийн яам болон Төрийн өмчийн хороо хариуцдаг байна. Цаашид холбогдох хуулинд өөрчлөлт оруулж БОНХЯ болон ТХГН-ийн захиргаад (ХЗ) нь хамгаалалттай газрын сүлжээнд концессийн менежментийн талаарх бүхийл асуудлыг хариуцан зохицуулж байх үүрэг хүлээлгэхийг зөвлөмж болгож байна. Хамгаалалтын захиргаа\БОНХЯ нь концессийн боломжуудыг хөгжүүлэх, хариуцах талаар өөрийн ажилтнууд, хамтрагчид болон төрийн бусад байгууллагыг (шаардлага гарсан тохиолдолд) удирдан зохион байгуулахаар хуулинд туссан байвал зохино.
- ▶ Хамгаалалттай болон нөөц газрууд дахь концессийн талаар гаргасан ХЗ\БОНХЯ ба аймаг\сумын шийдвэрийг зөвлөлдөх хороогоор дамжуулан орон нутгийн бүлэгтэй хуваалцана. ХЗ\БОНХЯ-ны эхлүүлсэн төслүүдийг тэдгээрийг санал болгосон хамгаалалттай эсвэл нөөц газрын холбогдох зөвлөлдөх хороотой хамтран үргэлжлүүлнэ. Гаднаас ирсэн саналуудыг зөвхөн ХЗ\БОНХЯ санал нь зарчим, зорилготой нийцсэн буюу нийцэх боломжтой гэж үзсэн, цаашид хэлэлцүүлэг хийхэд шаардлагатай мэдээллийг санал гаргагчаас ирүүлсэн гэсэн тохиолдолд зөвлөлдөх хороонд танилцуулна.
- ▶ Концессийн үйл ажиллагаа нь стратеги, менежмент болон бизнес төлөвлөгөөний хүрээнд тодорхойлогдсон байх ёстой.

- ▶ Мөн концессийн үйл ажиллагаа нь ХЗ\БОНХЯ, орон нутгийн хамтрагчид болон хувийн хэвшлийнхэнд үр ашгаа өгдөг байх ёстой. Бүтээн байгуулалтаас олох үр ашиг нь санхүүгийн болон санхүүгийн бус холимог ашиг байж болно.
- ▶ Хамгаалалттай болон нөөц газрын хэсэгт ганцаараа эзэмших эрхийг тухайн газарт олон нийт нэвтрэх өөр газар байхгүй тохиолдолд олгож болох юм. Харин олон нийт нэвтрэх өөр газар байгаа тохиолдолд ганцаараа эзэмших эрхийг аялагчдад санал болгож буй үйлчилгээнээс олох цэвэр ашиг нь үйл ажиллагааг тэнцвэржүүлж байгаа тохиолдолд л авч үзэж болох юм.
- ▶ Эрсдэлийн менежментийн стратегийг сонирхол, оруулсан хөрөнгө оруулалтыг хамгаалах зорилгоор бүх концесст баримтлах ба ХЗ болон БОНХЯ нь аливаа бизнесийн дампуурал эсвэл бүтээн байгуулалтын үйл ажиллагааны хугацаа, нөхцлийг мөрдөхгүй байх тохиолдлыг тооцно.
- ▶ Концессийн боломжийг үнэлэх, сонгох үйл явц болон үргэлжлүүлэн батлах үйл ажиллагаанд хөгжлийн боломжийн цогц байдал, цар хүрээ мөн шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ болон бүх талуудын сонирхох хөрөнгө оруулалтаас олох орлого зэргийг харгалзан үзэх ёстой.
- ▶ Концесс олгогдсон хамгаалалттай эсвэл нөөц газрын ХЗ-нд орохоор таамаглаж буй концессээс олох орлогын хувийг хамгаалалттай газрын менежментийн үйл ажиллагаа болон концесс олгогдсонтой холбогдон гарсан захиргаа, менежментийн шаардлага, нэмэлт үйл ажиллагааны зардлыг тэнцвэржүүлэхэд ашиглана.
- ▶ Хамгаалалттай болон нөөц газрын байгаль, соёл ба амралтын үнэ цэнийг хамгаалах нь эрхэм зүйл бөгөөд хүсэлт гаргагчийн бүтээн байгуулалт нь эдгээр үнэт зүйлд мэдэгдэхүйц аюул учруулахгүй гэдэг нь нотлогдсон тохиолдолд л зөвхөн концессийн үйл ажиллагааг батлах болно.
- ▶ Бүхийл концесст өндөр түвшний байгаль орчны стандарт мөрдөхийг шаардана. Энэ зарчим нь бүтээн байгуулалтын саналуудыг сонгох, бүтээн байгуулалт хийх, дууссан бүтээн байгуулалтын хугацаа ба нөхцлүүд мөн хэрвээ шаардлагатай бол бүтээн байгуулалтыг үгүй хийх ба газрыг нөхөн сэргээх зэрэгт нөлөөлнө.
- ▶ Арилжааны аялал жуулчлалын бүтээн байгуулалт нь тухайн хамгаалалттай эсвэл нөөц газрын байгалийн ба эсвэл соёлын аялал жуулчлалын үйл ажиллагааг бэхжүүлэх ёстой.
- ▶ Хамгаалалттай газар дахь арилжааны аялал жуулчлалын бүтээн байгуулалтын явцад орон нутгийн бүлгийн сонирхол, чадавх болон хүртээмжийг харгалзан тэдний оролцоог шууд болон шууд бусаар бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ үзүүлэх байдлаар хангах ёстой. Сургалт явуулах, ажлын байр бий болгох ба бизнесийн бүтээн байгуулалт хийх болон Монголын соёлыг танилцуулах байдлаар зочлогсдийн сонирхлыг нэмэгдүүлэх мөн орон нутгийн бүлгийн соёлтой холбох саналуудыг таатайгаар хүлээж авна.

6.2 Зөвлөмж болгож бодлого ба журмууд

Эдгээр бодлого ба журмууд нь концессийн олгох болон менежментийг залахад чиглэгдсэн болно. Концессийн менежментийн журмын гол арга хэмжээнд доорх зөвлөмжүүдийг оруулсан:

- ▶ Концесс олгох
- ▶ Хүсэлт гаргагчид зориулсан зөвлөмж
- ▶ Хөрөнгө оруулалтын боломж бүрдүүлэх
- ▶ Газар сонгох
- ▶ Хүсэлтийг үнэлэх
- ▶ Үзэл баримтлал боловсруулах ба эцэслэн дуусгах
- ▶ Концессийн гэрээг эцэслэн дуусгах

Дараагийн хэсэгт концессийн гэрээний хоёр төрөлд буюу 1-д жижиг үйл ажиллагаа явуулж эзэмших түгээмэл лиценз\зөвшөөрөл хэлбэрийн концессийн гэрээ 2-т дийлэнх концесс хамаарах “түрээсийн” хэлбэрийн концессийн гэрээнд анхаарал хандуулаа.

Зураг 1-т бүх төрлийн концессийн хянахад шаардлагатай үйл ажиллагааг санал болгов.

Концессийн гэрээ байгуулах

Монгол улсын хамгаалалттай газруудад концессийн санал болон гэрээ үүсэж гарах хэд хэдэн зам байна. Эдгээрийг доор тодорхойлов. Концессийн санал нь нэг бол жижиг буюу энгийн эсвэл том хэмжээтэй буюу илүү цогц байна. Тэдгээрийн хэр цогц нарийн байхаас үл хамааран концессийг үнэлэх, зохион байгуулах ажлыг зөвлөмжийн дагуу нэг хэвийн тогтсон аргаар явуулна.

Өнөөгийн ашиг сонирхолууд

БОНХЯ\ХЗ-ны хариуцан хэрэгжүүлдэг өмчийн талаарх олон ашиг сонирхол нь тухайн газрыг хамгаалалтанд авахаас өмнө байсан газар эсвэл тэдгээр нь өвлөж авсан байх зэргээс үүдэлтэй байж болно. Нөөц газрын менежментийг явуулах мөн иймэрхүү төрлийн газрын асуудлыг зохицуулахдаа БОНХЯ\ХЗ нь ашиг сонирхлын эзний хадгалж үлдсэн эрхийг хүндэтгэх үүрэгтэй байж магадгүй. Өөрөөр хэлбэл БОНХЯ\ХЗ нь энэ нь ашиг сонирхлыг зохистойгоор үгүй хийж болох аргыг олж болно.

ТХГН-ийн тухай хуулиар газрыг хамгаалалтанд авсанаар одоогийн эзэмшил эсвэл хуулиар зөвшөөрөгдсөн ашиглалт зэрэг нь өртөж болзошгүй хэдийч концессийн гэрээ эсвэл бусад эрхээр хамгаалагдаагүй үед БОНХЯ\ХЗ тухайн эзэмшил, ашиглалтыг үргэлжлүүлэх шийдвэр гаргавал энэ ажиллагааг концессийн менежментийн журмын хүрээнд оруулан журамлах ажиллагаа явуулах хэрэгтэй.

Нөөц газрын дотор ашиг сонирхол оршин байгаа тохиолдолд хуулийн дагуу шинэ эзэмшил тухайлбал тухайн газарт нөлөөлөл үзүүлэх бусад талд олгох тухай шийдвэр гаргахаасаа өмнө үүнийг анхаарч үзэх ёстой.

Шинэ саналууд

Концессийн гэрээ нь шинэ санал байдлаар гарч ирж болно. Эдгээр нь арилжааны эсвэл арилжааны бус агуулгатай байж болно. Тэдгээр нь мөн:

- ▶ Хөрөнгө оруулагч тэргүүлсэн байх хандлага – энэ тохиолдолд хөрөнгө оруулагч засгийн газарт хандан өөрийн санаачлагаар хөрөнгө оруулах санал гаргах эсвэл БОНХЯ\ХЗ тодорхой газар оноохгүйгээр концессийн санал хүлээж авахад нээлттэй байх өргөн хүрээтэй мэдээллийн хариу болгож эсвэл сонирхлоо илэрхийлэх тухай мэдээллийн шууд нөлөөгөөр аль эсвэл шууд хэлэлцээрийн байдлаар илэрч болно.
- ▶ Засгийн газар тэргүүлсэн байх хандлага – засгийн газрын зүгээс хөрөнгө оруулагчдад хандан сонирхлоо илэрхийлэхийг уриалсны дагуу эсвэл тухайлсан нэг газар эсвэл олон газар ба ландшафттай холбоотойгоор сонирхол илэрхийлэх зэрэг хандлагатай байж болно.

Энэ хоёр хандлагын аль аль нь БОНХЯ\ХЗ ба хөрөнгө оруулагчдад давуу болон сул талыг агуулах бөгөөд энэ аргыг сонгох тохиолдолд дээрхийг харгалзан үзэх шаардлагатай (хүснэг 3-ийг үзэх).

Зураг 2, 3-д цогц буюу том хэмжээний газарт концесс олгогдоход БОНХЯ\ХЗ баримтлах шаардлагатай хөрөнгө оруулагч тэргүүлсэн ба засгийн газар тэргүүлсэн байх хандлагын үе шатуудын гол санааг санал болгов.

Хүсэмжит зорилтдоо хүрэхийн тулд зөв аргыг сонгох нь

БОНХЯ\ХЗ өөрийн зорилтдоо хүрэхийн тулд дээрх хоёр хандлагын холимог аргыг сонгож болно. Жишээг доор харуулав:

- a) **Концессийг хөрөнгө оруулагчдийг татах арга болгож ашиглах** - БОНХЯ\ХЗ нь ТХГН-ийн тухай хуулиар хамгаалагдсан газруудад шинэ үйл ажиллагаа явуулах зах зээлээс сонгогдсон боломжуудыг тодорхойлж тэдгээрийг сурталчилж болно
- b) **Концессийг бүтээн байгуулалтыг хянах эсвэл хязгаарлахад ашиглах** – Зарим тохиолдолд БОНХЯ\ХЗ нь нэг эсвэл цөөн тооны үйл ажиллагаа эрхлэгчдэд уралдаант шалгаруулалтын хэлбэрээр эрхийг хуваарьлах аргыг сонгож болно. Уралдаант шалгаруулалтын хэлбэрээр олгогдсон концесс нь доорх үйл ажиллагааг зохицуулах арга болж ашиглагдаж болно:

- ▶ Байгаль орчин, соёл, нийгэм эсвэл зочлогчдийн аюулгүй байдлыг хангах талаар чадавх хүрэлцэхгүй газруудад хүрэх, нэвтрэх ажлыг зохион байгуулахад;
- ▶ Зөвшөөрөл хүсэх эрэлт нь зөвшөөрөгдсөн хязгаарыг давсан газруудын эзэмшлийг зохион байгуулахад
- ▶ эсвэл тодорхойлогдсон боломж, үйлчилгээг төрийн нэрийн өмнөөс хариуцан хүргэх бизнес эрхлэгч хэрэгтэй тохиолдолд:

Олонх бизнес эрхлэгч уралдаант шалгаруулалтын журмаар зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг дэмждэг бөгөөд энэ нь зах зээлийн хэмжээг хязгаарлах байдлаар өрсөлдөөний давуу талыг олгодогтой холбоотой.

Ихэнх тохиолдолд боломжит бизнес эрхлэгчдийн өнгөрсөн хугацаанд гүйцэтгэсэн ажлын байдал болон цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах эрмэлзэл зэргийг нь үнэлдэг.


с) **Концессийг орон нутгийн бүлгийн амьжиргааг дэмжих эсвэл сайжруулахад ашиглах** – БОНХЯ\ХЗ онцгой тохиолдолд тухайлсан ашиглалтанд концессийн гэрээг шууд байгуулах хэрэгтэй болж болно.

- ▶ БОНХЯ\ХЗ тохиромжтой арилжааны боломжийг тодорхойлсон гэж үзсэн үед ;
- ▶ Тусгайлсан үйл ажиллагаа эсвэл газартай холбоотой аюулгүй байдал, байгаль орчин соёлын асуудал байгаа тохиолдолд:
- ▶ Хамгаалалттай газрын зорилтыг ийм концессийн гэрээг олгосноор хамгийн сайнаар биелүүлж болох тохиолдолд;
- ▶ Санал болгож буй үйл ажиллагаа нь тухайн газрын менежментийн төлөвлөгөөтэй таарч буй тохиолдолд.

Үүнтэй нэгэн адил хамгаалалттай газар дахь уламжлалт ашиглалт болон үйлчилгээ зэрэг арилжааны бус эзэмшил болон эрх нь шинэ санал болон гарч ирж болно. Хувийн ашиг сонирхол ч мөн ийм хэлбэрийн эрхийг шаардаж болно. Гагцхүү санал болгож буй ямар үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд байгааг нягталж үзэх нь чухал. Харин тухайн үйл ажиллагаа өмнө нь зөвшөөрөгддөг байсан учраас цаашид ч зөвшөөрөгдөнө хэмээн үзэх нь буруу болно.


Зураг 1.

Концессийн Санал, Үнэлгээ ба Менежментийн үйл ажиллагаа




Зураг 2.

Концессийн гэрээний менежмент




Зураг 3.

Хөрөнгө оруулагч тэргүүлсэн хандлагын шийдвэр гарах явц



Зураг 4. Засгийн газар тэргүүлсэн хандлагын шийдвэр гарах явц



6.3 Санал гаргагчдад зориулсан зөвлөмж боловсруулах нь

Концессийн саналын талаарх тодорхой арга, зөвлөмжийг боловсруулан танилцуулах нь үйлдвэрлэл/бүлэг эсвэл засгийн газрын санаачилсан аль нь хамаагүй санал цагаа олж, хангалттай боловсроход нэн хэрэгтэй. Тодорхой арга, зөвлөмж нь санал боловсруулах таатай боломжийг бүрдүүлнэ. Эдгээр нь цаг хэмнэж бүх талыг төлөвлөлт хийх болон нөөцийг хуваарьлахад туслалцаа үзүүлнэ. Санал гаргагч нь хүлээн зөвшөөрөгдөхүйц саналын төрлийн талаар буюу зөвшөөрөгдөж болохуйц байршилүүд (ялангуяа хөрөнгө оруулагч тэргүүлсэн хандлагад); засгийн газрын шаардлагууд ба шийдвэр гаргахад нөлөөлөх үе шатны талаар төсөөлөлтэй байх хэрэгтэй. Засгийн газрын агентлагууд ба ажилтнууд нь мөрдөх шаардлагатай үе шатны талаар ойлгомжтой мэдээлэлтэй байх ба ажилтнуудын ажил, үүргийн хуваарьт оногдуулах болон төсөв хуваарьлахад нь туслалцаа үзүүлнэ. Концессийн талаарх мэдээлэл нь үйл ажиллагааны зарим чухал үе шатны талаар илүү тодорхой байх нь ялангуяа үйлдвэрлэл/бүлэгийн зүгээс боломжийг ашиглахад саад болж байгаа гэж үзсэн асуудлуудыг тодорхойлж гаргах нь нэн чухал болно. Чухал зүйлүүдэд:

- ▶ Эрэлхийлж байгаа бүтээн байгуулалт эсвэл үйл ажиллагааны өргөн төрлүүд (жишээлбэл менежментийн зорилт, зочлогсдийн таашаалтай холбоотой гэх мэт)
- ▶ Концессийг батлах ба үйл ажиллагаанд нөлөөлөх хууль эрхзүй, төлөвлөлт ба бодлогын шаардлагууд
- ▶ Концессийн гэрээний хугацаа ба боломжит эзэмшлийн төрлүүд
- ▶ Шийдвэр гаргалтын үе шатууд болон шийдвэрлэх үед шийдвэр гаргалтанд ашиглах зорилт, стандартууд ба эсвэл шаардлага
- ▶ Батлахтай холбоотой шаардлагууд (байгаль орчны үнэлгээ, төлөвлөгөө батлуулах гэх мэт) ба тэдгээрийн концессийн үнэлгээний үйл ажиллагааны үе шаттай холбогдох байдал

Концессийн саналуудад анхаарах асуудлыг товхимол гэх мэтийн баримт бичигт тусгасан байх хэдийч ХЗ өргөн хүрээтэй үйл ажиллагааны зөвлөмжийг боловсруулан бэлэн байлгах нь үйлдвэрлэл/бүлгийн гаргасан сайн дурын саналд хариулт шууд өгөх давуу талыг бүрдүүлнэ. Эдгээр үйл ажиллагаа ба зөвлөмж, эрх мэдлийн хүрээг боловсруулах явцад зарим боломжуудыг хязгаарлаж (хууль эрхзүйтэй холбоотой асуудлууд, төлөвлөлт ба эзэмших эрх гэх мэт) байгаа асуудлыг ойлгох, гарцыг олох мөн үнэлгээ хийх ба батлах ажиллагааг илүү оновчтой болгох боломж бий.

Гол зөвлөмжүүд – Санал гаргагчдад зориулсан зөвлөмж

Засгийн газар эсвэл хөрөнгө оруулагч тэргүүлсэн байхаас үл хамааран сонирхсон талуудад мэдээлэл хэзээд бэлэн байх хэрэгтэй

- ▶ Зөвхөн тогтвортой ба ландшафтад тохирох бүтээн байгуулалт ба хамгаалалттай газрын хамгааллын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх болон зочлогсдийн таашаалыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг л дэмжихийг илэрхийлсэн тодорхой зөвлөгөөг өгөх шаардлагатай.
- ▶ Нийтийн эзэмшлийн газарт бүтээн байгуулалт хийх, эзэмших эрх олгох, зөвшөөрөл ба лиценз батлах хууль эрхзүйн шаардлагууд нь бэлэн, тодорхой байх хэрэгтэй.
- ▶ Үйл ажиллагааны явцад хийгдэх үе шатны (*Засгийн газар эсвэл хөрөнгө оруулагч санаачилсан байхаас үл хамааран*) талаар тухайлбал байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба бусад батлах ажиллагаа зэргийг тодорхой тайлбарласан байвал зохино.
- ▶ Саналын талаар шийдвэр гаргах бүхийл түвшинд тодорхой зорилт, стандарт ба шалгуурыг мөрдөхөд анхаарч ажиллах шаардлагатай.
- ▶ Шийдвэр гаргах үйл ажиллагааны зөвлөмжийг хэвлүүлэн боломжит хөрөнгө оруулагчид болон олон нийтэд хүртээмжтэй байх боломжийг бүрдүүлэх.

6.4 Талбарыг сонгох журмууд

Тогтвортой концесс хэрэгжүүлэхэд ихэнх тохиолдолд талбар сонгох нь хамгийн чухал хэсэг нь байдаг. Буруу талбар сонгосноор тохиромжтой хөрөнгө оруулагчдийн сонирхлыг бага хэмжээгээр эсвэл бүр татахгүй байхад хүрч болох ба үүнийг зах зээлд гаргахын тулд бэлтгэх нь нөөцөө дэмий үрсэн хэрэг болно. Өөрөөр хэлбэл зохимжгүй талбар сонгох нь бизнес эрхлэгчийн менежментийн үйл ажиллагаанд хүндрэл учруулах буюу концесс нь хамгаалалттай газрын байгалийн болон соёлын үнэт зүйлийг өвийг хөндсөн бол дээрхээс ч хүнд асуудал тулгарна.

Талбарын тохирох байдлыг үнэлэх шалгуур

Бүхийл арилжааны бүтээн байгуулалтанд таарсан “туйлын зохистой” талбарыг сонгоход шаардлагатай бүхнийг багтаасан эцсийн жагсаалт гаргах гэдэг нь хэзээ ч боломжгүй юм. Яагаад гэвэл бүхийл хамгаалалттай газар дахин давтагдашгүйтэй адил концессийн үйл ажиллагаа бүр давтагдахгүй онцлогтой. Эдгээрийг харгалзан үзэж хамгаалалттай газруудад арилжааны бүтээн байгуулалт хийх тохиромжтой газрыг үнэлэхэд хоёр гол шалгуур чухал болохыг тодорхойлов:

Зорилгод нийцсэн байх

Энэ нь тухайн газрын физикийн шинж чанар ба санал болгож буй үйл ажиллагаатай хэр зохицолтой байх талаарх үнэлгээ юм. Үүнд доорх хүчин зүйлүүдийг оруулж болно:

- ▶ Тухайн талбар нь бүтээн байгуулалт/үйл ажиллагаа болон холбогдох үйлчилгээнд хэмжээний хувьд хүрэлцэх байдал
- ▶ Талбарын өндөршил, хөрсний төрөл ба ургамалжилт нь санал болгож буй бүтээн байгуулалтын хэлбэр, холбогдох байгууламж ба өсөн нэмэгдэх зочлогсод тохиромжтой эсэх тухай
- ▶ Талбар нь байгалийн гамшигт (жишээ нь үер, давалгаа, шуурга ба түймэр гэх мэт) нэрвэгдэх эрсдлийн бүсэд байршдаггүй эсвэл хэт мэдрэмтгий газар биш байх

Зайн тохиромжтой байдал

Концессийг амжилттай болоход шаардлагатай харагдахуйц бус хүчин зүйлийг олж илрүүлэхэд энэ хэсэг чиглэнэ. Эдгээр нь доорх хүчин зүйлсээс бүрдэж болно:

- ▶ Талбар аялал жуулчлалд ач холбогдолтой байх байдал – байршил сонгоход хамгаалалттай газрын үнэт зүйлийг харгалзах эсвэл бүтээн байгуулалт хийхээр санал болгосон газрын “мэдрэмж”-ийг тусгах шаардлагатай. Жишээлбэл хэрвээ зочлогсод хамгаалалттай газарт онцгой ландшафт үзэхээр ирдэг бол талбар нь тэр ландшафтыг л харуулж чадахуйц байхаар сонгох ёстой. Хэрэв арилжааны бүтээн байгуулалтад “шүтээний” газрыг санал болгох нь түгээмэл биш бол тухайн сэтгэл татам газарт аль болох ойролцоо байх асуудлыг харгалзан үзэх хэрэгтэй.
- ▶ Талбарын дахин давтагдашгүй онцгой байдал: тухайн орон нутагт байдаг өөр бүтээн байгуулалттай төстэй бүтээгдэхүүн санал болгох байршлаас татгалзах нь зүйтэй. Талбар нь хэтэрхий их хүн ирдэг л биш бол хөрөнгө оруулагчдад ямар нэгэн онцгой зүйлийг санал болгохуйц байх ёстой.
- ▶ Бусад хамгаалалттай газрууд дахь бизнесийн үйл ажиллагаа болон зочлогсдийн хэрэгцээнд нийцсэн байх байдал: талбар нь хамгаалалттай газрын нөөцийн зөрчилтэй ашиглалтын эсрэг хамгаалалтын бамбай болох ёстой. Жишээлбэл адал явдалт аялал жуулчлалын талбарыг шувууд үүрэлдэг газрын ойролцоо эсвэл хоргоддог газарт ойр сонгож болохгүй.

Санал болгож буй арилжааны бүтээн байгуулалттай холбогдон гарах тухайлсан үйл ажиллагаанд анхаарах ёстой талбар сонгох бусад шалгуур:

1. **Нэвтрэх боломж:** жуулчдын таашаалд нийцэх төрлийн тээврийн хэрэгслээр тухайн газар нэвтрэх боломжийг бүрдүүлэх нь чухал. Хэрвээ жилийн турш нэвтрэх боломжгүй бол

улирлын чанартай нэвтрэх боломж нь арилжааны зориулалтаар санал болгож байгаа бүтээн байгуулалтад ямар нөлөө үзүүлэх талаар үнэлгээ хийх шаардлагатай. Хэдийгээр тухайн бүтээн байгуулалтын мөн чанараас хамаарч уг газарт хүрэх замд тавигдах шаардлага олон янз байдаг ч дийлэнх арилжааны бүтээн байгуулалтанд газраар\замаар явж нэвтрэх нь түгээмэл. Санал болгосон жуулчны үйлчилгээнд хүрэхийн тулд зарим тохиолдолд нэвтрэх бусад хэлбэрийг (жишээ нь нисдэг тэрэг, завь, явган зэрэг) сонгох хэрэгтэй байж болно. Ийм тохиолдолд бүтээн байгуулалтыг босгох явцдаа нэвтрэх боломжийн тохиромжтой байдлыг анхаарч үзэх нь чухал.

2. **Талбарын уян хатан байдал:** хэрвээ боломжтой бол санал болгож буй талбар нь аль болох том байх нь хөрөнгө оруулагчид\үйлдвэрлэл эрхлэгчдэд зорилтот зах зээлийн шаардлага, таашаалд нийцэхүйцээр шинэлэг байж бүтээн байгуулалтын загвараа гаргах боломжийг бүрдүүлдэг. Хэт их хориглох зүйлтэй талбар нь хөрөнгө оруулагчдийн сонирхлыг хязгаарлаж болзошгүй.
3. **Зочлогсдын анхаарлыг татахуйц байх:** ихэнх арилжааны бүтээн байгуулалт нь аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд санал болгож болохуйц талбар сонгохыг шаарддаг. Хамгаалалттай газарт хийгдэх дийлэнх бүтээн байгуулалт нь анхаарал татахуйц орчинтой байхыг шаарддаг.
4. **Шаардлагатай үйлчилгээг авч болохуйц байх:** холбогдох үйлчилгээ болох эрчим хүч, ус, цэвэрлэх байгууламжийг байгуулах эсвэл холбогдох боломжтой байх мөн үйлчилгээний дэд бүтцийг тухайн талбар өөрөө бий болгох чадавхтай байх зэрэг нь олонх арилжааны бүтээн байгуулалтын төрлүүдэд талбар сонгохдоо тавих шаардлага байх ёстой.
5. **Санал болгож буй арилжааны бүтээн байгуулалтын ойролцоо шууд өрсөлдөхүйц бизнесийн төрлүүд байгуулагдсан байх:** Шинээр арилжааны бүтээн байгуулалт хийх талбарыг тодорхойлох явцдаа тэр газрын дотор эсвэл ойролцоо явагддаг бизнесийн үйл ажиллагааг анхааралдаа авах шаардлагатай. Шинэ бүтээн байгуулалт нь тэнд байгаа аялал жуулчлалын бүтээгдэхүүнтэй шууд өрсөлдөхгүй байх эсвэл сөрөг нөлөө үзүүлдэггүй байх ёстой. Харин шинэ зорилтот зах зээлд тохирох арилжааны бүтээн байгуулалтыг дэмжсэн талбарыг өрсөлдөгч хэмээн тооцохгүй. Жишээлбэл: тансаг зэрэглэлийн байрны үйлчилгээнд тохирох талбарыг ойролцоо орших гэр чиргүүлтэй аялах хамгаалалттай газарт шууд өрсөлдөгч болно хэмээн тооцох шаардлагагүй.

Талбарын зохицолт байдалд нөлөөлж болзошгүй хөгжлийн саадууд

Концесс хэрэгжихэд нөлөөлж болзошгүй анхаарал хандуулах шаардлагатай саадуудыг доор дурьдав:

- Нэвтрэх саадууд (улирлын, замын чанар гэх мэт)
- Эзэмших эрх
- Хамааралтай омгийн бүлгийн доторх зөрчил
- Усанд хүрэх боломжгүй байх
- Танигдсан шүтэгддэг газрууд
- Зочлогсдийн аюулгүй байдал хангагдаагүйгээс нэмэлт менежментийн зардал шаардах
- Улс төрийн нөлөө хэт ихтэй газарт санал болгосон бүтээн байгуулалтыг оролцогч талууд хүчтэй эсэргүүцэх.

Гол зөвлөмжүүд-Талбар сонгох

- Талбар нь тухайн газрын мөн чанарыг харуулах, бүтээгдэхүүний онцлогтой холбогдох ба зочлогсдийн анхаарлыг татдаг байх ёстой.

- Талбар нь доорхийг агуулсан байна:
- Үйлчилгээ болон зочдын тээвэрлэлт нэвтрэхэд амар байх (заавал замаар гэлтгүй);
- Усны хангамжтай;
- Талбай нь бүтээн байгуулалтын хэмжээнд хүрэлцээтэй ба тогтвортой дэд бүтцийг тусдаа бий болгох боломжтой;
- Талбарын ойролцоох эсвэл хүрээлсэн хамгаалалттай газар эсвэл байгалийн үзэсгэлэнт газарт аялах, нэвтрэх боломжтой нөхцөл бүрдсэн байх
- Бүтээн байгуулалт хийхээр оноосон газрын хилийн дотор талбарын нарийн загвар гаргах, сонголт хийхэд уян хатан байх
- Талбар нь төрөөс баримталдаг хууль журам, бодлого болон хамгаалалттай газрын менежмент ба соёлын өвийн төлөвлөгөөний шаардлагуудтай нийцсэн байх шаардлагатай.
- Талбарын хөгжил нь бусад хамгаалалттай газрын үйл ажиллагаа эсвэл зочлогсдийн хэрэгцээ шаардлагатай мөн нийцсэн байх шаардлагатай.
- Санал болгосон үйл ажиллагааг нотлогдохуйцаар буюу орон нутгийн бүлэгт өгөх өгөөжийг оруулан харуулах
- Талбар нь тогтвортой хөгжлийг дэмжихүйц байх шаардлагатай буюу:
 - Тухайн газрын болон орчны бүсийн байгалийн болон соёлын үнэт зүйлтэй тохирсон байх;
 - Байгаль орчны чанар ба экологийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж буй байгалийн нөөц, эрчим хүч ба усыг тогтвортой, үр дүнтэй ашиглах;
 - Ландшафтын үзэгдэх байдал, чанарыг хадгалах, хэвээр нь үлдээх зөв төрөл ба хэмжээ;
 - Зочлогсдод санал болгох бүх үйлчилгээний нэг хэсэг байж зочлогсод ашиглахад зохимжтой, тухайн талбар ба орчны онцлогт тохиромжтой байх
- Бүлгийн өгөөжийг нэмэгдүүлж, тэдэнтэй зөвлөлдөн үйл ажиллагаагаа ил тод байлгаснаар бүлгийн дэмжлэгийг авах ажлыг хөхүүлэн дэмжих.

6.5 Концессийн үнэлгээний шалгуурын заавар

Засгийн газраас Концессийн саналыг үнэлэх үйл ажиллагааны үе шат бүрт тавигдах тодорхой шалгуурыг тодорхойлж нийтэд мэдээлэх нь зүйтэй. Эдгээр шалгуур нь Сонирхлоо илэрхийлсэн эсвэл хөрөнгө оруулагч тэргүүлсэн хандлагын хариу өгөх чадамжтай байх ёстой. Үнэлгээний шалгуурыг ашигласнаар:

- Ил тод, хариуцлагатай шийдвэр гарах;
- Засгийн газар бодит, үр дүнтэй шийдвэр гаргах, агентлагын нөөц-концессийн зорилт нь урьдчилан тавигдаж шийдвэр гаргагчдийг чиглүүлэх ба саналууд эдгээр зорилтыг хангаж байгаа эсэхээс хамааран нөөцийн хувийг нэмэгдүүлэх зэрэгт дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын концессийн талаарх зорилт болон хамтарсан үйл ажиллагааны ашигтай байдлын талаар хөрөнгө оруулагчид урьчилан мэдэх боломжийг хангах.

Үнэлгээний шалгуурын жишээ болон ХЗ-ны ажилтнууд гүйцэтгэх ёстой үнэлгээний тайлангийн жишээг Хавсралт 2-г танилцуулна (Хавсралт 3).

- ▶ Концесстой холбоотой шийдвэр гаргах журмуудыг боловсруулан хөрөнгө оруулагч тэргүүлсэн ба засгийн газар тэргүүлсэн алин хамаагүй тэнцвэртэй авах боломжтой болгох мөн өмнө нь хэвлүүлэх
- ▶ Засгийн газар тэргүүлж хөрөнгө оруулагчдад хандсан тохиолдолд эхний алхам нь сонирхлыг тандах ба сонирхсон талуудын бизнес ба тогтвортой, ландшафтад ээлтэй ашиглалт ба зочлогсдийн таашаалд нийцүүлэх чадавхийг үнэлэх
- ▶ Урьдчилсан шатны шалгаруулалтын шалгуураар дэмжигч цаашид төслөө дэлгэрэнгүй болгож боловсруулах мөн саналын үнэлгээ хийгдэхээс өмнө үнэлэх хэрэгтэй.
- ▶ Хэд хэдэн санал гаргагч байгаа тохиолдолд санал гаргагчийн тоог цөөрүүлж сонгосон бүлэгтэй (2 эсвэл 3 байвал зохимжтой) болохын тулд нэмэлт үнэлгээний шат буюу урьдчилсан концепци ирүүлэхийг шаардах хэрэгтэй болно.

Урьдчилсан шатны шалгуур нь зөвхөн доорх гурван чиглэлд анхаарах:

- ▶ Бизнес эрхлэгчийн нэр хүнд, туршлага, гол зорилтыг хэрэгжүүлэх чадавх
- ▶ Тогтвортой бизнесийн загвар
- ▶ Хамгаалалттай газарт тохирсон концепц
- ▶ Урьдчилсан шатанд тогтвортой байдлын дэлгэрэнгүй шалгуур тавихгүй байх

Концепцийн урьдчилсан үнэлгээний шалгуур нь тогтвортой үр дүнд хүрэх чадавхийг тодорхойлоход л голлож анхаарах ёстой. Гол шалгуурууд нь:

- ▶ Төслийн арилжааны тогтвортой байдал ба хэрэгжих боломж
- ▶ Тухайн талбар\газрын байгаль, соёлын үнэт зүйлтэй зохицох зохицол
- ▶ Байгалийн нөөц, эрчим хүч ба ус болон хогны менежмент, бохирдлоос хамгаалах зэргийг оролцуулаад эдгээрийг тогтвортой, үр дүнтэй ашиглах нөхцлүүд
- ▶ Тухайн талбарын өгөгдөл ба ландшафтын тогтоцод барилга, байгууламжийн хэмжээ, хэлбэр таарамжтай эсэх ба байгаль орчны төрхийг өөрчлөхийг бага байлгах
- ▶ Орон нутгийн бүлэгтэй хамтран ажиллах ба тэдэнд дэмжлэг үзүүлэх .

Хөрөнгө оруулагч ба газрын даамал нарын төслийг хэрэгжих хүртэл ажиллахад хамаатай үүргийг тодорхойлох, дэмжлэг үзүүлэх журмын санал буюу эсвэл санхүүгийн урамшуулал олгох тухайд мэдээлэл гаргах талаар ажиллах хэрэгтэй.

- ▶ Засгийн газрын агентлаг дундын нэг ажилтан ажиллуулах кейс менежментийн аргыг оролцуулан үйл ажиллагаанд улс төрийн дэмжлэг ба засгийн газрын амлалтыг баталгаажуулах.
- ▶ Үйл явцын энэ шатанд эзэмших эрх\зөвшөөрөл\гэрээний хугацаа ямар байх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулах
- ▶ Хяналтын аудитор томилох мөн ил тод байдлыг хангах ба том хэмжээний эсвэл маргаантай ашиглалтын асуудлаар санал гаргагч\нар\-ийн оюуны өмчийн эрхийг хамгаалах зорилгоор нууц хадгалах журам боловсруулах
- ▶ Засгийн газар тэргүүлсэн хандлагын явцад хоёр эсвэл гурван үе шаттай аргыг ашиглах буюу үүгээр дамжуулан засгийн газар боломжтой сонголтуудаас тохирох талбарын талаар итгэлтэй болох ба мөн тухайн талбарын бэлэн байдлын судалгааг засгийн газар\хөрөнгө оруулагч хэлэлцэх боломжийг бүрдүүлнэ.
- ▶ Эхний шатанд мэдээллийн төлөвлөсөн шаардлага гаргах ба үнэлгээний шалгуурыг тодорхой болгох болон үйл ажиллагааны хугацаа ба боломжит зардлын тухай тодорхой байж хөрөнгө оруулагчдийн гаргах зардлыг бууруулах
- ▶ Дээд тал нь гурван санал гаргагчийг урьдчилан сонгон шалгаруулах.

6.6 Хөгжлийн үзэл баримтлал (илүү цогц концесст зориулсан)

Энэ үе шатанд цөөн тооны дэмжигч (засгийн газар тэргүүлсэн үйл ажиллагаанд) эсвэл хөрөнгө оруулагч тэргүүлсэн үйл ажиллагааны тохиолдолд нэг дэмжигчийг талбарт ажиллах өөрсдийн концепцийг илүү дэлгэрэнгүй боловсруулахаар урина. Үүнд тухайн газар эсвэл талбарын ашиглалтын талаарх хөгжлийн концепцийн төлөвлөгөө; санал болгож буй зочлогсдийн үйлчилгээнүүд; байгаль орчин, нийгэм ба эдийн засгийн тогтвортой байдлыг хангах аргууд зэрэг тусгагдана. Санал болгож буй бүтээн байгуулалтын боломж ба бэрхшээлтэй талуудыг үнэлэхийн тулд талбарыг цаашид судлах шаардлагатай болно.

Энэ үе шатнаас гарах үр дүнд хэд хэдэн гол зүйлүүд нөлөөлнө.

Тодорхой, тууштай, цагаа олсон үйл ажиллагаа

Концепц боловсруулах үе шатанд тавигдах шаардлагууд ба тэдний бэлтгэсэн концепцтэй холбоотой шийдвэр яаж гардаг талаар дэмжигч эсвэл дэмжигчид нь тодорхой мэдээлэлтэй байх нь чухал. Тэд цаашид өрсөлдөхийн тулд зарцуулах цаг ба нөөцийн орлого-зарлагаа хэмжих болно. Зарцуулах цаг болон үйл ажиллагааны нарийн төвөгтэй байдал нь зарим сайн бизнес эрхлэгчдийг (ялангуяа жижиг бизнес эрхлэгчдийг) үйл явцаас гаргах эсвэл болиулах талтай. Энэ үе шатанд бизнес эрхлэгчдийг цаашид үргэлжлүүлэх урамшуулал болгон засгийн газраас санхүүгийн дэмжлэг үзүүлж шалгаруулалтын сүүлийн шатанд шалгарсан дэмжигчийг дараагийн шатанд концепцийн дэлгэрэнгүй загвар бэлтгэхэд нь дэм болж болох юм. Энэ шатанд кейс менежментийн аргыг (бүлэг 4.5-ийг үзэх) үргэлжлүүлэх хэрэгтэй.

Хамтын ажиллагааны аргыг талбарыг судлах үлдсэн ажилд хэрэглэх нь талбарын зөвшөөрөл байгаль орчны болон бусад стандартыг хэрхэн мөрдөхийг баталгаажуулахад нь дэмжигчид туслах болно.

Энэ шатанд засгийн газраас судалгаа явуулах буюу талбарын зөвшөөрөл ба зочлогсдийн ашиглалт зэрэгтэй холбоотой асуудлаар мэдээлэл өгөх нь зүйтэй болохыг санал болгож байна.

Орон нутгийн бүлэгтэй холбоо тогтоох аливаа батлах ажиллагааг удирдан зохицуулах ажлыг холбогдох агентлаг эсвэл бүлгийн байгууллалагуудаар дамжуулан засгийн газар сайтар гүйцэтгэх хэрэгтэй.

Дэмжигч нь талбараа судлах, дэд бүтэц ба үйлчилгээний боломжуудыг гаргах, зах зээлийн шинжилгээ хийх болон бусад концепцид тусгагдах асуудлуудад анхаарлаа хандуулна.

Нууц материал болон оюуны өмчийг хамгаалах нь

Дэмжигчийн хөгжлийн концепцид орсон оюуны өмч болон арилжааны нууц мэдээллийн хамгаалалт баталгаатай байх нь үйл ажиллагааны энэ шатанд орлого-зарлагын тооцоо гаргах тэдний ухамсарт нөлөөлнө. Дэмжигчийн арилжааны үйл ажиллагааны тухай мэдээлэл болон талбартай холбоотой дэлгэрэнгүй саналыг арилжааны дотоод нууц мэдээлэл гэж үзнэ.

Олон нийт ба талуудын ойлголт

Концессийн үйл ажиллагааны энэ шатанд талууд болон бүлгүүдэд концессийн үйл явц, боломжит өгөөжийн талаар засгийн газрын зүгээс үргэлжлүүлэн мэдээлж мөн (шаардлагатай тохиолдолд) орон нутгийн бүлэг болон талуудад (жишээ нь талбарын зөвшөөрөл, орон нутгийн малчид ба аялал зугаалгын ашиглалт) үзүүлж болох нөлөөлийн талаар дэлгэрэнгүй хэлэлцүүлгэ эхлүүлэхийг зөвлөж байна. Бүлгийн зүгээс байгалийн болон соёлын үнэт зүйлд бүтээн байгуулалт хэрхэн нөлөөлөх талаар, мөн тухайн газрыг нийтээр ашиглах тухайд санаа зовинож бас шийдвэрийг хэрхэн гаргаж байгаа талаар болон үйл явцад хэрхэн оролцох талаар мэдлэг дутагдаж байж болно. Шийдвэр гаргах үйл явцад ил тод байдлыг хангахгүй байх нь нийтийн эзэмшлийн газарт ажилжааны бүтээн байгуулалт байгуулах талаарх олон нийтийн итгэл, дэмжлэгийг бууруулж магадгүй.

Олон нийт болон талуудад ирээдүйн бүтээн байгуулалтын талаар эхний шат болон бүхийл шатны туршид мэдээлж олон нийтийн саналыг тусгах боломжийг хангах, энэ үйл ажиллагааны үр дүнд олон нийтийн хандлагыг мэдэх мөн үйл ажиллагааны эцсийн шатнаас өмнө олон нийтийн санааг тусгахад (олон нийтийн санал илэрхий болж үйл ажиллагааны хугацааг хойшлуулахад хүргэж болзошгүй тохиолдолд) тустай.

Гол зөвлөмжүүд– Концепц боловсруулах үе шат

- ▶ Засгийн газрын худалдан авах ажиллагаа болон батлах үйл ажиллагаанд кейс менежментийн аргыг хэрэглэх нь хөрөнгө оруулагчдийн зарцуулах цаг, зардлыг бууруулах мөн ил тод, тууштай байхад хэрэгтэй.
- ▶ Хөрөнгө оруулагч нар арилжааны дотоод нууц мэдээлэл болон оюуны өмч нь хамгаалагдсан болох тухай итгэлтэй байх нь чухал.
- ▶ Концесстой холбоотой худалдан авалт, батлах ба захиргааны ажилтай холбоотой үйл ажиллагаа нь засгийн газрын тэгш эрхийг хангах, ил тод байх ба тууштай байдлыг хадгалах шаардлагуудтай нийцсэн байх шаардлагатай.
- ▶ Хангалттай нөөц ба туршлагажсан төрийн албан хаагчид амжилттай концессийн үйл явцыг хянах шаардлагатай.

Эцсийн үнэлгээний шалгуур

Хэрэглэхэд тодорхой шалгуур ба ил тод үйл явц нь сүүлийн шатанд буюу концепцийн загвараа гаргаж, эзэмших эрхээ хэлэлцэн тохиролцох шатны дэмжигчийг тодруулах шийдвэр гаргахад чухал болно. Урт хугацааны өгөөжийг тооцож үнэлгээг явуулах шаардлагатай ба том хэмжээний концессоор бүтээн байгуулалт хийж санхүүгийн бие даасан байдалд хүрэхэд ихэнх тохиолдолд хэдэн жил шаарддаг болохыг анхаарах хэрэгтэй. Мөн орон нутгийн бүлэгт өргөн хүрээнд өгөөжөө өгөх болон засгийн газарт өгөх санхүүгийн дундаж өгөөжөөс төслийн олон тооны үр нөлөө гарахыг ч бас анхаарах шаардлагатай. Ихэнх тохиолдолд засгийн газарт санхүүгийн дундаж өгөөжөө өгөх явдал хэрэгжиж биелэхэд хэдэн жил шаардагддаг. Эдгээрийг харгалзан үзэж эцсийн үнэлгээний шалгуурт оруулах шаардлагатай байж болзошгүй зүйлсийг доор оруулав.

- ▶ Байгаль орчин ба санхүүгийн тогтвортой байдлын шалгуураар саналыг дахин дүгнэх.
- ▶ Засгийн газар ба бүлэгт хөрөнгө оруулалтаас орох (нийгмийн ба хамгааллын) дундаж өгөөж
- ▶ Орон нутгийн бүлэгт өгөх өгөөж
- ▶ Харилцагчдийн үйл ажиллагаатай холбоотой хамгийн бага хэмжээний нөлөөллийг ч оруулан тухайн газрын бусад ашиглагчид ба зочлогсодтой харилцах ба нөлөөллийг зохицуулах арга хэмжээ
- ▶ Бизнес эрхлэгч ба хамгаалалттай газрын ажилтнуудад тухайн газар дээр нь тохиолдох асуудлууд ба урт хугацааны үр дүнтэй хамтын ажиллагааны боломжууд
- ▶ Төслийн үр дүнд олон нийтийн хамгаалалттай газрыг дэмжих ба хандах хандлагын түвшин нэмэгдэх.

6.7 Концепцийг эцэслэх ба Концессийн гэрээ/Батлах үйл ажиллагаа

Энэ шатанд сүүлийн дэмжигч засгийн газрын агентлагуудтай хамтран ажиллаж эцсийн концепц болон талбарын загварыг тодорхойлно. Энэ санал нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээ ба бусад төлөвлөгөөний батлалт болон мөн холбогдох хуулийн дагуух эзэмших эрх эсвэл гэрээний хууль ёсны субъект болно. Хуулийн заалт болон бүтээгдэхүүнээс хамааралтайгаар өөр төрлийн эзэмших эрх эсвэл гэрээ байгуулж болох эсэх талаар шийдвэрлэхийг тэмдэглэж байна. Концессийн гэрээтэй

холбоотой гаргасан зарчмуудыг бусад төрлийн эзэмших эрх эсвэл гэрээнүүдэд ашиглаж болохоор зориулагдсан.

Концепцийн загварыг эцэслэх ба төслийг эцэслэн батлах шаардлагуудыг мөрдөх явцад тодорхой хэмжээний үйл ажиллагааны давхцал гарч болно. Төслийг батлах, талбарын загвартай холбоотой агентлагуудын хооронд өөр өөр сонирхол, эрхзүйн болон шаардлага байж болох юм. Бүтээн байгуулалтын агуулга, шинж ба байршилаас хамааран олон төрлийн хууль эрхзүй болон орон нутгийн төлөвлөгөөний шаардлагын дагуу албан ёсны зөвшөөрөл авах шаардлагатай болж болно.

Энэ шатанд боловсруулагчид шаардлагатай бүхийл мэдээллийг хүргэх ажлыг зохион байгуулж үйл явцыг дэмжих, шаардлагатай бус саатлаас сэргийлэх, засгийн газрын агентлагуудыг бүтээн байгуулалтын төлөвлөлтөнд нийтээрээ оролцохыг уриалах, зөвлөх ба батлах үйл ажиллагааг ончтой болгоход кейс менежментийн арга чухал үүрэгтэй.

Концессийн гэрээний агуулга

Уул нь засгийн газар үйл ажиллагааны эхэнд тодорхой хугацаа ба нөхцлийг тодорхойлж (Зөвлөмжийг үзэх), томоохон концессийн нарийн дэлгэрэнгүйг энэ шатанд хэлэлцдэг байхаар үлдээх нь зохимжтой. Концессийн гэрээ нь засгийн газрын зорилт (жишээ нь тогтвортой үр дүн) болон хөрөнгө оруулагчдийн зорилгыг (жишээ нь арилжааны ашиг ба баттай байдал, зах зээлийн шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн гаргах, тогтвортой байдлын зорилт) хангаж байх үйл ажиллагааг нэгтгэн агуулсан байх хэрэгтэй.

Засгийн газрын болон хөрөнгө оруулагчийн аль алины зорилтыг хангахуйц байж хамтарсан ба үр дүнтэй байхад нөлөөлөх концессийн гэрээний агуулга нь доорхийг тусгах:

- ▶ Эзэмших эрхийн хугацаа;
- ▶ Байгаль орчин, нийгэм ба соёлын тогтвортой байдал;
- ▶ Хамтарсан ажлын үр дүнд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн таатай үр дүнд хүрэхэд шаардлагатай арга хэмжээнүүд

Эзэмших эрхийн хугацаа

Аялал жуулчлалын бүтээн байгуулалтын арилжааны оршин тогтнол нь хөрөнгө оруулалтаас хангалттай орлого олох боломжийг олгох ёстой эзэмших эрхийн хугацаанаас маш их хамааралтай. Үйл ажиллагаа эрхлэх концессийн хувьд энэ нь хамаарал багатай буюу 5 жил хүртэл хугацаатай байхад боломжтой. Томоохон буюу илүү цогц концессийн хувьд санхүүгийн чадвартай болж явагдаж байгаа дэд бүтэц ба үйлчилгээгээ тэтгэж чадах хэмжээнд хүрэхэд эзэмших эрхийн хугацаа нөлөөлж болно.

Концессийн гэрээний хугацаа богино байх тохиолдолд эзэмших эрхтэй холбоотой шийдвэр саатах ба шинэчлэх эсэх нь тодорхойгүй байх зэрэг нь хамгаалалттай болон байгалийн үзэсгэлэнт газар аялал жуулчлалын хамтарсан үйл ажиллагаа эрхлэх сонирхлыг бууруулдаг болохыг хөрөнгө оруулагчид олон тайланд тэмдэглэжээ. Богино хугацааны гэрээ ба гэрээг шинэчлэх эрх дутагдалтай байх нь хөрөнгө оруулагчдад шинэ санаачлага хэрэгжүүлэх, үйл ажиллагаагаа сайжруулах зэрэгт санхүүжилт олоход нь хүндрэл учруулж өндөр чанартай үйлчилгээ үзүүлэх ба засвар тохижолт хийх хөрөнгө оруулалтын сонирхлыг бууруулдаг. Дэлхийн улсууд дахь хамгаалалттай газарт олгогдсон концессийн гэрээний хугацааг хуулиар дээд тал нь 10-50 жил байхаар тогтоосон байдаг бол зарим тохиолдолд концессийн бодлогоор шийдвэрлэнэ хэмээн үлдээсэн нь ч байна.

Томоохон эсвэл гол концессуудын хувьд оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөж чадахуйц талбар эзэмших эрхийн хугацаа нь багаар бодоход 20 жил, томоохон дэд бүтэц оролцуулсан төслүүдийн хувьд 30-50 жил байхаар байна. Концессийн гэрээг шинэчлэх эсвэл дуусгавар болохтой холбоотой урамшуулал эсвэл боломж бүрдүүлсэн байх нь олон хөрөнгө оруулагчдийн хувьд тааламжтай

нөхцлийг бүрдүүлж гэрээний хугацаанд бүтээгдэхүүнээ үргэлжлүүлэн сайжруулах урамжуулал болдог.

Зарим концессийн хувьд зочлогсод санал болгосон бүтээгдэхүүн ба түүний зах зээлд сонирхолтой байх байдал нь мөн үйл ажиллагаа эрхлэгчийн явуулдаг бусад төрлийн үйл ажиллагаатай (тухайлбал явган аялах, туулах чадвартай машинаар аялах, завиар аялах зэрэг) ойр холбогдсон байж болно.

Хамгаалалттай газарт эдгээр үйл ажиллагаатай холбоотой аливаа зөвшөөрөл эсвэл лицензийг олгоходоо гол талбарын эзэмшлийн хугацаатай уялдуулан шийдвэрлэх нь энэхүү туршилтын саналыг хамгаалахад тус болох ач холбогдолтой.

Тогтвортой байдлын нөхцлүүд

Талбар эсвэл үйл ажиллагаанд зориулсан концессийн гэрээ нь уг бүтээн байгуулалт байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлын зорилгод хүрэх болон талбарын дотор ба ойр байгаа үнэт зүйлсийг хамгаалах баталгаа болох зохицуулалтын гол хэрэгсэл болно. Бүтээгдэхүүн ба түүний үйл ажиллагаатай холбоотой нөхцлүүдийг жишээлбэл байгалийн болон соёлын өвийг хамгаалах тусгай арга хэмжээ, бохирдолоос сэргийлэх, талбарт нэвтрэх зохицуулалтууд, бусад зочлогсодтой холбоотой асуудлууд зэргийг гэрээнд тусгаж энэ зорилтыг хангаж болох юм. Түрээс нь мөн менежмент хариуцсан агентлагууд болон концесс эзэмшигчийн байгаль орчны менежмент ба хууль тогтоомжтой нийцэх байдалтай холбоотой хүлээх хариуцлагыг тодруулж өгч болно.

Концессийн гэрээ нь нийцсэн үйл ажиллагааны талаар болон нийцээгүй үйл ажиллагаа явуулах, явуулсан тохиолдолд ноогдуулах шийтгэлийн талаарх журмыг тусгасан мониторинг ба тайлангийн загварыг оруулсан байх хэрэгтэй. Энэ үйл ажиллагааны үр дүнг хангах ба бизнес эрхлэгчийг эдгээр асуудлыг шийдвэрлэж чадахуйц байлгахад дээрх заалтууд арилжааны хувьд голч байж нөлөөнд өртсөн зүйлийг сайжруулах санхүүжилтийг батлах нь хэцүү биш байх нь чухал. Мөн гэрээг зөрчсөн талаар менежмент хариуцсан агентлагаас албан ёсны бичиг ирүүлж авах шаардлагатай арга хэмжээ ба үүнийг гүйцэтгэх хугацааг оруулсан байвал зохистой.

Хэрэгжих боломж ба гүйцэтгэлийн арга хэмжээнүүд

Хэрэв тухайн газарт аялал жуулчлалын дэд бүтцийг сайн хөгжүүлэхгүйгээр бүтээн байгуулалтыг анхлан хийж байгаа бол хамтарсан үйл ажиллагаа эхэлж харилцагчдийг татах хүртэл олох орлого бага байх болов уу хэмээн аялал жуулчлалын үйл ажиллагааг олон жил явуулагсад үзэж болох талтай. Үйл ажиллагааны эхний 5 жилд санхүүгийн зөөлөн нөхцөлтэй заалт санал болгох нь бүтээн байгуулагчийг анхны хөрөнгө оруулалтаа талбартаа бүрэн оруулах мөн зах зээлд хөлөө олоход нь тустай.

Концесс хэрэгжих боломж нь засгийн газар дараа нь тухайн газрын ойролцоо өрсөлдөгч бүтээн байгуулалтыг дэмжиж батлах эсэхээс мөн хамаарах бөгөөд бүтээн байгуулагчид үүнийг тэдний анхдагч байсан хүчин чармайлт, алсын харааг ганхуулсан хэрэг гэж үзэх талтай.

Бүтээн байгуулагчийн итгэл, ирээдүйд оршин тогтнох чадварыг доорх байдлаар нэмэгдүүлж болно:

- Тусгай тохиролцоо (жишээ нь талбар ашиглах эсвэл бүтээгдэхүүн/үйл ажиллагаа эрхлэх онцгой эрх);
- талбарын эргэн тойрон өрсөлдөгчгүй бүс байх;
- бүтээн байгуулалтын боломжууд ойролцоо гарах тохиолдолд тэдгээрийг эрхлэх боломжийг бүтээн байгуулагчид олгох.

- ▶ Концессийн гэрээний заалтууд нь өндөр зэрэглэлийн үйл ажиллагаа эсвэл тогтвортой үр дүнд хүрэхэд сайнаар нөлөөлж болно. Жишээ нь гэрээг шинэчлэхийг байгаль орчны болон бусад зорилтыг эсвэл бүлэгт өгөөжөө өгсөн (ажлын байр, сургалт гэх мэт) байдлаар нь дүгнэж шийддэг байж болно. Үүнтэй төстэйгээр санхүү ба эсвэл байгаль орчин, нийгэм ба эдийн засгийн талаар хийхээр бэлтгэсэн хөрөнгө оруулагчийн амлалтын хэмжээнээс гэрээний хугацааг хамааруулж болно.

Засгийн газруудаас бусад газрын концесст санал болгодог бусад арга хэмжээ (гэрээнд заавал тусгах шаардлагагүй)-нд талбар дээр нь үзүүлэх дэмжлэг эсвэл сонирхолтой хөрөнгө оруулалтыг дэмжих ерөнхий дэмжлэг, үйл ажиллагаа зэрэг орсон болно. Зарим жишээ дурьдвал:

- ▶ Талбарт нэвтрэх чухал дэд бүтцийг барихад дэмжлэг үзүүлэх (Кейс Судалгаа 3-ыг үзэх: Southern Ocean Lodge Kangaroo Island);
- ▶ Нэвтрэх замыг засах, арчлах;
- ▶ Талбарын бүтээн байгуулалт болон дэд бүтцийг түймрийн эрсдэлээс сэргийлэх менежмент;
- ▶ Хамгаалалттай газрын байгууламжууд ба дэд бүтцийг бизнес эрхлэгч ашиглах заалтууд (жишээ нь цэвэрлэх байгууламжууд, усны хангамж, эрчим хүч, ачаа тээврийн үйлчилгээ, илүү байшин барилгыг ашиглах гэх мэт);
- ▶ Тодорхой бүтээн байгуулалтанд оруулах хөрөнгө оруулалтанд татварын хөнгөлөлт үзүүлэх (Кейс Судалгаа 11-ийг үзэх: Kenya Wildlife Service)

Гэрээнд санал болгох агуулга

Хавсралт 4 –д концесст зориулагдсан нийтлэг түрээсийн агуулгууд ба нөхцлүүдийг харуулсан. Засгийн газар ба хөрөнгө оруулагчдад хүсэмжит үр дүнд хүрэхэд шаардлагатай түрээсийн гол заалтуудыг тогтвортой эко бүтээгдэхүүнийг бий болгох арга хэмжээний жишээнүүдийн хамт доорх Хүснэг 7-д тоймлов.

Тухайн тохиолдол бүрт шаардлага хангах нөхцлийг тохиролцоход уян хатан байх шаардлагатай учраас доорх нь зааж сургасан байхаар тооцоолоогүй болно.

Хүснэгт 10. Концессийн гэрээний гол хүчин зүйлүүд

Заалт	Боломжит Агуулга
Гэрээний зорилго	Талбарт хийгдэх бүтээгдэхүүн, үйл ажиллагаа ба хавсарга үйлчилгээний талаарх тодорхойлолт
Гэрээний хугацаа	Бүтээн байгуулалтын хэмжээ, зорилго ба чанартай бүтээгдэхүүн гаргахад шаардлагатай арилжааны бодит өгөөжийг харгалзах
Гэрээний сунгалт	Шилдэг үйл ажиллагаа нэвтрүүлэхийг урамшуулах зорилгоор байгаль орчны болон бусад зорилтыг хэрхэн хангаснаар нь сунгалт хийх эсэхийг шийдэх Концесс эзэмшигчийн гэрээ шинэчлэх эсвэл тухайн газар аялал жуулчлалын аливаа талбарт ирээдүйд бүтээн байгуулалт хийх саналд “Татгалзах Эхний Эрх”-тэй байх нь хөрөнгө оруулагчдад тэдний эхэлсэн ажлыг өрсөлдөгчид ашиглан байр суурийг нь ганхуулахгүй байхад итгэлтэй байх боломжийг олгоно.
Түрээс	Газрыг тодорхой хугацаанд ашиглуулснаас засгийн газар ашиг олох ханш Бүтээн байгуулалт, үйл ажиллагааг эхлүүлэх, барихад орох хугацааг харгалзан түрээсийн боломжит шатлалыг нэвтрүүлэх Онцгой нөхцөл байдалд таарах түрээсийн хэлбэрийг тогтоохдоо уян хатан байх. Бизнес эрхлэгчид тогтсон түрээс төлөхөөс илүүтэй орлогоос хувь төлөхийг илүүд үзэж болох .
Нийтлэг заалтууд	Гэрээг цуцлах эсвэл гэрээний нөхцөлийг зөрчих ба засаж сайжруулах, урамшуулал ба гэрээг дуусгавар болгоход хүргэх тохиолдлуудыг хамруулах, Байгалийн болон соёлын өвийг хамгаалах байгаль орчны ба бусад арга хэмжээтэй нийцүүлэхэд заалтуудын зөрчлийг ашиглаж болно. Гэхдээ эдгээр заалтууд арилжааны хувьд голч байж нөлөөнд өртсөн зүйлийг сайжруулах санхүүжилтийг батлах нь хэцүү биш байх нь чухал. Мөн гэрээг зөрчсөн талаар газрын менежмент хариуцсан агентлагаас албан ёсны бичиг ирүүлж авах шаардлагатай арга хэмжээ ба үүнийг гүйцэтгэх хугацааг оруулсан байвал зохистой.
Уялдаа холбоо	Тогтмол хурал \улирал бүр\ зохион байгуулах нь ажлын уялдаа холбоо хангах, мэдээлэл авах сайн арга дэмжлэг болно. Мөн Концесс эзэмшигчидтэй сониноор дамжуулан аль аль талын сонирхож буй асуудлаар хэлэлцэх, сайн ажиллагаатай концесс эзэмшигчдийг танилцуулах аргыг ашиглан өргөн хэмжээнд мэдээлэл солилцож харилцах нь чухал(US Parks Service Greenline-ийг үзэх).
Хууль эрхзүй ба журам	Холбогдох хууль дүрэм, журмуудтай нийцүүлсэн талуудын хүлээх үүргийг тодорхойлсон тойм
Бүтээн байгуулалт хийх	Бүтээн байгуулалтын ажлын талаар ил тод байх, эхлэх ба дуусах хугацаа, Барилгын материал ба арга, байгаль орчны нөхцлүүд ба нөхөн сэргээх шаардлагууд Бүтээн байгуулагч Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө бэлтгэж барилга барих ажилд шаардлагатай сайн туршлагаас хэрэгтэй бүхийл зүйлийг оруулах.
Байгаль орчинд тогтвортой үйл ажиллагаа ба менежмент	Бүтээн байгуулалтаас шалтгаалан нөхцлүүд нь дараах хүчин зүйлүүдийг тусгаж болно: <ul style="list-style-type: none"> › Талбар байх ирэх ажилтнууд\зочлогсдийн тооны дээд хязгаар › Хүрэх\очих зохицуулалт болон тээврийн арга хэмжээ › Усны суваг, хөрс, ус ба экосистемийн менежмент › Хог, ус ба эрчим хүчний менежмент, › Дуу чимээ ба агаарын чанар › Соёлын үнэт өвийн менежмент › Түймрээс сэргийлэх ба түймрийн менежмент › Зочлогсдийн үйл ажиллагааг хамгийн бага нөлөөлөлтэй байлгах шаардлагууд (хэрэв тусдаа зөвшөөрөл аваагүй бол) › Засвар үйлчилгээ ба сайжруулалт хийх шаардлагууд › Ажилтнуудын сургалт ба мэдээлэл › Мониторинг, тайлан ба аудит (тэдгээрийн дүрмэндээ тусгах хариуцлагууд) › Үйл ажиллагаа, менежмент ба засвар үйлчилгээ явуулах Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө бэлтгэх нь тогтвортой үйл ажиллагааны сайн

Заалт	Боломжит Агуулга
	туршлага болно. Энэ нь олон оронд Эко-гэрчилгээ олгох нөхцөл болдог.
Бүлэг ба бусад зочлогсодтой харилцах харилцаа	Орон нутгийн бүлэгтэй уялдаатай ажиллах ба тэдэнд үзүүлэх нөлөөллийн менежмент <ul style="list-style-type: none"> ▶ Бусад зочлогсод ба тэдний үйл ажиллагаа мөн бусад ашиглагчдад бүтээн байгуулалт болон тэдний хамтрагчдийн үзүүлж болзошгүй нөлөөллийн менежмент
Хамтын ажиллагааны боломжууд	Засгийн газартай хамтран ажиллахаар хэлэлцэн тохирсон хамгаалалттай газрын менежмент, интерпретац, орон нутгийн бүлэгт өгөх өгөөжийн асуудал. Жишээлбэл: зүйлийн мониторинг, хог ургамлын менежмент, бүтээгдэхүүн, үйлчилгээг орон нутгаас хангах, орон нутагт ажлын байр бий болгох ба сургалт зохион байгуулах

Гол зөвлөмжүүд –Эцсийн концепц ба Концессийн гэрээ

- ▶ Засгийн газрын хангалттай нөөц ба тохирсон туршлагатай ажилтнууд нь хөрөнгө оруулагч болон Засгийн газартай ажиллаж концессийн амжилттай гэрээг тохиролцож эцсийн концепцийг бүрдүүлэх шаардлагатай.
- ▶ Талбарыг эзэмших эрхийн хугацааг анхны оруулсан хөрөнгө оруулалт, түүний энэ хөрөнгө оруулалтаас олох үр ашгийг харгалзах (жишээ нь: томоохон дэд бүтцийн хувьд 30-50 жилийн хугацаатай), мөн эрхийг сунгахдаа боломж эсвэл урамшуулалыг харгалзан тогтоох хэрэгтэй.
- ▶ Концесс өндөр түвшинд хөрвөж байх баталгаа нь ихэнх тохиолдолд засгийн газрын дэмжлэг байна.
- ▶ Онцгой зохицуулалт, бүтээн байгуулалтын ойролцоо өрсөлдөөнийг хязгаарлах эсвэл бүтээн байгуулалтын боломжууд ойролцоо гарах тохиолдолд тэдгээрийг эрхлэх боломжийг бүтээн байгуулагчид олгож бүтээгдэхүүн\үйлчилгээгээ зах зээлд гаргах боломжийг сайжруулах
- ▶ Үйл ажиллагааны эхний 5 жилд санхүүгийн санхүүгийн зөөлөн нөхцөлтэй заалт санал болгох нь бүтээн байгуулагчийг анхны хөрөнгө оруулалтаа талбартаа бүрэн оруулах мөн зах зээлд хөлөө олоход нь тустай.
- ▶ Засгийн газрын бүхийл агентлагууд шинэ ажил\бүтээн байгуулалт-ын ард гарахын тулд Кейс менежмент ба газрууд\департамент хоорондын зохицуулалттай ажиллах нь чухал.
- ▶ Төрийн бусад байгууллагад (жишээ нь: Аялал жуулчлал Соёлын газар эсвэл бусад төстэй) дэмжлэг үзүүлэх ажлыг дэмжих нь зүйтэй.
- ▶ Том концессийн үйл ажиллагаатай холбоотой газарт бага хэмжээний аливаа концессийг олгохдоо боломжтой бол гол талбарын эзэмшлийн хугацаатай уялдуулан шийдвэрлэх нь чухал.

7 КОНЦЕССИЙН МЕНЕЖМЕНТИЙН СТРАТЕГИ БА ҮЗҮҮЛЭХ ТУРШИЛТЫН ТАЛБАРУУД

7.1 Орхоны Хөндийн Байгалийн Цогцолбор Газар

Өнөөгийн байдал

Орхоны Хөндийн Байгалийн Цогцолбор Газар нь SPAN төслийн үзүүлэх туршилтын хоёр талбарын нэг юм. Улаанбаатар хотоос 360 км-ийн зайд орших энэ цогцолбор газар нь 1996 онд байгуулагдаж 2006 онд бүсчлэлийг нь шинэчлэн тогтоосон байна. Цогцолбор газар 353.000 га талбайг хамардаг.

Хамгаалалттай газрын дотор таван жилийн зөвшөөрөлтэй 21 жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байна. Хамгаалалттай газар энд байгаа жуулчны баазуудаас ямар ч орлого авдаггүй. Гэр бааз барих тухай хүсэлт гаргасан тохиолдолд хамгаалалтын захиргаанаас зөвшөөрлийг олгох эсэх тухай саналаа Захиралд\БОНХЯ-ны ТХГНУГ-ийн даргад илгээдэг.

Хамгаалалттай газарт явагдаж байгаа аялал жуулчлалын бусад боломжууд:

- 14 хоногийн морин аялал (Монгол-Францын хамтарсан компани)
- Жуулчны улирлын оргил үеэр орон нутгийн гэр бүл булгийн цэвэр ус зочлогсод борлуулах.
- Төвхөн хийд рүү мориор тээвэр хийх (гадаадын хүн 15,000 төгрөг, дотоодын хүн 7,000 төгрөг, харин гадаадынхны 70% нь явганаар аялж хүрдэг)
- Төвхөн хийдийн ойролцоо хоноглох (ямар нэгэн төлбөр авдаггүй)
- Аялалын бизнес эрхлэгч олон хүн\байгууллага цогцолбор газарт зочлогсдийг авч ирдэг.
- Цогцолбор газар жилд ойролцоогоор 30000 зочин хүлээж авдаг. Цогцолбор газрын нэвтрэх зөвшөөрлөөс олдог орлого нь ойролцоогоор 21 сая төгрөг. Цогцолбор газарт үүнээс багахан нь эргэж ирдэг.

Орхоны Хөндийн Байгалийн Цогцолбор Газрын Аялал Жуулчлалын Менежментийн Төлөвлөгөө 2012 – 2015 нь цогцолбор газарт байгаа аялал жуулчлалын хөгжлийн өнөөгийн байдлын шинжилгээг иж бүрэн хийсэн. Энэ нь өнөөгийн давуу болон сул тал мөн төлөвлөгөөний зорилт, зорилгыг тодорхойлжээ. Давуу болон сул талын шинжилгээ нь менежментийн өнөөгийн асуудлуудыг шийдвэрлэх талаар концесс хэрхэн хамгийн үр дүнтэй ажиллахыг тодорхойлоход маш чухал болно:

<p>ДАВУУ ТАЛУУД</p> <ul style="list-style-type: none"> ➢ Өргөн уудам онгон зэрлэг нутаг ба түүх, соёлын маш их нөөц ➢ Эртний Монголын түүх, соёлын дурсгалт газар хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн ➢ 2004 онд ЮНЕСКО-гийн Дэлхийн Соёлын өвд бүртгэгдсэн ➢ Улаанбаатар хотод харьцангуй ойр ➢ Дэд бүтэц боломжийн хөгжсөн ➢ Монголын аялал жуулчлалын уртраг, өргөргийн дагуух замын уулзвар ➢ Орон нутгийн иргэд болон ажилтнууд нь аялал жуулчлалын бага зэрэг 	<p>СУЛ ТАЛУУД</p> <ul style="list-style-type: none"> ➢ Жуулчдад зориулсан мэдээлэл хомс ➢ Зарим газарт жуулчны баазууд хэт бөөгнөрсөн ➢ Байрны чанар муу ➢ Идэвхтэй бус аялал жуулчлалын хэвшил ➢ Жуулчны маркетинг ба сурталчилгаа, бодлого сул ➢ Гадаад, дотоодын зочлогсдын талаар мэдээ цуглуулдаггүй ба нэгдсэн мэдээлэл байхгүй ➢ Орон нутгийн түвшний аялал Lack of local level tourism policy
<p>БОЛОМЖУУД</p> <ul style="list-style-type: none"> ➢ Эко, соёлын, адал явдалт болон шашны аялал жуулчлал хөгжүүлэх өргөн боломж ➢ Бусад хамгаалалттай газрын ХЗ-тай хамтран ажиллах үйл ажиллагааг 	<p>АЮУЛУУД</p> <ul style="list-style-type: none"> ➢ Байгаль, хүний нөлөөгөөр түүх ба соёлын газрууд эвдрэх, гэмтэх ➢ Бусад сайн сурталчлагдсан бүсүүдэд жуулчдаа алдах

<ul style="list-style-type: none"> ▶ өргөжүүлэх боломж ▶ Соёлын болон шашны аялал жуулчлалаар Азийн жуулчдын анхаарлыг татах ▶ Аялал жуулчлалын үйлчилгээг сайжруулснаар жуулчдын тоог нэмэгдүүлэх ▶ Уул уурхайн хэвшилт ажилладаг гадаадын хүмүүст зориулсан хөтөлбөр зохиож олон тооны жуулчин хүлээж авах ▶ ОХБЦГ-т Аялал Жуулчлалын Үндэсний Цогцолбор байгуулах зэрэг үндэсний хэмжээний бодлого 	<ul style="list-style-type: none"> ▶ Байгаль орчны бохирдол ▶ Зохион байгуулалтгүй дотоодын жуулчдаас үүдэлтэй сөрөг нөлөө
--	--

Төлөвлөгөөний зорилт ба зорилго мөн гол үйл ажиллагааг доор тоймлов. Хүснэгэнд тодруулсан үйл ажиллагаануудад концессийн стратегийг хэрэгжүүлэн дэмжлэг үзүүлж болно.

Зорилт 1: Онгон байгаль, түүхийн дурсгал ба соёлын өвийг хамгаалах

№	Үйл ажиллагаа	Үр дүнгүүд	Хариуцагч	хугацаа	Ач холбогдол
1.1	Хамгаалалттай газрын ач холбогдолыг таниулах, сурталчлах зорилгоор байгаль, түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулах	Аялал жуулчлалын ачааллыг бууруулж аялах газар, хүмүүсийг татдаг газруудын талаар дэлгэрэнгүй судалгаа явуулж түүндээ үндэслэн аяллын хөтөлбөрийг уртасгах	ОХБЦГ-ийн ХЗ, “SPAN” төсөл, дунд сургуулиуд, ТББ-ууд ба орон нутгийн захиргаад	2012 оны 10 сараас эхлэн	Хамгийн чухал
1.2	Хамтын гэрээг үндэслэн хамгаалалтын үүргийг орон нутгийн бүлэгт шилжүүлэх	Аялал жуулчлалын оргил үед хамгаалалтын журмыг мөрдүүлэх	ОХБЦГ-ийн ХЗ, “SPAN” төсөл, ТББ-ууд, орон нутгийн захиргаад, бүлгэмдлүүд	2012 оны 10 сараас эхлэн	Хамгийн чухал
1.3	Төвхөн хийд, Улаанцутгалангийн хүрхрээ, Хүйсийн Найман нууранд аялал жуулчлалын даацад үндэслэгдсэн бодлого	Төлөвлөгөөний дагуу хогийн менежментийн арга хэрэгслийг ашиглах нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулахад тустай	ОХБЦГ-ийн ХЗ, Өвөрхангай аймгийн Байгаль Орчин аялал жуулчлалын газар, орон нутгийн захиргаад, “SPAN” төсөл	2012 оны 10 сараас эхлэн	Хамгийн чухал
1.4	ОХБЦГ-т аялал жуулчлалыг зохицуулах бодлого боловсруулан хэрэгжилтийг хянах	Жуулчдын нөлөөлөл ба шаардлагад үндэслэгдсэн зохицуулах дүрэм	ХЗ ба менежментийн зөвлөл	2013	Хамгийн чухал
1.5	ОХБЦГ-т нэвтэрсний хураамжаас олсон орлогын тодорхой хувийг зарцуулах	Нэвтэрсний хураамжаас олсон орлогын 30 хувийг хамгаалалттай газарт аялал жуулчлал хөгжүүлэхэд зарцуулна.	БОАЖЯ, ХЗ ба менежментийн зөвлөл	2013 оноос	чухал

Зорилт 2: аялал жуулчлалд хамаатай бүх төрлийн талуудтай хамтран ажиллах ажиллагааг бэхжүүлэх

№	Үйл ажиллагаа	Үр дүн	Хариуцагч	Хугацаа	Ач холбогдол
2.1	Менежментийн Зөвлөлийн үйл ажиллагааг бэхжүүлэх	Аялал жуулчлалын бодлого ба “Бэлэн мөнгөний эргэлтийн Сан”-ийн дэд бүлэг байгуулах	ХЗ ба менежментийн зөвлөл ба төслүүд	2012 оноос эхлэн	Чухал
2.2	Аялал жуулчлалд хамаатай талууд болон орон нутгийн бүлэг тэй хамтран ажиллах	Бүлгийн төлөвлөлтийн хамтын ажиллагааны хөгжил Нутгийн иргэд нэмэлт орлого олох эх үүсвэрийг нэмэгдүүлэх Гол байршилүүд дахь хогийн менежментийг сайжруулах	ОХБЦГ-ийн ХЗ, “SPAN” төсөл, орон нутгийн захиргаад, бүлгэмдлүүд	2012 оноос эхлэн	Чухал
2.3	Орон нутгийн Зочны байр\ Эко гэрт тавигдах үйлчилгээний стандарт боловсруулан батлах	Орон нутгийн Зочны байрны үйлчилгээ сайжрах	ОХБЦГ-ийн ХЗ, Өвөрхангай аймгийн Байгаль Орчин аялал жуулчлалын газар, орон нутгийн захиргаад, “SPAN” төсөл	2012-2014	Чухал
2.4	Аялал жуулчлалын байгууллагын байгаль орчин хамгаалахтай холбоотой үйл ажиллагааг дэмжих сурталчлах	Байгаль орчны үнэт зүйлийг хамгаалах талаар мэдээлэгдэж мөн үйлчилгээний чанар сайжирна	ОХБЦГ-ийн ХЗ, Менежментийн зөвлөл ТББ-ууд, орон нутгийн захиргаад, аялал жуулчлалын байгууллагууд	2013 оноос	Чухал
2.5	Хамгаалалттай газрын үнэ цэн, байгаль орчин, биологийн олон янз байдал, түүхийн дурсгалууд ба нүүдэлчний амьдралын хэв маягийг сурталчлах, мэдлэг олж авах, мэдээлэл солилцох ажил хийх, бэхжүүлэх	Шинэ хөтөлбөр, чадвар хөгжүүлэх, аялал жуулчлалын аюулгүй байдлын талаар Хөтөч нарт зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах. ОХБЦГ-ын аялал жуулчлалын тогтвортой хөгжилд зориулсан веб хуудас нээх Жуулчдын тоо нэмэгдэх ба дотоодын жуулчдын аялах хандлагад эерэг өөрчлөлт гарах	ОХБЦГ-ийн ХЗ “Дэлхийн Өв - Орхон голын нүүдэлчид-” ТББ ба төслүүд	2012 оноос	Хамгийн чухал
2.6	Брэнд бий болгох: Зөвшөөрөл ба хүлээн зөвшөөрөх	ОХБЦГ-ийн брэнд бий болгох, ОХБЦГ-ийн “Гол” үнэт		Яаралтай	Чухал

		зүйлийг агуулсан брэндийн мөн чанарыг хөгжүүлэх		
2.7	2 жил тутамд явуулах жуулчны судалгааны асуулгад үндэслэн аялал жуулчлалын төлөвлөгөөг шинэчлэх	Судалгааны асуулгад үндэслэн аялал жуулчлалын төлөвлөгөөг шинэчлэх хэрэгтэй		2012 ба 2014 онд Чухал

Зорилт 3: Байгаль орчин ба орон нутагт ээлтэй аялал жуулчлалын дэд бүтэц

№	Үйл ажиллагаа	Тайлбар	Хариуцагч	Хугацаа	Ач холбогдол
3.1	Аялал жуулчлалын хөтөлбөрүүд, замын чиглэл ба хоноглох газрыг заасан мэдээллийн самбар босгох	Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл ба хог тарих асуудлыг зочлогсдийг зөв зохион байгуулснаар арилгана. Төлөвлөгдсөн газруудад хоноглох газруудыг байгуулах	ОХБЦГ-ийн ХЗ	2012 оноос	Чухал
3.2	Аялал жуулчлалын мэдээллийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх	Төвхөн хийд, Улаанцутгалангийн хүрхрээ, Хүйсийн Найман нууранд улирлын чанартай мэдээллийн төв байгуулах	ОХБЦГ-ийн ХЗ “Дэлхийн Өв - Орхон голын нүүдэлчид-” ТББ	From 2013	Чухал

Зорилт1: Байгалийн онгон байдал, түүхийн дурсгалт газар болон соёлын өвийг хамгаалах

Цогцолборт газарт зориулсан менежментийн саяхан батлагдсан төлөвлөгөө байгаа бөгөөд биологын олон янз байдалд учирч байгаа аюул болон тэдгээр аюулыг хэрхэн шийдвэрлэх аргыг энд тусгажээ.

- Хамгийн чухал нь энд аялал жуулчлалтай холбоотой хэд хэдэн асуудал үүсч байгаа талаар хүлээн зөвшөөрсөн бөгөөд эдгээрийн заримыг нь концессийн стратегээр шийдвэрлэж болох юм.
- Дотоодын болон гадаадын жуулчид гал гаргаж болохгүй газарт хоноглон бас хогоо үлдээгээд явдаг тохиолдлууд гарчээ.
- Жуулчид ОХБЦГ-ийн түүхийн болон соёлын дурсгалуудыг үзэхээр очих нэг гол зам байхгүй.
- Түүхийн болон соёлын дурсгалуудыг хамгаалах зөв арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй (мөн тэдгээрийг бүртгэсэн ерөнхий бүртгэл ч байхгүй);
- Нэг газарт хэт олон жуулчны бааз төвлөрсөн нь байгалийн үнэт зүйлд сөргөөр нөлөөлж байна.
- Уул овоо тахих уламжлалт аргыг хэрэглэхээ больсон.
- Дээрх асуудлыг шийдвэрлэх аргыг ингэж тодорхойлжээ. ОХБЦГ-ийн ХЗ нь “Нутгийн иргэдийн бүлэгт түшиглэсэн, байгаль орчинд ээлтэй” аялал жуулчлалын бодлого баримтлан хэрэгжүүлэхдээ;
- Аялах шинэ газруудыг тодорхойлж шон\гэмдэг байрлуулах;

- Орон нутгийн иргэдэд зориулан байгаль орчинд ээлтэй экологийн аялал жуулчлал хөгжүүлэх талаар сургалт явуулах (гар урлал урлах эсвэл тэмээ, морь унуулах гэх мэт);
- Төвхөн хийд, Үүртийн тохой, Улаанцутгалангийн хүрхрээ, Хүйсийн Найман нууранд эко гэр ажиллууулах;
- Байгалийн ба түүхийн аялал жуулчлал хөгжүүлэхэд орон нутгийн малчдыг оролцуулах;
- Хужирт, Хотонт, Хашаат суманд жуулчны бааз барих боломжтой газрууд бий;
- ОХБЦГ-ийн түүх, соёлын дурсгалуудтай газруудад аялал жуулчлал хөгжүүлэхийн тулд жуулчдын тоог хянах шаардлагатай.
- ОХБЦГ-ийн түүх, соёлын дурсгалуудыг хамгаалах, хадгалж үлдэх ажилд орон нутгийн бүлгийн гишүүдийг оролцуулах хэрэгтэй.

Концессийн Менежментийн Стратеги – Зөвлөмжүүд

Менежментийн төлөвлөгөөнд хамгаалалттай газрын үнэт зүйлийг хамгаалах ба концесстой холбоотой асуудлуудыг тодорхойлжээ.

БОНХЯ\ХЗ нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан асуудлууд ба зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд холимог арга хэрэглэж болох юм. Өмнөх бүлэгт тоймилсон эрхзүйн хүрээний нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн тохиолдолд л эдгээр аргуудыг хэрэглэх боломжтой. Үүнтэй уялдан дараах үйл ажиллагааг зөвлөмж болгож байгаа ба нарийвчилсан алхамуудыг Хүснэгт 11-д үзүүлэв.

1. *Үнэт зүйлийг хамгаалахын тулд цогцолборт газрыг ашигладаг бүхийл аялал зохион байгуулагчидтай концессийн гэрээ байгуулах* –үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвшөөрөл олгодог болсноор ХЗ нь түүх, соёлын дурсгалуудтай газруудад аялах замыг хянаж түүх, соёлын дурсгалуудтай газрыг хамгаалах үйл ажиллагааны стандарттай болно.
2. *Концессийг ашиглан зөв газарт хөрөнгө оруулалтыг татах* – цогцолборт газрын нутаг дэвсгэрт жуулчны олон тооны бааз үйл ажиллагаа явуулж байгааг энд тэмдэглсэн ба эдгээр концессийг ирэх 5 жилд шинэчлэхээр төлөвлөгджээ. Энэ хугацаанд нэг эсвэл цөөн тооны бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулах эрхийг өрсөлдөөний журмаар олгох ажил явагдана. Жуулчны баазын концессийг өрсөлдөөний журмаар олгож доорх асуудлыг шийдвэрлэх хэрэгсэл болгон ашиглах:
 - Байгаль орчин, соёл, нийгэм эсвэл зочлогсдийн аюулгүй байдалтай холбоотойгоор хүрч чадахгүй байгаа талбар\газруудад нэвтрэх ажлыг зохион байгуулахад;
 - Зөвшөөрөл хүсэгчдийн тоо нь хүлээн зөвшөөрөх хязгаарыг давсан газруудад нэвтрэх ажлыг зохион байгуулж Хужирт, Хотонт, Хашаат суманд жуулчны баазуудыг шилжүүлэх
 - Зах зээлийг тодорхой хэмжээнд хязгаарлах давуу тал олгодог учраас үйл ажиллагаа явуулах эрхийг өрсөлдөөний журмаар олгохыг бизнес эрхлэгчид дэмжих хандлагатай. Бизнес эрхлэгчдийн чадамжийг өнгөрсөн хугацаанд явуулсан үйл ажиллагааны байдал болон цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах тууштай байдал зэргийг ихэнхдээ харгалзан үнэлдэг.
3. *Концессийг орон нутгийн бүлгийн амьжиргааг дэмжих эсвэл сайжруулах зорилгоор ашиглах*–концессийн тусгай гэрээг тодорхой төрлийн ашиглалтанд онцгой нөхцөлд орон нутгийн тухайлсан бүлэгт шууд олгох:
 - Орон нутгийн бүлгийн зөвлөлдөх хороо, БОНХЯ\ХЗ арилжааны үйл ажиллагааны тохиромжтой боломж бүрдсэн гэж тодорхойлсон газарт (жишээ нь Хүрхрээний дэргэд гар урлалын зүйл борлуулах);
 - Тухайн талбар эсвэл үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдал, байгаль орчин ба түүхийн асуудал байгаа газарт (Төвхөн хийдэд нэвтрэх)

Концессийн ийм төрлийн гэрээ байгуулснаар хамгаалалттай газрын зорилгыг биелүүлэх хамгийн сайн боломж бүрдэнэ хэмээн менежментийн төлөвлөгөөнд тодорхойлжээ.

4. *Хөрөнгө оруулагчдийг урих* – сүүлийн шатанд цогцолборт газрын зүгээс товхимол бэлтгэн гаргахыг зөвлөмжлөв. Товхимолд бусад боломжууд болох өндөр зэрэглэлийн үйлчилгээ бий болгох (цөм газруудад) болон түүхийн аялал, хөтөчтэй аялал ба халуун рашаанд явганаар аялж очих зэргийг тодорхойлж болох юм. Хамгаалалттай газрын менежерийн хэлснээр зөвхөн мориор л явж хүрэхээс өөр очих боломжгүй ер бусын сайхан газрууд цогцолборт газарт байдаг ажээ. Хэрвээ сайн маркетинг, үйл ажиллагаа явуулж чадвал энэ түвшний онцгой эрх нь зочлогсдын сонирхлыг ихээр татах болно.

Бизнесийн төлөвлөгөөг цогцолборт газрын орчны нутгийн иргэдийн зөвлөлгөөтэйгээр бэлтгэх нь чухал. Бизнес төлөвлөгөө нь боломжуудыг тодорхойлж хамгаалалттай газрын хамгаалалтын үйл ажиллагаанд бизнесийн боломжуудаас олсон орлогыг хэрхэн ашиглах талаар мөн дурьдах ёстой. Хэрэв цогцолборт газрын боломжит орлого хангалттай болсон тохиолдолд энэ орлогоос хамгаалалттай газрын тусын тулд орон нутгийн иргэдийг аялал жуулчлалын хэвшилт ажиллах боломжоор хангах эсвэл орон нутгийн бүлгийн зарим төсөлд тухайлбал сургуулийн хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулах нь эргээд цогцолборт газарт тустай.

Хүснэгт 11. Гол үйл ажиллагаа –Концессийн Стратегийн хэрэгжилт-Орхоны Хөндий

Үндсэн чиглэл	Үйл ажиллагаа	Ач холбогдол
Концессийн менежментийн бодлого, зохицуулалтыг бэхжүүлэх	Үндсэн чиглэлийн 1-д заасны дагуу цогцолборт газарт одоо байгаа бүх ашиглагчидтай бодлого, зөвлөмжийг ашиглан 1 хүртэлх жилийн концессийн туршилтын гэрээ байгуулах Хураамж болон орлого хуваалцах тухай зохицуулалтыг орон нутгийн захиргаа, бүлэгтэй харилцан тохиролцох	<i>Өндөр</i>
	Одоо байгаа концесс эзэмшигчидтэй мэдээлэл солилцох албан ёсны мэдээллийн сүлжээ бий болгож мэдээлэл солилцох ба туршилтын концессийн гэрээ хэрхэн ажиллаж байгаа талаар хамтын ажиллагаа тогтоох. Эдгээр мэдээллийг Үндсэн чиглэлийн 1-д заасны дагуу бодлого, удирдамжийг эргэн харахад ашиглана.	<i>Дунд зэрэг</i>
	Концессийн систем бүрэлдмэгц цогцолборт газарт үйл ажиллагаа явуулж байгаа концессийн тоо, төрлийг тодорхойлох. Концессийн тоо, чанарыг хянахын тулд өрсөлдөөний журмаар олгогдох, үр дүнтэй байх концессийн төрлүүдийг тодорхойлох.	<i>Дунд зэрэг</i>
	Тухайлсан концессийг өрсөлдөөний журмаар олгох шаардлагатай эсэх талаар бүлэг ба концесс эзэмшигч нартай зөвлөлдөх .	<i>Дунд зэрэг</i>
	Концесс эзэмшигч нарт өрсөлдөөний журмаар олгох талаар аль болох эрт (хамгийн багаар бодоход 6 сарын өмнө) мэдээлж бэлтгэл хангуулах	<i>Дунд зэрэг</i>
	Бодлого, удирдамжинд заасны дагуу концесс эзэмшигч нарт мэдээлэл, баримт бэлтгэн өгч үйл ажиллагааг зохицуулах	<i>Дунд зэрэг</i>
Тогтолцоо ба бүлгийн хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх	Бүлгийн зөвлөлдөх хороо байгуулж концесс хэрэгжүүлэх ба менежмент хийхэд дэмжлэг үзүүлэх -орон нутгийн бүлэг, захиргаа ба орон нутгийн үйлдвэрлэгчдийн төлөөлөл	<i>Өндөр</i>
	Концессийн стратеги, ашиг тусын талаар сургалт явуулж зөвлөлдөх хорооны чадавхийг бэхжүүлэх	<i>Өндөр</i>

Үндсэн чиглэл	Үйл ажиллагаа	Ач холбогдол
Стратеги ба олон талт бизнес хөгжлийн загвар хөгжүүлэх	Зөвлөлдөх хороотой хамтран цогцолборт газрын бизнес төлөвлөгөө бэлтгэх- үндсэн зах зээлийг тодорхойлох, одоогийн саналд байгаа дутуу орон зай, бүлэг, үйлдвэрлэгчдийн санал болгож болохуйц концессийн хамгийн сайн боломжууд, концессийн шаардлагын биелүүлэхэд шаардлагатай чадавх бүрдүүлэлт зэргийг оруулах. Энд бүх ашиглалтыг буюу нөөцийн ашиглалт, аялал жуулчлал гэх мэт оруулах, Орон нутгийн бүлэгтэй хамтран зөвлөлдөж тэдгээрт шууд олгох концессийн боломжуудыг судлах, Хамгааллын ажилд (хуулийн хэрэгжилт, судалгаа) дэмжлэг үзүүлэх бусад боломжуудыг мөн авч үзэх нэмэр болох,	<i>Өндөр</i>
	Концесс эзэмшигчдийн одоогийн сүлжээг ашиглан орон нутгийн бүлэгт боломж олгох шинэлэг хамтын ажиллагааны хэлбэр бүрдүүлэх, өргөжүүлэх	<i>Дунд зэрэг</i>

7.2 Их Нартын Байгалийн Нөөц Газар

Их нартын чулуу нь Дорноговь аймгийн баруун хойд хэсэгт хээрийн болон говийн ландшафтын хэв шинжит хадархаг нутаг бөгөөд Монгол орны төдийгүй дэлхийн хэмжээнд ховорт тооцогдох аргаль хонь, янгир ямааны тархац нутгийн зүүн захын популяци амьдардаг онцлог нутаг юм.

Их Нарт орчмын газрыг аргаль хонины популяцийн тогтвортой өсч үржих нөхцлийг хангах зорилгоор 1996 онд Байгалийн нөөц газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан. Их Нартын БНГ нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Бичигт баг, Айраг сумын Нарт багийн нутгийг хамран оршдог.

Даланжаргалан сумын Бичигт баг нь нөөц газрын дотор орших ба 124 өрх 414 хүн амтай. Нөөц газрын хилийн дотор 28 малчдын өвөлжөө, хилийн гадна 12 өвөлжөө байдаг. Нарт баг нь мөн нөөц газрын дотор байрлах агаад 211 өрхийн 371 хүн амтай.

Нутгийн иргэдийн амьжиргааны гол үүсвэр нь МАА-н бүтээгдэхүүн ба түүхий эд (жишээ нь: арьс, шир, ноос, ноолуур, мах, сүү болон сүүн бүтээгдэхүүн) ба өрхийн орлогын 60 хувь нь ноос, ноолуур борлуулсны орлогоос бүрддэг.

Малчид МАА-гаас өөр орлогын эх үүсвэртэй болохыг хүсдэг. Жишээ нь Бичигт багийн 25 өрхийн эмэгтэйчүүд “Их Нарт-Бидний Ирээдүй” нэртэй нутгийн иргэдийн байгууллага байгуулж бэлэг дурсгалын зүйл үйлдвэрлэх болон ноосоор гар бүтээгдэхүүн урлаж жуулчид, зочлогсод борлуулж байна.

Аргалийн Судалгааны Төв

Энхүү гайхамшигтай судалгааны төв нь Денверийн амьтны хүрээлэнгийн жилийн 150 мянган ам долларын төсвөөр санхүүждэг. Уг төвд 5 ажилтан, баазын менежер ба хоёр жолооч ажилладаг. Энд аргаль хонь, махчин амьтад ба тасын судалгааны төслүүд явагддаг.

Төв нь олон нийтэд зориулсан нээлттэй өдрүүдтэй ба орон нутгийн багш нарыг сургаж АНУ-тай сургуулийн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлдэг, менежментийг төлөвлөгөөг боловсруулахад мэргэжлийн зөвлөхүүд ажиллуулах(US25,000), хилийн зураас тэмдэглэхэд дэмжлэг үзүүлсэн, Монгол орны байгалийн аялал жуулчлалын бусад бүсэд аялах судалгааны аялал зохион байгуулах зэрэгт дэмжлэг үзүүлж, байгаль хамгаалагчдийн сургалтын хэрэгцээний талаар судалгаа хийж байгаль хамгаалагчдийн сургалтын гарын авлага боловсруулсан ба тэдэнд зориулсан хууль хэрэгжүүлэх ба анхны тусламж үзүүлэх сургалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

Earthwatch байгууллагын сайн дурын ажилтнууд 2000 ам доллар төлж дээр нь нисэх зардлаа өөрсдөө гарган энэ төвд 11 өдөр ажилладаг ба энэ хөтөлбөр нь маш алдартай.

Халзан уулын рашаан сувиллын газрыг төр хариуцан ажиллуулдаг. Энэ сувиллын газар нь арьс, зүрх, толгойны өвчин, хоол боловсруулах эрхтэн ба хоёр төрлийн чихрийн шижинг анагаахад зориулагдсан. Хавдар болон элэгний өвчинг анагаахад ашиглаж болохгүй. Олны ярьдгаар энэ рашаан нь дэлхийд хоёрт орох анагаах увьдастай рашаан болно.

Аялал жуулчлалын “Nomadic Journeys” компани 2008 онд энд гэр баазаа нээсэн. Их Нартын бүсэд үлдсэн цөөн байгалийн булгийн нэгний дэргэд бааз байрладаг. Гадаад эзэнтэй компани байнгын төлөвлөгдсөн аяллуудыг монгол орноор тойрон явуулдаг.ТХГН-ийн тухай хуулийн гадаадын хөрөнгө оруулалтыг хориглох тухай заалтыг үндэслэн цогцолборт газар жуулчны бааз барихыг хориглодог. Гэр бааз нь гэр-хоолны газар, гэр-гал тогоо, гэр-угаалгын газрыг оролцуулаад 8 гэртэй. Жуулчны гэр нь дотроо 2-3 ортой. Ерөнхийдөө баазын гэрийн ор нь жилийн хоногын 10-15 хувьд нь жуулчин ба зочинтой байдаг. 2011 онд жуулчны баазад хамгийн олон тооны зочин (162 зочин эсвэл 366 ор) ирсэн тухай тэмдэглэгджээ. Аялалын бизнес эрхлэгч монгол хүн аялал жуулчлалын баазыг цогцолборт газарт байгуулсан гэж ойлгогдсон. Үйл ажиллагаа нь, сарын сүүлээр эхэлж есдүгээр сард

дуусдаг. Орчны суманд үйл ажиллагаатайгаа холбогдуулан компаниас төлдөг газар ашиглалтын хураамжийн төлбөрийн мөнгөөр Байгаль Орчны Итгэлцлийн Сан байгуулжээ.

Хэдийгээр Их Нартын байгалийн нөөц газрын захиргаа нь хамгааллын ажил гүйцэтгэх үүрэгтэй тусгайлсан бүтэцгүй, нөөц газрын хамгааллын төлөвлөгөөгүй ч 2000 оноос эхлэн орон нутгийн захиргаа, ТББ, бүлгэмдлүүд ба олон улсын байгууллагын дэмжлэг, тусламжтайгаар хамгаалалтын үүргийг гүйцэтгэж иржээ.

2012 онд цогцолборт нөөц газрын менежментийн төлөвлөгөөг бэлтгэжээ. Нөөц газрын хамгаалалтын ажлын зорилго, зорилтуудыг төлөвлөгөөнд оруулжээ. Зорилт 6-д байгалийн нөөц газрын үнэт зүйлийг сайжруулах ба аялал жуулчлалын (олон төрлийн) тодорхой хэлбэрийг хөгжүүлэхээр заажээ. Гол үйл ажиллагаануудыг доорх байдлаар тодорхойлжээ:

- НГ-ын аялал жуулчлалын хөгжлийн хөтөлбөр боловсруулж менежментийн зөвлөлөөр батлуулах
- Аялал жуулчлалын бүсүүдийг тогтоож тэдгээрт холбогдох журамтай нийцүүлэх, хөгжүүлэх
- Явган, морьтой аяллын замыг тогтоох
- НГ-т хогийн менежментийн журам боловсруулж мөрдөх
- Аялал жуулчлалын үйл ажиллагаанд нутгийн бүлгэмдлийг оролцоход туслах боломжийг судлах, турших
- Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэх сонирхол, хүсэлтэй иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах (жишээ нь жуулчдад зориулсан байр\хоноглох газар бий болгох, хөтөлөх, ахлах гэх мэт)
- Аялал жуулчлалын бизнес эрхлэгчдэд зориулсан НГ-ын аялал жуулчлалын бүтээгдэхүүнтэй танилцуулах аялал зохион байгуулах
- Аялал жуулчлалын зориулалтаар газар ашиглах концессийг турших
- Судлаач-жуулчдын аяллын хөтөлбөрт нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээг оруулах
- Москва-Улаанбаатар-Бээжин- Москва чиглэлийн галт тэргээр аялдаг жуулчидтай Говьсүмбэр ба Сайншандад уулзаж НГ-аар аялуулах санал боловсруулах, хэлэлцэх.

Концессийн Менежментийн Стратеги – Зөвлөмжүүд

Менежментийн төлөвлөгөөнд аялал жуулчлалын өнөөгийн үйл ажиллагаа ба орон нутгийн бүлгийн нийгэм-эдийн засгийн хөгжил мөн хамгаалалттай газрын үнэт зүйлийн хамгаалалттай холбоотой асуудлуудыг тодорхойлжээ.

Менежментийг төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол хамтрагч нь БОНХЯ\ХЗ байхыг хүлээн зөвшөөрчээ. Ингэснээрээ орон нутгийн засаг захиргаа болон мэргэжлийн төрийн бус байгууллагад менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зарим гол үйл ажиллагааг концессийн стратегээр дамжуулан хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж болох юм. Өмнөх бүлэгт тоймилсон эрхзүйн хүрээний нэмэлт өөрчлөлтүүдийг хийсэн тохиолдолд л эдгээр аргуудыг хэрэглэх боломжтой. Үүнтэй уялдан дараах үйл ажиллагааг зөвлөмж болгож байгаа ба нарийвчилсан алхамуудыг Хүснэгт 12-д үзүүлэв.

1. *Үнэт зүйлийг хамгаалахын тулд цогцолборт газрыг ашигладаг бүхийл аялал зохион байгуулагчидтай концессийн гэрээ байгуулах*—үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвшөөрөл олгодог болсноор ХЗ нь түүх, соёлын дурсгалуудтай газруудад аялах замыг хянаж түүх, соёлын дурсгалуудтай газрыг хамгаалах үйл ажиллагааны стандарттай болно.
2. *Концессийг ашиглан зөв газарт хөрөнгө оруулалтыг татах, чадавхийг бүрдүүлэх* – нөөц газрын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын арилжааны болон ашгийн төлөө бус үйл ажиллагаа эрхэлдэг газрууд байгааг тэмдэглэсэн. Эдгээр үйл ажиллагаа эрхлэгчид нь явган ба морин аяллын зам тогтоох, аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэх сонирхол, хүсэлтэй иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах (жишээ нь жуулчдад зориулсан байр\хоноглох

- газар бий болгох, хөтөчлөх, ахлах гэх мэт), нутгийн иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцуулахад зэрэгт дэмжлэг үзүүлж болох юм.
3. *Концессийг орон нутгийн бүлгийн амьжиргааг дэмжих эсвэл сайжруулах зорилгоор ашиглах*—концессийн тусгай гэрээг тодорхой төрлийн ашиглалтанд онцгой нөхцөлд орон нутгийн тухайлсан бүлэг д шууд олгох: жуулчны үйл ажиллагаа эрхлэгчид тохиромжтой саналыг тодорхойлсон тохиолдолд (жишээ нь Эмэгтэйчүүдийн хоршоогоор дамжуулан гар урлалын бүтээгдэхүүн борлуулах, явган, морин аяллын хөтөч хийх)

Концессийн ийм төрлийн гэрээ байгуулснаар хамгаалалттай газрын зорилгыг биелүүлэх хамгийн сайн боломж бүрдэнэ хэмээн менежментийн төлөвлөгөөнд тодорхойлжээ.

Хүснэгт 12. Гол Үйл ажиллагаа–Концессийн Стратегийн хэрэгжилт–Их Нартын Байгалийн Нөөц газар

Үндсэн чиглэл	Үйл ажиллагаа	Ач холбогдол
Концессийн менежментийн бодлого, зохицуулалтыг бэхжүүлэх	Үндсэн чиглэлийн 1-д заасны дагуу нөөц газарт одоо байгаа бүх ашиглагчидтай (Судалгааны төв, Рашааны газар, жуулчны баазууд) бодлого зөвлөмжийг ашиглан концессийн туршилтын гэрээ байгуулах Хураамж болон орлого хуваалцах тухай зохицуулалтыг орон нутгийн захиргаа, судалгааны байгууллагатай харилцан тохиролцох	<i>Өндөр</i>
	Одоо байгаа концесс эзэмшигчидтэй (Судалгааны төв, Рашааны газар, жуулчны баазууд) мэдээлэл солилцох албан ёсны мэдээллийн сүлжээ бий болгож мэдээлэл солилцох ба туршилтын концессийн гэрээ хэрхэн ажиллаж байгаа талаар хамтын ажиллагаа тогтоох. Эдгээр мэдээллийг Үндсэн чиглэлийн 1-д заасны дагуу бодлого, удирдамжийг эргэн харахад ашиглана.	<i>Дунд зэрэг</i>
Тогтолцоо ба бүлгийн хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх	Бүлгийн зөвлөлдөх хороо байгуулж концесс хэрэгжүүлэх ба менежмент хийхэд дэмжлэг үзүүлэх -орон нутгийн бүлэг, захиргаа ба орон нутгийн үйлдвэрлэгчдийн төлөөлөл	<i>Өндөр</i>
	Концессийн стратеги, ашиг тусын талаар сургалт явуулж зөвлөлдөх хорооны чадавхийг бэхжүүлэх	<i>Өндөр</i>
Стратеги ба олон талт бизнес хөгжлийн загвар хөгжүүлэх	Зөвлөлдөх хороотой хамтран нөөц газрын бизнес төлөвлөгөө бэлтгэх- үндсэн зах зээлийг тодорхойлох, одоогийн саналд байгаа дутуу орон зай, бүлэг, үйлдвэрлэгчдийн санал болгож болохуйц концессийн хамгийн сайн боломжууд, концессийн шаардлагын биелүүлэхэд шаардлагатай чадавх бүрдүүлэлт зэргийг оруулах. Энд бүх ашиглалтыг буюу нөөцийн ашиглалт, аялал жуулчлал гэх мэт оруулах Орон нутгийн бүлэгтэй хамтран зөвлөлдөж тэдгээрт шууд олгох концессийн боломжууд болох морин ба явган аяллыг судлах Хамгааллын ажилд (хуулийн хэрэгжилт, судалгаа) дэмжлэг үзүүлэх бусад боломжуудыг мөн авч үзэх нэмэр болох	<i>Өндөр</i>
	Концесс эзэмшигчдийн одоогийн сүлжээг (Судалгааны төв, Рашааны газар, жуулчны баазууд) ашиглан орон нутгийн бүлэгт боломж олгох шинэлэг хамтын ажиллагааны хэлбэр бүрдүүлэх, өргөжүүлэх	<i>Дунд зэрэг</i>

8 СТРАТЕГИ ХЭРЭГЖҮҮЛЭХ

8.1 Зөвлөмжүүд

Хэрэгжүүлэх

гол үйл

ажиллагаа

Энэ тайлангийн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхийн тулд ТХГН-ийн тухай хуулинд өөрчлөлт оруулах шаардлагатай. Санал болгож буй өөрчлөлтүүд нь концессийн менежментийн хамгаалалттай газрын хууль эрхзүй хүрээний хамгаалалт болж концессийн үйл ажиллагааг хамгаалалттай газрын хамгаалалын ажилд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай тэнцвэртэй аргыг ашиглах, шинэ шинэлэг, тоног төхөөрөмжүүд ба үйлчилгээ оруулж ирэх, эзэмших эрхийн баталгааг хангах ба нутгийн иргэдийн концессийн менежментэд оролцох эрхийг зөвшөөрөх хууль ёсны дагуух газар ашиглалт болохыг хүлээн зөвшөөрнө. Санал болгож буй өөрчлөлтүүд нь доорх болзлыг тавина:

- Концесс олгож болох бүхийл үйл ажиллагаа
- ТХГН болон түүний орчны бүсэд концессийн үйл ажиллагааны олон төрлийг явуулж болох нөхцөл, хэлбэр
- ТХГН-т концесс эзэмшигч үйл ажиллагаа явуулахдаа заавал мөрдөх тогтвортой байдлын хэм хэмжээ гэх мэт нөхцөл, хугацаа (5 жил, 10 жил үүнээс ч урт хугацаанд),
- Орон нутгийн захиргаатай хуваалцахаар тохиролцох орлого, хураамж
- Гадаадын хөрөнгө оруулах боломжууд
- Өрсөлдөөнөөр олгогдсон концессууд
- Концессийг эхлүүлэх ба үргэлжлүүлэх хугацаа болон концессийн гэрээ заасан хугацаанаас өмнө дуусгавар болох нөхцөлүүд
- Төр, үйлдвэр/бүлэг ийн тэргүүлсэн концессийн хөгжлийн журам
- Концессийн үйл ажиллагааны удирдлага
- ТХГН-т концессийн үйл ажиллагааны явцад байгаль, хүрээлэн буй орчинг сайжруулах нөхцөлүүд

8.2 Бусад зөвлөмжүүд

1. Засгийн газар болон хөрөнгө оруулагч талын аль алины тэргүүлсэн тогтвортой хөгжлийн зохистой боломжуудыг нийт ТХГН-ийн хэмжээнд хэрэгжүүлэх зохицуулалтын болон тогтолцооны тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх
2. Соёлын өвийг зохистой ашиглах, экологийн тогтвортой байдлыг дэмжих мөн тухайн газар, нөөцийн менежментийн зорилготой нь нийцэхүйцээр ашиглагчдийн үйл ажиллагаа, эрхийг зохицуулах тодорхой бодлого болон журмыг энэхүү стратегид тусгасан зарчмыг үндэслэн гаргах
3. Концессийн менежментийн тогтолцооны төвлөрсөн зохицуулалт бий болгох
4. ТХГН-т хөрөнгө оруулах идэвхтэй аргыг нэвтрүүлж тогтвортой аялал жуулчлал болон уламжлалт ашиглалтыг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх болон бусад нийгэм, эдийн засгийн үр дүн өгөх Төр -Хувийн хэвшлийн хамтын ажиллагааны санаачлагыг өрнүүлэх,
5. Стратегийн төлөвлөлт боловсруулан ТХГН-т чанартай зочин/жуулчны үйлчилгээ үзүүлэх дэд бүтэц, тоног төхөөрөмж болон үйлчилгээ болон орон нутгийн бүлгүүдийн амьжиргааг тэтгэхүйц, байгалийн болон соёлын сайн чанартай бүтээгдэхүүн санал болгож чадахуйц хамгийн ихээр хөрөнгө оруулалт шаардагдаж буй газруудад хөрөнгө оруулалтыг чиглүүлэх. Энэ аргыг бусад газарт концессийг хязгаарлах арга болгон ашиглах
6. Концессийн үйл ажиллагааг засгийн газарт орлого оруулахад тэр нь улмаар ТХГН-ийн сүлжээний хамгаалал, менежментэд дамжин ороход ашиглах

7. Концессийн менежментийн сургалт, чанарын баталгааг хангах ба албан хаагчид болон бүлгүүдийн бизнесийн хөгжил, үйлчилгээний чанар ба стандартыг нутагшуулах\өөриймшүүлэх зэрэгт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
8. Бүлгийн зөвлөлдөх бүлгийг байгуулан Монгол улсын ТХГН-уудад концессийн менежментийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх
9. Концессийн менежментийн үр дүнтэй, тэгш эрхийг хангасан, хөтлөн явуулахад хялбар, өнөөгийн тогтолцоонд зохицсон, хэрэгжихүйц эрхзүйн орчинг бий болгох шаардлагатай
10. Концессийн удирдлагын шинэ тогтолцоог Орхоны Хөндийн байгалийн цогцолборт газар болон Их Нартын байгалийн нөөц газар турших.

ҮНДСЭН ЧИГЛЭЛ 1.

Хууль тогтоомж болон бодлогын тогтолцоог бэхжүүлэх

Үйл ажиллагаа	Алхмууд	Ач холбогдол
1.1 Концессийн менежментийн стратегийг баталж Засгийн газрын тэргүүлэх чиглэлтэй холбох.	<i>Холбогдох сайд нар, агентлагуудын дарга нар болон орон нутгийн удирдлагад стратегийг танилцуулж нэмэлт оруулах</i>	Яаралтай
	<i>Сайд ба улс төрийн дэмжлэг олох эсвэл концессийн стратеги йн гол хандивлагч-ялагчийг олох</i>	Яаралтай
	<i>ХЗ ба бусад төрийн холбогдох ажилтнуудад стратеги ба агуулга танилцуулах</i>	Яаралтай
	<i>Концессийн стратеги хэрэгжүүлэх төсөв тодорхойлох ба 2014/15 онд хэрэгжүүлэх бизнесийн кейс бэлтгэж нутгийн иргэд ба ХЗнд оруулж болох төсөв ба ашгыг таамаглан гаргах</i>	Яаралтай
1.2 ТХГН-ийн тухай хуулийг эргэн харж концессийн менежментийг төвд нь тавих	<i>Энэ стратегийн 5.1.1 ба 5.2.2 бүлэгт санал болгосны дагуу ТХГН-ийн тухай хуулинд (мөн бусад холбогдох хуулинд) оруулах нэмэлт өөрчлөлтийг бэлтгэх</i>	Өндөр
	<i>Концессийн ач холбогдлын талаар Сайд нар болон зөвлөхүүдэд сайн тайлбарлаж хууль эрхзүйн нааштай өөрчлөлтийг хийхийг баталгаажуулах</i>	Яаралтай
1.3 Концессийн менежментийн тогтвортой байдлыг хангах бодлого, удирдамж бий болгох	<i>5.2 дугаар бүлэгт санал болгосны дагуу үйлдвэрлэгчид, орон нутгийн бүлэг болон төрийн бусад агентлагтай хамтран зөвлөлдөж Концессийн Бодлогын ноорог бэлтгэх</i>	Өндөр
	<i>5.3 дугаар бүлэгт санал болгосны дагуу үйлдвэрлэгчид, орон нутгийн бүлэг болон төрийн бусад агентлагтай хамтран зөвлөлдөж Санал гаргагчид зориулсан Журам бэлтгэх</i>	Өндөр
	<i>5.4 дүгээр бүлэгт санал болгосны дагуу үйлдвэрлэгчид, орон нутгийн бүлэг болон төрийн бусад агентлагтай хамтран зөвлөлдөж Талбар сонгох Журам бэлтгэх</i>	Өндөр
	<i>5.5 дугаар бүлэгт санал болгосны дагуу үйлдвэрлэгчид, орон нутгийн бүлэг болон төрийн бусад агентлагтай хамтран зөвлөлдөж Концессийн Саналыг Үнэлэх Шалгуур гаргахад бэлтгэх</i>	Өндөр
	<i>5.7 дугаар бүлэгт санал болгосны дагуу том, дунд, жижиг хэмжээний Концесс байгуулах Гэрээний Загвар бэлтгэх</i>	Өндөр
	<i>Орхоны хөндий болон Их Нартын Байгалийн нөөц газарт хэрэгжүүлэх концессийн туршилтын бодлого, удирдамж, үнэлэх шалгуур ба загварын талаар үйлдвэрлэгчид болон төрийн байгууллагын санал авч тусгах шаардлагатай.</i>	Өндөр
	<i>Бодлого, зохицуулалтын хүрээг 2 жилийн дотор эргэн харж зорьсон зорилгод хүрэх ба хууль хэрэгжүүлэх журмын авцалдаа холбоог баталгаажуулах</i>	Дунд зэрэг

ҮНДСЭН ЧИГЛЭЛ 2.

Тогтолцоо ба бүлгийн хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх		
Үйл ажиллагаа	Алхмууд	Ач холбогдол
2.1 Засаглалын үр дүнтэй ил тод зохицуулалтууд бий болгох	Концессийн бодлогын хэрэгжилт, хөгжилт, удирдамж мөн батлах ажиллагааг хариуцсан мэргэжлийн ажилтнуудтай концессийн менежментийн нэгжийг БОНХЯ\ХЗ-нд байгуулах	Өндөр
	Концессийн менежментийн стратегийн хэрэгжилтэнд хангалттай хөрөнгө хуваарьлагдсан байхыг баталгаажуулах	Өндөр
	Хариуцлага иж бүрэн цуваа тогтолцоо бүрдүүлэх: бүсийн захирлуудад хариуцуулсан эрхүүд, жишиг үйл ажиллагаа, санхүүгийн хяналт, сонирхлын зөрчлийн тухай дүрмүүд зэргийг оруулан эдгээрийн засгийн газрын авилгын эсрэг бодлоготой уялдуулж боловсруулах	Өндөр
	Концессийн зөвлөлдөх бүлгийг гол хамгаалалттай газрууд орших бүсүүдийн үйлдвэрлэл, орон нутгийн захиргаа ба бүлгийн төлөөллийг оруулан байгуулах	Дунд зэрэг
	Бүлгийн гүйцэтгэх гол үүрэг нь концессийн стратеги төлөвлөгөө ба концессийн менежментийг батлах үйл ажиллагааг ХЗ\БОНХЯ хэрхэн явуулж буйг хянах болно	Өндөр
	Санхүүгийн менежментийн үйл явцын ил тод байдлыг бүрдүүлж концессийг үнэлэх, орлогыг ил тод байлгах ба тайлагнах зэргийг тусган оруулах	Өндөр
	Засаглалын нэмэлт дэмжлэг хүсэх: авилгатай тэмцэх газраас мэргэжлийн концессийн менежментийн ажилтнуудад дэмжлэг үзүүлж эрх мэдэлтний ба засгийн газар дахь хувийн ашиг сонирхлын бүлгийн дарамтаас хамгаалах.	Өндөр
	Хамгаалалттай газар дахь концессийн менежментийн талаар веб хуудас нээж концессийн менежментийн бодлого, үйл ажиллагааг үйлдвэрлэгчид ба бүлэгт мэдээлэх	Дунд зэрэг
Шардлагатай бол системийг эргэж харах, тохируулах	Концессийн менежментийн электрон систем байгуулж хамгаалалттай газар дахь концессийн талаарх мэдээлэл цуглуулах, зохион байгуулах, цэгцлэх, өгөх ажиллагааг нэгдсэн, үр дүнтэй хэлбэрээр зохион байгуулах	Дунд зэрэг
	Концессийн стратегийн удирдамж, загварыг 2 жилийн дотор үйлдвэрлэгчид ба засгийн газрын бусад агентлагтай хамтран эргэн харж зорьсон зорилгод хүрэх ба хууль хэрэгжүүлэх журмын авцалдаа холбоог баталгаажуулах	Дунд зэрэг
	Орон нутгийн захиргаа, бүлэгт стратегийг танилцуулан тэдний саналыг тусгах	Өндөр
	Концессийг зохицуулахад оролцогч засгийн газрын байгууллагууд, ХЗ-ны ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх стратеги ба тусгай сургалтын хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх	Өндөр
	Зөвлөлдөх бүлгийн хурлын хөтөлбөрийг гаргаж концессийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, орон нутгийн бүлэгт санал болгох концессийн боломжуудыг хэлэлцэх ба концессийн менежментийг батлах үйл ажиллагааг ХЗ\БОНХЯ хэрхэн явуулж буйг хянах	Өндөр
	Бодлого ба удирдамж бэлэн болсоны дараа орон нутгийн бүлэгт концессийг 1 жилийн хугацаатай шууд олгож одоо явагдаж байгаа концессийн гэрээг эргэж харах	Өндөр
	Бүлэгт олгогдсон концест дэмжлэг, зөвлөгөө өгч байгаль хамгаалал ба бүлэгт нийгэм-эдийн засгийн өгөөж өгөх зорилгоо биелүүлэхийг нь баталгаажуулах	Өндөр
	2.2 Засгийн газрын болон бүлгийн дотоод чадавх бүрдүүлэх	Өндөр

ҮНДСЭН ЧИГЛЭЛ 3.

Стратеги ба олон талт бизнес загвар хөгжүүлэх		
Үйл ажиллагаа	Алхмууд	Ач холбогдол
3.1 Зорилгодоо нийцсэн хөрөнгө оруулалтын стратегийн боломжуудыг тодорхойлох	<i>Засгийн газрын агентлагууд, аялал жуулчлалын байгууллагууд, орон нутгийн бүлэг ба аялал жуулчлалын бизнес эрхлэгчидтэй бүс\орон нутгийн хэмжээнд хамтран ажиллаж концессийн үйл ажиллагааны боломжуудыг тодорхойлох</i>	Дунд зэрэг
	<i>Концессийг хэрэгжүүлэхийн тулд өөрчлөх шаардлагатай менежментийн төлөвлөгөө\ төлөвлөгөөний зохицуулалтуудыг эргэн харах</i>	Дунд зэрэг
	<i>Засгийн газрын сүлжээгээр үйлдвэрлэгчид, бүлэгт түгээгдсэн товхимолоор дамжуулан гол бүсүүдийн үйлдвэрлэгчид, бүлэгт хүртээмжтэй концессүүд, хөрөнгө оруулалтын боломжуудыг хөгжүүлэх, санал дэвшүүлэх</i>	Дунд зэрэг
3.2 Гол газруудад тогтвортой концесс хөгжүүлэхийн тулд үйлдвэрлэл, бүлэг ба төрийн бусад байгууллагатай тогтоосон харилцаагаа бэхжүүлэх	<i>Одоо байгаа концесс эзэмшигчдийг оролцуулах зорилгоор ойлголт бий болгох, цаашидын хамтран ажиллагааны төлөө 2.1 ба 2.2-т зөвлөмжилсний дагуу бүлгийн зөвлөлдөх хороо байгуулах</i>	Дунд зэрэг
	<i>Одоо байгаа концесс эзэмшигчидтэй байнгын харилцаа тогтоож сониноор дамжуулан сайн үйл ажиллагааг сурталчлан хамгаалалттай газрын сүлжээний талаарх шинэ мэдээлэл өгч тэдний дэмжлэгийг авах</i>	Дунд зэрэг
	<i>Цаашилбал Монгол улсын ТХГН-ийн сүлжээний хэмжээнд концесс эзэмшигчдийн сүлжээ бий болгож үүнийг засгийн газар болон концесс эзэмшигч нар харилцан мэдээлэл солилцох, цаашидын хөрөнгө оруулалт, санал дэвшүүлэх зорилготой хамтын ажиллагаа бүрдүүлэх боловсролын чуулган хэлбэрээр ашиглах</i>	Дунд зэрэг

Орхоны Хөндийн Байгалийн Цогцолборт Газар		
Үндсэн чиглэл	Үйл ажиллагаа	Ач холбогдол
Концессийн менежментийн бодлого, зохицуулалтыг бэхжүүлэх	Үндсэн чиглэлийн 1-д заасны дагуу цогцолборт газарт одоо байгаа бүх ашиглагчидтай бодлого, зөвлөмжийг ашиглан 1 хүртэлх жилийн концессийн туршилтын гэрээ байгуулах Хураамж болон орлого хуваалцах тухай зохицуулалтыг орон нутгийн захиргаа, бүлэгтэй харилцан тохиролцох	Өндөр
	Одоо байгаа концесс эзэмшигчидтэй мэдээлэл солилцох албан ёсны мэдээллийн сүлжээ бий болгож мэдээлэл солилцох ба туршилтын концессийн гэрээ хэрхэн ажиллаж байгаа талаар хамтын ажиллагаа тогтоох. Эдгээр мэдээллийг Үндсэн чиглэлийн 1-д заасны дагуу бодлого, удирдамжийг эргэн харахад ашиглана.	Дунд зэрэг
	Концессийн систем бүрэлдмэгц цогцолборт газарт үйл ажиллагаа явуулж байгаа концессийн тоо, төрлийг тодорхойлох. Концессийн тоо, чанарыг хянахын тулд өрсөлдөөний журмаар олгогдох, үр дүнтэй байх концессийн төрлүүдийг тодорхойлох.	Дунд зэрэг
	Тухайлсан концессийг өрсөлдөөний журмаар олгох шаардлагатай эсэх талаар бүлэг ба концесс эзэмшигч нартай зөвлөлдөх .	Дунд зэрэг
	Концесс эзэмшигч нарт өрсөлдөөний журмаар олгох талаар аль болох эрт (хамгийн багаар бодоход 6 сарын өмнө) мэдээлж бэлтгэл хангуулах	Дунд зэрэг
	Бодлого, удирдамжинд заасны дагуу концесс эзэмшигч нарт мэдээлэл, баримт бэлтгэн өгч үйл ажиллагааг зохицуулах	Дунд зэрэг
Тогтолцоо ба бүлгийн хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх	Бүлгийн зөвлөлдөх хороо байгуулж концесс хэрэгжүүлэх ба менежмент хийхэд дэмжлэг үзүүлэх -орон нутгийн бүлэг, захиргаа ба орон нутгийн үйлдвэрлэгчдийн төлөөлөл	Өндөр
	‣ Концессийн стратеги, ашиг тусын талаар сургалт явуулж зөвлөлдөх хорооны чадавхийг бэхжүүлэх	Өндөр
Стратеги ба олон талт бизнес хөгжлийн загвар хөгжүүлэх	Зөвлөлдөх хороотой хамтран цогцолборт газрын бизнес төлөвлөгөө бэлтгэх- үндсэн зах зээлийг тодорхойлох, одоогийн саналд байгаа дутуу орон зай, бүлэг, үйлдвэрлэгчдийн санал болгож болохуйц концессийн хамгийн сайн боломжууд, концессийн шаардлагын биелүүлэхэд шаардлагатай чадавх бүрдүүлэлт зэргийг оруулах. Энд бүх ашиглалтыг буюу нөөцийн ашиглалт, аялал жуулчлал гэх мэт оруулах, Орон нутгийн бүлэгтэй хамтран зөвлөлдөж тэдгээрт шууд олгох концессийн боломжуудыг судлах, Хамгааллын ажилд (хуулийн хэрэгжилт, судалгаа) дэмжлэг үзүүлэх бусад боломжуудыг мөн авч үзэх нэмэр болох,	Өндөр
	Концесс эзэмшигчдийн одоогийн сүлжээг ашиглан орон нутгийн бүлэгт боломж олгох шинэлэг хамтын ажиллагааны хэлбэр бүрдүүлэх, өргөжүүлэх	Дунд зэрэг

Их Нартын Байгалийн Нөөц Газар		
Үндсэн чиглэл	Үйл ажиллагаа	Ач холбогдол
Концессийн менежментийн бодлого, зохицуулалтыг бэхжүүлэх	Үндсэн чиглэлийн 1-д заасны дагуу нөөц газарт одоо байгаа бүх ашиглагчидтай (Судалгааны төв, Рашааны газар, жуулчны баазууд) бодлого зөвлөмжийг ашиглан концессийн туршилтын гэрээ байгуулах Хураамж болон орлого хуваалцах тухай зохицуулалтыг орон нутгийн захиргаа, судалгааны байгууллагатай харилцан тохиролцох	<i>Өндөр</i>
	Одоо байгаа концесс эзэмшигчидтэй (Судалгааны төв, Рашааны газар, жуулчны баазууд) мэдээлэл солилцох албан ёсны мэдээллийн сүлжээ бий болгож мэдээлэл солилцох ба туршилтын концессийн гэрээ хэрхэн ажиллаж байгаа талаар хамтын ажиллагаа тогтоох. Эдгээр мэдээллийг Үндсэн чиглэлийн 1-д заасны дагуу бодлого, удирдамжийг эргэн харахад ашиглана.	<i>Дунд</i>
	Концессийн тогтолцоог буй болсон нөхцөлд нөөц газарт үйлчлэх концессийн хэлбэр болон тоог тодорхой болгох. Концессийн тоо болон чанарыг хянах зорилгоор өрсөлдөөний журмаар сонгоход давуу тал бүхий концессын хэлбэрийг илрүүлэх,	<i>Дунд</i>
	Аль нэг концессийн өрсөлдөөний журмаар сонгох хэрэгцээ байгаа эсэх талаар орон нутгийн бүлэг ба концесс эзэмшигчтэй зөвлөлдөх,	<i>Дунд</i>
	Концессийн үйл ажиллагаанд оролцож болзошгүй концесс эзэмшигчдэд өрсөлдөөний арга хэлбэрийн талаар аль болох эртнээс мэдэгдэх (дор хаяад 6 сарын өмнөөс),	<i>Дунд</i>
	Концесс эзэмшигчдэд зориулан бодлого ба зааварчлага тус бүрээр нь холбогдох мэдээлэл, бичиг баримт, удирдамжийг бэлтгэх,	<i>Дунд</i>
Тогтолцоо ба бүлгийн хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх	Бүлгийн зөвлөлдөх хороо байгуулж концесс хэрэгжүүлэх ба менежмент хийхэд дэмжлэг үзүүлэх -орон нутгийн бүлэг, захиргаа ба орон нутгийн үйлдвэрлэгчдийн төлөөлөл	<i>Өндөр</i>
	Концессийн стратеги, ашиг тусын талаар сургалт явуулж зөвлөлдөх хорооны чадавхийг бэхжүүлэх	<i>Өндөр</i>
Стратеги ба олон талт бизнес хөгжлийн загвар хөгжүүлэх	Зөвлөлдөх хороотой хамтран нөөц газрын бизнес төлөвлөгөө бэлтгэх- үндсэн зах зээлийг тодорхойлох, одоогийн саналд байгаа дутуу орон зай, бүлэг, үйлдвэрлэгчдийн санал болгож болохуйц концессийн хамгийн сайн боломжууд, концессийн шаардлагын биелүүлэхэд шаардлагатай чадавх бүрдүүлэлт зэргийг оруулах. Энд бүх ашиглалтыг буюу нөөцийн ашиглалт, аялал жуулчлал гэх мэт оруулах Орон нутгийн бүлэгтэй хамтран зөвлөлдөж тэдгээрт шууд олгох концессийн боломжууд болох морин ба явган аяллыг судлах Хамгааллын ажилд (хуулийн хэрэгжилт, судалгаа) дэмжлэг үзүүлэх бусад боломжуудыг мөн авч үзэх нэмэр болох	<i>Өндөр</i>
	Концесс эзэмшигчдийн одоогийн сүлжээг (Судалгааны төв, Рашааны газар, жуулчны баазууд) ашиглан орон нутгийн бүлэгт боломж олгох шинэлэг хамтын ажиллагааны хэлбэр бүрдүүлэх, өргөжүүлэх	<i>Дунд</i>

Иш татсан эх сурвалж

- Asia Foundation (2009), *Compendium of Laws Mongolian Citizens Reference Book Volume 1*
- Department of Conservation (NZ) & Denniston Heritage Trust (2010), *Tourism Operator Expression of Interest: for the operation of the historic Denniston tourism experience.*
- Department of Environment, Climate Change and Water NSW (2011), *Sustainability assessment criteria for visitor use and tourism in New South Wales national Parks.*
- Department of Environment, Climate Change and Water NSW (2011), *Sustainability Guidelines for visitor use and tourism in NSW national Parks.*
- Department of Environment, Climate Change and Water NSW *Sustainability assessment criteria for visitor use and tourism in New South Wales national parks and Sustainability Guidelines for visitor use and tourism in NSW national parks 2011*
- Department of Natural Resources, Environment, the Arts and Sport (NRETAS) (2011), *Litchfield National Park Draft Plan of Management, May.*
- Department of Natural Resources, Environment, the Arts and Sport (NRETAS) (May 2011), *Litchfield National Park Draft Plan of Management.* NRETAS (September 2011), Annual Report 2010-11.
- DOC & DHT (2010), *Tourism Operator Expression of Interest: for the operation of the historic Denniston tourism experience.* DOC and operator websites - www.doc.govt.nz and www.dennistonmineexperience.co.nz.
- Government of Alberta, Tourism, Parks and Recreation website, www.tpr.alberta.ca 2013
- Inspiring Place, in association with Gregory Burgess Architects (2009), *Design Guidelines for Nature-Based Tourism. Consultation Draft.* August.L.E.K. Consulting (2011), *Tourism Investment and Regulation Review: Final Report, 3 August 2011.*
- Kenya Wildlife Service (2013) website, www.kws.org/tourism/investment_procedures.
- Meredith Wray et al (2010), *Sustainable regional tourism destinations: best practice management, development and marketing*, CRC for Sustainable Tourism Pty Ltd.
- Meredith Wray et al (2010), *Sustainable regional tourism destinations: best practice management, development and marketing*, CRC for Sustainable Tourism Pty Ltd; Parks and Wildlife Service Tasmania (2006), *Pencil Pine-Cradle Valley Visitor Services Zone Plan 2006.*
- Ministry of Nature Environment and Tourism (2012) *Orkhon Valley National Park Tourism Management Plan 2012 – 2015*, UNDP
- Nature is Future Fund 2011 *Management Plan for Orkhon Valley National Park 2011 – 2015*
- NSW National Parks and Wildlife Service, *Parks Eco Pass Guidelines for Applicants, 2013*
- Parks and Wildlife Service Tasmania (2006), *Pencil Pine-Cradle Valley Visitor Services Zone Plan 2006.*
- Paul F. J. Eagles, Cynthia M. Baycetch., Xiaoye Chen, Lina Dong, Elizabeth Halpenny, Pia B. Kwan, Jasminka J. Lenuzzi, Xiye Wang, Honggen Xiao, Yubing Zhang (2000), *Guidelines for Planning and Management of Concessions, Licenses and Permits for Tourism in Protected Areas* Tourism Planning and Management Program University of Waterloo, Ontario, Canada
- Paul F. J. Eagles, Stephen F. McCool and Christopher D. Haynes (2002) *Tourism in Protected Areas; Best Practice Protected Area Guidelines Series No. 8* World Commission on Protected Areas Prepared for the United Nations Environment Programme, World Tourism Organization and IUCN – The World Conservation Union

The Allen Consulting Group (2011), *Framework Guide to Facilitate Tourism Investment*, Melbourne. L.E.K. Consulting (2011), *Tourism Investment and Regulation Review: Final Report, 3 August 2011*.

Tourism WA and Department of Environment and Conservation (2011a), *Naturebank: Natural Tourism in Western Australia – Exceptional ecotourism development opportunities*. March (available on www.tourism.wa.go.au/naturebank).

Tourism WA and Department of Environment and Conservation (2011b), *Commercial Visitor Accommodation and Associated Activities at Mt Hart Wilderness Lodge – Expression of Interest, Guidelines for Submission*.

TRC Tourism (2011) *Best Practice Guidelines for Eco-Opportunities in Protected and Natural Areas*, Tourism and Protected Areas Forum

UNDP (2012), *Management Plan for Ikh Nart Nature Reserve 2012 – 2016 “Strengthening of Protected Area Network” 2012*

Urbis (2011), *National Tourism Planning Guide: A best practice approach*.

US Parks Service *Concession Management Guidelines* website www.nps.gov 2013

Хавсралт 1 Үүрэг ба хариуцлага

Монгол улсын Тусгай Хамгаалалттай Газар Нутгийн сүлжээ

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 27, 28, 29 ба 31 дүгээр зүйлүүдэд тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээний менежментийг хариуцах байгууллагуудын бүрэн эрхийг зааж өгсөн байдаг.

Засгийн газар	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар	ТХНУГ
<ul style="list-style-type: none"> ▶ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; ▶ тусгай хамгаалалттай газар нутагт явуулах судалгаа, шинжилгээний ажлын журам, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөл олгох, холбогдох тайлан, мэдээллийг авч нэгдсэн санд оруулах; ▶ биологийн төрөл зүйлд судалгаа, тооллого явуулах, бүртгэл хөтлөх аргачлал, хөтөлбөрийг батлах, зөвшөөрөгдсөн бүсээс ажиглалтын зориулалтаар дээж, сорьц авах, хэмжилт хийх, сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор ан амьтныг агнах, барих журам тогтоох; ▶ ойг арчлах, ойжуулах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх журам, хөтөлбөрийг баталж, нөхөн сэргээх газрын хэмжээ, уг ажлыг гүйцэтгэх арга, технологийг тогтоох; ▶ хортон шавьж, мэрэгчид, түймрээс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх журам, аргачлал тогтоох, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас тусгай хамгаалалттай газар нутагт учирсан хор уршгийг багасгах арга хэмжээ авах; ▶ рашаан, эмчилгээ, сувилгааны зориулалттай бусад эрдэс, байгалийн дагалт баялгийг ашиглах журам, эмийн, хүнсний болон техникийн 	<ul style="list-style-type: none"> ▶ өөрийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Засаг даргын илтгэлийг хэлэлцэж зохих шийдвэр гаргах, түүний биелэлтийг хангуулах; ▶ нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай саналыг дээд шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал буюу Засгийн газарт уламжлах; ▶ нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтоох. 	<ul style="list-style-type: none"> ▶ тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; ▶ өөрийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг улсын тусгай болон орон нутгийн хамгаалалтад авах талаар санал боловсруулж зохих байгууллагад уламжлах; ▶ байгалийн нөөц газар, дурсгалт газрын хамгаалалтыг эрхлэх. 	<ol style="list-style-type: none"> 1) Тусгай хамгаалалттай газрын тухай хууль тогтоомж, хамгаалалттай холбоотой журмуудын биелэлтийн хэрэгжилтийг хангах; 2) судалгаа шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн бүс нутгийн хамгаалалтын хүрээнд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг нь хянах; 3) Холбогдох журмын дагуу судалгааны зорилгоор сорьц авах, зэрлэг ан амьтны сүргийн бүтцийг хянах, байгалийн нөөц баялгийг сэргээх, ойг цэвэрлэж арчлах; 4) Ан амьтанд усны эх булаг гаргах, өвс тэжээл бэлтгэх, долоох давс хужир цацах, саравч барих болон зохих журмын дагуу биотехникийн бусад арга хэмжээ авах; 5) Рашаан ус, эмчилгээний бусад эрдэс баялагийн ашиглалтыг зохих журмын дагуу байлгах; 6) Аялал, жуулчлалын зөвшөөрөгдсөн чиглэлийг заасан тэмдэг босгох байрлалыг тогтоох, журам боловсруулах, тусгай хамгаалалттай газар нутагт шаардлагатай байр барих, иргэд аж ахуйн нэгжтэй хамтран байгууламжуудыг арчлан тордох; 7) Зөвшөөрөгдсөн бүст байгуулсан суурин, барилга байгууламжийн засвар үйлчилгээг хянаж, батлагдсан төлөвлөгөөний дагуу хийлгэх;

Засгийн газар	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар	ТХНУГ
<p>зориулалттай ургамлын жагсаалт, тэдгээрийг түүж бэлтгэх журмыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтоох;</p> <ul style="list-style-type: none"> ▶ аялал, жуулчлалын зам, чиглэл, журам тогтоох; ▶ тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүс дэх суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлах; ▶ тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох; ▶ Монгол улсын засгийн газартай зөвшилцөн тусгай хамгаалалттай газар, дархан цаазтай газарт хамгаалалтын захиргаа байгуулж, даргыг нь томилох. 			<p>8) Байгалийн тахилгат газрыг тахиx болон бусад уламжлалт ёс заншлын үйлдлүүдийг зохицуулах;</p> <p>9) Тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол, хамгаалалтын горим журам, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай холбогдох хууль тогтоомжийн талаар олон нийтэд таниулан ойлгуулах, мэдээ мэдээллийг бүртгэж мэдээллийн сан байгуулах;</p> <p>10) Зохих журмын дагуу иргэд, аж ахуйн нэгжийн ашиглаж болох газар, уг зөвшөөрөгдсөн газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох.</p>

Хавсралт 2 Концесст оролцох хүсэлтийг үнэлэх шалгуурууд

Шинээр тавьсан хүсэлтийг үнэлэх шалгуур	ТХНУГ-г шууд илэрхийлэх	Салбарын магадлан итгэмжлэлээр дамжуулан харуулж болох
<p>Байгаль орчны хувьд тогтвортой, соёлд нийцсэн практик</p> <ul style="list-style-type: none"> ➢ санал болгож буй үйл ажиллагаа/ чиглэл/ байршил нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, бодлого, зорилтуудтай нийцэж байгаа, эсэх? ➢ Байгаль орчинд гарч болох нөлөөлөл бий, эсэх? ➢ Бусад хамгаалалттай газрыг ашиглагсад болон тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй үүсч болох зөрчил бий, эсэх? ➢ Тусгай хамгаалалттай газарт байгаа байгууламж, дэд бүтцэд үзүүлэх нөлөө бий, эсэх? ➢ Гаргаж буй хүсэлтэнд дараах зүйлст үзүүлэх нөлөө аль болох бага байлгах талаар авах арга хэмжээг харуулсан, эсэх. Үүнд: <ul style="list-style-type: none"> ➢ ургамал зэрлэг амьдтыг хамгаалах ➢ тухайн газар нутаг, ландшафтыг хамгаалах ➢ түүх, соёлын холбоотой газрыг хамгаалах ➢ усны чанарыг хамгаалаж, тордох ➢ дуу, шуугианы хяналт ➢ хорт утааны хаягдлыг багасгах ➢ хог хаягдал багасгах, түүний менежмент ➢ эрчим хүчний ашиглалтыг багасгах ➢ Энэ хүсэлт, өөр, хамтран эзэмшиж буй газартай холбоотой эсэх? Хэрэв тийм бол, зөвлөлдөх журам болон Үйлчилгээний эрхээс татгалзах тухай нэмэлт баримт бичиг байх. ➢ Үйл ажиллагаа нь уугуул Абориген иргэдийн өвийг тайлбарласан шаардлагуудтай нийцэж буй эсэх? 		
<p>Байгаль, орчны талаар өндөр чанартай, сайн тайлбарлах байдал</p> <ul style="list-style-type: none"> ➢ Санал болгож буй үйл ажиллагааны тайлбарлан таниулах, танин мэдэхүйн үнэ, цэнэ юу болох? ➢ Энэ нь явуулах үйл ажиллагаа, хэрэглэгчдийн бүлэг, ба тухайн газар нутагт хэрхэн тохирох? ➢ Тайлбарын хэлбэр, агуулга болон хүрээ зохих чанарын түвшинд байгаа, эсэх? 		
<p>Үйлчлүүлэгч/оролцогчдод өндөр чанартай, найдвартай, тохиромжтой үйлчилгээг үзүүлэх</p> <ul style="list-style-type: none"> ➢ Хүсэлт гаргагч нь харилцагчийн үйлчилгээ, үйл ажиллагааны зохих журамтай, эсэх? ➢ Хүсэлт гаргагч нь өөрийн үйл ажиллагааг зах зээлийн эрэлт, шаардлагад хариулсан байдлаар санал болгож буй, эсэх? 		
<p>Худалдааны байнгын ашигтай байдлыг хангах бизнесийн удирдлагын үр дүнтэй систем</p> <ul style="list-style-type: none"> ➢ Хүсэлт гаргагч нь өөрийн чадамж, чадвараа үйл ажиллагааны заавар болон гамшгийн үед ажиллах төлөвлөгөөгөөрөө харуулж байгаа, эсэх? ➢ Тухайн үйл ажиллагаанаас ТХНУГ-т санхүүгийн боломжийн ашиг өгөх, эсэх? ➢ Тухайн аж ахуйн нэгж ямар түвшний магадлан итгэмжлэхтэй вэ? ➢ Хүсэлт гаргагч нь, үйл ажиллагаагаа байнга сайжруулж ирснээ харуулах ямар систем, арга барилтай вэ? 		
<p>Эрсдлийн үр дүнтэй удирдлага</p>		

Шинээр тавьсан хүсэлтийг үнэлэх шалгуур	ТХНУГ-г шууд илэрхийлэх	Салбарын магадлан итгэмжлэлээр дамжуулан харуулж болох
<ul style="list-style-type: none"> ▷ Санал болгож буй, зочлон ирэгчид ба хөтөчийн тооны харьцаа оновчтой практикийн стандартад нийцэж байгаа, эсэх? ▷ Хүсэлт гаргагчид эрсдлийн удирдлагын стратеги бий, эсэх? ▷ Хүсэлт гаргагчид нийтийн эрсдлийн даатгалд хамрагдсан баримт бичиг байгаа, эсэх? ▷ Тоног төхөөрөмж нь салбарынхаа стандартад тохирч буй, эсэх? ▷ Засвар, үйлчилгээний болон капитал бүтээн байгуулалтын зохих системтэй, эсэх? 		
<p>Удирдагчид ба хөтөч нар нь зохих туршлагатай, ур чадвартай, сургалтанд хамрагдсан байдал</p> <ul style="list-style-type: none"> ▷ Удирдагчид ба хөтөч нар нь хангалттай туршлагатай, ур чадвартай, санал болгож буй үйл ажиллагааг явуулж чадах, эсэх? ▷ Шаардлага хангасан, ажиллагсадаа хөгжүүлэх сургалтын хөтөлбөр бий, эсэх? 		
<p>Хууль, тогтоомжид нийцэх байдал</p> <ul style="list-style-type: none"> ▷ Хүсэлт гаргагч, бусад агентлаг, газруудын шаардлагатай зөвшөөрөл авсан, эсэх? ▷ Тээврийн яам ▷ Далайн, тэнгисийн эргийн үйлчилгээнийг газар ▷ Бусад 		

Хавсралт 3. Үнэлгээний тайлангийн стандарт загварын жишээ

Хүсэлтийн ерөнхий зүйлс
Хүсэлт гаргагчийн нэр
Хүсэлтийн дугаар
Гардуулсан огноо
Файлын дугаар
Үнэлгээний огноо
Санал богосон үйл ажиллагааны тухай тайлбар
ТХНУГ-ийн нөөц газрын төрөл
ТХНУГ-ийн нөөц газрын нэр
ТХНУГ, Сан, эсвэл Удирдах зөвлөлийн аль нь хариуцаж байгаа?
Сан/Зөвлөл-д дээрхийн дагуу мэдэгдсэн огноо
Ашиглах тусгай газрууд.
Хүсэлт гаргач одоогийн байдлаар ямар нэгэн тусгай зөвшөөрөлтэй юу?
Одоогийн тусгай зөвшөөрлийн дугаар
Одоогийн тусгай зөвшөөрлийн дагуу явуулдаг үйл ажиллагаа
Хүсэлт гаргагч өмнө нь ТХНУГ-аас тусгай зөвшөөрөл авч байсан, эсэх?
Хүсэлт гаргагч одоогоор өөр муж/газар нутагт тусгай зөвшөөрөл эзэмшдэг, эсэх?
Хүсэлт
Дараах үйл ажиллагаа явуулахыг хүсч-нд гаргасан дугаартай хүсэлт:
үйл ажиллагаа/нууд/:
үйл ажиллагаа явуулах газар:
Хавсаргасан мэдээлэл
Хүсэлтэнд дараах мэдээлэл хавсаргаж өгсөн:
Санал болгож буй үйл ажиллагааны үнэлгээний тайлан
Энэхүү үйл ажиллагааг Хуулийн холбогдох заалтын дагуу зөвшөөрч болно/болохгүй
Энэхүү үйл ажиллагааг нь Тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө/Менежментийн зорилтуудтай нийцнэ/нийцэхгүй
Санал болгож буй үйл ажиллагаанд ТХНУГ-ын тусгай хамгаалалттай газрын талаарх бодлогын дараах зүйлс хамаарна (Жагсаалт оруул)
Энейхүү үйл ажиллагаа нь ТХНУГ-ын тусгай хамгаалалттай газрын талаарх бодлогын дараах зүйлстэй нийцэхгүй (Жагсаалт оруул)
Байгаль орчны хувьд тогтвортой, соёлд нийцсэн практик
Үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болохуйц нөлөөллүүд (Жагсаалт оруул)
Үнэлгээгээр тодорхойлсон, бусад тусгай хамгаалалттай газрыг ашиглаж байгаа хүмүүс болон тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай гарч болох зөрчлүүд (Жагсаалт оруул)
Тусгай хамгаалалттай газар дахь барилга байгууламж, дэд бүтцэд үзүүлж болох нөлөөлөл (Жагсаалт оруул)
Хүсэлт гаргагч нь дараах асуудлуудтай холбоотой нөлөөллийг хамгийн бага байлгах арга хэмжээний

талаар хангалттай харуулсан/харуулаагүй. Үүнд:
• ургамал, зэрлэг амьтан хамгаалах
• тухайн газар нутаг, ландшафтыг хамгаалах
• түүх, соёлын холбоотой газрыг хамгаалах
• усны чанарыг хамгаалаж, тордох
• дуу, шуугианы хяналт
• хорт угааны хаягдлыг багасгах
• хог хаягдал багасгах, түүний менежмент
• эрчим хүчний ашиглалтыг багасгах
Дараах нэмэлт хөнгөвчлөх арга хэмжээнүүдийг шаардлагатай гэж үзэв: Жагсаалт оруул
Байгаль орчны болон соёлын үнэ цэнгийн талаар чанартай, сайн тайлбарлах
Санал болгож буй үйл ажиллагааны сургалт, тайлбарлан таниулах талаар харуулаагүй / зарим зүйл дурдсан - тайлбарлана
Үйл ажиллагаа, үйлчлүүлэгчдийн бүлэг, ба газар нутагт тохирохгүй зүйл - тайлбарлана
Тайлбарын хэлбэр, төрөл, ба агуулга чанарын шаардлага хангаагүй/хангасан - тайлбарлана
Санал болгож буй үйл ажиллагаа Абориген иргэдийн өвийн талаар хангалттай тайлбарласан/тайлбарлаагүй - Тайлбарла
Хүсэлт гаргагч Абориген иргэдийн хамтлагтай зөвшилцөөгүй - тайлбарла
Тусгай зөвшөөрлийн нэмэлт нөхцлүүд шаардлагатай гэж үзсэн
Жагсаалт оруулна уу
Харилцагч/оролцогчиддоо дээд зэргийн чанартай, найдвартай, тохирсон үйлчилгээ үзүүлэх
Хүсэлт гаргагч нь харилцагчийн үйлчилгээ, үйл ажиллагааны зохих журамтай/журам байхгүй эсвэл хангалтгүй. Тодорхой тайлбар оруул.
Хүсэлт гаргагч нь өөрийн үйл ажиллагааг зах зээлийн эрэлт, шаардлагад хариулсан байдлаар санал болгож буй/болгоогүй. Тодорхой тайлбар оруул
Тусгай зөвшөөрлийн нэмэлт нөхцлүүд шаардлагатай гэж үзсэн
Жагсаалт оруулна уу
Худалдааны байнгын ашигтай байдлыг хангах бизнесийн удирдлагын үр дүнтэй систем
Хүсэлт гаргагч нь өөрийн чадамж, чадвараа үйл ажиллагааны заавраараа харуулж чадсан/чадаагүй
Аж ахуйн нэгж магадлан итгэмжлэгдсэн/итгэмжлэгдээгүй
Ямар магадлан итгэмжлэхтэйг дурьдна уу!
Хүсэлт гаргачид, үйл ажиллагаагаа байнга сайжруулж ирснээ харуулах журам байгаа/байхгүй. Тодорхой тайлбар оруул.
Эрсдлийн үр дүнтэй удирдлага
Санал болгож буй, зочлон ирэгчид ба хөтөчийн тооны харьцаа оновчтой практикийн стандартад нийцэж/нийцэхгүй байгаа. Тодорхой тайлбар оруул.
Хүсэлт гаргагч гамшгийн үед ажиллах төлөвлөгөө болон эрсдлийн удирдлагын стратеги боловсруулсан/боловсруулаагүй. Тодорхой тайлбар оруул.
Хүсэлт гаргагчид нийтийн эрсдэлийн даатгалд хамрагдсан баримт бичиг байгаа/байхгүй
Засвар, үйлчилгээний болон капитал бүтээн байгуулалтын зохих системтэй/системгүй
Удирдагчид ба хөтөч нар нь зохих туршлагатай, ур чадвартай, сургалтанд хамрагдсан байдал

Удирдагчид ба хөтөч нар нь хангалттай туршлагатай, ур чадвартай, санал болгож буй үйл ажиллагааг явуулж чадна. Тодорхой тайлбар оруул
Шаардлага хангасан, ажиллагсадаа хөгжүүлэх сургалтын хөтөлбөр бий, эсэх?
Хууль, тогтоомжид нийцэх байдал
Хүсэлт гаргагч, бусад агентлаг, газруудын шаардлагатай зөвшөөрөл авсан/аваагүй? Тээврийн яам, бусад?
Бусад нөхцлүүд
Нийтлэг тусгай зөвшөөрөлд заасан, үйл ажиллагааны ерөнхий ба тусгай нөхцлүүдээс гадна дараах нэмэлт нөхцлүүдийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлагатай. Үүнд: (жагсаах)
Бүс нутгийн ажилтнуудаас хийх шаардлагатай тусгай хяналт шалгалт ба мониторинг
Жагсаалт оруул
Зөвлөмж ба цохолт
Концессийн захиргааны ажилтан, санал болгож буй үйл ажиллагааны нөлөөллийг, боломжийн хирээр, аль болох бүхэлд нь авч үзсэн болно. Энэхүү хүсэлтийг, дээр дурьдсан нөхцлүүдийн дагуу зөвшөөрөхийг/доор дурьдсан шалтгааны улмаас (Жагсаалт оруул) үл зөвшөөрөхийг зөвлөж байна.
Хавсралтууд
Дараах бичиг баримтуудыг хавсаргасан бөгөөд, зохих байдлаар тэмдэглэв
Тусгай нөхцлүүдийг дурьдсан концессийн зөвшөөрлийн төсөл
Нэр
Гарын үсэг
Огноо

Хавсралт 4. Концессийн нийтлэг гэрээ - БОНХЯ/ТХГНУ-ын концессийн гэрээний агуулга ба нөхцөлүүд

Дэлхий даяар, тусгай хамгаалалттай газрын концессийн менежментийн гэрээнд дараах нийтлэг шинж чанаруудыг тусгасан байдаг. Түрээсийн гэрээг эцэслэн шийдэхэд гол төлөв саад тотгор болдог, хувийн секторын болгоомжилдог зүйлст бүхэлдээ ач холбогдол өгсөн болно.

Концессийн гэрээний агуулга

- ▶ Гэрээний талууд – Засгийн газрын Агентлаг/Сайд ба тусгай зөвшөөрөл эзэмшигч
- ▶ Гэрээний зорилгын тодорхойлолт
- ▶ Ерөнхий нөхцлүүд
- ▶ Тодорхойлолт ба тайлбар
 - a) Хууль тогтоомж/Акт гэж юуг хэлэх
 - b) Орлого гэж юуг хэлэх
 - c) Түрээсийн суурь болон эргэлтийн төлбөр гэж юуг хэлэх (томоохон концессийн гэрээнд)
 - d) Бусад төлбөрүүд гэж юуг хэлэх (жижиг буюу үйл ажиллагаа голлосон концессийн гэрээнд)
 - e) Эхлэх хугацаа гэж юуг хэлэх
 - f) Хугацаа ба опц гэж юуг хэлэх
 - g) Хэрэглээний үнийн индекс буюу жилийн өсөлт гэж юуг хэлэх
 - h) Түрээс гэж юуг хэлэх
 - i) Тусгай зөвшөөрөл гэж юуг хэлэх
 - j) Бүтээн байгуулалт (хөгжүүлэлт) гэж юуг хэлэх
 - k) Байгаль орчны хор хөнөөл гэж юуг хэлэх
 - l) Санхүүгийн жил ба тайлангийн хугацаа гэж юуг хэлэх
 - m) Гэрээний нөхцөлд заасан нутаг дэвсгэр гэж юуг хэлэх
 - n) Гэрээний нөхцөлд заасан үйл ажиллагаа гэж юуг хэлэх
 - o) Засгийн газрын зөвшөөрөл гэж юуг хэлэх
 - p) Засгийн газрын төлөөлөл гэж юуг хэлэх
 - q) Концесс эзэмшигчийн эрх гэж юуг хэлэх
 - r) Коцесс эзэмшигчийн төлөөлөл гэж юуг хэлэх
 - s) Концесс эзэмшигчийн эрх гэж юуг хэлэх
- t) Болон бусад бүх стандарт болон хууль зүйн тодорхойлолт ба тайлбарууд

Урьдчилсан нөхцлүүд

- ▶ Концесс эзэмшигч нь шаардлагатай бүх зөвшөөрөл, бүрэн эрх, чиглэлийг авсан байх,

ТАЙЛБАР:

Тухайн газрыг эзэмших эрхийг олгохын өмнө зайлшгүй байх ёстой гэж Засгийн газрын эрх бүхий байгууллагын тооцож байгаа зүйлс орно. Үүнд, тахиж шүтдэг газартай холбоотой зөвшөөрөл, бүтээн байгуулалтын батлагдсан дүрэм, согтууруулах ундааны тусгай зөвшөөрөл, операторын магадлан итгэмжлэл болон эрх бүхий байгууллагын хамаарах үүрэгтэй холбоотой аливаа зүйлс орно.

- Шаардлагатай бүх даатгалыг хийлгэсэн байх
- Концесс эзэмшигчид зөвшөөрсөн аливаа бүтээн байгуулалт, сайжруулалтанд шаардлагатай санхүүжилт бэлэн байх
- Концесс эзэмшигчийг батлан даасан батлагаа бэлэн байх

ТАЙЛБАР:

Концесс эзэмшигчийн санхүүжилт авах боломж нь гэрээний нөхцлөөс, гэрээний дагуу хүлээж буй үүрэг хэр зэрэг хүнд, дарамттай байхаас шалтгаална. Ялангуяа, гэрээгээр эзэмших хугацаа их богино юм уу, гэрээ цуцлах нөхцөл нь их хатуу байвал банкууд зээл олгохдоо дургүй байдаг.

ТАЙЛБАР:

Урьд нь, тусгай хамгаалалттай газрын концессийн гэрээнд хувийн батлагаа байхад хангалттай байлаа. Харин өнөөдөр бол энэ нь нилээд ярвигтай болоод байгаа юм. Урьд нь, байгаль орчин, түүний хамгаалалтанд санаа тавьдаг хувь хүнтэй ТХГ-ын гэрээг голдуу хийдэг байсан. Харин одоо бол, ТХГ-н дэд бүтэц нь дэлхийн хэмжээний өрсөлдөх чадвартай байхын тулд нилээд боловсронгуй байж, тэр хэмжээгээрээ их хөрөнгө оруулалт шаарддаг болжээ. Иймд хувийн секторын хөрөнгө оруулагч тэр бүр хувийн батлагаа гаргаж өгөөд байхыг хүсдэггүй байна. Дүрмийн санг хувийн өмчөөр бүрдүүлсэн бол, санхүүжүүлэгчийн томилсон захирлууд хувийн батлагаа барагтай бол гаргаж өгөхгүй. Иймд, ТХГ эрх бүхий байгууллага энэ шаардлагаа арай өөр байдлаар хангах арга замыг хайх хэрэгтэй.

ТАЙЛБАР:

Хэрэв Засгийн газрын эрх бүхий байгууллага ямар нэгэн хэлбэрээр явцын дунд дэмжлэг үзүүлсээр байх юм бол, төслийн хувь заяанд сайнаар нөлөөлж, алслагдсан нутагтай холбоотой эрсдлийг бууруулан, төсөл амжилттай хэрэгжих магадлал өндөр болно. Засгийн газрын эрх бүхий байгууллагаас оруулж болох хувь нэмэрийн жишээ нь:

- а) тухайн газарт очих замын тогтмол арчилгаа
- б) Шигүү ойн түймрээс сэргийлэхийн тулд, ойг хяналтан дор шатаах
- в) Хог хаях газар, бохир ус цэвэрлэх байгууламж, усан хангамж, цахилгааны эх үүсвэр, орон тооноос илүү ажилчдын байр, зорчигч ба ачааны хольмог тээврийн үйлчилгээ гэх мэтийн төсөлд ТХГ-т газар ашиглах зөвшөөрлийг хөрөнгө оруулагчид олгох

- Тухайн газартай холбоотой өмнөх, үнэгүй буюу барьцаанд тавиагүй г.м. түрээсийн гэрээ, тусгай зөвшөөрлийг хураах шаардлага гарч болно
- Банкны батлагаа гаргаж өгөх
 - Засгийн газрын эрх бүхий байгууллагад төсөв ба бизнес төлөвлөгөөгөө өгөх
 - Тухайн газарт хэрэгжүүлэх аливаа бүтээн байгуулалтын төлөвлөгөөг өгч зөвшөөрүүлэх
 - Засгийн газрын эрх бүхий байгууллагаас (зарим тохиолдолд) зарим нэг үйлчилгээ, чухал дэд бүтцийг хангахыг зөвшөөрсөн
 - Түрээслүүлэгчийн зүгээс (зарим тохиолдолд) төслийн санхүүжилтэнд туслах

Бүтээн байгуулалтын талаар хүлээх тодорхой үүрэг

Оператор (концесс эзэмшигч)-н зүгээс ямар нэг бүтээн байгуулалт хийж сайжруулах ажлын санал гаргаж зөвшөөрөөгүй тохиолдолд, Тусгай хамгаалалттай газрын эрх бүхий байгууллага (голдуу Сайд) түүнд тусгай хамгаалалттай газрын хэсгийг түрээслэх эрх буюу тусгай зөвшөөрөл олгохгүй.

- Ажил эхлүүлэх хугацаа
- Ажил дуусгах хугацаа

- ▶ Зарим тохиолдолд, ажилд шаардлагатай наад захын хөрөнгө
- ▶ Ажлыг шалгах журам
- ▶ Ажил эхэлсэн боловч ямар нэгэн шалтгаанаар дуусаагүй бол ямар арга хэмжээ авах
- ▶ Ажлын үр дүнд олгосон аливаа концесс

Удирдлага/эзэмшил өөрчлөгдөх

- ▶ Аж ахуйн нэгж зарагдах буюу удирдлага, эзэмшил нь өөрчлөгдсөн тохиолдолд Засгийн газрын эрх бүхий байгууллага шинэ операторын чадварыг шалгах болно

Бүтээн байгуулалтын ажлын журам

- ▶ Бүх хийгдэх ажил зөвшөөрөгдсөн төлөвлөгөө, үзүүлэлтийн дагуу явагдна
- ▶ Ажлыг хийж гүйцэтгэхэд зарцуулах хугацаа
- ▶ Ажлын явцад тусгай хамгаалалттай газарт болон нийтийн бүсэд нэвтрэх хязгаарлалтын нөлөө
- ▶ Тогтвортой дэд бүтэц ашиглах үүрэг (хэрэв заасан бол)
- ▶ Хог, ямар нэгэн шингэн хаягдал, орчныг бохирдуулж болох бусад зүйлсийг зайлуулах буюу боловсруулах наад захын стандарт
- ▶ Байгаль орчны ослын талаар мэдээлэх
- ▶ Аврах, яаралтай арга хэмжээ авахтай холбоотой нөхцлүүд
- ▶ Хэрэглэх аливаа тусгай арга зүй
- ▶ Барилгын ажлын үед хяналт хийх нөхцлүүд
- ▶ Туслан гүйцэтгэгчид болон ажилтнуудад тавих шаардлага

Концессийн гэрээг шинэчлэх

- ▶ Концессийн гэрээний хугацаа дуусахад сунгах болон сонгож болох (опц) хугацаа
- ▶ Гэрээг шинэчлэхэд хүргэх нөхцөл ба мэдэгдэх хугацаа

ТАЙЛБАР:

Концессийн гэрээг сунгах заалт нь хувь хөрөнгө оруулагчид таатай нөхцөл юм. Хөрөнгө оруулагч нь гэрээний сунгалтын нөхцлийг аль болох өөрөөс хамааралтай байлгахыг чухалчилна. ТХГ-н эрх бүхий байгууллага нь энэ нөхцлийг, шинээр хөрөнгө татан оролцуулах болон сайн практикийн зарчмыг хэрэгжүүлэх хөшүүрэг болгон ашигладаг байна.

Хураамж, түрээсийн төлбөрийг авч үзэх

- ▶ Гол төлөв төлбөрийн хуваарьт зааж өгсөн байдаг
- ▶ Багахан концесс дээр бол хураамж төлнө
- ▶ Томоохон, гол концессийн хувьд суурь түрээс, эргэлтийн түрээсийн төлбөр
- ▶ Хураамж, түрээсийн төлбөрийг хянаж үзэх журам ба хугацаа
- ▶ Хураамж, түрээсийн төлбөрийг төлөх хэлбэр ба хугацаа
- ▶ Хураамж, түрээсийн төлбөрийн хэмжээг тооцож тогтоосон тухай тэмдэглэл хөтлөх (гол, том концессын хувьд эргэлтийн түрээсийн төлбөр, жижиг буюу үйл ажиллагаанд тулгуурласан коцесст бол зочин нэг бүрийн хураамж)

ТАЙЛБАР:

Аялал жуулчлалын аливаа бүтээн байгуулалт бэлэн болтлоо нэг буюу түүнээс дээш жил үргэлжилж болно. ТХГ-н бүтээн байгуулалт нь, хол байрлал, улирлын чанартай байдал, хөрөнгө оруулалтын их хэмжээнээс болж бүүр ч удаан хэрэгжих нь бий. Хөрөнгө оруулагчийг 5 жилийн түрээсийг төлбөрөөс чөлөөлөх нь их тустай бөгөөд үйл ажиллагаагаа тогтвортой явуулж эхлэх боломж олгоно.

ТАЙЛБАР:

Түрээсийн төлбөрийн шатлалтай хэлбэрийг их төлөв хэрэглэдэг

ТАЙЛБАР:

ТХГ-н эрх бүхий байгуулага ТХГ дахь бүтээн байгуулалтаас шууд үр ашиг хүртэнэ гэж хүлээх ёсгүй. Урт хугацааны туршид, түрээсийн төлбөр болон бусад орлогоос ТХГ-г эерэг нөлөө үзүүлэхээс биш ашиг авах гэж яарснаас төслийг нурааж ч болно.

ТАЙЛБАР:

Операторууд нь, түрээсийн тогтмол хэмжээтэй төлбөрөөс хувиар тооцсон төлбөрийн бүтцийг илүүд үздэг, гэхдээ энэ нь бүтээн байгуулалтын байрлал болон шинж чанараас ихээхэн хамаарна. Түрээсийн төлбөрийн тогтоосон нэг хэмжээ бүх тохиолдолд таарна гэж байхгүй тул түүнд уян хатан хандах хэрэгтэй.

Бүртгэл, тэмдэглэл

- › Зарим, тодорхой бүртгэлүүдийг хөтлөж, явуулж байх үүрэг:
- › Санхүү, худалдааны
- › Хөрөнгө бүртгэлийн
- › Аялалын холбогдолтой тоо
- › Аюултай ачаа, барааны бүртгэл
- › Асбестын бүртгэл
- › г.м, бусад.

Албадан төлбөр барагдуулах

- › Албадан төлөлтийн байдалд хүргэж болох үйл явдал, нөхцлийг дурьдах
- › Гол төлөв, ийм хоёр төрлийн үйл явдал байдаг
- › Автоматаар албадан төлбөр барагдуулж, гэрээг дуусгавар болгох:
- › Дампуурал
- › Гэмт хэрэгт холбогдох
- › Түрээсийн гэрээ зөрчсөнөөс үүдэлтэй албадан төлүүлэлт:
- › Ажилтнууд болон зочлон ирэгсдээс, эсвэл операторын санамсар, болгоомжгүйгээс болж байгаль орчинд хохирол учруулснаас.

- ▶ Урьд өмнөх жишээнээс харахад, дээр дурьдсан шалтгааны улмаас, хамаарагч Сайд түрээсийн гэрээг өөрийн эрхийн хүрээнд цуцлах хүртэл арга хэмжээ авдаг бөгөөд заримдаа ийм шийдвэрийг шууд гаргадаг байна..

ТАЙЛБАР:

Бүтээн байгуулагч нь, албадан төлүүлэлт, гэрээ цуцлалтын талаар заасан дарамтнаас айж болгоомжлохгүй байх нь чухал.

ТАЙЛБАР:

Дээр дурьдсан, автоматаар гэрээ цуцлахад хүргэхээс бусад аливаа албадан төлүүлэлтийн өмнө, ТХГ-ын эрх бүхий байгууллага түрээслэгчид зөрчлийн талаар бичгээр мэдэгдэж, зөрчлийг арилгах боломж олгоно. Хэрэв тухайн зөрчлийг арилгах боломжгүй бол, ТХГ гарсан хохирлыг нөхөх, торгууль гэх мэт ямар нэгэн өөр арга хэмжээ авна. Ийм аливаа арга хэмжээ нь, санхүүгийн хувьд боломжийн, шударга байх ёстой.

ТАЙЛБАР:

Бичгээр өгөх мэдэгдэлд, зөрчлийг арилгах боломжийн хугацаа, нөхцлийг зааж, эргэж шалгаж хугацаа, зөрчлийг арилгаагүй бол авах дараагийн арга хэмжээний тухай тодорхой заасан байна.

ТАЙЛБАР:

Бүтээн байгуулагчийн зүгээс, шаардлагатай холбоотой эрсдлийг хүлээн авах боломжгүй, эсвэл зөрчил арилгах нэмэлт үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг банк болон санхүүгийн бусад байгууллагаас авч чадахааргүйгээс бусад тохиолдолд аль болох гэрээг автоматаар (Сайдын түвшинд) цуцлах арга хэмжээ авахгүй байвал зохино.

Концессийн гэрээний дагуу газар нутаг ашиглах болон ашиглалтын хэлбэр

- ▶ Ашиглалтыг зөвшөөрсөн тодорхой хэлбэрүүд
- ▶ Гэнэтийн аюулын үед ашиглах хэрэгслэл, яаралтай ажиллагааны хүлээх үүрэг
- ▶ Хууль журам, мэдэгдэл, бусад зөвшилцөж тохирсон төлөвлөгөөг дагаж мөрдөх үүрэг
- ▶ Хор, хөнөөлтэй ашиглалтын үйл ажиллагаа гаргахгүй байх
- ▶ Түлэх мод ойгоос авахгүй, мод огтлохгүй, гэрийн тэжээмэл амьтан байлгахгүй, хор хөнөөлтэй ургамал тарихгүй байх зэрэг ашиглалтанд хамаарах хязгаарлалтууд.
- ▶ Түлш, шатхууны сав гэх мэтийн овор ихтэй дэд бүтцийн зүйлсийг заасан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах
- ▶ Гал түймрээс сэргийлэх, аюулгүй байдлын талаар хүлээх үүрэг
- ▶ Хог, хаягдал зохицуулах үүрэг
- ▶ Олон нийтийн очих боломжийг хангахтай холбоотой бусад үүрэг

ТАЙЛБАР:

Бүтээн байгуулагчийн зүгээс тодорхой хэмжээний онцгой эрхийг чухалчилж хүсэх нь бий. Боломжтой бол энэ хүсэлтийг биелүүлэх хэрэгтэй. Өрсөлдөгч орж ирэхэд саад тавиагүй бол хөрөнгө оруулагч барагтай бол оролцох дургүй байдаг.

Арчилгаа, засвар, өөрчлөлт

- ▶ Стандарт болон нөхцлүүдийг дагаж мөрдөх үүрэг

- Концессийн гэрэний төгсгөлд дэд бүтцийг ямар байдалтай (нөхцөл) үлдээх талаарх хүлээх үүрэг (хэрэв заасан бол).
- Засгийн газрын эрх бүхий байгууллагын шалгах эрх
- Годорхой материал, химийн бодис гэх мэтийг ашиглахгүй байх үүрэг (хэрэв заасан бол).
- Хортон шавьжийн талаар хүлээх үүрэг
- Газар эвдрэлийн талаар хүлээх үүрэг

Даатгал

- Даатгал хийлгэсэн байх үүрэг, даатгалын төрөл, хамрах хүрээ г.м.
- Сэргээн босгох үүрэг

Нөхөн төлбөр

- Чөлөөлөх – газар нутгийг ашиглалтын эрсдлийг түрээслүүлэгч өөртөө авах
- Нөхөн төлбөр – доорх шалтгаануудын улмаас үүдэн гарсан, Засгийн газрын эрх бүхий байгууллагаас тавьсан, хохирлын, шүүхийн, нэхэмжлэлийн холбоотой нөхөн төлбөрийг концесс эзэмшигч төлж барагдуулна. Үүнд:
 - a) Концесс эзэмшигч гэрээгээ зөрчсөн
 - b) Концесс эзэмшигчийн хүлээсэн үүргийн биелэлт зөрчилтэй
 - c) Концесс эзэмшигч хууль зөрчсөн
 - d) Концесс эзэмшигчийн үл тоомсорлох байдал г.м.

Засгийн газрын эрх бүхий байгууллагатай тохирсон зүйлс

- Концесс эзэмшигчийн тайван, амгалан байдал
- Түрээсийн гэрээ дуусгавар болоход концесс эзэмшигч хийсэн зүйлсээ буцааж буулгахыг зөвшөөрөх (эс зөвшөөрөх)
- Түрээсийн төлбөрийн хэмжээг бууруулж болох нөхцөл
- Зарим дэд бүтэц, үйлчилгээг концесс эзэмшигчийн зардлаар хангах үүрэг
- Батламжлах, ажиглалт, судалгаа хийх гэх мэт аливаа асуудлаар гарах зардлыг концесс эзэмшигч хариуцах.

ТАЙЛБАР:

Концесс эзэмшигч засгийн газрын эрх бүхий байгууллагатай тогтмол (улирал бүр) уулзаж, тохирсон асуудлуудаа ярилцаж баримтжуулдаг явдал нийтлэг байдаг бөгөөд, үүнийг сайн практик гэж үздэг. Энэ нь, харилцааг сайжруулж, хамтын ажиллагааны илүү сайн уур амьсгалыг бүрдүүлдэг.

Журам тогтоосон зүйлс

- Эрх, үүргээс чөлөөлөх, татгалзах
- Мэдэгдэл
- Бүрэн эрх, үүрэг
- Гэнэтийн зардал
- Нутаг дэвсгэр, байр савыг шалгах
- Дахин эхлэх нөхцөл

- Хууль, тогтоомжийн заалтыг дагаж мөрдөх
- Томилгооны нөхцлүүд
- Үнэ цэн тогтоох
- Маргаан шийдвэрлэх

Сонгох, татгалзах давуу эрх

- Концесс эзэмшигчид дараах тохиолдолд давуу эрх олгох явдал нь хэвийн үзэгдэл юм. Үүнд:
- Концессийн гэрээний сунгалт
- Тусгай хамгаалалттай газрын эрх бүхий байгууллагын чөлөөлсөн бусад газарт бүтээн байгуулалт хийх боломж

ТАЙЛБАР:

Бүтээн байгуулагч нь, хийхээр зорьж байгаа зүйлийнхээ үр дүнг аль болох өөрөөсөө хамааралтай, хянах боломжтой байлгах аливаа арга замыг эрж хайдаг бол хөрөнгө оруулагч нь, өөрийн оюуны өмчийг аль болох хамгаалах эрмэлзлэлтэй байдаг. Давуу эрх олгох нь эдгээр хүсэлтийг хангах нэг арга юм.

Бүтээн байгуулалтыг эзэмшигч

- Концесс эзэмшигчийн хийж бүтээсэн, сайжруулсан бүх зүйл Засгийн газрын эрх бүхий байгууллагын мэдэлд үнэ төлбөргүй очих, эсэх?
- Гэрээний хугацаа дуусах үед, Засгийн газрын эрх бүхий байгууллага концесс эзэмшигчид үлдэгдэл үнийг төлөх, эсэх?
- Концесс эзэмшигч, бүтээн байгуулсан зүйлээ эзэмшиж, элэгдлийг нь хариуцан, гэрээ дуусах үед зах зээлийн үнэ цэнээр худалдах боломжтой байх, эсэх?

Бусад нөхцлүүд

- Нисэх онгоцны зурвас байгаа эсэх?
- Урсгал ус, усан зогсоол г.м. байгаа эсэх?
- Тусгай хамгаалалттай газарт хогийн цэг/нүх байгаа эсэх?
- Цахилгааны дундын үүсгүүр, нарны үүсгүүр байгаа эсэх?
- Холбогдох аялал жуулчлалын зөвшөөрөл байгаа эсэх?
- Түрээслэж байгаа газар дотор буюу ойр орчимд тахиж шүтдэг газар байгаа эсэх, байгаа бол ямар нөхцөл, хязгаарлалт тавигдах?

Гүйцэтгэлийн хуудас

Газар нутгийн төлөвлөлт, хавсаргана

Гол, чухал мэдээллийн хуваарийг хавсаргана

- Төлбөл зохих түрээс/ашиглалтын хураамж
- Түрээс/хураамжийн нягтлал
- Хугацаа

ТАЙЛБАР:

Хөрөнгө оруулалтын цар хэмжээнээс хамааран банкнаас нь тодорхой хэмжээний доод хугацааг тулгадаг учраас хөрөнгө оруулагч аль болох урт хугацаатай гэрээ хийхийг хүсдэг байна. Хөрөнгө оруулагч нь тухайн бизнесээс зөвхөн анхны болон, урт хугацааны ашгийг харах бус, бизнесийн үлдэгдэл үнэ цэнд бас анхаардаг гэдгийг ТХГ-н эрх бүхий байгууллага тооцож үзэх ёстой. Өөрөөр хэлбэл, тэд өөрсдийн нөр их зүтгэл, зорилтоороо бүтээсэн зүйлийнхээ үнэ цэнг гаргаж авахын тулд дараа нь худалдах ямар нэг зүйлтэй байхыг хүснэ гэсэн үг юм. Иймд түрээсийн гэрээний хугацаа урт байх тусмаа сайн байдаг. Наад захын хугацаа 20 жил байхыг стандарт гэж үзнэ, дээд тал нь 99 жил байх нь ч тийм гайхах зүйл биш.

Сонголт хугацаа

- › Төлбөрийн нарийвчилсан зүйл
- › Зөвшөөрөгдсөн ашиглалт